Зөвшөөрсөн: 58

Татгалзсан: 32

Бүгд: 90

64.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

67.Байнгын хорооны саналаар Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 33

Бүгд: 90

63.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

68.Байнгын хорооны саналаар Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58

Татгалзсан: 32

Бүгд: 90

64.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

69.Байнгын хорооны саналаар Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58

Татгалзсан: 32

Бүгд: 90

64.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

70.Байнгын хорооны саналаар Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60

Татгалзсан: 30

Бүгд: 90

66.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

71.Байнгын хорооны саналаар Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60

Татгалзсан: 30

Бүгд: 90

66.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

72.Байнгын хорооны саналаар Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58

Татгалзсан: 32

Бүгд: 90

64.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

73.Байнгын хорооны саналаар Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 31

Бүгд: 90

65.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

74.Байнгын хорооны саналаар Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61

Татгалзсан: 29

Бүгд: 90

67.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

75.Байнгын хорооны саналаар Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61

Татгалзсан: 29

Бүгд: 90

67.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

76.Байнгын хорооны саналаар Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60

Татгалзсан: 30

Бүгд: 90

66.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

77.Байнгын хорооны саналаар Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58

Татгалзсан: 32

Бүгд: 90

64.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

78.Байнгын хорооны саналаар Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 31

Бүгд: 90

65.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

79.Байнгын хорооны саналаар Хувийн хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56

Татгалзсан: 34

Бүгд: 90

62.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

80.Байнгын хорооны саналаар Хувиргасан амьд организмын тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 37

Бүгд: 90

58.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

81.Байнгын хорооны саналаар Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 33

Бүгд: 90

63.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

82.Байнгын хорооны саналаар Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 31

Бүгд: 90

65.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

83.Байнгын хорооны саналаар Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58

Татгалзсан: 32

Бүгд: 90

64.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

84.Байнгын хорооны саналаар Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 33

Бүгд: 90

63.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

85.Байнгын хорооны саналаар Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60

Татгалзсан: 30

Бүгд: 90

66.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

86.Байнгын хорооны саналаар Шүүх шинжилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 36

Бүгд: 90

60.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

87.Байнгын хорооны саналаар Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56

Татгалзсан: 34

Бүгд: 90

62.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

88.Байнгын хорооны саналаар Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 33

Бүгд: 90

63.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

89.Байнгын хорооны саналаар Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58

Татгалзсан: 32

Бүгд: 90

64.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

90.Байнгын хорооны саналаар Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 33

Бүгд: 90

63.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн болон Эдийн засгийн байнгын хороодод шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Арав дахь асуудал буюу Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудал санал хураалтаар үргэлжлэв.

Н.Учрал: Байнгын хорооны саналаар Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52

Татгалзсан: 38

Бүгд: 90

57.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Арван нэг. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 40 гишүүн 2025.10.10-ны өдөр өргөн мэдүүлсэн/

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслөөс Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Батжаргал завсарлагын хугацааг ажлын 3 өдрөөр сунгаж байгаа тухай мэдэгдэж, Улсын Их Хурлын дарга Н.Учрал уг асуудлаар ажлын 3 өдрийн завсарлага өгөв./18:04/

Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулга сонсох

Улсын Их Хурлын дарга Н.Учрал дараах хууль, тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав.

Үүнд:

1.Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:06/

2. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:06/

3.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:07/

4.Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:07/

5.Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:08/

6.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:08/

Арван хоёр.“Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, гүйлгээ сангийн орлого, зарлагын 2025 оны гүйцэтгэл, 2026 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгч С.Наранцогт, мөн банкны Санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин, мөн газрын Эрдэнэсийн сангийн ахлах эдийн засагч Т.Тэлмэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт М.Мандхай нар байлцав.

Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга танилцуулав.

Санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Г.Хосбаяр нарын тавьсан асуултад Монголбанкны Ерөнхийлөгч С.Наранцогт, мөн банкны Санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./18:25/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 12 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 6 цаг 50 минут үргэлжилж, 126 гишүүнээс 92 гишүүн хүрэлцэн ирж, 73.0 хувийн ирцтэйгээр 18 цаг 25 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 26-ны өдөр,
Баасан гараг Төрийн ордон “Их хуралдай” танхим 10 цаг 25 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Учрал: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгаж мэндчилье ээ. Ирц 59.5 хувь 75 гишүүн хүрэлцэн ирсэн байна. Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

1 дүгээрт, Монгол Улс болон ЕСБХБ хоорондын зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

2 дугаарт, Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр соёрхон батлах тухай хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

3 дугаарт, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

4 дүгээрт, Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

5 дугаарт, Хянан шалгах түр хорооны сонсголын тайлан, санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

6 дугаарт, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн. Төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

7 дугаарт, Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

8 дугаарт, Улсын Их Хурлын асуулгын цаг,

Асуулгын цагийн дараа үл хөдлөх хөрөнгө борлуулахад төлдөг 2 хувийн татварыг хүчингүй болгох асуудлаар хуулийн төсөл санаачлах тухай Нийтийн өргөдлийн талаарх төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсоно.

10 дугаарт, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

11 дүгээрт, “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

12 дугаарт, “Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, гүйлгээ, сангийн орлого, зарлагын 2025 оны гүйцэтгэл, 2026 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32.1-д хууль санаачлагч хэлэлцүүлгийн аль ч шатанд санаачилсан хуулийн төслөө татан авч болно гэж, 32.3-д хуулийн төслөө татан авах тохиолдолд тухайн төсөл нь хэлэлцүүлгийн аль ч шатанд байгаагаас үл хамаарч хууль санаачлагч хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд энэ тухай танилцуулснаар хууль санаачлагч хуулийн төслөө татан авсанд тооцно гэж заасны дагуу Засгийн газраас 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуулийн төсөл татан авах тухай Засгийн газрын 1/144 дугаартай албан бичиг ирүүлснийг уншиж танилцуулъя.

Хуулийн төсөл татан авах тухай.

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2025 оны 5 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн Арилжааны тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл ШШГБ-ын тогтолцоо, Шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Иргэний болон Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Эрүүгийн болон Зөрчлийн хэргийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслүүд болон эдгээр хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32.1 дэх хэсэгт заасны дагуу тус тус татан авч байгааг үүгээр мэдэгдэж байна. Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг хавсаргав.

Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар гэсэн Хуулийн төсөл татан авах тухай албан бичгийг та бүхэнд танилцууллаа.

Засгийн газраас 5 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн ШШГБ-ын тогтолцоо, Шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын хууль Эрүүгийн болон Зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Иргэний болон Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Арилжааны хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг татан авсанд тооцлоо.

***“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын
төсөл /үргэлжилнэ/***

Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчаас асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан. Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт явуулах хэрэгтэй байна. Гишүүд танхимд цуглая. Энэ 64-өөр санал хураана.

АН-ын дарга бүлгийн дарга гишүүдээ танхимд цуглуулъя. АН-ын гишүүдийг танхимд урьж байна. АН-аас Сайнхүүгийн Ганбаатар гишүүн ганцаараа ирсэн байна шүү. АН-ын гишүүдийг урьж байна. Энэ зүрх судасны эмнэлэг барьж байгуулах зээлийн хэлэлцээр юм байгаа юм шүү дээ тийм биз. 3 дугаар эмнэлгийн дэргэд чадавхыг дэмжих дээрээс нь 50 хувь нь буцалтгүй тусламж. Хоёрдугаарх нь нөгөө

олон сургууль, цэцэрлэг. Азийн хөгжлийн банкны, онцгой байдал, гамшгийн асуудал байгаа шүү.

Өнөөдөр эрхэм гишүүдэд бас мэдээлсэн. D-Парламент дээр AI шинжилгээ орсон шүү. Тэгэхээр одоо Их Хуралд өргөн мэдүүлчихсэн байгаа хуулиудыг хиймэл оюунаар дүн шинжилгээ хийж байгаа юм. Хүний эрхийн зөрчил байна уу, эдийн засгийн эрх чөлөөний зөрчил байна уу, Үндсэн хуулийн зөрчил байна уу, Улс төрийн эрх, эрх чөлөөний зөрчил байна уу гэдгийг хиймэл оюун шинжилж байгаа юм.

Тийм учраас цаашид Их Хурал хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн хууль тогтоомжийг хүлээж авахгүй ээ. Эхлээд хиймэл оюун дээр шинжилгээ хийгээд, хүний эрхийн зөрчлүүд байвал буцаана гэдэг ийм ажлыг эхлүүлж байгаа юм. Засгийн газраас ч бай, Их Хурлын гишүүдээс ч бай. Тэгэхээр Их Хурлын гишүүд хууль санаачлагч нар мөн судлаачид хууль боловсруулсан бол тэр апплөүд хийгээд хууль дээрээ дүн шинжилгээ хийж болно.

Дээрээс нь зохицуулалтын шинж чанартай, редакцын нөгөө бас агуулгын засваруудыг хиймэл оюун нэг минутад л хийж байгаа. Тэгэхээр энэ бол мэдээж 100 хувь алдаагүй байна гэж байхгүй. Гэхдээ өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 378 хууль дээр ажиллаад өгөгдөл болгож хувиргасан. Тэгээд их өгөгдөл дээр дүн шинжилгээ хийж байгаа болохоор мартана санана гэж байхгүй. Дээрээс нь хиймэл оюунд нөгөө танил тал, хамаатан садан байхгүй учраас ар өврийн хаалгагүйгээр асуудалд хандана тийм. Тамгын газар таньдаг хүн байна уу гэх шаардлагагүй болж байгаа гэсэн үг. Хиймэл оюун наадах хуулийг чинь нөү гэж байна гэвэл шууд хэлээд хиймэл оюун дээр дүн шинжилгээ хийгээд хариуг нь явуулна л гэж байгаа юм.

Дэгийн хуулийн 44.3-аар Монгол Улс болон ЕСБХБ хоорондын зээлийн хэлэлцээр, АХБ-ны банк хоорондын санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр соёрхон батлах тухай хуулийн төслийн санал хураалтыг түр хойшлуулж байна. Нэгтгэж санал хураая.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна аа. Энэ Засгийн газарт чиглэл өгөх тухай нөгөө сэргээгдэх эрчим хүчний тогтоол, нөгөө газрын тос, бүтээгдэхүүний хараат байдлыг бууруулах тухай Засгийн газарт чиглэл өгөх тогтоол байгаа.

Бүртгэлийн санал хураалт явуулъя, бүртгэлийн санал хураалт байна. Ирц 50 гишүүн дэмжиж байна.

Ингээд Байнгын хорооны саналаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

54 гишүүн дэмжиж, 69.2 хувийн саналаар тогтоолын төслийг дэмжлээ. Тогтоолын төслийг баталлаа. Болормаа гишүүнийг дэмжсэнээр протоколд, тэмдэглэлд үлдээе.

Улсын Их Хурлын гишүүдэд талархал илэрхийлье. Ногоон эрчим хүч, ногоон эдийн засгийг дэмжих тогтоолын төсөл батлагдлаа. Энхцэцэг гишүүнд баяр хүргэе баярлалаа.

10.40 цаг

Дараагийн асуудалд оръё.

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Улсын Их Хурлын гишүүд хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо Байнгын хорооны саналаар Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт. Санал хураалтад бэлтгэе. Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураана.

Санал хураалт.

53 гишүүн дэмжиж, 53 хувиар 79 гишүүн дэмжлээ. 53 гишүүн дэмжиж, 67.1 хувиар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцье ээ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураана. Санал хураалт.

53 гишүүн дэмжиж, 67.1 хувиар санал дэмжигдлээ. Идэрбат гишүүнийг дэмжсэнээр протоколд үлдээе.

3. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураана. Санал хураалт.

54 гишүүн дэмжиж, 68.4 хувиар санал дэмжигдлээ.

Арбитрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

55 гишүүн дэмжиж, 69.6 хувиар санал дэмжигдлээ.

5.Ахмад настны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

56 гишүүн дэмжиж, 70.9 хувиар санал дэмжигдлээ.

6.Банкан дахь мөнгөн хадгаламжийн тухай, Даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

55 гишүүн дэмжиж, 69.6 хувиар санал дэмжигдлээ.

7.Векселийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

55 гишүүн дэмжиж, 69.6 хувиар санал дэмжигдлээ.

8.Даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

58 гишүүн дэмжиж, 73.4 хувиар санал дэмжигдлээ.

9. Жолоочийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

58 гишүүн дэмжиж, 72.5 хувиар санал дэмжигдлээ.

10.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

59 гишүүн дэмжиж, 73.8 хувиар санал дэмжигдлээ.

11.Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

57 гишүүн дэмжиж, 71.3 хувиар санал дэмжигдлээ.

12.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

58 гишүүн дэмжиж, 72.5 хувиар санал дэмжигдлээ.

13. Ирээдүй өв сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

57 гишүүн дэмжиж, 71.3 хувиар санал дэмжигдлээ.

14. Кино урлагийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

59 гишүүн дэмжиж, 72.8 хувиар санал дэмжигдлээ.

15. Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

57 гишүүн дэмжиж, 70.4 хувиар санал дэмжигдлээ.

16. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

58 гишүүн дэмжиж, 71.6 хувиар санал дэмжигдлээ.

17. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

56 гишүүн дэмжиж, 69.1 хувиар санал дэмжигдлээ.

18. Нөхөрлөлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

57 гишүүн дэмжиж, 70.4 хувиар санал дэмжигдлээ.

19. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

58 гишүүн дэмжиж, 71.6 хувиар санал дэмжигдлээ.

20. Санхүүгийн түрээсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

57 гишүүн дэмжиж, 70.4 хувиар санал дэмжигдлээ.

21.Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

58 гишүүн дэмжиж, 71.6 хувиар санал дэмжигдлээ.

22.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

58 гишүүн дэмжиж, 71.6 хувиар санал дэмжигдлээ.

23.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

58 гишүүн дэмжиж, 71.6 хувиар санал дэмжигдлээ.

24.Улс төрийн намын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

59 гишүүн дэмжиж, 72.8 хувиар санал дэмжигдлээ.

25.Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

57 гишүүн дэмжиж, 70.4 хувиар санал дэмжигдлээ.

26.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

57 гишүүн дэмжиж, 70.4 хувиар санал дэмжигдлээ.

27.Үндэсний төлбөрийн системийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

56 гишүүн дэмжиж, 69.1 хувиар санал дэмжигдлээ.

28.Хадгаламж зээлийн хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

57 гишүүн дэмжиж, 70.4 хувиар санал дэмжигдлээ.

29.Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

56 гишүүн дэмжиж, 69.1 хувиар санал дэмжигдлээ.

30.Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

53 гишүүн дэмжиж, 65.4 хувиар санал дэмжигдлээ.

31.Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

56 гишүүн дэмжиж, 69.1 хувиар санал дэмжигдлээ.

32.Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

58 гишүүн дэмжиж, 71.6 хувиар санал дэмжигдлээ.

33.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

57 гишүүн дэмжиж, 70.4 хувиар санал дэмжигдлээ.

34.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

57 гишүүн дэмжиж, 70.4 хувиар санал дэмжигдлээ.

35.Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

55 гишүүн дэмжиж, 67.9 хувиар санал дэмжигдлээ.

36.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

55 гишүүн дэмжиж, 67.9 хувиар санал дэмжигдлээ.

37.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

57 гишүүн дэмжиж, 70.4 хувиар санал дэмжигдлээ.

38.Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

56 гишүүн дэмжиж, 69.1 хувиар санал дэмжигдлээ.

39.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

54 гишүүн дэмжиж, 65.9 хувиар санал дэмжигдлээ.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

58 гишүүн дэмжиж, 70.7 хувиар санал дэмжигдлээ.

41.Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

56 гишүүн дэмжиж, 68.3 хувиар санал дэмжигдлээ.

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

Хянан шалгах түр хорооны тайлан, санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжилнэ/

Дараагийн асуудалд оръё.

Н.Учрал: Хянан шалгах Түр хорооны сонсголын тайлан, санал дүгнэлт Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Улсын Их Хурлын гишүүд Хянан шалгах Түр хорооны тайлан санал дүгнэлт болон Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асууж, хариулт авч үг хэлж дууссан. Одоо Хянан шалгах Түр хорооны саналаар санал хураалт явуулна. АН-ын бүлгийн гишүүдийг урья.

ОТ-н Хянан шалгах түр хорооны тогтоол хэлэлцье. Энэ бол 64 байх албатай биш шүү дээ. Тийм биз дээ. Одоо Хянан шалгах Түр хорооны тайлан, санал дүгнэлт болон Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах асуудлаар санал хураалтыг явуулна аа. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалтыг явуулна.

ОТ бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд хийсэн тусгай шалгалт, нээлттэй сонсголын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг

баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулах гэж байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

69 гишүүн дэмжиж 81.2 хувиар Оюу Толгойн бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд хийсэн тусгай шалгалт, нээлттэй сонсголын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталлаа.

Улсын Их Хурлын гишүүд Түр хорооны хянан шалгагч, шинжээчид, ажлын хэсэгт төрийн албан хаагч нарт талархал илэрхийлье. Мөн Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны дарга Батнайрамдал, Түр хорооны гишүүдэд талархал дэвшүүлье ээ. Баярлалаа.

Монгол. Улсын Их Хурлын тухай хуулийн 28.10-д Хянан шалгах түр хороо хяналт шалгалтаар цуглуулсан нотлох баримтад үндэслэж гаргасан тайлан санал дүгнэлтээ Улсын Их Хуралд танилцуулах ба тайлангаа танилцуулснаар уг хороог татан буугдсанд тооцно гэж заасны дагуу ОТ бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий Хянан шалгах Түр хороог татан буугдсанд тооцлоо.

11.05 цаг

***Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк
хоорондын Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл
/Засгийн газар 2025.12.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах,
үргэлжилнэ/***

Одоо 2 санал хураалт явуулна аа. Зүрх судасны өвчлөлийг бууруулах чиглэлээр хийгдэх олон ажлуудыг дэмжих зорилготой Монгол Улс болон ЕСБХБ хоорондын зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хэлэлцээрийг эцэслэн батална.

Монгол Улс болон ЕСБХБ хоорондын зээлийн хэлэлцээрийг соёрхон баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулах тул гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт явуулна. Монгол Улс болон ЕСБХБ хоорондын зээлийн хэлэлцээрийг соёрхон баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

71 гишүүн дэмжиж 83.5 хувиар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн тул Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийг эцэслэн баталсанд тооцлоо.

Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт талархал илэрхийлье ээ.

Дараагийн асуудлаар санал хураана.

Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.12.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, үргэлжилнэ/

Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр соёрхон батлах тухай хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан. Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг соёрхон баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

Улсын Их Хурлын гишүүдийн 68 гишүүн дэмжиж, 80 хувиар санал дэмжигдлээ.

Сургууль, цэцэрлэг барьж байгуулах, онцгой байдлын тоног төхөөрөмж дэд бүтцийг сайжруулахад чиглэсэн энэхүү төсөл амжилттай батлагдлаа.

Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн тул Батнайрамдал гишүүнийг дэмжсэнээр протоколд үлдээе.

Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн тул Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр Соёрхон батлах тухай хуулийг эцэслэн баталсанд тооцлоо.

Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт талархал илэрхийлье ээ.

Үргэлжлүүлээд Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ. Хуулийн төслийг би өөрөө санаачилсан тул Бат-Эрдэнэ даргаар хурлаа удирдуулъя аа.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал нарын 3 гишүүн 2025.12.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийн асуудалдаа оръё.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцүүлгийг явуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дарга Ням-Осорын Учрал танилцуулна. Учрал даргыг индэрт урьж байна.

Н.Учрал: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Ард түмний элч төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн та бид иргэнээ төрийн хүнд суртал, хуулиас давсан дүрэм журмыг.

Ж.Бат-Эрдэнэ: Микрофон жоохон чангалах уу?

Н.Учрал: Гох дэгээнээс чөлөөлж, чөдөр тайлах хууль шийдлүүд хэлэлцэж эхлээд байна. Улсын Их Хурлын даргын хувьд хүнд суртлын дарамтаас хүнээ иргэдээ чөлөөлөх, эдийн засаг, улс төр, иргэний эрх, эрх чөлөөг нь дархлахын төлөөх чөлөөлье санаачилга дэвшүүлж ажиллаж байна. Чөлөөллийн санаачилгыг төрийн бодлого хөтөлбөр болгох эхний дорвитой алхам нь Улсын Их Хурлын гишүүдийн хамт өргөн барьсан Хүнд суртлын ачаа, дарамт, авлигын сүлжээнээс чөлөөлөх зөвшөөрөл мэдэгдлийн тухай хууль, дагалдах 90 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл юмаа.

Шууд хэлэхэд төрийн хууль тогтоох дээд байгууллага иргэнээ төрийн анхан, дунд шатан дахь хүнд суртал, хээл хахуулийн сүлжээнээс чөлөөлөх тэмцэл эхэлж байгаа юм аа. Хүнд сурталтнууд хөндлөн шугамтай үнэмлэх өвөртөлсөн байцаагч түшмэдийн дарамтаас хөдөлмөрлөө, бүтээе гэсэн эгэл жирийн иргэнээ чөлөөлөх нь энэ үзэл санааны үндсэн зорилго үнэ цэн юмаа. Талхныхаа мөнгийг олъё, ашиг орлогоо нэмье, амьдрал ахуйгаа өөд татъя гэсэн иргэнээ элдэв шалтаг тоочиж ийш тийш ахин дахин гүйлгэдэг, эрээн алаг цаас нэхдэг, зовоож чирэгдүүлдэг, хааж боодог, загнаж зандардаг, машин тэргээр нь зөөлгөдөг, дайлуулж цайлуулдаг, авлига хахууль нэхдэг нь үнэн.

Хүний хүслийг хяссан хүнд суртлын хана хэрэм босгож, авлига хахууль нэхэж, дээрэмддэг нь бодит үнэн болжээ. Зөвшөөрөл мэдэгдлийн хуулийг Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэж дэмжсэний дараа 8 нэрийн дэлгүүр нээх гээд 4 сар хөөцөлдөөд бүтэхгүй эцэст нь 3 саяын хахууль өгөөд ч зөвшөөрлөө гар дээрээ авч чадаагүй байгаа гэдгээ хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хэлсэн бүсгүйг үнэн үгийнх нь төлөө өнөөдөр дарамталсан байна.

Улсын Их Хурлын даргын хувьд хууль зүйн бодлогын зөвлөхөө илгээж, тэр иргэнтэй уулзуулсан. Дарамт шахалтад орсон эмэгтэй ярилцлагыг минь устгаад өгөөч гэж гуйж байна аа. Малын ахмад эмч D-парламент болон Засгийн газрын 11 11 төвд хандахдаа 100 гаруй төрлийн бичиг цаас шаарддаг. Тусгай зөвшөөрлөө 5 жил бүр сунгуулах болгонд заавар зөвлөгөө өгөх бус заавал өө хайж торгодог. Ийм байхад хөдөө орон нутагт малын эмч олдохгүй шүү дээ гэж ярьж байна. 6 нэрийн дэлгүүрээ 8 нэрийн дэлгүүр болгоход галын аюулгүй байдал, ажлын байрны дүгнэлт гэх мэт алга дарам цаас бүр үнэ ханштай. Кадастрын зураг мэдэхгүй газрын албаны мэргэжилтэнд тайлбарлаж ойлгуулахад хүрдэг гэж бас нэгэн иргэн баталж хэлээд хавтаст дүүрэн цаас боть ном шиг зузаан бичиг баримт үзүүлж байна аа.

Хуулиар 22 хоногт багтаан олгох ёстой зөвшөөрөл эрээд олддоггүй эрдэнэ болсон нь авлигын сүлжээ хориглолтын системийн хор уршиг юмаа. Зөв биш буруу болсон зөвшөөрлийн биш буруутгалын болсон тогтолцооны хохирогч нь эдлэх ёстой эрхээ эдэлж чадахгүй байгаа иргэн юмаа.

Улсын Их Хурал Зөвшөөрлийн тухай хуулийг 2022 онд батлахдаа мянга гаруй төрлийн зөвшөөрлийг 381 болгож цөөлсөн. Гэтэл үүнээс хойш дүгнэлт, гэрчилгээ, тохирол, лавлагаа, сертификат, магадлалын итгэмжлэл, бүртгэл гэх мэтээр нэр зүсийг нь өөрчилж хувиргаад ахиад мянгыг нэмж зохион үйлдвэрлэж, иргэний эрхийг чөдөрлөж, хүний хүслийг хяссан байна аа. Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаас хойш 20 зөвшөөрөл хуулиар шинээр нэмэгдсэн. Зөвшөөрөл гэдэг нэргүй боловч бүртгэл 264, дүгнэлт 232, гэрчилгээ 132, магадлан итгэмжлэл 30, сертификат 9 болж нэмж хуулиар зохиогдсон.

Зөвшөөрөл гэдэг нэргүй 667 зөвшөөрөл зохиож, 667 чөдөр тушаа зангидсан байна. Иймээс салбарын хуулиудад зөвшөөрөл нэртэй хориглолт босгосоор байгаа тул Зөвшөөрөл мэдэгдлийн хуулийг дагалдах 90 гаруй хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийг санаачлан боловсрууллаа.

Хүнд суртлын системийн хохирогч нь зөвхөн ажилсаг хөдөлмөрч ард иргэд биш ээ, улсаараа, эдийн засгаараа бүгдээрээ хохирогч болж байна. Эдийн засгийн хүндрэл нүүрсний үнэ 2 дахин бууснаас гадна талхныхаа мөнгийг олъё, амьдрал ахуйгаа аваад явъя гэсэн иргэндээ зай биш лай болсон иргэндээ итгэх бус элдвээр зовоодог хүнд суртал, авлигын сүлжээний үр дагавар мөн. Төр гайхамшиг бүтээхгүй нь үнэн. Төр гамшиг болох ёсгүй ээ. Зөвшөөрөл мэдэгдлийн тухай болон түүнийг дагалдуулан танилцуулж байгаа 90 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар эрсдэл багатай ахуйн болон нэг удаагийн шинжтэй үйл ажиллагааг зөвшөөрлөөр биш зөвхөн мэдэгдлээр эрхэлж эхэлнэ ээ.

Дугуй засвар, үсчин, гутал засвар, оёдлын цех гэх мэт хэзээ, хаана юу нээснээ гар утаснаасаа ганц мэдэгдээд шууд эхэлнэ ээ. Иргэн танд аймаг, дүүрэг, нийслэл 30 хоногт хариу хэрвээ өгөөгүй бол шууд зөвшөөрсөнд тооцно. Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны жагсаалтыг маш тодорхой болгож хуульчилна аа.

Зөвшөөрлийн тухай хуультай зөрчилдсөн салбарын хуулиуд дахь зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох эрхүүдийг бүрэн цуцална аа. Төрөөс мэргэжлийн холбоодод 100 гаруй зөвшөөрлүүдийг олгох, сунгах зэрэг ажлыг бүрэн шилжүүлнэ ээ. Явцын хяналтаар үйл ажиллагаа нь доголдолгүй тохиолдолд шууд аль нэг даргын гарын үсгээр биш автоматаар сунгагддаг болно оо.

Зөвшөөрөл гэдэг нэргүй зүсээ хувиргасан зөвшөөрлүүдийг нэг мөр эмхлэн цэгцэлж эрс багасгана Улсын Их Хурлын даргын хувиар чөлөөлье санаачилга төрийн бодлого болгон хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, зөрчсөн хууль журмын чөдөр тушааг тайлах болно оо. Эдлэх ёстой эрхийнхээ төлөө тэмцэж хүнд суртлын сүлжээний үнэнийг дэлгэж байгаа иргэн сэтгүүлч хэн бүхнийг Улсын Их Хурлын даргын санаачилсан чөлөөлье төрийн бодлогоор өмгөөлөн хамгаална гэдгийг хууль тогтоох дээд байгууллагын даргын хувьд зарлаж байна аа.

Эрх чөлөөт иргэн өөрийн сонгож байгуулсан төрийн өмнө эрхээ эдлэх гэж гуйж гудайх ёсгүй ээ. Эрх чөлөө бол хэн нэгний өгдөг баярын бэлэг биш. Эрх чөлөө бол эрх мэдэлтний өгдөг эд зүйл биш ээ. Эрх чөлөө бол иргэн бүрийн хайрлан хамгаалж, хамтдаа тэмцэж олдог эрхэм нандин үнэт зүйл юмаа. Хүн чанаргүй хүнд суртлаас хүнээ чөлөөлөхийн төлөө хамтдаа ажиллацгаая аа. Иргэнээ хүнд суртал, дүрэм журмын түгжээнээс чөлөөлье.

Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Зөвшөөрөл мэдэгдлийн хуулийн хэлэлцэх эсэхийг дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Төслүүдийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Очирбат танилцуулна.

Г.Очирбат: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Х.Ганхуяг, Б.Заяабал нараас 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хууль, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч нь олон улсад хэрэглэгдэж байгаа мэдэгдэл мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны талаарх зохицуулалтыг бий болгох, зарим төрлийн тусгай болон энгийн зөвшөөрлийг мэдэгдэл хүргүүлсний үндсэн дээр эрхлэх, тусгай зөвшөөрлийн төрөл, ангиллыг дахин тодорхойлох, нэр томъёог жигдлэн хуульчлах, тодорхой төрлийн зөвшөөрөл олгох процессын журмыг салбарын хуулиудад тусгах, зөвшөөрөл эзэмшигчдэд тавигдах явцын хяналт цахимжилтыг сайжруулах замаар Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн захиргааны хэм хэмжээний акт, журмын зөвшөөрлийн харилцааг зохицуулан зөвшөөрөл олголтын процессыг хүндрүүлж байгаа нөхцөлийг арилгаж, хүнд суртал, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хуульд заасан хугацаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага түргэн шуурхай хүндрэл чирэгдэлгүй зөвшөөрөл авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад нэмэлт өөрчлөлтийг оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулжээ.

Хуулийн төслийг D-Parliament.mn цахим сайтад байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байна аа.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Зөвшөөрлийн тухай хуулийг дагалдуулан үндэслэлгүйгээр дүрэм журмыг баталж, хүнд суртал, ашиг сонирхлын зөрчил үүсгэдэг байдлыг энэ хуулийн нэмэлт өөрчлөлтөөр хэрхэн хязгаарлах. Мөн тухайн салбартаа монопол байдалтай ААН-үүдийн тусгай зөвшөөрлийг тэдгээрт давуу байдал олгохгүй байхаар хэрхэн зохицуулах, шударга өрсөлдөөн хэрхэн бий болгох талаар.

Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат Зөвшөөрлийн хууль болон түүнийг дагасан олон тооны дүрэм журам, хэм хэмжээний актууд болон одоо мөрдөгдөж байгаа стандартууд нь нийгмийн харилцааг бүрэн зохицуулж чадаж байгаа эсэх талаар.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа төрийн захиргааны төв байгууллагууд зөвшөөрөл олгоод өөрөө гүйцэтгэлд нь хяналт тавьдаг байдал зохистой эсэх талаар. Мөн нэг үйл ажиллагаа эрхлэхийн тулд хэд хэдэн байгууллагаас тусгай зөвшөөрөл авч олон шат дамжлага дамжин хугацаа алддаг байдлыг хэрхэн сайжруулах талаар.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан тусгай зөвшөөрөл олгодог боловч гүйцэтгэлд нь хяналт тавьдаггүй, үүрэг, хариуцлага хүлээдэггүй байгууллагуудын уялдааг хэрхэн хангаж байгаа талаар тус тус асуулт авч хариулт авсан болно оо.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат тусгай зөвшөөрөл олгогч байгууллагууд ААН-үүд бизнес эрхлэгчдээ дэмжиж, хуулийг хэрэгжүүлэхдээ хүнд суртал, ашиг сонирхлоос ангид байх талаар.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар хяналт ил тод байдлыг сайжруулах чиглэлээр мэргэжлийн холбоодод тусгай зөвшөөрөл олгох эрхийг шат дараалалтайгаар шилжүүлж байгаа боловч хамаарал бүхий ААН-үүд өөрсдөө мэргэжлийн холбоо байгуулаад түүгээрээ дамжуулан давуу байдал бий болгох, шударга өрсөлдөөнийг хааж, хүнд суртал, ашиг сонирхлын зөрчил үүсгэж байгааг анхаарах ийм сөрөг үзэгдлийг таслан зогсоох талаар.

Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж энэ хуулийн төслүүд батлагдахдаа иргэд бичил жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн эрх ашигт нэн түрүүнд нийцсэн байх, тэдэнд хүндрэл дарамт учруулахгүй байхаар зохицуулалттай байх тус тус санал хэлсэн болно оо.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11-д заасны дагуу зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахад Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 70.06 хувь нь дэмжсэн бөгөөд хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг мөн дэмжсэн болно оо.

Байнгын хорооны санал хураалтын явцад хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Виртуал хөрөнгийн үйлчилгээний үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно оо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооны санал дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оролцох ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя. Ням-Осорын Учрал Монгол Улсын Их Хурлын дарга хууль санаачлагч, Хассуурийн Ганхуяг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайд, Батжаргалын Заяабал Монгол Улсын Их Хурлын гишүүн, Бавуужавын Мягмарнаран Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Сүхээгийн Тэнгис Улсын Их Хурлын даргын засаглал хариуцсан зөвлөх, Баатарчулууны Золбоо Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ мониторингийн газрын дарга, Д.Аюуш Монгол банкны Хууль эрх зүйн газрын захирал, Шагдаржавын Хандсүрэн Монгол банкны зөвшөөрлийн албаны дарга, Намжидын Хүдэрчулуун Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн, Жаргалсайханы Мөнх-Оргил Санхүүгийн зохицуулах хорооны Хууль эрх

зүйн хэлтсийн дарга, Дамдинпүрэвийн Батзориг Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Хуягийн Номинбилэг Эрчим хүчний зохицуулах хорооны тусгай зөвшөөрлийн газрын дарга, Маамбын Үнэнбат Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ эрх зүйн газрын дарга, Аюурзанын Энх-Эрдэнэ Хууль зүй, дотоод хэргийн яамны Зөвшөөрөл бүртгэлийн хэлтсийн дарга, Баяртогтохын Нямсүрэн Эрчим хүчний яамны Гэрээ эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн, Түвдэндоржийн Балжинням Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны байгалийн нөөцийн бодлого зохистой бодлого зохистой ашиглалтын газрын дарга, Лхагвасүрэнгийн Батзориг Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны химийн бодисын нөлөөллийн бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн. Оюуны Одбаяр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга, Дамдинсүрэнгийн Батзориг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газрын Материал үйлдвэрлэлийн хэлтсийн дарга, Бавуудоржийн Алтансүх Боловсролын яамны Төрийн захиргаа удирдлагын газрын дарга, Хүрэлбаатарын Санчигдорж Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Геологийн бодлогын газрын дарга, Туулхангайн Ганбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Гэрээ эрх зүй, гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Энхтайваны Мөнхнасан Зам тээврийн яамны авто тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга, Сүхээгийн Мяндасмаа Зам тээврийн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын хэлтсийн Хуулийн хэлтсийн дарга, Юрагийн Отгонбилэг Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга, Хөхөөгийн Тамир Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга, Алтайн Лувсан-Очир Харилцаа, холбооны зохицуулах хорооны ажлын албаны дарга, Кагватын Гулжан Сангийн яамны Хууль эрх зүйн газрын ахлах шинжээч, Мөнхбаатарын Мөнхнаран Харилцаа, холбооны зохицуулах хорооны Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Бямбасүрэнгийн Туяа Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Пүрэвээгийн Алтанцэцэг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын захирал, Маамхүүгийн Оюунчимэг Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын ахлах шинжээч, Баатарсүрэнгийн Батзориг Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, Нямсамбуугийн Нарангэрэл Дээд мэргэжлийн боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга, Чимэдрэгзэнгийн Баярмаа Боловсролын яамны тусгай зөвшөөрлийн газрын Хуулийн хэлтсийн ахлах шинжээч, Түмэндэмбэрэлийн Золзаяа Эдийн засаг, хөгжлийн яамны Бизнес, орчны бодлогын газрын зөвшөөрлийн нэгдсэн сангийн хөгжүүлэлт хариуцсан ахлах мэргэжилтэн.

Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны санал дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна аа. Нэрс гарч ирлээ. Хэн юм бэ? Пүрэвдорж алга байна, Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Тэгээд Зөвшөөрлийн тухай хууль нэлээн хялбаршуулсан аятайхан юмнууд орж ирж байгаад баяртай байгаа. Хэд хэдэн асуулт байна. Мэргэжлийн холбоодод тодорхой хэмжээний зөвшөөрлүүдийг олгож эхэлсэн. Мэргэжлийн холбоодод дээр олгож байгаа зөвшөөрлийг хэрхэн хялбаршуулж байгаа вэ? Энд ямар нэг хүндрэл нөхцөлтэй байдал байгаа юу? Судалгаа шинжилгээ хийсэн үү? гэдгийг 1 дүгээрт асуумаар байна.

2 дугаарт, Зөвшөөрөл олгох хугацаатай холбоотой асуудлууд байгаа. Зөвшөөрөл олгохдоо тодорхой хугацааг заавал зааж өгдөг. Тэд хоног хүртэл гэж. Төрийн байгууллагууд дийлэнхдээ тухайн хоногийн эцсийн хугацаа хүртэл хүлээлгэж байгаад нягтлах нэрийн доор бараг эцэст нь тулгаж байж зөвшөөрлийг олгож байгаа. Энэ бол нэг талдаа зөвшөөрлийг хялбарчилж байгаа мэт болгож цахимжуулж байгаа хэлбэр явж байгаа боловч нөгөө талдаа хугацаагаар хясан боогдуулах өрсөлдөөнд шударга бусаар нөлөөлөх ийм нөхцөл байдал бол байдаг аа. Энэ бол төрийн байгууллагууд дээр байдаг зүйл. Энийг хэрхэн шийдвэрлэх боломжууд байгаа вэ гэдгийг асуух гэсэн юм.

3 дугаарт, иргэдийг төөрөгдүүлж байгаа асуудлууд байна. Ялангуяа бизнес эрхлэгчдийг. Би одоо Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаар ажиллаж байхад манай Учрал Их Хурлын дарга маань Цахим хөгжлийн сайдаар ажиллаж байсан. Тэр үед бол бүх мэдээллийг цахимжуулах хэлбэрийн хүрээнд зөвшөөрлийг бүгдийг нь цахим хэлбэрт шилжүүлж байсан. Сая Батбаатар сайд очоод дөнгөж сая цахимжуулж байгаа юм шиг мэдээллүүд дахиад тавиад эхэлчихлээ. Тэгээд энэ одоо аль 2023 онд 2022 онд цахимжчихсан байсан зүйлсүүдийг ингээд сайд нар дураараа очоод дахин цахимжуулж байгаа хэлбэрээр төөрөгдлүүд үүсгээд байж болдог юм уу? Энийг ер нь энэ төрийн захиргаан дээр ажиллаж байгаа төрийн өндөр дээд албан тушаалтнуудтай холбоотой асуудал дээр ер нь яаж шийдвэрлэх ёстой юм бэ?

Дараагийн асуулт Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай дагалдаж орж ирж байна. Тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх бодлого зохицуулалт, менежментийг сайжруулах, Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах зөвшөөрөлтэй холбоотой мэргэжлийн санал зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн дүрмийг батлах гэдэг ийм заалт байна. Энэ ямар утга учиртай заалт вэ гэдгийг асуух гэсэн юм.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар ч тэр, төрийн захиргааны төв байгууллага нь өөрөө ажиллаж байгаа, дээрээс нь тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа ажиллаж байгаа. Тухайн захиргаанаас бол тодорхой хэмжээний мэргэжлийн дагуу арга хэмжээг аваад явдаг. Гэтэл дахиад төрийн захиргааны байгууллагын дэргэдэх орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн дүрмийг батлах гэж оруулж ирж байгаа нь яг ямар учир зүйгээр оруулж ирж байгаа заалт вэ гэдгийг асуух гэсэн юм. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Хууль санаачлагч Ням-Осорын Учрал дарга.

Н.Учрал: Энэ тухайн үед Засгийн газраас Зөвшөөрлийн хуулийг өргөн мэдүүлээд тэгээд манай Хассуурийн Ганхуяг гишүүн ажлын хэсгийг нь ахлаад тэгээд Их Хурлаар батлуулсан юм байна лээ. Тэгээд нийтдээ тухайн үед нөгөө Бямбацогт сайд бас батлуулсан юм байна. Ажлын хэсэгт ажилласан. Ингээд 360 болсон юм байна лээ. Сайнзориг бас байдаг юм. За яах вэ тэгээд Монгол төрийн төлөө тэгээд хэн ажиллах нь яах вэ дээ тийм биз дээ. Тэгээд 360 болсон зөвшөөрөл чинь түүнээс хойш дахиад 20-иор нэмэгдчихлээ. Тэгээд түрүүн хэлснээр нөгөө гэрчилгээ магадлан итгэмжлэл гээд янз бүрийн нэрээр зүсээ хувиргаад нэмэгдээд ороод ирлээ. Тэгээд бид нарт нэг ийм арга зам ингээд илэрхийлдэг нэг ийм бүртгэл гэж нэрлэххээд л зөвшөөрөл шиг бүртгэлтэй нэг ийм олон хэлбэрээр ингээд яваад

байхаар бүртгэл, магадлан эзэмшил, сертификат, гэрчилгээний чинь тоо мянга гарчихаар зөвшөөрөл буурсны ач холбогдол гарахгүй байгаа юм л даа.

Тэгээд энэ удаа бол мэдэгдэл гэж юу юм бэ гэдгийг нь тухайлан хуульчилж байгаа юм. Шууд тэр худалдаа үйлчилгээний чиглэлийн үйл ажиллагаануудыг хаана ямар газар, ямар байршилтай, ямар үйл ажиллагаа явуулахаа мэдэгдэж байна. Мэдэгдэж байгаагийн шаардлага бол дараа нь нөгөө хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуй гээд зүйлүүд дээр төр хяналтаа тавиад, иргэдийнхээ ахуй байдал дээр хяналтаа тавиад явах шаардлагатай. Зүгээр энгийн зөвшөөрөл гэж байдаг, энгийн зөвшөөрөл рүү бол тусгай зөвшөөрлөөс олон энгийн зөвшөөрөл шилжүүлж байна. Яагаад энгийн зөвшөөрөл рүү шилжүүлж байна гэхээр энгийн зөвшөөрөл 22 хоног дотор төрийн байгууллага тэр зөвшөөрлийг олгосноо эргэж хариу мэдэгдээгүй бол шууд эхэлнэ гэдэг ийм зөвшөөрлийн хуулийн зарчим байгаа юм. Хариу өгөхгүй бол шууд ажлаа эхэл гэж.

Тэгэхээр энэ хуулиар бид нар энгийн зөвшөөрлийн тоог нэмэгдүүлж байна. Дээрээс нь нийт 120 энгийн зөвшөөрөл, 30 мэдэгдлийг хуульчлаад энийг мэргэжлийн холбоодод руу шилжүүлэх эрх зүйн орчныг нээж байна. Ингээд ер нь зах зээл дэх төрийн оролцоог бууруулах л зорилготой ийм хууль болж байгаа юм. Төсвийн хүрээ ч тэгж батлагдсан шүү дээ. Тэгэхээр энэ зөвшөөрлийн хууль гарснаараа бол нөгөө хөдөлбө, ажиллая, хөдөлмөр эрхэлбө, амьдралаа авч явъя гэсэн хэн болгон чөлөөтэй амьдрах боломжийг нь л чөлөөлж өгч байгаа юм. Жишээ нь өчигдөр өнөөдөр бид нар энэ сэргээгдэх эрчим хүчний тогтоол баталлаа шүү дээ. Тэгэхээр нарны панел тавиад төвийн дулаанд өгье өө гээд тэндээсээ орлого олъя гэхээр дахиад л зөвшөөрөл нэхнэ. Тэр 10 гаруй бичиг баримтыг чинь хэн бүрдүүлээд явах юм бэ.

Дээрээс нь өнгөрсөн хугацаанд сая Бат-Эрдэнэ сайд хэлсэн тэр цахимын сайд байх үеэс авхуулаад бид нар цахимжуулах ажлыг хийсэн. Одоо нийт 122 зөвшөөрлийг бүрэн цахимжуулж дууссан. Энийг яамдууд хэрэглэх л ёстой ингэвэл хүн оролцохгүй байхгүй юу. Тухайн үед ингээд дуусчихсан хэрэглэх л хэрэгтэй.

Ж.Бат-Эрдэнэ: За болсон уу, тодруулах юм уу. За Ганхуяг сайд.

Х.Ганхуяг: Ер нь мэргэжлийн холбоотой асуулт асуулаа. Тэгээд энэ бол 2022 онд эрхийг нь нээж өгсөн. Яах вэ жагсаалт дээр ер нь тусгай зөвшөөрлийн нэр, хэн олгох вэ гэдэг нь л орчихсон байгаа. Эрх бүхий байгууллагууд нь л орчихсон байгаа. Гэхдээ эрх бүхий байгууллага нь гэрээгээр аль нэг мэргэжлийн холбоодод шилжүүлж өгөх асуудал нь нээлттэй болсон байгаа. Одоо барилгын ассоциаци бол барилгын холбоотой зөвшөөрлүүд өгдөг. Гэхдээ яагаад шууд тэр ассоциацид нь өгдөггүй шалтгаан нь юу вэ гэхээр бас тодорхой хэмжээнд энэ чинь циклээрээ солигддог явагддаг байх ёстой юм. Тэгэхгүй зарим манай мэргэжлийн холбоодод бол бас хүнд суртал гаргах асуудлууд гарсан. Яг одоо ингээд хяналт шалгалт хийгээд явж байхад.

Тийм учраас яг тэр салбарын яаман дээр нь зөвшөөрлийг нь олгох эрхийг нь өгөөд тэгээд яам нь мэргэжлийн холбоогоор хийлгэх үү, аль мэргэжлийн холбоогоор хийх вэ гэдэг нь эрхийг нь нээгээд өгчихсөн байгаа гэсэн үг.

Ж.Бат-Эрдэнэ: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Тэгэхээр нөгөө ААН-үүдийнхээ үйл ажиллагаа, иргэдийнхээ бизнес эрхлэх боломж сайжруулж өгснөөр эдийн засгийн эргэлт сайжирна л даа. Мэргэжлийн холбоодод төрөөс илүү хялбар, хөнгөн, хүнд сурталгүй байна гэж бодоод тодорхой зөвшөөрлүүдийг мэргэжлийн холбоодоор дамжуулуулж олгодог ийм тогтолцоо руу шилжсэн нь зөв гэж бодож байгаа. Гэхдээ эргээд харахаар зарим тохиолдолд зарим мэргэжлийн холбоодод маань өөрсдөө төрөөс илүү хүнд сурталтай болсон байна. Энийг бизнес эрхлэгчид ААН-үүд ч бас дурдаж байгаа. Тийм учраас цааш цаашдаа олгож байгаа энэ зөвшөөрлүүд маань илүү хялбарших ёстой гэдэг дээр санал нийлнэ. Мэдээж стандартаа барих ёстой. Хувийн хэвшил рүү аль болох эрхийг шилжүүлэх ёстой. Гэхдээ хариуцлагагүй хандаж байгаа мэргэжлийн холбоодод дээрээ тодорхой хэмжээний хариуцлагын арга хэмжээг авч явах нь зүйтэй болов уу гэж бодож байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн алга байна. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Өдрийн мэнд хүргэе ээ. Ер нь төрийн хүнд суртал багасгах түүнээс үүдэлтэйгээр авлига, давуу байдал бий болгох гэдэг асуудлыг багасгах ёстой, цэгцлэх, ёстой гэдэг энэ үзэл санааны хүрээнд дэмжиж байгаа. Гэхдээ энэ маш олон хууль маш олон нарийн зохицуулалтыг тусгасан хууль учраас нэлээн няхуур харах ёстой байна гэдгийг бас цохон тэмдэглэе 3 асуулт байна аа.

1 дүгээрт энэ зөвшөөрлийн тухай хуулийг 2022 онд батлаад 2023 оны 1 сарын 1-ээс хэрэгжсэн. Тухайн үед энэ хуулийг гаргахдаа бас л хуулиас гадуур зөвшөөрөл үүсгэхгүй энэ хүнд суртлыг багасгана л гэдэг үзэл баримтлалын доор нэлээн том ийм хуулийг баталсан байгаа юм. Тэгээд энэ хууль чинь хэрэгжээд 3 жил болсон байна. Тэгээд сая танилцуулгад дурдагдсанаар тэр хууль гарснаар нөхцөл байдал дээрдээгүй ч юм шиг, зөвшөөрөл гэдэг нэрийн доор дахиад юм үүсгэчихсэн ч юм шиг иймэрхүү мэдээлэл сонсогдоод байна л даа.

Тэгэхээр үнэхээр энэ Зөвшөөрлийн тухай хууль 2022 онд баталж гараад 3 жил хэрэгжихэд хууль нь муудаа одоо ийм нөхцөл байдал нь сайжраагүй байгаад байгаа юм уу, эсвэл хууль байгаа ч гэсэн хэрэгжилт дээрээ алдаад, хэрэгжилтийн механизм нь сул байгаад байгаа болохоор ахиц дэвшил байхгүй байгаад байгаа юм уу. Тэгэхээр энэ хууль дээр та бүхэн мэдээж хэрэгжилтийн дүн шинжилгээ, үр нөлөө эд нар гээд хийсэн байх. Яг юундаа байгаад 3 жилийн өмнө баталсан энэ хууль чинь болохгүй одоогийн нөхцөл байдал чинь ингээд өмнөхөөсөө ч гэсэн сайн дээрдээгүй байна гэдэг дүгнэлт гараад байгаа юм бэ гэдэг дээр 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт ингээд чөлөөлье зөвшөөрлөө больё оо гээд бас илүү ингээд эрх чөлөөг энэ иргэддээ, ААН-үүддээ олгоё оо гээд тэгж байна. Тэгтэл Засгийн газраас чинь Эдийн засаг хөгжлийн сайд нь МХЕГ-ыг буцаагаад байгуулна гэдэг юмыг зарлаад явж байна. Тэгээд энэ чинь бид нар яаж уялдах юм бэ гэдгийг хармаар байна. Ер нь яах вэ МХЕГ энэ авлига хүнд суртлыг үүсгэдэг гэдгээрээ маш том механизм байсан. Тэрийгээ буулгасан. Гэхдээ би яах вэ хувь хүний хувьд энэ дээр бүгдийг нь буулгах биш яг энэ хүнсний асуудал, эмийн асуудал гээд хүний эрүүл мэндэд маш их нөлөөтэй энэ асуудал дээр босоо удирдлагатай нэгдсэн хяналтыг хийдэг энэ механизм нь бол байх ёстой гэж үздэг юм. АНУ-ын FDA ч гэдэг юм уу, Солонгос ч гэдэг юм уу яг хэдхэн энэ хүний эрүүл мэндэд холбоотой асуудлууд дээр мэргэжлийн хяналт нь байх ёстой. Тэр нь бол ийм цомхон асуудлаар бусад асуудал дээр салбарт байх ёсгүй гээд. Тэгтэл энд мэргэжлийн ерөнхий газрыг

нь дахиад байгуулна, хяналт шалгалтаа хийнэ л гээд хяналт шалгалт байхгүй болчихжээ л гээд. Тэгтэл энэ дээр нь болохоор зөвшөөрөл дээр хэрэггүй мэдэгдэлтэй байхад болно оо гэдэг юм байж байгаа. Энэ дээр ер нь яаж нэгдсэн бодлогоо харж байгаа вэ?

3 дугаарт ер нь нөгөө нуухыг нь авах гэж байгаад нүдийг нь сохолж болохгүй гэдэг юм энэ нарийн деталиуд дээр нэлээн харагдаж байна. Техникийн хувьд ч гэсэн мэдээж олон хүн ажилласан юм шиг байна. Тэгээд зүгээр нэг 2 жишээ л дурдахад жишээ нь би одоо нэг Тамхины хяналтын тухай хууль хүнд хэрэгтэй хууль хийчихье гээд оруулж байсан. Ингээд Тамхины хяналтын хууль дээр тэгтэл ингээд зөвшөөрөл мэдэгдэл болгоод мэдэгдэл ингээд ороод ирж байгаа юм. Мэдэгдлээр одоо хийх үйл ажиллагаанд чинь бол миний харж байгаагаар тамхитай холбоотой юм алга байна. Тэгэхээр тэр бол хуулийн нэмэлт, өөрчлөлт шаардлагагүй юм ороод ирчихсэн байна.

2 дугаарт Тамхины хяналтын тухай хуулийн 6.1-ийг хүчингүй болгож байгаа юм байна. 6.1 нь юу вэ гээд тэгэхээр энэ тамхи үйлдвэрлэх, импортлох, экспортлох, энэ худалдаалах орчин нөхцөл болон тамхин дахь хорт бодисын агууламжийн талаар эрүүл мэндийн дүгнэлтийг Эрүүл мэндийн яам гаргах ийм нөхцөл байгаа байхгүй юу. Тэгээд бид нар чинь стандарттай энэ тамхинд чинь ямар ямар хорт бодис байгаад байгаа юм, зөвшөөрөгдөхгүй юмнууд байгаад байгаа юм уу гэдэг дүгнэлтийг мэргэжлийн байгууллага хийдэг юмыг нь байхгүй болгоно гэж байгаа юм. Тэгээд байхгүй болгочихоор ямар ч тийм дүгнэлт байхгүй ямар ч хорт бодистой хамаагүй ийм тамхи тамхин бүтээгдэхүүн орж ирэх нөхцөлийг бүрдүүлэх юм уу гээд гэх мэтчилэн ийм нарийн нарийн юм байна. Мэдэгдлийн үйл ажиллагаан дээр энэ хорт хий.

Ж.Бат-Эрдэнэ: Хууль санаачлагч Учрал гишүүн хариулъя.

Н.Учрал: Тэгээд Зөвшөөрлийн хууль бол маш сайн хууль. Маш их дэвшил авчирсан. Мянга гаруй зөвшөөрлийг 360 луу буулгасан. Гэтэл Зөвшөөрлийн хуулийг хэрэгжүүлэхдээ бид нар алдсан. Үүнийг өөр сиймхий ашиглаж, хуулийн цоорхой ашиглаж өөрөөр хэрэглэсэн. Нэг ёсондоо бол нөгөө бүртгэл гэрчилгээ, магадлан итгэмжлэл, сертификат гэдэг нэрээр бид зөвшөөрөл өгөөгүй зүгээр л бүртгэж байгаа юм гэж хэлдэг. Тэгсэн мөртөө бүртгэнэ гэдэг чинь юу вэ гэхээр бүртгэсэн бүртгээгүйгээ хариулахгүй болохоор зөвшөөрөлтэй л адилхан. Гэрчилгээ өгч байна эхэлнэ гэхээр яг л адилхан зөвшөөрөл нэрийг нь л өөрөөр өгчхөөд байгаа байхгүй юу. Нэг ёсондоо дэд захирал гэдэг нэрийг хяналтын менежер гэж нэрлэхээд байгаатай яг адилхан. Дэд захирал гэдэг нэрийг бүтээмжийн менежер гээд нэрлэхээд байна шүү дээ. Өөрөөр нэрлэхээд тэрнээс биш агуулга нь адилхан. Тэгээд бид нар юмыг ингээд нэг аргалаад сурчихсан юм байна лээ л дээ. Одоо тэгээд жишээ нь нийслэл дээр аймаг орон нутаг дээр бид нар нэг төр нэг иргэддээ иргэдээ сайн сайхан амьдруулж авч байгаа цалин орлого нь амьдралд ахуйд нь хүрэх тийм нөхцөлийг бүрдүүлж чадахгүй байж ядаж тэр нэг айл нэг өрх өөрөө орлогоо бүрдүүлээд, өөрөө нэг оёдлын цех байгуулаад, өөрөө нэг дугуй засвар ажиллуулаад амьдаръя гэхэд нь дахиад саад тотгор учруулаад байгаагаасаа болих л ёстой. Төр тус болдоггүй юмаа гэхэд зай гаргаж өгөх ёстой, боломж гаргаж өгөх ёстой. Тэгээд явцын хяналтыг сайжруулах нь бол дараагийн асуудал.

Дээрээс нь юунаас болж хүчинд хэрэгжээгүй вэ гэхээр Зөвшөөрлийн хууль гарсны дараа Зөвшөөрлийн хуулийн нэг концепт чинь хуульд заагаагүй л бол бусад

нь чөлөөтэй эрхэлж болно оо гэж байгаа юм. Тэр 360-д хамаараагүй л бол. Дээрээс нь янз бүрийн хуульд авсан журам гаргахыг хориглосон. Гэтэл зөвшөөрлийн шинж чанартай зөвшөөрлийн үйл ажиллагаа процессыг илүү хүндрүүлсэн 56 журам байсан шүү дээ. Намайг тухайн үед Хэрэг эрхлэхийн дарга байхад зөвшөөрлийн зөвлөлийг ахалж байсан би. Тэгэхэд 56 зөвшөөрлийг хуулийг давсан журмыг хүчингүй болгосон. Түүн шиг энэ хууль гарснаараа 100 гаруй журам дахин хүчингүй болно шүү. Тэгэхгүй бол хуульчилсны дараа энэ хугацаануудыг сунгадаг байхгүй юу. 22 өдрийн дотор энгийн зөвшөөрөл өгнө өө гээд байхад 7 хоног бичгийг авна, 7 хоног хариулна, 7 хоног ирнэ, очно гээд ингэсээр байгаад хэдэн сар, ялангуяа энэ орон нутгууд дээр.

2 дугаар асуудал мэргэжлийн хяналтын байгууллага бол явцын хяналт хийх ёстой. Эрсдэлийн үнэлгээнд суурилах ёстой. Одоо мэргэжлийн хяналт ч юу байх вэ тэр салбарт байгаа хяналтууд тэд нар эрсдэлийн үнэлгээнд суурилах ёстой. Эрсдэлийн үнэлгээнд суурилж чадвал зөвшөөрөл сунгах гэж авах гэж байгаатай адилхан хүнд суртал үүсгэхээ больё оо. Эрсдэлийн үнэлгээнд суурилаад болж байвал шууд автоматаар сунгагддаг ийм зарчим руу шилжихгүй бол нэг минут авчихъя.

Б.Бат-Эрдэнэ: Учрал гишүүн нэг минут.

Н.Учрал: Тэгэхээр энд мэргэжлийн хяналтыг сэргээж байгуулах гэхээсээ илүүтэйгээр Их Хурал тогтоол гаргасан. Тэр тогтоол дээр юу гэж байгаа вэ гэхээр салбарт байгаа хяналтуудын чиг үүргийг давхардлыг арилгаад нэгдсэн хяналт шалгалтын төлөвлөгөөтэй бол оо л гэж байгаа юм. Тэгэхгүй аймгаас ирнэ, дүүргээс ирнэ, сумаас ирнэ, агентлагаас ирнэ, яамнаас ирнэ. Энэ давхардал чинь бүр утгаа алдлаа шүү дээ. Тэгээд зөвшөөрөл авах гэж нэг юм болно, дараа нь тэр нэг шалгалтуудыг нь давах гэж нэг юм болно. Тэгэхээр энэ хуулиар бол илүү нөгөө хяналтын тогтолцоог нөгөө эрсдэлийн үнэлгээнд суурилах чиглэл рүү нь явуулсан.

Дээрээс нь хууль хэрэгжихгүй байгаа дээр дахиад нэг зүйл хийхэд 122 зөвшөөрлийг цахимжуулчихаад байхад системд нэвтэрчихсэн мөртөө системийнх нь тусламжтайгаар зөвшөөрөл авах процессоо бид нар дэмжиж чадахгүй байгаа төрийн байгууллагууд. Тэгээд нөгөө цаасаа нэхсээр л байгаа байхгүй юу. Тэгээд ингээд л ийм л асуудлууд байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Номинчимэг гишүүн тодруулъя.

О.Номинчимэг: Тэгэхээр өмнөх хууль нэлээн уг нь бизнест ээлтэй болгох гэж гарсан хууль маань хэрэгжихгүй байгаа асуудлыг дурдлаа. Тэгэхээр яг л бид нар тэгвэл энэ хуулийг ч гэсэн хэлэлцээд батлахдаа хэрэгждэг, хэрэгжихдээ зөв хэрэгждэг, Учрал даргын хэлж байгаа шиг хийдэлгүй л тийм хуулийг бид нар гаргах хэрэгтэй байна. Тэгээд тэр дээр анхаарах анхаарч ажиллах хэрэгтэй байх аа. Дээр нь яах вэ энэ түрүүний хэлсэн энэ деталиудыг харах юм нэлээн олон юм байна аа. Одоо тэгээд цаашид ажлын хэсэг дээр мэдээж нэлээн яригдах байх. Тэгэхээр хүнд суртлаас мэдээж бид нар энийгээ чөлөөлөх ёстой. Тэгээд бизнесийн орчноо сайжруулах тал дээр анхаарч байгаа дээр сайшаалтай байгаа. Гэхдээ хүнд суртал маань яг юун дээрээ очоод энэ хүнд суртал нь үүсчхэж байна вэ, зөвшөөрөл дээрээ байна уу, энэ техникийн дүгнэлтүүд дээрээ байна уу эсвэл хүнийх нь механизм тогтолцоондоо байна уу, албан байгууллагын соёлдоо байна уу гэдгийг бас нэг дүн шинжилгээ хийгээд энэ талынх нь.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн.

Л.Энх-Амгалан: Учрал даргад Ганхуяг гишүүн гээд энэ Зөвшөөрлийн хуультай бас 2.3 жил ноцолдсон, бас тодорхой том дэвшлүүд гарсан. Энийг бол хүлээн зөвшөөрөх ёстой. Мянга гаруй тусгай зөвшөөрлийг өгөх нэг 250-д авчирна гэдэг бол бас их том эрх зүйн дэвшил гэж би хэлэх гээд байна. Эрх зүйн дэвшил. Харамсалтай нь сая Учрал гишүүн ч гэсэн хэлээд байх шиг байна. Энэ хэрэгжилт дээр ерөөсөө манайхан чинь ингээд нэг ийм нугалаа хийдэг, нугалаа хийхдээ бүүр тэгэхэд хийдэг нугалаа нь ийм технологи болчихсон ийм ард түмэн шүү дээ. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд ер нь нөгөө манай төрийнхний таргалсан, хувийнхний турсан 2 бол нөгөө Дагдангийн эхнэрийн таргалсан, Цэрмаагийн турсан хоёртой тэнцэнэ гэдэгтэй яг л адилхан дүйцэхүйц ийм л үйл явдал болсон.

Өнөөдөр ерөөсөө энэ бизнесийнхэн чинь татвар гэхээсээ илүү энэ бизнесийн үйл ажиллагаа явуулах гэж байгаа баялаг бүтээгч нар чинь энэ зөвшөөрөл, тийм ээ, одоо энэ нэг зөвшөөрлөө сунгах эс үгүй оруулж ирсэн бараа бүтээгдэхүүнээ бүртгүүлэх гэдэг нэг ийм том босго давна гэдэг чинь үнэхээр хүнд шүү дээ, хүнд байгаа шүү дээ. Яг үнэнийг хэлэхэд бол. Ер нь ингээд төрд нэг энэ залуучууд орох гээд нэг шунаад үхэлдээд бид нарын нөгөө ярьж дууссанаар нөгөө нэг цүнх баригч нар орох гээд гүйлдээд байдаг чинь ерөөсөө л энэ нэг гарын үсгийн л дон шүү дээ. Гарын үсгийн дон. Энэ ингээд бүүр тарифтай болчихсон. Тэгээд ерөөсөө яг энэ зөвшөөрлийн чинь цаана төрийн хүнд суртал, төрийн авлигал, албан тушаалын дон эрх мэдлүүд чинь ерөөсөө л энэний цаана л нуугдаж байгаа шүү дээ. Нуувчин дотор байж байгаа нуугдаж байгаа зүйлүүд. Тэгээд монголчуудын нөгөө арын хаалга гар хүндрүүлнэ гэдэг асуудал чинь ерөөсөө л энэ зөвшөөрөл дээр л байгаад байгаа юм.

Тэгэхээр би нэг хэд хэдэн ийм сонгодог бизнес хийдэг зөвшөөрлүүд байна Учрал дарга аа. Өнөөдөр Монгол Улсад яг ингээд энэ 3 асуудал 3 салбар байгаа юм. Өнөөдөр нэг эмийн бүртгэл гэж. Монгол Улсад хүн ер нь энэ эрүүл мэндийн салбарт үйл ажиллагаа оруулж ирж байгаа энэ компаниуд олон улсад хүлээн зөвшөөрөгдчихсэн патентаа авчихсан, чанарын хүлээн зөвшөөрөгдсөн энэ эмүүдийг Монгол Улсад бүртгэх үйл ажиллагаа бол тамын ажил. Маш тамын ажил. Энэ бол яг мафи тодорхой бүр бизнесийн бүлэглэлүүдийн ашиг сонирхлыг хөндсөн тэр бараа бүтээгдэхүүнүүд нь орж ирж чаддаггүй. Зөвшөөрлүүдээ авч чаддаггүй.

Хоёр дахь нь энэ гаалийн кодчлолын асуудал байгаа юм. Барааны кодчлолын асуудал. Одоо гаалийнхаа байцаагчтай хуйвалдаж байгаад ижил төрлийн бараа ороод ирэнгүүт нөгөө компаниуд нь хуйвалдаж байгаад тэгээд өрсөлдөөнүүдийг яг тэр өөр кодчлолоор кодлуулдаг. Тэгээд тэрнийх нь өртөг өсчихдөг. Яг адилхан стандарт AOS авчихсан бараа бүтээгдэхүүнүүдийг аль олон улсын ангилал нь нэг ангилалд байгаа юмыг манайх өөрөөр бүртгэчихсэн өчнөөн үй түмэн тохиолдол байгаад байна шүү дээ энэ гааль дээр. Зөвхөн нэг гаалийн байцаагчийн үзэмжээс болж.

Гурав дахь марзан юм бол энэ байгаль орчны үнэлгээний зөвшөөрөл гээд зөвхөн Байгаль орчны яамны газрын дарга нар үе үеийн газрын дарга нарын үнэлгээ хийдэг давуу эрхтэйгээр ганцхан тэд нарын зөвлөх компаниуд нь авдаг давуу эрхтэй зөвшөөрөл байсан саяхныг хүртэл. Гэх мэтчилэнгээр бид нарт бол маш марзан марзан зөвхөн одоо ёстой нөгөө монгол ухаан монголчилно гэдэг шиг

нэг ийм марзан юмнууд маш их байна аа. Тэгэхээр энийг бид нар яг үнэхээр яг өргөс авсан юм шиг авч чадах юм бол энэ тодорхой дэвшил болно оо.

Ер нь бол бид нар сайн стратеги, сайн эрх зүйн шинэчлэлүүдийг хийдэг. Яг эргээд хэрэгжилт дээрээ бид нар нураад уначихдаг. Зүгээр нэг ийм төрийн дунд шатны албан тушаалтнуудын үзэмжээс болоод л нураад уначихдаг зөндөө тохиолдлууд байж байгаа шүү дээ. Би олон жишээ дурдаж чадна. Нэг үйлчилгээний төв дотор бизнесийн үйлчилгээний төв дотор 2 ресторан нээгдэхэд нэгийнх нь рестораных нь эзэн нь өөрөө тэр тусгай зөвшөөрөл өгдөг хотын төрийн хүнд суртлын ресторан, нөгөөдөх нь бол зүгээр нэг ард иргэд өөрсдөө нэг бизнес эрхлэгч адилхан ресторан нээхэд тэрнийхээ миний рестораны дэргэд ресторан нээсэн учраас зөвшөөрлийг нь өгөхгүй гээд тэр ресторан нь дампуурч байсан түүх байгаа шүү дээ. Ийм гашуун түүх байгаа шүү дээ. Өдөр тутам байгаа юм. 7 нэрийн нөгөө нэг архи зардаг зөвшөөрлөөс авхуулаад энэ сум дээр, аймаг дээр, нийслэл дээр алхам тутамд энэ дарга.

Ж.Бат-Эрдэнэ: Учрал гишүүн хариулъя.

Н.Учрал: Засгийн газарт яг Хэрэг эрхлэхийн сайд байхад бол зөвшөөрлийн зөвлөлийг Ерөнхий сайд ахалдаг учраас Хэрэг эрхлэхийн даргын хувиар өдөр тутмын үйл ажиллагааг нь хариуцаж байсан. Уг нь хуулиараа шинэ зөвшөөрөл нэмэх гэж байгаа бол Зөвшөөрлийн зөвлөл хуралдаад дүгнэлт өгдөг юм байна лээ. Тэгэхдээ хэзээ ч үгүй шүү дээ, хэзээ ч тэгж байгаагүй. Зөвшөөрлийн зөвлөлд сайд нар хэзээд санал дүгнэлт аваад зөвшөөрөл нэмж байсан юм. Тэр байтугай Их Хурал дээр ажлын хэсэг дээр зөвшөөрөл дураараа нэмчихсэн байна лээ шүү дээ тийм.

Тэгээд дараа нь Эдийн засаг, хөгжлийн сайд болсон. Эдийн засаг, хөгжлийн сайдаар бол зөвшөөрлийн санг хариуцдаг юм байна лээ Эдийн засгийн сайд. Сан гээд ингээд нэг систем дээр бүртгэгддэг хэсгийг нь. Яг олон нийтэд харуулдгийг нь Цахимын сайд хариуцдаг юм байна лээ. Энэ 3 хүн эв зүйгээ олж ажиллахын үндсэн дээр энэ зөвшөөрөл хүнд суртал нь буурах юм байна лээ. Тэгэхээр энэ 3 хүн яадаг вэ гэхээр эрх мэдлийг авах гээд байдаг байхгүй юу. Энэ нэг манай энэ дарга нар чинь ер нь ингээд ерөөсөө энэ яг тэр сайдын албанд очихоор ингээд эрх мэдэл нь тэрнээсээ салж болдоггүй юм шиг ингэж ханддаг байхгүй юу.

Тэгэхээр энэ хуулийг Засгийн газар санаачилж болохгүй юм байна лээ. Энийг чинь Хассуурийн Ганхуяг гишүүн ажлын хэсэг дээр байгаад дараа нь Хэрэг эрхлэх дээр энэ Ганхуяг гишүүний багийнхан манай энэ Хэрэг эрхлэхийнхэн бүгдээрээ ажилласан шүү дээ. Тэгээд яамдаас санал аваад тойроод ирэхээр энэ зөвшөөрөл нь байх ёстой, энэ нь байх ёстой энэ чинь тусгай зөвшөөрөл байх ёстой энэ чинь энгийн байж болохгүй гээд ингээд баахан санал ирээд эргээд харсан чинь яг хэвээрээ байгаа байхгүй юу. Тэгээд сая Их Хурлын даргаар томилогдсоныхоо дараа засаг руу шууд Заяабал гишүүн бид 3-ын нэртэй санал явуулаад санал дүгнэлтээ авсан юм. Нэг ёсондоо одоо бол салбарын эрх ашгууд яригдахгүй.

Тийм учраас би энэ Их Хурал дээр ажлын хэсэг байгуулна, ашиг сонирхолгүй хүмүүсийг оруулна аа. Тэгэхгүй дахиад нөгөө Их Хурал дээр ажлын хэсэг байгуулчихсаны дараа дахиад янз бүрийн юм нэмээд байхыг үгүйсгэхгүй. Тэгээд танихын аргагүй болчихдог байхгүй юу. Яагаад гэвэл чи эрх мэдлээсээ аягүй их тийм салж байгаа юм чинь. Тэгэхээр яг энэ Амгаа гишүүний хэлээд байгаа яг үнэн байхгүй юу. Тэр эрүүл мэндийн салбарт одоо Эрүүл мэндийн яам өөрсдөө л

хариулах хэрэгтэй байх. Одоо тэр гааль дээр. Гаалийн хүнд суртал гээд л сая нэлээн л үзлээ шүү дээ. Тэгэхдээ л ямар ч байсан хил боомт дээр буугаад суугаад байдаг чинь больчихсон. Гашуун сухайт Ганц мод дээр очихоор. Ямар ч байсан тэр сая хэлэлцээр хийхийн үед хоорондоо мэдээлэл солилцохыг нь холбоод хийчихсэн. Ямар ч байсан нэг үеэ бодвол их өөрчлөгдсөн шүү дээ. Тэгээд болно гэвэл болно. Гол нь энд би насаараа байхгүй шүү. Энэ төрийн ажил бол насаараа би энэ дарга байхгүй гэдгээсээ л салж л харахгүй бол зөвхөн тэр байгаа ажил дээрээ л нэг нэг юм нэмж авах гээд байдаг хандлага байгаад байдаг нь л аягүй хэцүү юм билээ. Тэгээд тэр салбарын яамдад энэ нөхцөлөө өөрсдөө тайлбарлах байх аа.

Ж.Бат-Эрдэнэ: Учрал даргын гишүүний хэлсэнчлэн Засгийн газар өөрсдөө хийдэг үү гэдэг дээр харин санал нэг байгаа шүү. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн тодруулна.

Л.Энх-Амгалан: Яах вэ ер нь бол улс төрийн манлайлал их чухал юм байна лээ л дээ. Би энэ 2 салбар хариуцаж сайдаар нь ажиллаж байсан. Тэгээд энэ их, дээд сургуулиудын чанаргүй их дээд сургуулиудын нэг 99 их дээд сургуулиудыг би нэг 65 болтол хүртэл цэгцэлж байсан. Бодитой л үр дүн болж байсан. Харамсалтай нь буцаагаад эргээд сэргээгээд байгаа юм байна лээ л дээ. Бүүр нэмээд байгаа юм байна лээ тоог нь. Хөдөлмөрийн сайдаар ажиллаж байхад бол энэ нэг орчуулагчдын товчоо ажиллуулах зөвшөөрөл, тэр нөгөө жолооны үнэмлэхний зөрчил зөвшөөрөл гээд ингээд яамдад нь хоорондоо энэ зөвшөөрлөө булаацалдаад байдаг нэг ийм заваан төрийн дон байдаг шүү дээ. Энийг арилгавал арилгаж болдог ийм сайн жишгүүд байдаг юм л даа.

Хамгийн гол асуудал бол бид нар хууль хийж болно оо, сайхан хууль баталж болно хэрэгжилт. Тэр тусмаа өнөөдрийн бид нарын хамгийн их зовоож байгаа асуудал бол яг энэ тусгай зөвшөөрлүүдийнх нь тоо багасаж байгаа ч гэсэн тусгай зөвшөөрөл олгож байгаа, сунгаж байгаа, түдгэлзүүлж байгаа, сэргээж байгаа, хүчингүй болгож байгаа энэ хүнд суртал чинь бол маш хүнд том хүнд суртал байна шүү. Учрал сайд аа, Учрал дарга аа, тиймээ. Энэ асуудал дээр л бид.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Сархадын Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ажлын хэсгийнхний өдрийн амар амгаланг айлтгая. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хувьд хэлэлцэхийг бүрэн дэмжиж байна аа. Энэ одоо өчигдөр бид бас нэг чухал асуудал хэлэлцээд өнөөдөр алга цохиод шийдвэр гаргачихлаа. Хувийн хэвшлийг дэмжих, эдийн засгаа либералчлах, иргэдийн аж ахуй эрхлэх энэ боломжийг өргөжүүлэх бол манай Засгийн газрын манай жишээ нь сөрөг хүчний энэ Улсын Их Хурал дахь бүхий л одоо жишээ нь улс төрийн намууд эвслийн бол гол зорилт нь. Бид эдийн засгаа либералчлахгүйгээр бол улс орноо ер нь урагшлуулж чадахгүй юм байна гэдгээ бол ойлгочихсон байж байгаа. Энэнтэй холбоотой шийдвэрийг шуурхай гаргах ёстой.

Зөвшөөрлийн тухай хуультай холбоотой энэ шийдвэр гарсан шийдвэр гараад эхнээсээ үр дүн нь зохих түвшинд гараад явж байгаа. Энийг сайшаах ёстой. Энэ гарсантай холбоотойгоор энэ ажлыг бол тухайн үед Учрал дарга Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд байх үедээ өөрөө манлайлж хийсэн үр дүнгүүд гарсан байгаа. Тэгэхээр энэ үр дүнг бол цааш нь үргэлжлүүлэх ёстой. Гэхдээ завсар

нь бол асуудал гарч байна аа. Хэрэгжилттэй холбоотой бэрхшээлүүд гарч байна. Тэрнээс гадна жишээ нь магадгүй зайлшгүй шаардлагатай гэж үзээд өөр хэлбэрийг нь зохион байгуулалт хийчхээд зохицуулалт хийчхээд тэрүүгээр дамжуулсан энэ хүнд суртал үүсэж байна. Бид ер нь засаглалыг боловсронгуй болгох, засаглалыг аль болох иргэдэд ойртуулах хялбар байлгах үүднээс 2 зүйлийг чухалчилж байсан. Нэг нь бол цахим шилжилт. Энэ бол таны хариуцаж үр дүнг нь бид хамтдаа үзэж байгаа зүйл. Хоёр дахь нь чиг үүргийг шилжүүлэхтэй холбоотой. Төрийн зарим чиг үүргийг шилжүүлэх.

Тэгэхээр миний асуулт 3 асуулт байна. Эхнийх нь бид ямар ч байсан энэ зөвшөөрлүүдийг цахим болгох чиглэлээр 251 зөвшөөрлийн 178-ыг нь бол цахим болгочихсон юм байна цаана нь нэг 73 үлдсэн байна. Яг энэ юунаас болсон бэ гэдгийг бас судалсан уу? Яагаад энэ цахим болж чадаагүй вэ? Цахим бол хялбаршуулж аль болох хүний оролцоогүй болгодог тэрнээс гадна бол хариу нь хурдан авагддаг цаг хүч, хөрөнгө хүч тэрнээс гадна жишээ нь хөрөнгө мөнгө хэмнэдэг ийм том шилжилт шүү дээ. Энэ чинь хэмнэж байгаа өөрөө их сайн үр дүн. Тэгэхээр энэ юунаас болсон юм бэ гэдэг нэг ийм асуулт байна.

2 дахь зүйл мэргэжлийн холбоод ассоциациудад зөвшөөрөл олгох эрхийг шилжүүлсэн. Энэ өөрөө чиг үүргийн шилжилтийн маш чухал арга хэрэгсэл шүү дээ. Энэний үр дүн ер нь хэр болсон бэ гэдгийг асуумаар байна? 100 жишээ нь ассоциац 100 зөвшөөрлийг мэргэжлийн холбоодод шилжүүлсэн үр дүн гарсан байгаа. Заримыг нь бид сонсож мэдэж байна. Энийг тодорхой ярих ёстой. Энэ бол өөрөө судлагдсан байгаа гэдэгт эргэлзэхгүй байна.

3 дахь зүйл зөвшөөрөлгүй болгочихоор зэрэг бүх юм сайхан болохоос гадна ямар бас бэрхшээл гарсан бэ гэдэг ийм асуулт гарч ирж байгаа юм. Заримыг нь зөвшөөрөлгүй болгочихсон чинь тэрийг дагаад үйл ажиллагаатай уялдсан, хяналттай холбогдох уялдсан зарим нэг сорилтууд дагалдсан. Энийг бол тодорхой тодорхой салбарууд дээр бол ажил хариуцаж байсан хүний дунд би мэдэж байна. Бас манай зарим гишүүд ч гэсэн ярьж байх шиг байна. Энэ бүх зүйлийг нарийн тооцсон уу?

Сая Номинчимэг гишүүн асууж байна. Мэдээж хэрэг бид энэ хөнгөвчлөх нь чухал, хялбарчлах нь чухал. Гэхдээ энийг бол нарийн судалж тогтоож байж тухайн салбарын онцлог, тухайн үйл ажиллагааны онцлогоос шалтгаалсан байдлаар ялгаатай тогтоох чиглэлээр одоо энд ажлын хэсэгт орсон яамдад, холбогдох шинэ газрууд хэр сайн ажилласан бэ гэдэг ийм асуултыг би 4 дэх асуулт болгож тавьж байна аа.

Ж.Бат-Эрдэнэ: Учрал гишүүн хариулъя.

Н.Учрал: Ер нь зөвшөөрлийг өгөхдөө их сүржин ханддаг юм байна лээ. Өгөх тэр эхлээд тэр зөвшөөрөл авах процесс ер нь мэдэхгүй энэ бол нэлээн ийм том ажил шүү. Дэлхийн оюуны өмчийн байгууллагад нэг шинэ бүтээл нэг бүртгүүлэх гээд байгаа юм шиг л юм болж байгаа шүү дээ. Тэгэхдээ нэг онцлогтой нь тэнд дандаа ингээд ар өврийн хаалга хэрэглэдэг. Тэр үнэн. Өгсний дараа харин мартчихаж байгаа юмаа. Нэг зөвшөөрөл өгчихсөн бол мартчихаж байгаа юм. Тэрний дараа тэр иргэдэд ямар хор уршиг учруулж байна, тэр хүнс, эрүүл мэнд тэр аюулгүй байдалд нь ямар хор уршиг учруулж байна гэдэг дээр явцын хяналт бараг байхгүй. Тэгээд явцын хяналт байдаггүй учраас дараа нь зөвшөөрлөө сунгах гээд ирэхээр бүх юмыг

шинээр эхлүүлдэг. Зүв зүгээр ажиллаж байсан үйл ажиллагааг зөвшөөрөл сунгахын төлөө нөгөө хүмүүс чинь бүх бичиг баримтаа бүгдийг нь эхнээс нь цэгцлээд яг шинэ зөвшөөрөл авч байгаа юм шиг. Яагаад тэгдэг вэ гэхээр явцын хяналт байдаггүй. Дээрээс нь тэр нөгөө эрсдэлийн үнэлгээнд суурилсан шинжилгээ хийдэггүй байхгүй юу. Тэгээд хаана хаанаас шалгалт ирсэн юм бэ гэхээр агентлагаас, дүүргээс тэгээд яамнаас, одоо нэг зохицуулах хорооноос мэдэхгүй ингээд маш их шалгалт. Тэгээд л нэг бүгдээрээ нэг улаан канттай тамгатай хүмүүсээр л дүүрлээ л дээ. Энийг цэгцлэхгүй болж бид нар нэг ард иргэддээ нэг тийм том тус болж чадахгүй юмаа гэхэд жоохон жоохон зай болж л өгөх ёстой байна.

Тийм учраас явцын хяналтаа сайжруулаад бид нар нөгөө эрсдэлийн үнэлгээнд суурилсан байж чадвал бүрэн боломжтой. Энэ бэлтгэлийг хийчихсэн. Жишээ нь Цахимын сайд байхад ч гэсэн манай И-Монгол тиймээ дата төв одоо энэ манай залуучууд байна. Энэ Тэнгис энэ Мягмарнаран эд нар ингээд хийчихсэн шүү дээ. Цахим сая одоо Зулпхар сайдын хэлж байгаагаар цахимаар бэлэн. И-бизнесийг бид нар танилцуулчихсан бэлэн. Энэний чинь ард байгаа тэр Лайсенс.мн гээд байгаа зөвшөөрлийн санг манай Сангийн яамны тэр и-баримт одоо манай энэ Батбилэг эд нар. Тэгээд сая би Эдийн засгийн яам дээр очсон манай энэ Золоо байна. Ийм залуучууд бүгдээрээ хийчихсэн. Зүгээр л энд нэгтгэдэггүй байхгүй юу. Зөвшөөрлөө энүүгээр өгөхийг хүсдэггүй. Заавал гараар өгөхийг хүсдэг, заавал өрөөндөө авчирч ингэж бөхийлгөж ингэж хүмүүсийг ингээд ёслуулж, торт авч ингэж цэцэг навчаар булуулж өгөх ийм сонирхол өндөртэй.

Тийм учраас би салбарын сайд биш учраас Их Хурлын гишүүний хувиар салбарын эрх ашгийг огт оруулахгүйгээр энэ хуулийг барьж байгаа. Энэний цаана олон хүмүүс юм ярина. Энэ заавал байх ёстой. Ингэдэг юм төр энийгээ л авч байвал бараг улс орон сайхан болно. Болдог байсан бол болчих байсан, болохгүй байгаа юм. Тийм учраас тэгээд зоригтой мэргэжлийн холбоонд өгөхийг нь өг. Тэгээд цахимаар явуулах энэ 100 хувь цахимаар явуулаад хүнээс хамааралгүй хувиа байвал зөвшөөрлийн тэр газарт ажиллах хүний сонирхол ч багасчихна.

Ж.Бат-Эрдэнэ: Сархадын Зулпхар гишүүн тодруулъя.

С.Зулпхар: Зохих үр дүн гарч байгаад талархалтай байгаа. Ер нь гараасай ч гэж бид хүлээж байгаа шүү дээ. Энэ зөвшөөрөл олгоно гэдэг бол төрийн зүгээр үйлчилгээ юм байгаа юм. Энэ бол төрийн хүнд суртал биш ноён суртал нь угаасаа биш. Тэгэхээр энэнтэй холбоотой сая л бид 3 зүйлийг ярилаа шүү дээ. Нэг бол цахим шилжилтээ бол бүрэн хийе, сайн хийе. 2 дахь нь бол чиг үүргээ жишээ нь шилжүүлбэ. 3 дахь зүйлийг бол ажлын хэсгийн ахлагч маш тодорхой хэлж байна. Явцын хяналт байхгүй бол зөвшөөрөлгүй болгоно гэдэг өөрөө дур зоргын байдал руу бас хөтөлнө. Энийг заавал бид бодож явах ёстой. Сайн кэйсүүд байна. Би тэр мэргэжлийн холбоод руу шилжүүлсэн зүйлийг би сарын өмнө Ноос ноолуурын холбооныхонтой уулзсан юм. Тэгснээ би чинь одоо гадаадад ноолуураа самнаснаар нь экспортолж байгаа шүү дээ. Энэний жишээ нь зөвшөөрлийг тэндээс өгчхөж байна. Лабораторийнх нь хяналтыг лабораторийн шинжилгээг тэндээс гаргаж байна. Маш хурдан болж байна. Үр дүн нь яасан гэхлээр зэрэг энэ жил бид нар ноолуураа экспортлоод маш их хэмжээний жишээ нь экспортынх нь хэмжээг нэмэгдүүлчихлээ шүү дээ. Энэ өөрөө бол хувийн хэвшлийг дэмжих юм.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Дахиад сунгах уу? Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Тэгэхлээр энэ төрийн чиг үүргийг шилжүүлэх энэ шилжилтийг мэргэжлийн холбоодод шилжүүлж байгаа нь сайн үр дүнгээ өгч байна. Тэгэхээр энэ зүйлийг бид цааш нь сайн туршлагыг дэлгэрүүлэх ёстой юм байна гэж ойлгох ёстой. Нөгөөтээгүүр явцын хяналттай холбоотой бэрхшээл байна. Нэг бол одоо зөвшөөрөлгүй болгосонтой холбоотой бас бэрхшээл байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлийн сургалтын зөвшөөрлийг өгдөг байсан ч зөвшөөрөлгүй болгочихсон чинь дор дорын сургалтууд ихэсчихсэн. Хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр тэнд бол хүн бэлтгэдэг, тэр нь одоо жишээ нь үйлдвэрлэлийн процесс дээр, ААН-үүд дээр хөдөлмөрийн аюулгүй байдлаа хариуцдаг хүн зөвшөөрөлгүй сургалтаар очоод хүний эрүүл мэнд аюулгүй байдалд жишээ нь нөлөөлж болзошгүй ийм байдал үүсэх гээд байгаа юм. Тэгэхээр энэ дээр бол зөвшөөрлийг нь өгөөгүй ч гэсэн явцын хяналтыг нь, сургалтын хяналтыг нь тавьдаг бас ийм зүйлүүдийг бол холбогдох яам нь анхаарах ёстой. Тэгж байж энэ бол үйл ажиллагаа маань бүрэн бодитой үр дүнтэй болно оо гэдгийг бид ойлгох ёстой юм байна гэж үзэж байна.

Ер нь бол зарчмын хувьд бол бид энэ хуулийг бол маш шуурхай гаргаад гэхдээ бүр нарийн судлаад шүү дээ. Тэгээд энийг батлах ёстой гэдэгт би.

Ж.Бат-Эрдэнэ: Үг хэллээ. Дуламын Бум-Очир гишүүн.

Д.Бум-Очир: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Хуулийн төслийг дэмжиж байгаагаа хэлмээр байна аа. Энэ төр нь бас ард иргэддээ хүндрэл учруулаад муухайгаар хэлбэл бид нар чинь одоо заримдаа тамлаад байна шүү дээ энэ нийт хүмүүсээ. Тэгэхээр энэ нэг зовлонгоос нь салгах их чухал хуулийн төсөл гэж ойлгож байна. Гэхдээ бас нөгөө талдаа миний нэг асуумаар бодмоор зүйл байгаад байна. Тэр нь юу гэхээр энэ зөвшөөрлийг зарим салбарт чангаруулах ёстой юу гэдэг асуудал. Сая Энх-Амгалан гишүүн хэлээд гарлаа. 99 их сургууль бид нар чинь 3 сая 500 мянган хүнтэй 600 мянга орчим. Тэр олон их сургууль, дээд сургууль хэрэгтэй байсан юм уу, үгүй юм уу. Одоо 65 гэдэг ч гэсэн ер нь олон шүү дээ. Тэгээд яг их сургуулиуд дээрээ очихоороо чанар маш муу. Тэгэхээр энэ бол магадгүй зөвшөөрлийг нь чангатгах ёстой ийм асуудал байгаа болов уу гэж харагдаж байгаа юм. Бүх сургуулийг хэлж байгаа юм биш шүү муу сургуулиуд байгааг хэлж байгаа юм.

Тэгэхээр бас нэгэн зүйл байна. Жишээ нь чангатгах гэдэг дээр энэ шашны байгууллагуудыг яах юм бэ? Одоо сүүлийн нэг энэ намар саяхан болтол явж өнгөрлөө шүү дээ. Энэ нэг шинэ тэнгэр газар гээд нэртэй шашны урсгал Монгол сувд гэдэг сүмийн асуудал явж байна шүү дээ. Над дээр хүртэл өргөдөл гомдол ирчихсэн байна. Энэ шашны байгууллагаа шалгаж өгөөч, гаж урсгалаа шалгаж өгөөч, ард иргэдийг мунхруулаад байна, амгалан тайван байдлыг нь алдагдуулаад байна, үндэсний эв нэгдлийг бусниулах гээд байна гэдэг ийм санал гомдлууд ирж байна шүү дээ. Тэгэхээр зарим салбарт магадгүй энэ Зөвшөөрлийн тухай хуулийг юм уу, зөвшөөрлийг нь чангатгах шаардлага харагдаад байгаа юм л даа. Тэгээд нэг хэсэг та бүхэн мэдэж байгаа байх. Шашин шүтэх, эс шүтэх тухай хуулийн асуудал яригдаад 2019 онд шашны байгууллагуудын тухай судалгаа хийгдээд, шашны байгууллагууд ялангуяа гаднын гэж хэлэх шашны байгууллагуудын тоо эрс нэмэгдчихсэн ийм нөхцөл байдлууд үүссэн шүү дээ. Тэгэхээр зарим салбарт энэ зөвшөөрлийг нь чангатгах шаардлага байгаа юу байна гэж зүгээр би харж байгаа юм. Тэгэхдээ энэ асуудлыг анхаарч үзэж амжсан уу гэдгийг нэгд тодруулмаар байна.

Дараагийн нэг зүйл юу вэ гэхээр энэ зөвлөмжийг уншихаар маш олон зөвлөмж гэмээр журам нэмж гарах юм шиг уншигдаад байна аа. Зөвлөмж гэдэг дээр. Гараагүй байгаа маш олон журмууд байна. Тэгээд нэмж гарах шаардлагатай юм шиг ийм агуулгууд. Гэтэл нөгөө талдаа бид нар дэндүү олон журамтай болчихсон байна гээд Хууль зүйн сайд хүртэл хэлээд байгаа шүү дээ. Монгол Улс бол журмын орон болчихлоо гээд. Тэгэхээр энэ сая бас Учрал сайд хэлж байна. 100 орчим журмыг цуцалсан гээд. Тэгэхээр яах вэ цуцалж байгаа нь сайн хэрэг. Одоо хэрэгтэй хэрэггүй олон журам байгаад байх нь. Тэгэхээр журам нэмэгдэх шаардлага үүсэх үү? Тодорхой тооны журам. Яагаад гэхээр энэ хуулийн төсөл дээр журам нэмэгдэх юм шиг уншигдаад байгаа юмаа гэдгийг тодруулмаар байна.

Дараагийн нэг зүйл энэ 5 дугаар хуудсан дээр байгаа. Түрүүн энэ хорт бодисын тухай асуудал нэг жилийн нийт хэрэглээ нь 100 гр, 100 кг юм уу. 100 кг тийм байна хүртэл жилийн химийн хорт болон аюултай бодис импортлох ашиглах гэдэг тэгээд мэдэгдлээр гэж байгаа юм л даа. Тэгэхээр энэ хэмжээгээрээ авсан юм байна гэж би ойлгосон. Мянган килограмм болчихвол арай өөр, 100 болчихвол мэдэгдлээр гээд. Тэгэхээр энэ аюултай нөхцөл байдал үүсэхгүй юу. Янз бүрийн эрсдэлт үр дагавар бий болохгүй юу. Химийн хорт бодис гэдэг бол бас бид нар анхаарах зүйл шүү дээ. Тэгэхээр энэ дээр зарим нэгэн ийм зүйлсийг тодруулж өгнө үү.

Ж.Бат-Эрдэнэ: Хууль санаачлагч Учрал гишүүн хариулъя.

Н.Учрал: Энэ хуулиар сүм хийд шашны байгууллага байгуулах асуудал бол энэ хуулийн харилцаанд үйлчлэхгүй хамаарахгүй гэж ойлгож болно. Тэгээд бид бас нэг зүйлийг ойлгох ёстой. Энэ зах зээлийн тогтолцоог энэ эрэлт нийлүүлэлттэй нь л хамтатгаж авч үзнэ гэхээс зөвшөөрлөөр зах зээлийг удирдана гэж ойлголт байж болохгүй. Зөвшөөрлөөр зах зээлийг удирдана гэвэл энэ чинь коммунист улс болно шүү дээ. Тэгэхээр ер нь зах зээлийн зарчмаар асуудалд ханддаг л байх ёстой юм байгаа юм ер нь бол. Тэрнээс тэр зөвшөөрлийг тэр салбарт өгөх өгөхгүйдээ биш байхгүй юу. Зах зээл өөрөө хэрвээ тэнд зөвшөөрөл өгсөн ч бай, өгөөгүй ч бай тэр чанаргүй байвал тэр байгууллага орлогогүй болно, ашиггүй болно, тэгээд дампуурна. Зах зээл нь тийм шүү дээ. Тэрнээс зөвшөөрөл гэдэг зүйлээр зах зээлийг удирдаад энэ тэд байх ёстой, энэ тэд байх ёстой энэ монопол гээд ингээд удирдаад байвал энэ өөрөө ардчилсан оронд тохирохгүй.

Бид нар нэгэнт 90 онд зах зээлд шилжчихсэн ардчилсан орон. Ийм цаг үед би ч гэсэн сургууль соёл төгссөн хүн. Тийм учраас миний итгэл үнэмшил бол аливаа зүйлийг зах зээлийн журмаар нь хөгжүүлэх ийм л итгэл үнэмшилтэй. Тийм учраас энэ чөлөөлье гээд байгаа санаачилга бол өөрөө хүнд суртлаас чөлөөлөх ёстой. Энэ хүн төрийн энэ хана хэрмийг багасгах ёстой. Ингээд 3.6 сая хүн тэгээд эрх чөлөөний төлөө хүн ажил төрлөө хийдэг өөрөө өрх нь орлогоо олдог ийм чөлөөтэйгөөр амьдрах бололцоог нь бий болгох ёстой. Гэхдээ иргэний аюулгүй байдлыг хангах ёстой учраас тэр зөвшөөрөл олгочихсон ч бай тэр явцын хяналтууд нь байнга хийгдэж байдаг, иргэнээ хамгаалж байдаг ийм нөхцөлийг бүрдүүлэх ёстой байхгүй юу. Тэгээд зөвхөн эрх чөлөө гэдэг чинь зөвхөн дураараа авирлахыг хэлнэ гэж ойлгож болохгүй. Эрх чөлөө мэдээж эрх үүргийн нэгдэл. Эрхээ эдэлж, үүргээ хүлээх ёстой. Тэгээд эрх үүргийн нэгдэл чинь өөрөө хариуцлага.

Тийм учраас бид энэ тал руу нь илүү харж энэ зөвшөөрлийн хууль дээр хандах ёстой юм байна лээ. Тэрнээс яг зөвшөөрлийг барьчхаад зах зээл дээр зохицуулалт хийгээд эхэлбэл энэ буруу зүг рүү явна аа. Тэгэхээр энэ зөвшөөрлийн

хууль бол илүүтэйгээр төрийн чөдөр тушаа гох дэгээ болоод байгаа асуудлыг багасгах, нөгөө авлигыг бууруулах, ашиг сонирхлоосоо л хол байх тал руу нь илүү боловсруулах гэж хичээсэн. Дүрэм журмуудыг бол тусад нь биш дүрэм журмуудыг хуульд нь тусгаж байгаад нийцүүлээд. Тийм учраас 100 журам энэ хууль батлагдвал цуцлагдана.

Ж.Бат-Эрдэнэ: Бум-Очир гишүүн тодруулна.

Д.Бум-Очир: Би нэг мэдээллийн чанартай зүйл хэлж байна. Нэгэнтээ иргэдээс энэ шашны байгууллагуудын асуудлаар санал гомдол ирээд байгаа учраас хувь гишүүний хувьд энэ асуудлыг цаашид анхаарч ажиллана аа. Сүүлийн үед судалж байгаа, мэдээлэл цуглуулж байгаа, анхаарч байгаа гэдгээ албан ёсоор мэдэгдмээр байна. Цаашид ч гэсэн энэнтэй холбоотой бусад асуудлыг анхаарах болно оо гэдгийг албан ёсоор мэдэгдэхийг хүсэж байна аа. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Пүрэвжавын Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаа юмаа. Тэгэхдээ бас хэд хэдэн зүйл байна хэд хэдэн. Ер нь зүгээр 2002 онд баталсан хуулийн араас ингэж яваад энэ хуулийнхаа хэрэгжилтээр гарч байгаа хүндрэл бэрхшээл сайжруулах зүйлийг нь бас ингээд 3 жил дотроо оруулж ирээд ингээд сайжруулах гээд явж байгаа нь хамгийн сайн жишиг болж байна. Бид хэд урьд нь хууль батлаад мартчихдаг байхгүй юу. Тэгээд хандлагууд байдаг юм. Үгүй энэ хуулийг чинь түрүү жил баталсан учраас энэ жил хүрч болохгүй гээд ингээд хүрч ядаад . Алдаа гарсан бол дор нь засах ёстой. Ингэхийн тулд байнгын ажиллагаатай парламент байж байгаа байхгүй юу. Тэгээд энэ хандлагыг бид нар бас анхаарч эвдэж өөрчилж, магадгүй өчигдөр баталсан хууль байж болно, алдаа байна. Бизнес т хүндрэл учруулж байвал өнөөдөр оруулж ирээд засах ёстой. Тэгэхдээ мэдээж хууль тогтоомжийн хуулиараа дор хаяж олон нийтийн хэлэлцүүлэг энэ тэрийг хуулийн процессын үе шат байгаа. Би зүгээр зарчмын хувьд хэлж байгаа юм. Тэгээд мартаж болохгүй л гэсэн үг.

Тэгэхээр энэний араас ингээд хэрэгжилт дээр нь ажиллаж байсан хүн маань алдаа эндэгдлээ хараад хууль санаачлаад орж ирж байгаа нь туйлын бас сайшаалтай буюу хууль тогтоомжийн хууль дээр гарч байгаа том жишиг шүү гэдэг зүйлийг би энд тэмдэглэж хэлмээр байгаа юм. Гэхдээ дотор нь орж байгаа зүйлүүд дээр нэг болгоомжилж байгаа зүйлүүд байна аа.

Уг нь Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар зөвхөн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрөлтэй эсвэл энгийн зөвшөөрөлтэйгөөр бусад үйл ажиллагааг эрхлэх чөлөөтэй эрхлэх боломжтой. Гэтэл энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр харин бид нар жоохон ухрах гээд байна уу даа. Тусгай зөвшөөрөл энгийн зөвшөөрлөөс гадна мэдэгдэл гэдэг зүйлтэй болчихлоо. Уг нь энэ мэдэгдэлтэй байна уу, мэдэгдэлгүй юу, үгүй гэдгээрээ үл хамаараад тэр бизнесийг эрхлэх нь зөв. Энэ эрх чөлөө энэ эрх нь байгаа байхгүй юу. Тэгэхээр одоо энэ мэдэгдэлд дурдагдаагүй бизнесүүдийг бас хийнэ гэж ойлгох уу, хийхгүй гэж ойлгох уу?

Тэгэхээр бас концепцын хувьд ярилцах зүйл байгаа шүү. Яах вэ зүгээр эрсдэлийн түвшнээс нь үнэлээд шууд чөлөөтэй эрхлэх боломжгүй учраас тодорхой хэмжээний мэдээллийг хүргүүлэх байдлаар энэ бизнесийн үйл ажиллагааг эрхлэх

боломжийг нь олгож байгаа гэдэг байдлаар үе шат руу буюу аажимдаа үндсэн хуулийн дээрх зарчим руу явах гэж байна л гэж би ойлгож байгаа юм. Тэгэхээр магадгүй ингээд цөөн тооны юмнуудыг мэдэгдлээр гэхээд бусад үйл ажиллагаануудыг энэ мэдэгдэл дээр ч алга, тусгай зөвшөөрөл дээр ч алга, энгийн зөвшөөрөл дээр ч алга гээд ингээд улам бизнесийг болих юм болчих вий. Энэ дээр уг нь би суурь үзэл санааг нь дэмжиж байгаа юм. Хэлэх гээд байгаа санааг нь. Тэгэхдээ энэ дээр ажиллаж байгаа ажлын хэсэг хууль зүйн техник дээр ажиллаж байгаа залуучууд анхаарах ёстой байсан шүү. Би энийг одоо хэлмээр байгаа юм.

2 дугаарт яах вэ дагаж байгаа хуулиудыг энэ тэр болоод үндсэн төслүүдийг харахад бас анхаарах зайлшгүй шаардлага байна аа. Галт зэвсгийн хууль, химийн тухай хууль, цөмийн энергийн хууль энэ тэр дээр орж байгаа Ашигт малтмалын хууль дээр орж байгаа өөрчлөлт энэ тэрийг анхаарахгүй бол хэт задгайруулсан байна шүү. Бас энэ чинь тодорхой түвшинд хяналттай байж байх, эргээд энэ хуулийн асуудлууд нь нарийн үзэхгүй бол болохгүй. Тэгэхээр ер нь Засгийн газрын яамдаас энэ дээрээ зөвшөөрч байгаа юу? Ялангуяа тэр эрчим хүч, цөмийн энерги энэ тэр дээр ашигт малтмал, Уул уурхайн яам энэ тэр зөвшөөрч байгаа юу энийгээ. Энийгээ нэг анхаараач ээ гэж хүсэж байгаа юм.

2 дугаарт яах вэ зүгээр энэ хуулийн бас нэг дутагдалтай тал байдаг юмаа. Зөвшөөрлүүд хаана очдог вэ гэхээр сайдын ширээ рүү зөвшөөрөл орохоосоо өмнө доор нь гаргадаг нэг санал дүгнэлт гаргадаг нэг айхтар институцүүд бий. Хамтын шийдвэр гаргадаг төрийн дарга нарын цугладаг тэгээд тэр нь хуралдаж өгдөггүй, зөвшөөрлүүд гардаггүй тохиолдлууд ч бий. Тэгэхээр энэ хамтын шийдвэр гаргадаг процессууд энэ дээр жоохон харагдахгүй байгаад байгаа юм. Баагий дарга аа нэг минутаа авчихъя тэгэх үү? Тэгээд би нэгмөсөн.

Ж.Бат-Эрдэнэ: Сайнзориг гишүүнд нэг минут.

П.Сайнзориг: Баярлалаа. Тэгээд нэгмөсөн хариултаа авчихъя. Тэгээд ер нь зүгээр сая Учрал дарга үзэл баримтлалыг танилцуулахад хэлж байна лээ. Засгийн газар 1500 орчим зөвшөөрөл мянга орчим ч зөвшөөрлийг ингээд 330 руу буулгаад ирсэн боловч 600-аад мэдэгдэл бүртгэл энэ тэр байна гээд байгаа юм, байна гээд байгаа юм. Тэгэхдээ энэ зөвшөөрөлтэй адилтгах нэршлийн хувьд үл хамаараад ингэж үүсгэж байгаа нь Эрүүгийн хуулийн 22.1-д заасан хийх ёсгүй зүйлээ хийж байгаа энэ эрх мэдэл, албан тушаалаа урвуулж байгаа үйлдэл байхгүй юу. Ийм нөхдүүдийг төрийн албанаас зайлуулах ийм бололцоо байхгүй байна уу? Нэг талдаа бас 22.1 Эрүүгийн хууль чангадчихаад байгаа юмаа. Тэгэхээр магадгүй энгийн болоод зөвшөөрлийг өгөхгүй байгаа энэ асуудал дээр уг нь Эрүүгийн хууль гэхээсээ илүүтэй шууд төрийн албанаас халдаг баймаар ганцхан санкцтай л баймаар байгаа юм. Эрүүлжүүлчихээр аль аль тал нь хэлж өгдөггүй. Ингээд гэмт хэргүүд нуугддаг, төрийн зүйлүүд ингээд байгаад.

2 дугаарт энэ яамдаас энэ зөвшөөрөл өгдөг юмнуудыг аль болохоо болимоор байна. Манай Хууль зүйн яам бүүр Зөвшөөрлийн яам болсон шүү дээ.

Ж.Бат-Эрдэнэ: Ганхуяг гишүүн хариулъя.

Х.Ганхуяг: Зөвшөөрлийн хуулийн зөвшөөрлийг ч хамгийн зовлон бэрхшээл нь хамгийн сайн мэдэх хүн Сайнзориг гишүүн мөн. Хуулийн хэрхэн яаж боловсруулагдаж, ажлын хэсэг яаж хэлэлцэж явсныг бас хамгийн сайн мэдэх нь л

Сайнзориг. Яагаад ингэж яриад байна гэхээр яг 2022 оноос хойш өнөөдөр яагаад Учрал дарга бид 2 ингэж санаачлаад өргөн барих болсон шалтгаан нь юу вэ гэхээр анх өргөн барихдаа Зөвшөөрлийн хуулийг дагаад нэг 50 хэдэн хууль орж ирсэн юм салбар хууль. Тэгээд яагаад хууль батлагдсанаас хойш түрүүн Номинчимэг гишүүн ч асуугаад байна. Хэрэгжилт дээр нь ямар асуудал гарсан бэ гээд. Бусад нөгөө зөвшөөрлийн харилцаа зохицуулсан нийтдээ 160 гаруй хууль байгаа юм. Тэгээд нөгөөдүүлийг нь дагуулж өргөн бариагүйгээс болоод Зөвшөөрлийн хууль дээр ингээд зөвшөөрлөөс хасчихсан байтал салбар хууль дээрээ зөвшөөрөл нь хэвээрээ тэр нь өргөн баригдаагүй хуулиуд дээр хэвээрээ яваад байсан асуудлууд байгаа. Хамгийн их зовлонтой нь байсан одоо жишээ бол Сайнаа бараг санаж байгаа байх. Витамины хууль байдаг. Бид нар ингээд зөвшөөрөл энэ витамин дээр зөвшөөрөл шаардлагагүй гээд байхад салбар хууль дээр нь зөвшөөрөл байна гээд оруулчихсан. Тэгээд гаалиар оруулж ирэх гэхээр хурааж авдаг. Нөгөө аж ахуйн нэгжийн зөвшөөрөл нэхдэг. Энэ байдал тэр 160 гаруй хууль дотор бүгдээрээ байсан. Тэгээд анх энэ Зөвшөөрлийн хууль өргөн барихдаа нэг 50 гаруй хууль дагалдуулж өргөн барьсан байдаг юм. Тэгээд өнөөдөр энэ өргөн барихдаа жишээлбэл 80 хэдэн хууль өргөн барьчихсан байгаа. Тэгээд энийг яагаад өргөн барихгүй байсан шалтгаан юу вэ гэхээр зөвшөөрөл гэдэг маань тэр олгож байгаа гарын үсэг зурж байгаа хүний хувьд ерөөсөө л яг хар тамхи шиг л болчихоод байгаа байхгүй юу. Тэрүүгээр эрх мэдлээ баталгаажуулж байдаг, дунд шатынх нь тэрүүгээрээ авлигалаа авч байдаг, дарга нар нь тэнчээ аль нэг аж ахуйн нэгж компаниудын тэр давуу эрхийг нь хадгалж байдаг ийм асуудал байгаад байгаа юм.

Тийм учраас одоо яг энэ яг Засгийн газар дээрээ нэлээн манлайлал үзүүлж байж энэ хууль тэр салбар хуулиудыг ингэж давхар ингээд хамаад өнөөдөр өргөн барьсан асуудал байгаад байгаа юм. Мэдэгдэл гэдэг шинэ томьёоллыг оруулж ирсэн байна гэж ярьж байна. Энэ бол ерөөсөө л энгийн зөвшөөрлөөс мэдэгдэл рүү шилжүүлж байгаа. Тэрнээс биш мэдэгдэл гээд дахиад шинээр баахан үйл ажиллагаанууд оруулаад байгаа юм биш. Нэг ёсондоо жишээлбэл тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, энгийн зөвшөөрөл, мэдэгдэл гэдэг 3 ангилалтай л болж байна гэсэн үг. Тэгэхээрээ бид эрсдэлийн үнэлгээг нь хийгээд, эрсдэлийн үнэлгээгээр нь хамгийн бага эрсдэлтэйнүүдийг нь бүгдийг нь мэдэгдэл рүү эхний ээлжид хийж байгаа. Яваандаа бол манай аж ахуйн нэгжүүд ч ойлгоод, иргэд маань ч ойлгоод эрх бүхий хүмүүс нь ойлгоод ирэхээр бид нар мэдэгдлийнхээ тоог нэмээд яваад баймаар байгаа юм.

Зөвшөөрлийн зөвлөл гэж байгаа. Зөвшөөрлийн зөвлөл 3 жил тутам нэг удаа аудит хийх ёстой юм. Аудит хийснийхээ үндэслэл дээр зөвшөөрлийнхөө тоог бууруулах зарим нэг нь мэдэгдэл рүү шилжүүлэх энэ үнэлгээ хийдэг эрсдэлийн үнэлгээ хийдэг аргачлалыг нь хийгээд Засгийн газар тэр журмаар тэрийг нь батлаад эрсдэлийн үнэлгээний юутай болчихсон юм шаблом гэх юм уу тиймээ. Үнэлгээ хийдэг аргачлалтай болчихсон байгаа. Тэгэхээр тийм учраас Засгийн газрын хажууд байгуулагдсан байгаа Ерөнхий сайдын дэргэд байгуул.

Ж.Бат-Эрдэнэ: Ганхуяг гишүүнд Ганхуяг сайдад нэг минут.

Х.Ганхуяг: Тэгээд тэр эрсдэлийн үнэлгээ хийдэг аргачлалтай болсноор бид нар 3 жил тутам аль нэг үйл ажиллагаануудыг мэдэгдэл болгох юм уу эсвэл зөвшөөрлөөс бүр ингээд хасах ийм боломжууд бүрдээд явах юм. Гэхдээ л нөгөө асуудал юу вэ гэхээр нөгөө салбар хуулиудын заавал ч үгүй давхар хөнддөг нэг ийм асуудал үүснэ ээ. Тэр Эрүүгийн хуулийн 22.1 бол яалт ч үгүй чухал. Энэ бол яг

Сайнаатай би санал нийлж байна. Энэ дээр чинь үйл хөдлөл ерөөсөө л гарах л юм бол нөгөө асуудал үүсчхээд байдаг болохоор ерөөсөө тэр дунд шатны албан хаагч нар ерөөсөө хөдлөх дургүй. Тэгээд хөдлөхгүй болохоор чинь асуудлууд нь шийдэгдэхгүй яваад байдаг асуудал үргэлжилсэн хэвээрээ л байгаа. За баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Сайнзориг гишүүн нэг минут.

П.Сайнзориг: Би тэгээд санаагаа нэг давтчихъя аа. Тэгээд аливаа хуулийг баталсны дараах 5 жил хамгийн чухал байдаг. Энэ дээр алдаа оноогоо авбал тэр хуулийг дараа дараа нь огцом огцом шинээр, бүтэн шинэчлээд байх шаардлагагүй болдог юм. Тэгээд энэ асуудлыг хамгийн шинжлэх ухаанчаар харсан хүн манай Тэмүүжин сайд өөдөөс хараад сууж байна л даа хууль тогтоомжийн хуулийг. Тэгэхээр энийг хэрэгжүүлж байгаа хамгийн зөв жишиг зөвшөөрлийн хуулиас эхэлж байна шүү гэдэг зүйлийг би бас энэ протоколд үлдээе гэж бодож байна.

2 дугаарт энэ зөвшөөрлийг мэргэжлийн холбоо эсвэл эдийн засгийн холбоо юу гээд энэ рүү шилжүүлэх процессууд ерөөсөө аль ч хууль дээр байхгүй байгаа. Засгийн газрын хууль, Агентлагийн эрх зүйн байдлын хууль болон тэр хуулиуд дээр тодорхой оруулж өгмөөр байна. Засаг захиргаа нэгжийн тухай хууль дээр. Тэгэхээр энийг бас нэг цаашдаа хэдүүлээ анхааръя гэж бодож байна.

2 дугаарт Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хүн байвал тэр харуул хамгаалалт болон тэр янз бүрийн зөвшөөрлүүдээ Цагдаагийн ерөнхий газарт өг өө. Одоо Хууль зүй, дотоод хэргийн яам бодлогын яам биш бүүр үүдээрээ дүүрэн зөвшөөрөл харуул хамгаалалтын албаныхан зогсоочихсон энэ зөвшөөрөл өгдөг зөвшөөрлийн хэлтэстэй болчихсон явж байгаа шүү. Би үнэхээр санаа зовж байна. Бодлогын яам шиг байгаарай. Чиг үүргийн ерөнхий чиг үүргийн.

Ж.Бат-Эрдэнэ: Зөвшөөрөл өгч байгаа нөгөө аймаар хүмүүс чинь энд ирчихсэн байгаа гэж би ойлгоод байгаа шүү дээ ажлын хэсгийнхэн. За Ганхуяг сайд хариулъя.

Х.Ганхуяг: Сайнзориг гишүүний асуултад хариулъя аа. Мэргэжлийн яг зөвшөөрлийн хууль болон жагсаалт дээр шууд мэргэжлийн холбоог оруулж болохгүй. Яагаад вэ гэхээр энэ дээр бас нөгөө яг хувийн хэвшилтэй уулзаад явахад асуудал үүссэн юм. Одоо жишээ нь тэнхим рүү тэр самрын зөвшөөрөл гээд л шилжүүлэнгүүт дараад нь нөгөө танил тал, авлигал гээд асуудлууд үүссэн байдаг юм. Ассоциаци барилгын ассоциаци дээр тийм асуудал үүссэн. Тэгэхээр бид нар зүгээр эрх бүхий байгууллагын гэрээгээр хугацаагаар шилжүүлэх боломжийг нь нээгээд өгөх ёстой. Яг жагсаалтдаа болохоор төрийн эрх бүхий байгууллага нь өөрөө ороод явах ёстой юм байна лээ. Төрийн эрх бүхий байгууллага нь угаасаа 4 жил болгон солигддог болохоор бас нэг хуулийн дээр нь хууль үйлчилдэг юм нь байгаад байдаг юм байна лээ шүү. Энэ дээр бас нэг Сайнаа нэг анхаарчихмаар юм байна лээ.

Тэр харуул хамгаалалттай холбоотой тэр зөвшөөрлийг бол цагдаа руу олгох гээд ингээд асуудлууд явсан. Тэгэнгүүт Хууль зүйн яам эсрэг байр суурьтай, цагдаа дээр нэг эсрэг байр суурьтай асуудал юун дээр үүссэн бэ гэхээр цагдаагийн байгууллагаас зөвшөөрөл авсан тэр харуул хамгаалалтын байгууллага нь сүүлдээ гүйцэтгэх ажиллагаа явуулаад.

Ж.Бат-Эрдэнэ: Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн асуултаа асууя.

Х.Тэмүүжин: Зөвшөөрлийн тухай хуулийг дэмжиж байгаа юм. Ер нь бол нийгмийн нийгэмд ухаалаг бус, утга учир муутай, чирэгдэл зардал ихтэй, хүнд суртал, ойлгомжгүй байдлыг ингээд дөвийлгөсөн байдлууд л гараад байхаар л авлига гараад байгаа шүү дээ. Тэгээд энийг зогсоохын тулд Зөвшөөрлийн хууль гэж ерөнхий нэг кодфикац руу оруулах гэж байгаа энэ санааг бол дэмжиж байгаа. Гэхдээ судалгаатай хийхгүй бол эрсдэл гарч байгаа гэдгийг хэлье.

2022 оны 6 сарын 17-нд баталсан Зөвшөөрлийн хууль дээр Галт зэвсгийн тухай хуулиас давсан юм хуульчилчихсан. Галт зэвсэг түүний дагалдах хэрэгсэл гэдэг үг ороод ирсэн. Тэгээд юу болсон гэхээр гааль дээр ийм хэрүүл гарсан. Одоо яг амьдрал. Нэг иргэн галт зэвсэгтэй холбоотой эвдэрсэн нэг дуран хараа гэх мэтчилэн ингээд нэг тийм тийм зүйлийг ингээд оруулаад ирэх гэсэн чинь гааль дээр энэ тусгай зөвшөөрөлтэй юм байна шүү дээ. Зөвшөөрлийн тухай хууль дээр дагалдах хэрэгслийг ингээд биччихсэн байна гээд. Тэгээд зөвшөөрөл өгдөг цагдаагийн байгууллага дээр нь очоод ингээд гаальд тусгай зөвшөөрөл нэхээд байна гэнгүүт Галт зэвсгийн тухай хууль дээр ийм бүрэн эрхийг манайд олгоогүй шүү дээ. Бид энд тусгай зөвшөөрөл бичихгүй гээд. Иргэн учраа олохоо байчхаж байгаа юм. Гааль дээр нэг юм ярина, цагдаа дээр нэг өөр юм ярина.

Тийм учраас ингээд хууль хоорондын нийцэл болон үндсэн зохицуулалт нь юу шийдэж байгаа вэ гэдгийг ойлгохгүйгээр зөвшөөрлийн тэр хэсгийг бичихээр бас ийм гажиг үүсэж байгаа юм.

Дахиад би түрүүн хэллээ. Ухаалаг бус утга учир муутай, зардал чирэгдэл гаргадаг зүйлийг л энэ хуулиар хасах гэж оролдож байгаа. Одоо дагаж ирсэн хууль дээр нь ингээд би дахиад биччихэж байгаа юм. Одоо сумтай холбоотой хэсэг байна. Тэсэрч дэлбэрэх эрсдэлтэй нь дарь байхгүй юу. Хонгио толгой гэх мэт чинь зүгээр л металл. Энийг тээвэрлэхэд тусгай машин хэрэггүй шүү дээ. Гэтэл энэ дээр чинь ингээд тусгай машин байх ёстой гээд биччихэж байгаа юм. Дарийг тээвэрлэхэд бараг жилдээ юм уу, 2 жилээр нэг удаа л тээвэрлэх байх. Угсрагдчихсан байгаа сум бол тэсэрч дэлбэрэхгүй шүү дээ.

Тэгэхээр энэ аж ахуйн нэгж дээр ингээд ухаалаг биш, утга учир муутай дахиад зардал нэмээд эхэлчхэж байгаа байхгүй юу. Чи заавал ийм юмтай байна. 2 жилд нэг удаа хэрэглэх тээвэрт зориулаад машинтай байна гээд хуульчилчхаж байгаа байхгүй юу. Гэтэл тэсэрч дэлбэрэх бодисыг чинь тээвэрлэх тусдаа бизнес шүү дээ. Тэр аж ахуйн нэгжид байх албагүй байхгүй юу. 2 жилд нэг удаа өөр компаниар мөнгийг нь төлөөд тээвэрлүүлж болно шүү дээ гэх мэтчилэн ингээд нөгөө амьдралд байдаг зүйлүүдийг нь судалж байж хууль хийхгүй бол ингээд механик нөгөө албан тасалгааны цонхоор амьдрал сайхан харагдана гэдэг шиг нөгөө аж ахуйн нэгж бизнес эрхэлж байгаа иргэд дээрээ утга учир муутай хүнд суртал, дахиад давхар зардал, тэгээд албан тушаалтнаа эрх мэдэлжүүлсэн ийм үг өгүүлбэр биччихээр дунд нь иргэн юу үүсэж байна вэ гэхээр асуудлаа шийдэж чадахгүй, асуудлаа шийдэх арга зам нь юу болох вэ гэхээр аягүй бол авлига үлдэнэ шүү дээ.

Тэгэхээр бид нар нэр томъёонуудаа сайн судлах хэрэгтэй. Энд дахиад энэ 2 Зөрчлийн хууль болон Үндсэн хууль цаана байгаа тухайн харилцааг зохицуулж байгаа хууль 2 чинь аль нь дагуу юм. Дахиад тэр чиглэлээр нь кодфикацынхаа шийдлийг гаргахгүй бол гээд үндсэн зохицуулалт нь өөр юм яриад байдаг. Гэтэл

одоо Зөвшөөрлийн хууль нь өөр юм яриад байдаг. Дэлхийд галт зэвсгийг хянаж байгаа гуравхан л арга байгаа. Тусгай зөвшөөрөл өгч байгаа гол төмөр, замаг, хайрцаг анги энэ 3 нийлбэл галт зэвсэг. Тэрнээс бусад дээр нь тусгай зөвшөөрөл байхгүй.

Тэгэхээр одоо Зөвшөөрлийн хууль дээр чинь дагалдах хэрэгсэл гээд биччихээр бууны хөл авсан ч тусгай зөвшөөрөлтэй, нэг замгийнхаа нэг пүшиг.

Ж.Бат-Эрдэнэ: Ганхуяг гишүүн хариулъя.

Х.Ганхуяг: Ер нь нөгөө түрүүн хэлсэн шүү дээ. Одоо зөвшөөрлийн харилцаа зохицуулж байгаа 160 гаруй хууль байна гээд. Энэний нийцлийг нь маш сайн хангах ёстой юмаа. Яагаад гэхээр салбар хууль байвал салбарын тэр харилцааг зохицуулсан хууль байвал одоо Галт зэвсгийн тухай хууль байвал Галт зэвсгийн тухай хуулиа барьж явна. Зөвшөөрлийн хууль ерөнхий хууль шүү дээ. Нийтлэг харилцааг зохицуулж байгаа. Жагсаалт байгаа. Тэр салбарын хууль байхгүй бол зөвшөөрлийн процесс чинь ингэж явна шүү л гэдэг хууль шүү дээ. Та өөрөө уншсан байлгүй Зөвшөөрлийн хуулийг. Тэгэхээрээ тэр салбарын хуульдаа хэрэвзээ яг тэр дагалдах хэрэгсэл гээд л орсон бол дагалдах хэрэгслээр нь Зөвшөөрлийн хууль руу жагсаалт руу орж байгаа юм. Тэрнээс биш зөвшөөрлийн хуулиас салбарын хууль руу оруулаагүй байхгүй юу. Тийм болохоор энэ дагалдах энэ нөгөө дагуулж энэ салбарын хуулиудыг өргөн бариулаад байгаа шалтгаан нь тэр юм.

Тэр салбарын хууль дээрээ цөмөөрөө суух хэрэгтэй. Зөвшөөрөлтэй харилцаатай холбоотой юманд суух хэрэгтэй. Тэрнээс нь зөвшөөрлийн жагсаалт руу татаж байгаа байхгүй юу. Хууль зүйн яам нэмээд хариулчих. Сая тэр дагалдах хэрэгсэл дээр.

Ж.Бат-Эрдэнэ: Хууль зүйн яамнаас хэн хариулах вэ? Хууль зүйн яам. 4 номерын микрофон өөрийгөө танилцуулаарай.

Б.Батзориг: Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга хурандаа Батзориг илтгэж байна аа. Гишүүний саяын ярьсан асуудлаар ажлын хэсгийн хүрээнд энэ асуудал яригдсан байгаа. Бас цаашид бол энэ Улсын Их Хурал дээр дэмжигдсэн тохиолдолд дахиад цаашаа үргэлжлэх ажлын хэсэг дээр энэ асуудлыг илүү цаашаа боловсронгуй болгох асуудал дээр анхаарч ажиллахаар яригдсан байгаа. Галт зэвсгийн тухай хууль, түүнтэй дагалдах бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал дээр еще боловсронгуй болгох асуудал дээр яригдсан асуудал байгаа. Танилцуулж дууслаа.

Ж.Бат-Эрдэнэ: Тэмүүжин гишүүн тодруулъя.

Х.Тэмүүжин: Дахиад нэг Зөвшөөрлийн хуулийг далимдуулаад хэлэхэд биднүүс төр бас ингээд аль болох иргэнд хүнд сурталгүй, давхардсан зөвшөөрөлгүй, тийм зохицуулалтыг л бий болгох гэж оролдоод эрэл хайгуул хийгээд байх шиг байгаа юм. Гэхдээ нөгөө төрийн нэгдсэн бодлого байхгүй учраас жоохон учир дутагдалтай байх шиг байна. Тухайлбал Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг анх гаргахдаа хуульчдад энэ мэргэжлийн лиценз гэдэг зүйлийг нь нэг тодорхой болгоё оо. Тэгээд Хуульчдын холбоо энэ лицензийг ингээд олгодог байя, лицензийг ард нь мэргэжлийн хариуцлага гэдэг албан ёсны хариуцлагын систем нь

бий болоод, энэ мэргэжлийн өөрөө удирдах ёс болон өөрийн зохицуулалттай зохион байгуулалтыг хийе гэж бодож төлөвлөж хийсэн юм.

Тэгээд тэр зохицуулалт нь дахиад л нөгөө хүнд суртлыг л багасгах, давхардсан шалгалт, зөвшөөрлийн системүүдийг багасгах л зориулалттай байсан байхгүй юу. Тэгсэн чинь дахиад юу болсон гэсэн чинь Өмгөөлөгчдийн холбоог байгуулангуутаа Хуульчдын холбоо руу шалгалт авдаг, гэрчилгээ олгодог.

Ж.Бат-Эрдэнэ: Дахин нэг минут.

Х.Тэмүүжин: Өмгөөлөгчдийн холбоо руу шалгалт авдаг, дахиад зөвшөөрөл олгодог. Тэгээд сүүлдээ ингээд бодит байдал дээр харахаар түрүүн хэд хэдэн гишүүдийн үгэнд гарч байсан. Зах зээл дээр байгаа өмгөөлөгчид нь хэн өмгөөлөгч болох вэ гэж өөрийнхөө зах зээлийг нээдэг болоод хувирчихсан. Энэ чинь сонирхлын зөрчил шүү дээ. Энэнээс зугтаагаад хуульчдын холбоо гээд өмгөөлөгч, прокурор, шүүгч гээд өргөн бүрэлдэхүүнтэй оролцоод компанийн хуульч оролцоод зөвшөөрөл өгдөг систем байсан чинь ард нь нэг хаа гуяыг нь салгаад, үсчингээр бол толгой угаадгийг нь дахиад бизнес болгоод салгаад лицензтэй болгоод хаячихсан. Үсийг нь угааж байгаад л үсээ засах үйлчилгээ чинь чанар сайжирна шүү дээ. Гэтэл үс засах нь тусдаа, толгой үс угаах нь тусдаа хоёулаа лицензтэй болгоод хувиргачхаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр иймэрхүү одоо ингээд давхардсан зөвшөөрлийн системүүдийг мэргэжлийн холбоод дээр ч гэсэн зогсоохгүй бол цаашаагаа нөгөө төр дарга үйлдвэрлэдэг гэдэг шиг хувийн мэргэжлийн холбоод нь зөвшөөрөл үйлдвэрлэдэг системээр ингээд явах шинжтэй байна шүү.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Хүрэлбаатарын. Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Зөвшөөрлийн хуультай холбоотой нэг хэд хэдэн асуулт байна. 1 дүгээрт хуулийн төсөлтэй танилцахлаар Зөвшөөрлийн хууль дээр урьд нь Улсын дээд шүүх олгодог байсан энэ мэргэжлийн нэгдсэн холбооны зөвшөөрлийг бүгдийг нь улсын бүртгэлийн байгууллагад олгодог болгож байгаа юм байна гэж ойлгосон. Зөв ойлгосон уу. Хэрвээ тийм бол Улсын дээд шүүхийн саналыг авсан уу. Ер нь Улсын дээд шүүх энэ мэргэжлийн холбоодыг бүртгэгдсэнтэй холбоотой ямар асуудал гарч байсан юм бол. Үүнд хийсэн судалгаа шинжилгээ байна уу гэсэн нэг ийм асуулт байна. Энэ бол тогтолцооныхоо хувьд нэлээн том өөрчлөлт байгаа. Тэгэхээр энийг зайлшгүй тодруулж асуумаар байна. Тэгээд Улсын дээд шүүх дээр өөр дээр нь бас нэг туршлага байгаа байх тэрийг нь мэдмээр байна гэсэн нэг ийм асуулт.

2 дугаарт мэргэжил боловсролын хуульд орж байгаа өөрчлөлтийг би харлаа тухайлаад. Тэгээд Боловсролын ерөнхий хуулийн 20.1.3, 20.1.4, 20.1.5 дахь заасан энэ заалтуудыг хүчингүй болгочхож. Хүчингүй болгохоор ингээд төсөл орж ирж байгаа юм байна. Энэ ямар заалтууд вэ гэхээр боловсролтой холбоо сургуулийн зөвшөөрөл авахын тулд ЕБС гээд төсөөлье л дөө. ЕБС-ийн зөвшөөрөл авахын тулд стандартын шаардлага хангасан нь хичээлийн байртай байх, номын сантай байх, лабораторитой байх, биеийн тамирын заалтай байх гээд энэ заалтуудыг нь бид нар хасчихсан байна аа. Энэ яагаад ингэж хасаж байгаа юм бол оо гэсэн ийм асуулт байна.

3 дугаарт түрүүн тэсэрч дэлбэрэх бодис гээд ингээд хүмүүс хөндчихлөө. Яг үүнтэй адилхан Усны тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиуд дээр бас орж байгаа өөрчлөлтүүд жоохон анхаарал татаад байна. Ялангуяа энэ нөгөө олон хуулиуд дээр зөвшөөрөл таслал тавиад мэдэгдэл гээд оруулчхаж байгаа юм байна. Тэгэхээр нөгөө зөвшөөрөл дээр нэмэх нь мэдэгдэл орж ирээд байна л даа. Тэгэхээр би яг нөгөө Номинчимэг гишүүний хэлдэг саналыг дэмжиж асуух гээд байгаа юм. Зөвшөөрөл дээр нэмээд мэдэгдэл гэдэг ийм давхар юм орж ирээд байна уу, энэ ямар учиртай вэ? Эсвэл зөвшөөрлөө бид нар болиод мэдэгдэл болгох гээд байгаа юм уу гэдгийн ялгаа ерөөсөө харагдахгүй байна гэж асуух гээд байгаа юм.

Тэгэхээр яг энэ нөгөө хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой энэ маань цоо шинэ хууль биш бас тодорхой хэмжээгээр 2.3 жил хэрэгжиж ирсэн учраас тэрэнтэй холбоотой туршлагыг нь асуух гээд байгаа гэсэн үг.

Хамгийн сүүлд Их Хурлын Тамгын газраас энэ хуулийн бүрдүүлбэрийг хараад дахиад ингээд Д-парламент дээр хараад үзэхлээр нөгөө миний өчигдөр бас хэлж байсан хүний эрхэд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ нь ерөөсөө байхгүй байна аа, хүний эрхийг хязгаарлах заалт байхгүй гээд л ганцхан өгүүлбэртэй ингээд болчхоод байна аа. Ийм байдлаар одоо энэ цаашид хууль тогтоомжуудыг явуулмааргүй байна аа. Хууль тогтоомжийн тухай хуульд орсон өөрчлөлтийнхөө дагуу энэ хуулийн бүрдүүлбэр дээр тавигдах шаардлагуудаа бас хармаар байна гэсэн үг. Эсвэл тэр судалгаа юмнууд нь энэ дээр бүрэн ороогүй байна уу, бүрэн хэвлэгдэж тараагаагүй байна уу гэдэг дээр бас хариултаа өргөн барьсан санаачилсан гишүүн юугаа хэлчихвэл бас зөв болох байх. Хуралдааны тэмдэглэлд үлдээчихвэл зөв болох байх аа. Ийм асуулт.

Ж.Бат-Эрдэнэ: Хассуурийн Ганхуяг сайд хариулъя.

Х.Ганхуяг: Энэ мэдэгдэл гэдэг томъёоллыг яг энэ хуулийн юунд оруулж өгч байгаа юм. Мэдэгдэл гэдэг маань ямар нэгэн байдлаар эрсдэл багатай үйл ажиллагааг өөрийнх эрх бүхий байгууллагад нь мэдэгдээд үйл ажиллагааг шууд эхэлж болно оо гэдэг. Яагаад тэгж байна гэхээр үндсэндээ энэ чинь 2022 оны 6 сард энэ хууль батлагдсанаас хойш Улсын Их Хурлаас 3 удаа ажлын хэсэг гарч ажилласан байдаг. Хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор. Бид нар ингээд зөвшөөрлийг нь болиулаад, хуулиа батлаад, тэгээд хэрэгжилтээ шалгаад ингээд явангуут иргэд, аж ахуйн нэгжүүдээс гарч байгаа асуудлуудаар нь бид нар ингээд 3 удаа хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор шалгалт явуулаад санал дүгнэлтээ оруулаад, Их Хурлаас 3 удаа Улсын Их Хурлын тогтоол гарсан байдаг юм хуулийн хэрэгжилтийг шахсан.

Тэгээд үүнтэй холбогдуулаад бид нар ер нь үйл ажиллагааг нь илүү тодорхой болгох, энэ эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагаа дээр хүнд суртлыг багасгах зорилгоор энэ нэг шатлалыг гаргаж ирээд энгийн зөвшөөрөл буюу энгийн болон тусгай зөвшөөрлөөс хамгийн бага эрсдэлтэйг нь эхний ээлжид мэдэгдэл рүү шилжүүлж байгаа. Тэгснээрээ эргээгээд иргэд, аж ахуйн нэгжүүдээс гараас нь гардаг зардал цаг ингээд олон асуудлыг хэмнэж өгөөд гагцхүү стандартын дагуу шаардлагаар стандартын шаардлага хангасан байх ёстой гэдэг шаардлага нь тавигдана. Тэр эрх бүхий байгууллага нь шалгах хэрэгтэй байна, үйл ажиллагааг нь түдгэлзүүлэх хэрэгтэй байна. мөн тэр мэдэгдлийг бүр цуцлах хэрэгтэй байна.

Тийм учраас гэхдээ үйл ажиллагаа эхлэхэд нь ямар нэг хүнд сурталгүй эхлүүлэх боломжийг нь олгож байгаа гэсэн үг. Энэ бизнесийн орчинтой холбоотой шууд холбоотой хууль болохоор үндсэндээ 60 хоног хэлэлцүүлдэг, англи хэлээр орчуулж Д-парламентаар 60 хоног байршуулдаг, хувийн хэвшил болон эрх бүхий байгууллагуудтай нь хэлэлцүүлгүүдийг зохион байгуулдаг ийм дэгээр явдаг. Хүний эрхийн тэр асуудалтай болон тусгай хамгаалалт болон сургуулийн зөвшөөрөл болон мэргэжлийн нэгдсэн холбоотой асуудлаар Тэнгис нэмээд гүйцээгээд хариулчих.

Ж.Бат-Эрдэнэ: Нэрээ танилцуулаарай.

С.Тэнгис: Улсын Их Хурлын даргын Засаглал хариуцсан зөвлөх Тэнгис мэргэжлийн холбоотой асуултад хариулъя. Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль гээд 2024 оны 4 сард батлагдаад 6 сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн. Гэхдээ тухайн үеийн хуулийн зохицуулалтаар Улсын дээд шүүхэд улс төрийн намтай адилхан зохицуулалтаар мэргэжлийн нэгдсэн холбоодыг бүртгэе гэж хуульд тусгаж батлагдсан боловч Улсын дээд шүүх бол дараа нь үүн дээр бол бүртгэх боломжгүй юм байна гээд Үндсэн хуулийн цэцэд хүртэл хандах хэмжээний асуудал үүсээд тэгээд үндсэндээ бол энэ хуулийн үйлчлэл ингээд зогсчихсон байж байгаа юм.

Энэ асуудлыг нь шийдэхгүй болохлоор нөгөө Засгийн газар, Улсын Их Хурлаас баримталж байгаа олон реформууд төрийн чиг үүргийг мэргэжлийн нэгдсэн холбоодод шилжүүлэх энэ олон ажлууд зогсоод, магадгүй энэ Зөвшөөрлийн тухай хуулийн тодорхой энэ яригдаад байгаа асуудлууд дээр хүндрэл үүсэж байгаа юм. Тийм учраас мэргэжлийн нэгдсэн холбоодын бүртгэлийг бол улсын бүртгэлийн.

Ж.Бат-Эрдэнэ: Болсон уу. Гүйцээж хариулъя, дахиад нэг минут.

С.Тэнгис: Тэгэхээр мэргэжлийн нэгдсэн холбооны бүртгэлийг УБЕГ-т шилжүүлэхээр энэ хуулийн төсөлд дагалдаж оруулсан байж байгаа. УБЕГ бүртгүүлнэ гэдэг маань цаанаа түрүүн дурдсан энэ мэргэжлийн нэгдсэн холбоодын шаардлагыг хянаж бүртгүүлэхээр тусгаж байгаа. Өөрөөр хэлбэл зүгээр нэг холбоодыг мэргэжлийн нэгдсэн холбоогоор бүртгэхгүй, уг хуульд заасан тухайн салбарын одоо байгаа мэргэжилтнүүд, аж ахуйн нэгжүүдийн зах зээлийн болон тооны олонх аль алиныг нь хангасан байдлаар мэргэжлийн нэгдсэн холбоог монополын эсрэг газрын дүгнэлтээр баталгаажуулж бүртгэнэ. Тэгэхээр аль нэг хүний карманы, аль нэг юуны гэдэг ийм холбоодод байхгүй. Бүгдээрээ нэгдэж нэгдсэн холбоо болсны дараа бүртгэх учраас энэ зөвшөөрлийн хуульд заасан энэ олон асуудлууд шийдэгдэхээр байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Боловсролын яам.

Ч.Баярмаа: Боловсролын яам, Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах шинжээч Баярмаа. Гишүүний асуултад хариулъя. Боловсролын ерөнхий хуулийг 2023 оны 7 сарын 7-ны өдөр шинэчилж баталсан. Ингэхдээ 20.1 дэх хэсэг буюу гишүүний асуусны дагуу 20.1.10 хүртэл нийт 26 баримт бичгийг тусгай зөвшөөрөл олгохдоо нэхсэн байна гэсэн ийм дүгнэлт гарсан байдаг. Энэ тусгай зөвшөөрөл олгохын тулд иргэн хуулийн этгээдээс шаардаж байгаа баримт бичгүүдийг цөөлөх шаардлагатай учраас Боловсролын ерөнхий хуулийн 20.1.3, 20.1.4, 20.1.5 дахь хэсгийг зохих техникийн зохицуулалтад заасан шаардлагад заасан баримт бичгийг

дахиж шаардах шаардлагагүй учраас хасах нь зүйтэй юмаа гэсэн ийм саналыг боловсруулсан.

Ж.Бат-Эрдэнэ: Болсон уу. Баасанжаргал гишүүн тодруулъя.

Х.Баасанжаргал: Дээд шүүхийн Дээд шүүх дээр бүртгэл явагдаж байхад үүсэж байсан хүндрэл нь юу байдаг юм бол? Тэрийг та хэд судалж үзсэн үү? Миний мэдэхийн жишээ нь Оёдлын 2 мэргэжлийн холбоог бүртгүүлэх гээд хоёулаа зэрэг хандсан байдаг. Энэ нь маш их маргаан дагуулдаг. Тэгэхээр яг энэ мэт ингээд яг бодит практик дээр гарч байсан хүндрэлүүдийг Дээд шүүх юу гэж тайлбарладаг вэ? Энэ дээр нэг хариулт хэлээдхээч.

2 дугаарт тэр боловсролыг би ерөөсөө ойлгосонгүй. Энэ зөвшөөрөл авахад одоо жишээ нь энэ биеийн тамирын заал, мэргэжлийн шаардлага хангасан хичээлийн байр энэ тэр гэдэг шаардлагуудаа хүчингүй болгоод байгаа юм уу, эсвэл энэ нь өөр газар заачихсан байгаа учраас давхардаад байна гээд хүчингүй болгоод байгаа юм уу гэдгээ тодорхой хэлээдхээч. Өөр хэрвээ газар заасан гэж байгаа бол хаана заасан байгаа вэ гэдгийг тодорхой хэлээдхэ. Тэр хүний эрхийн үнэлгээний хувьд бас ямар тайлбар хэлэх вэ? Судалгаа нь эсвэл хийгдсэн үү, хийгдээгүй юу? Яг хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн үү? Нэмээд дарга аа, нэг минутыг нэмээд авчихъя.

Ж.Бат-Эрдэнэ: Баасанжаргал гишүүнд нэг минут өгье.

Х.Баасанжаргал: Энэ хууль тогтоомжид хийгдэх хүний эрхийн үнэлгээ гэдгийг бид нар зөвхөн хүний эрхэд гарч байгаа хязгаарлалт гэдгээр ерөөсөө ойлгож болохгүй. Хүний эрхийн хууль зүйн баталгааг хангах дээр хамгаалах дээр гэж өргөн хүрээнд харах хэрэгтэй. Тэгэхгүй ингээд одоо ингээд хууль тогтоомжууд дээр дагалдаж орж ирж байгаа судалгаануудыг харахаар хүний эрхэд хязгаарласан заалт байхгүй байна гээд л бол оо, ганцхан өгүүлбэр бичээд байгаа байхгүй юу. Гэтэл жишээ нь наад зах нь энэ дагалдаж орж ирж байгаа хуулиуд дээр жишээ нь Боловсролын хуульд орж байгаа энэ өөрчлөлт чинь сурч боловсрох эрхийн баталгаанд яаж нөлөөлөх вэ гэдэг дүгнэлт байх ёстой гэсэн үг. Ингэж өргөн агуулгаар нь харах ёстой. Тэрнээс ганцхан заалтаар энийг ерөөсөө харж болохгүй гэсэн үг.

Тэгэхээр цаашид манай Их Хурлын тамгын газар ч гэсэндээ энэ хууль тогтоомжийн хуулийнхаа энэ заалтыг холбогдох үнэлгээг заавал хийдэг байх шаардлагаа нарийн тавиач ээ. Тэгэхгүй энэ мэтээр ингээд халтуурдаад яваад байх юм бид нар энэ хууль ингэж баталсны хэрэг гарахгүй ээ гэдгийг бас хэлье. Тэгээд дараа дараагийн хуулиуд дээр дахиж ийм байдлаар хуулийг оруулж ирмээргүй байна аа.

Ж.Бат-Эрдэнэ: Боловсролын яамнаас хариулах уу?

Ч.Баярмаа: Тодруулж хариулъя. Боловсролын ерөнхий хуулийн хуульд боловсролын сургалтын байгууллага байгуулах буюу боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд тодорхой, одоо орчин нөхцөлийн буюу стандарт хангасан байх тухай заасан байдаг. Энэ стандарт буюу шаардлагыг бол Засгийн газрын тогтоолоор батална гэж заасан. Энэ хичээлийн байр, номын сан, лаборатори, дадлагын газар, тоног төхөөрөмж, биеийн тамирын заал зэрэг

тавих шаардлагыг Засгийн газрын тогтоолоор техникийн шаардлагаар батлах учраас тусгайлж тусгай зөвшөөрөл дахиж шаардах нь буруу юм гэж үзэж байгаа юмаа. Давхардаж байгаа гэсэн үг үндсэндээ. Тусгай зөвшөөрлийг олгох хүссэн иргэн хуулийн этгээдээс Боловсролын ерөнхий хуульд 26 баримт бичиг шаардахаар байгаа. Үүнийг 8 болгож бууруулж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Яахаар болсон. Нэмэлт асуулт асуугаад байна. Юу еще тодруулаад байна? Лхагвасүрэнгийн Соронзонболд. Дээд шүүхээс хүн байгаа юм уу? Хариулъя. 4 номер. Өөрийгөө танилцуулаарай.

С.Тэнгис: Улсын Их Хурлын даргын зөвлөх Тэнгис. Улсын дээд шүүх бол Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргасан. Хүсэлт гаргасан хүсэлтийн агуулга нь бол бид ингэж ойлгож байгаа нь нөгөө Улсын дээд шүүх бол өөрөө тийм бүртгэлийн газар байх ёстой юу гэдэг асуудал ярьсан байна лээ. Тэгээд мөн түүнтэй холбоотой ялангуяа тэр олон холбоод гарч байна маргаан үүсгэж байна шүү дээ. Нөгөө ийм холбоо, манайх мэргэжлийн, танайх мэргэжлийн бус гээд ийм асуудлуудыг шийдвэрлэх юм нь шүүхээр шийдвэрлүүлээд тэр маргаан үүссэн тохиолдолд эргээгээд тэр маргааных нь нэг эцсийн хянан шийдвэрлэх газар нь Улсын дээд шүүх өөрөө учраас дараа нь тухайн бүртгэлтэй холбоотой ийм маргаан асуудал үүссэн үед бас нөгөө шүүх тогтолцооны энэ асуудал нь өөр өөртөө эргэж ингэж яах юм байж болзошгүй гэдэг ийм юу гаргасан юм байна лээ. Тэрнээс биш мэргэжлийн нэгдсэн холбоо чинь өөрөө Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасан эдийн засгийн үйл ажиллагааны салбар ангиллаар байгуулагдаж байгаа учраас тэрэн дотор бол тийм нарийн нарийн оёдлын нэг, хоёр.

Ж.Бат-Эрдэнэ: За Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууя.

Л.Соронзонболд: Энэ зөвшөөрлийн тухай хууль орж ирснээрээ ингээд дагаад 90 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт орохоор байгаа. Тэгээд ер нь нөгөө нэг энэ зөвшөөрлийг хараад байхаар энэ бүрдүүлэх бичиг баримт гээд нэлээн том хэсгийг бүх төрлийн зөвшөөрөл дээр эзлээд байдаг. Тэгээд тэрийг нь харахаар болохоор тэр нь төрийн байгууллагаас ч авах бүрдүүлэх бичиг баримт байна. Хувийн байгууллагаас ч авах бүрдүүлэх бичиг баримт байна. Яах вэ зүгээр би энэ дээр нөгөө энэ ажлын хэсгээс нэг асуух гээд байгаа зүйл юу байна гэхээр жишээлбэл одоо иргэн хүн байлаа гэхэд ямар нэгэн зөвшөөрөл өгсөнгүйгээр тэрийг нь төрийн байгууллагатай байгаатай холбоотой мэдээлэл байж болно. Эсвэл банкнаас дансны үлдэгдлээ авчир ч гэдэг юм уу эсвэл нэг лавлагаа ч байдаг ч юм уу ийм мэдээллүүд байгаад байгаа юм.

Тэгэхээр нөгөө Е-Монголиа аппликэйшнаараа дамжуулаад иргэн хүн тэр тухайн зөвшөөрлийн процесстой холбоотойгоор төрийн болон хувийн байгууллагаас өөрийнхөө хувь хүнийхээ нэр дээр авах гэж байгаа тодорхойлолт, лавлагаагаа энэ зөвшөөрөл өгөх гэж байгаа байгууллага руу явуулаад өгнө үү гэдэг ийм хүсэлтийг явуулаад тэр нь Е-Монголиагаар процесслогдоод автоматаар явдаг энэ хэсгийг ер нь одоо энэ Зөвшөөрлийн тухай хууль дээрээ хэр нарийн тусгасан бэ гэдэг нэг ийм асуулт байгаа.

2 дугаарт нь болохоороо байгууллагуудын хувьд бас адилхан. Байгууллагууд зөвшөөрөл хүсэж байгаа шүү дээ тиймээ. Тэгвэл байгууллагын хувьд жишээлбэл яг Е-Монголиа биш байлаа гэхэд тэр Е-бизнес гэж яриад байгаа тэр платформ чинь эдгээр энэ мэдээллүүдийг ингээд шууд автоматаар хоорондоо солилцоод өөрөөр

хэлбэл тухайн байгууллагыг тэр байгууллагад гаргасан ийм хүсэлтийн дагуу төрийн ийм байгууллагаас эсвэл ийм арилжааны, ийм банкнаас ч гэдэг юм уу эсвэл хувийн ямар байгууллагууд юм эсвэл тэр мэргэжлийн холбоодоос ч байдаг юм уу энэ зөвшөөрлийн хүсэлтийн дагуу бид нар энэ тодорхойлолт лавлагааг хүргүүлж байна гэдэг талаар ингээд ажилладаг ийм нэгдсэн ийм систем бий болгох тал дээр ажлын хэсэг маань ер нь хуулийнхаа төсөл дээр юу тусгасан байгаа вэ гэдэг ийм асуулт байна аа.

Ж.Бат-Эрдэнэ: Хассуурийн Ганхуяг сайд хариулъя.

Х.Ганхуяг: Ер нь Зөвшөөрлийн хууль 2022 онд батлагдсан хуулиар ер нь бид нар хэд хэдэн шийдэл оруулсан байдаг юм. Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийг барина гээд. Одоо төр төрд байгаа мэдээллийг нэхэхгүй байхаар хуульчилчихсан юм. Зөвшөөрлийн хуульд орчихсон байгаа. Гэтэл асуудал бас юу үүсээд байна гэхээр Зөвшөөрлийн хууль нөгөө нийтлэг харилцааг зохицуулдаг. Аль нэг салбарын хууль байвал салбарын хууль нь давамгайлж үйлчилдэг болохоор бид нар нөгөө тэр салбарын хуулиудаа бүгдийг нь хөндөх шаардлага үүсчхэж байгаа. Одоо бид нар энэ дагаж орж ирсэн байгаа энэ 80 хууль дээрээ тэр Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийг барих шаардлага нь тавигдана гэсэн үг.

Эдийн засгийн хөгжлийн яаман дээр хийгдэж байгаа цахим платформ бол үндсэндээ нөгөө хиймэл оюун ухааныг ашиглаж нөгөө иргэн төрд тэр аж ахуйн нэгж гэсэн хоорондын харилцааг нь зохицуулах бөгөөд төр нь төрд байгаа мэдээллээ нэхэхгүй байхаар ингээд процессоо эхлүүлдэг байхаар хуульчилчихсан байгаа, одоо хуульчлаад тэр платформ нь хийгдээд явж байгаа гэсэн үг. Тэгээд нэгдсэн мэдээллийн сан бас бий болно гэсэн үг. Тэгэхээр уг нь таны яг ярьж байгаа асуудал бүгдээрээ хуульд бол тусчихсан юм. Аль нэг одоо даган өргөн баригдсан байгаа нөгөө дагах хуулиуд ороогүй асуудлууд бий. Тэгээд тэрийг нь цөмөөрөө хэлэлцүүлгийн явцад оруулах шаардлагатай бол оруулаад тэгээд хуулийн хэрэгжилтийг нэхэж шаардах ёстой энэ Засгийн газраас.

Ж.Бат-Эрдэнэ: Соронзонболд гишүүн тодруулъя.

Л.Соронзонболд: Тэгэхээр ер нь Эдийн засаг хөгжлийн яам ийм нэгдсэн платформыг хөгжүүлж байгаа юм байна гэж ойлголоо тийм ээ. Тэгэхээр 2024 оны байдлаар ч юм уу Монгол Улсын хэмжээнд зөвшөөрөл хүссэн нийт хүсэлт ойролцоогоор хэд байсан? Тэр нь болохоор эдгээр нэгдсэн платформ ашиглалтад орсноор хэд болж хүсэлтийн тэр явцыг аль шатанд явж байгаа юм. Ямар байгууллагаас ямар мэдээлэл татсан юм ч гэдэг юм уу энэ мэдээллүүд нь ингэж сайжирснаараа энэ зөвшөөрлийн өгөх хурд тийм ээ одоо жишээлбэл өмнө нь зөвшөөрлийг дунджаар 30 хоногт өгдөг байсан бол тэр нь 5 хоног болох гээд байгаа юм уу, 2 хоног болох гээд байгаа юм уу тиймээ. Нөгөө мэдэгдлээр явдаг болсноороо ямар ямар давуу тал үүсэх гээд байгаа юм гээд нэг ийм статистик мэдээллийн хувьд тодорхой тийм төсөөлөл байна уу?

Ж.Бат-Эрдэнэ: Хаанаас хариулах вэ? 4 номер.

Т.Золзаяа: Эдийн засгийн хөгжлийн яам Золзаяа. Зөвшөөрлийн нэгдсэн сан хариуцсан ахлах мэргэжилтэн. Одоо бол Зөвшөөрлийн нэгдсэн сан нийт 190 гаруй мянган зөвшөөрлийн бүртгэл мэдээллийг хийчихсэн байна. Түрүүн асуултад нэмж хариулахад төрийн бусад мэдээллийн сангуудаас нийт 33 мэдээллийн сангуудаас

мэдээллийг авч байгаа, мэдээлэл солилцож байгаа. Тэгэхээр зөвшөөрлийг нь хэрвээ нэгдсэн сангаар явах юм бол нөгөө хугацаандаа олгодоггүй байдал ч гэсэн бүгдээрээ засагдаад ингээд явах боломжтой болж байгаа. Одоогийн байдлаар 371 зөвшөөрлөөс 90 гаруй 95, 96 хувийг нь цахим хэлбэрт шилжүүлчихсэн байна. Цаашид энэ хууль маань батлагдвал бас мэдэгдлийг цахим хэлбэрт шилжүүлэхэд бүх бэлтгэл ажлыг хангасан байгаа. Ярьж дууслаа.

Ж.Бат-Эрдэнэ: Соронзонболд гишүүн тодруулъя.

Л.Соронзонболд: Эдийн засаг хөгжлийн яамны хүмүүс тодруулчихъя. Тэгэхээр одоо тэр платформ чинь Е-Монголиа эд нар луу ингээд иргэн тал руугаа шууд холбогдоод өөрөөр хэлбэл нөгөө нэг Е-Монголиа эд нар чинь таны ийм мэдээлэл дээр ийм хүн ингээд ийм байгууллагаас ч юм уу хандаж мэдээлэл авсан байна гээд явдаг шүү дээ. Тэрэнтэй адилхнаар одоо жишээлбэл яах нь вэ. Тэр 371 зөвшөөрөлтэй холбоотойгоор нэгэнтэй нь холбоотойгоор таны мэдээлэл ингэсэн байна шүү гэдэг мэдээллүүд нь ингээд дамждаг энэ хоорондоо уялдаатай ажиллагаанууд нь хийгдэж байгаа юм байна гэж ойлгочихлоо. Зөв үү?

Ж.Бат-Эрдэнэ: 4 номер.

Т.Золзаяа: Бид нар угаасаа анхнаасаа системээ угсрахдаа бүгдийг нь яг ингэж бодож хийсэн. Тэгэхээр одоо иргэний мэдээллийг төрийн байгууллага татаж авсан байлаа гэж бодоход тухайн иргэний зөвшөөрөлтэйгөөр заавал татаж авч байгаа. Яг энэ хуулийнхаа Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хуулийг хангаж энэ систем маань хийгдсэн. Тэгээд тухайн зөвшөөрөл хүсэж байгаа иргэдээсээ аль болох төрд байгаа мэдээллээ авахгүй байхаар бид нар бүх программчлалынхаа асуудлуудыг бүүр шийдчихсэн байгаа шүү тийм. Одоо энэ мэдэгдлүүд нь бүгдээрээ хийгдээд явж байгаа. Арилжааны банкны мэдээллийг бол одоо ямар нэгэн зөвшөөрөл дээр одоохондоо бол шаардаж байгаа тийм юм оруулаагүй, хувийнхаа хувийнхдаа бол хийгээгүй байгаа. Зөвхөн төрд байгаа мэдээллээ бид нар шууд авдаг байдлаар зохицуулж хийсэн.

Ж.Бат-Эрдэнэ: Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Амьдрал ахуйгаа нөхцөлөө сайжруулъя, бас одоо бизнес хийе, ашиг орлого олъя гээд ингээд нэг жоохон үйл ажиллагаа явуулах гээд эсвэл хашаа хороондоо тог цахилгаан татуулъя, цэвэр, бохир ус татуулъя гээд. Ингээд хамгийн их тээг саад болдог чөдөр тушаа болдог асуудлууд манай техникийн нөхцөл олгодог 3 байгууллага байдаг. Дулаан, эрчим хүч, ус суваг. Ингээд энэ 3 байгууллага дээр хамгийн их энэ зөвшөөрлөө олгох гэж бөөн ар өврийн хаалга, хүнд суртал, жирийн иргэн бол очоод авна гэж байхгүй болсон. Дарга нараар, эрх мэдэлтэй хүмүүсээр, танил талтай хүнээр яриулж байж жирийн иргэн байхгүй болохгүй гээд байсан ийм хүмүүсээр яриулахаар өгчихдөг, дарга нар гуйхаар, танил талтай хүн гуйхаар өгчихдөг энэний цаана дандаа нэг бол эрх мэдэлтэй албан тушаалтнуудаар авхуулдаг, нэг бол хээл хахуулиар техникийн нөхцөлөө өгдөг.

Тийм учраас энэ хуулийн хүрээнд энэ 3 байгууллагыг бүүр онцолж энэ тусгай зөвшөөрөл, энэ зөвшөөрлүүдийг яаж хурдан шуурхай, ар өврийн хаалга хэрэглэдэггүй, танил талын нүүр дарга цэргээр яриулдаггүй байх ийм байдал руу орох юм бэ. Энэ хууль батлагдсанаар. Энийг нэг та бүхэн хариулж өгөөч.

Дараагийн нэг асуудал бол бизнест хамгийн их хүндрэл суртал болж байгаа асуудал гааль. Гаалийн бүрдүүлэлтийг хангана гэдэг үнэхээр энэ бизнес эрхэлж байгаа, импортоор оруулж ирж байгаа, экспортоор гаргах гэж байгаа энэ хувийн хэвшил, аж ахуйн нэгжид бол үнэхээр нэг хүндрэл суртал болчихсон. Тэгээд тэд нар нь бүүр ингээд өөгшүүлчихсэн. Гарыг нь алгыг нь дээш нь л харуулахгүй бол үйл ажиллагаа нь явдаггүй. Тэгээд хаа хаанаа бүүр тодорхой сурчихсан, өгөөд сурчихсан, аваад сурчихсан, өгсөн хүний ажил үйлчилгээ, зөвшөөрөл, гаалийн бүрдүүлэлт хурдан гардаг. Өгөөгүй хүнийх гардаггүй.

Саяын 3 байгууллага дээр мөн адилхан ингэж яриулсан хүмүүсийн ажил бүтдэг, яриулаагүй хүмүүсийн ажил бүтдэггүй, хамгийн тод жишээ энэ Авлига хороолол байгаа биз дээ. Энэний цаана дарга нар л өөрсдөө ярьсан байгаа шүү дээ. Зөвшөөрлийг нь өгсөн байгаа шүү дээ техникийн нөхцөлийг нь. Тэрнээс тэр компани өөрөө очоод барьчхаагүй шүү дээ. Хууль батлагдсанаар энэ асуудлуудыг яах вэ гэдгийг нэг асууя.

2-т энэ гэр хороололд энэ нэг 8 нэрийн дэлгүүрийн зөвшөөрөл гэж байгаа юмаа. 6 нэрийн зөвшөөрөл гэж байдаг. 6 нэрийн зөвшөөрлөөсөө ялгаатай нь архи, пиво, согтууруулах ундаа зарах болохоороо 8 нэрийн зөвшөөрөл болчихдог. Хуучин мянган айлын дунд нэг 8 нэрийн зөвшөөрөл байна гээд байж байсан, сүүлдээ 500 болж хувирсан. Энэ хууль батлагдвал одоо энэ асуудал байхгүй болох уу? Хүсэлт гаргасан хүн болгон хувийн хэвшил болгон 8 нэрийн дэлгүүрээ нээгээд явж болох уу? Энэний цаана нөгөө архидалтын асуудал гардаг юм. Цагдаагийн байгууллага энд их дургүй байдаг юм. Архи согтууруулах ундаагаар үйлчилдэг цэгийн тоо нэмэгдлээ гээд их дургүй байдаг юм. Энэ хууль батлагдахаар энэ асуудлууд, энэ зөвшөөрөл юмнууд ямар ч хараа хяналтгүй болоод, дур дураараа мэдэгдлээ өгөөд 8 нэрийнхээ зөвшөөрөл дэлгүүрүүдийг нээгээд явах бололцоо боломж бүрдэх юм биш үү. Энийг юу гэж харж байгаа вэ? Энэ дээр нэг хариулт өгөөч. Дараа нь ахиад асуултаа тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? За 4 номер.

Т.Золзаяа: Эдийн засгийн хөгжлийн яам Золзаяа. Зөвшөөрлийн цахим системийг бид нар программчлахдаа угаасаа нөхцөл шаардлагыг нь хангаж байна уу, үгүй юу гэдгийг жишээ нь шалгадаг тийм функцүүд хийгдсэн байгаа. Жишээлэх юм бол татварын өртэй эсэх, нийгмийн даатгалаа төлж байна уу, үгүй юу. И баримт хэвлэж байна уу, үгүй юу, энэ болгоныг нь цахим системээр хяначхаж байгаа юм, шалгачхаж байгаа юм.

Тэгэхээр энд бол ямар нэгэн байдлаар тухайн зөвшөөрлийг олгодог эрх бүхий этгээдийн тэр субъектив хандлагууд тодорхой хэмжээнд буурна. Мэдээж хэрэг бүх шалгуурыг бид нар жишээ нь цахим системээр хянах боломжгүй тэгэхдээ боломжит бүх түвшинд нь тэрийг цахим болгоод ингээд явж байгаа. 8 нэрийн барааны дэлгүүрийн хувьд гэх юм бол мэдэгдлээр эрхэлнэ. Тэгэхдээ согтууруулах ундаагаар худалдах түүгээр үйлчлэх байх юм бол заавал тухайн зөвшөөрлийг авдаг хэвээрээ байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Тэгээд яах вэ ер нь бол цаашдаа энэ зөвшөөрөл олгодог байгууллагуудын үйл ажиллагааг цахимжуулах л хэрэгтэй байгаа юм л даа. Хүн олгож байгаа тохиолдолд тэр ар өврийн хаалга, танил тал, хээл хахуулийн асуудлууд ер нь буурахгүй. Энэ бүх асуудлуудыг хүний үйл ажиллагаанаас хараат бусаар тэгээд техникийн дэвшил технологи ашиглаж энэ зөвшөөрлүүдийг олгоод, тэр одоо шаардлагыг нь л хангачихсан байвал хэн байхаас үл хамаараад л олгодог байх асуудал руу л шилжих ёстой. Тэгж байж энэ түргэн шуурхай байх, алагчилдаггүй байх, ар өврийн хаалга хэрэглэдэггүй байх, танил тал гэж ярьдаггүй байх, хөөцөлддөггүй байх ийм асуудлууд чинь энэний цаана цэгцрэх ёстой л гэж бодож байгаа. Тэгээд цаашдаа энэ төрийн гол үйлчилгээний байгууллагууд энэ зөвшөөрлийг цахимаар олгодог байх, цахимжуулах асуудал руу бушуухан шилжүүлж байж энэ асуудал нэг мөр шийдэгдэнэ. Тэрнээс өнөөдөр энэ хууль батлагдангуутаа асуудал би шийдэгдэхгүй юм байна гэж ойлголоо. Зөв үү?

Ж.Бат-Эрдэнэ: Хассуурийн Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Сандаг-Очир гишүүн яг л зөв асуудлыг хөндөж байна. Ер нь тэгээд Зөвшөөрлийн хууль дээр ингээд бүгдийг нь цахимжуулахаар мэдээллийн нэгдсэн баазтай болохоор мэдээлэл технологи энэ тэр бид нар нэг 4 багц хууль баталж байсан шүү дээ. Нөгөө Мэдээллийн ил тод байдлын хууль, Хувь хүний нууцын тухай хууль гээд тэрийг бүгдийг нь хооронд нь уялдуулсан байдлаар Зөвшөөрлийн хуулиар бүгдийг нь оруулахаар хуульчилчихсан байгаа.

Мөн Смарт Говермент-2 гээд Дэлхийн банкны төслөөр энэ цахимжуулах асуудлыг нь санхүүжилтийг нь шийдчихсэн байгаа. Тэгээд одоо бол цаг хугацааны асуудал бид нар жоохон шахаж явах ёстой. Золзаяа дарга бас хурдан ажиллах хэрэгтэй. Тэгж байж цахимжуулж байж л ер нь энэ хүнд суртал гэдэг юм чинь энэ Зөвшөөрлийн хуулийн үр дүн нь гарах юм байгаа юмаа. Санал нийлж байна аа.

Ж.Бат-Эрдэнэ: Жамбын Батсуурь гишүүн алга байна, Бадарчийн Хэрлэн гишүүн алга байна, Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн алга байна, Жуковын Алдаржавхлан гишүүн асуулт асууя.

Ж.Алдаржавхлан: Анх ер нь зүгээр нэг ийм юмыг манай ажлын хэсгийнхэн анхаармаар юм байна лээ. Яг тусгай зөвшөөрөл өгдөг хүнээс илүү тэр тусгай зөвшөөрлийг бүрдүүлэх материалууд чинь өөрөө хүмүүсийг их зовоож байгаа юм Ганхуяг дарга аа. Энийг хэдүүлээ хуульдаа тусгаж өгмөөр байна. Жишээ нь одоо надад иргэдээс ирсэн хамгийн их том гомдлууд юун дээр байна вэ гэхлээр ингэж ярьж байгаа. Жишээ нь 8 нэрийн бараа ч юм уу, янз бүрийн ресторан, цайны газар ажиллуулах гэхлээр тэр Эрүүл мэндийн газраас, Хүнс, хөдөө аж ахуйн газраас ажлын байрны дүгнэлт гэж нэг айхтар юм авдаг гэнэ ээ. Ажлын байрны дүгнэлтийг авахын тулд тэр ганцхан байцаагчийг маш удаан хүлээдэг юм байна. Маш удаан хүлээдэг, цаг завьг нь хардаг, 30 хоног хүлээдэг, 14 хоног хүлээдэг, тэгээд тэр хүнийг машинаар очиж авдаг, буцаагаад хүргэж өгдөг ийм их тийм нөгөө нэг тусгай зөвшөөрлөөсөө илүү түүнийг бүрдүүлэх материалын жагсаалт гэж энэ аймшигтай хүнд суртал байна аа. Энийг яах юм бэ? Энэ асуудлыг нэг тийш нь болгохгүй бол одоо жишээ нь тэр архины зөвшөөрөл авахад галын аюулгүй байдлын дүгнэлт, ажлын байрны дүгнэлт, дүрс бичлэгийн тодорхойлолт гэх мэт материалыг бүрдүүлэх гэж 3-4 сар болдог гэж байна.

Тэгэхээр энэ юмнуудыг хэдүүлээ нэг цахимжуулж шийдэхгүй бол иргэдийн асуудал шийдэгдэхгүй юм байна лээ. Зөвхөн тусгай зөвшөөрөл өгдөг хүн рүү бид нар онилоод байдаг. Гэтэл тэр материалыг бүрдүүлэхэд оролцдог албан тушаалтнуудын асуудлыг бид нар огт ярихгүй байна. Энийг одоо энэ хуульдаа оруулж өгөөч ээ гэж.

2 дугаарт нь би Байнгын хороонд ярьсан. Энэ зөвхөн тусгай зөвшөөрөл өгдөг тэгээд хянадаггүй энэ 2.3 байгууллагын асуудлыг энэ хуулийн хүрээнд нэг тийш нь болговол яасан юм. Тэр Усны зохицуулах хороо гэж орон сууцын конторын зөвшөөрөл өгдөг. Тэгээд ус алдах, бохир алдах ийм асуудал үүсвэл тэр байгууллага огт оролцдоггүй. Нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газар, хотын ерөнхий менежер гээд улсууд аваарын байдалтай очоод ажилладаг. Нөгөө контор нь сайн муу ажиллаж байгааг тэр нийслэл дүүрэг дүгнэх эрх байхгүй. Ганцхан тэр тусгай зөвшөөрөл олгодог зөвхөн нэг ийм цаасан дээрх шахуу байгууллага л дүгнэдэг. Тэд нар хэзээ ч иргэдийн төлөө явдаггүй. Энэ усны зохицуулах хороо гэдэг байгууллагын асуудлыг нэг тийш нь болгомоор байна.

2 дугаарт Эрчим хүчний зохицуулах хороо гэж энэ бид нар чинь одоо эрчим хүчний хомсдолтой байгаа иргэд эрчим хүчнээ өөрсдөө үйлдвэрлэе гэхлээр элдэв хориг тавьдаг, элдэв тусгай зөвшөөрлөөр саад хийдэг энэ байгууллагын асуудлыг нэг тийшээ болгохгүй юм уу? Зөвхөн эрчим хүчний үнэ нэмэхээр гарч ирдэг бусад үед ингээд нам тайван алга болоод зөвхөн тусгай зөвшөөрлийг үйлдвэрлээд сууж байдаг ийм байгууллагуудын асуудлыг энэ хуулийн хүрээнд би шийдэх саналыг тавьж байгаа. Ялангуяа тэр Усны зохицуулах хороо гэж тэр нийслэл юм уу, аймгийн харьяанд байх ёстой юм байна лээ. Яг иргэдийнхээ хажууд байх ёстой тэр байгууллага нь. Тээр хол суучхаад зөвхөн зөвшөөрөл нь өгдөг асуудал болохоор огт оролцдоггүй ийм байна аа. Энэ 3 асуудал дээр нэг хариулт авмаар байна.

2 дугаарт нь хамгийн сүүлчийнх нь тэр Барилгын яамныхан байвал энэ Барилгын яам чинь хамгийн түрүүнд нөгөө бүх тусгай зөвшөөрлөө мэргэжлийн холбоонд шилжүүлсэн. Тэрийг шилжүүлснээр хэдэн хүн албан тушаалаасаа чөлөөлөгдөж, хэдэн орон тоо хэмнэгдсэн бэ? Тэр ер нь үр дүнтэй болсон уу, үгүй юу? Эсвэл ецө их хүндрэл учруулсан уу? энийг Барилгын яамныхан нэг хариулж өгөөч. Одоо жигтэйхэн шилжүүлсэн гэсэн. Зарим хүмүүс энэ их муу болсон гэж ярьдаг. Зарим хүмүүс болохлоор энэ их гоё байгаа гэж ярьдаг. Энийг энэ дээр Барилгын яамныхан нэг тайлбар өгөөч. За ийм 4 асуулт байна.

Ж.Бат-Эрдэнэ: Шадар сайд Хассуурийн Ганхуяг хариулъя.

Х.Ганхуяг: Усны хороо бол одоо юуны Барилга, хот байгуулалтын яамны харьяа юм байна. Тэгэхээр яг л нөгөө түрүүн яриад байгаа шиг бид нар энэ салбар хуулиуддаа энэ юмнуудаа шигтгэж өгөх ёстой юм. Одоо жишээлбэл усны хороог энэ орон нутгийн удирдлагын харьяа байна гэдгийг нь салбар хуульд нь хийж өгөх ёстой гэсэн үг. Учрал Их Хурлын дарга, Заяабал гишүүн бид 3-ын хувьд энэ хуулийг санаачилж байна гэсэн үг. Санаачлаад Улсын Их Хурал хэлэлцэх эсэх гээд явчих юм бол ажлын хэсэг байгуулагдаад явна гэсэн үг. Тэгэхээрээ таны хэлж байгаа агуулга хэрэвзээ шаардлагатай бол тэр салбар хуульд нь шигтгэх асуудлыг ажлын хэсгийн түвшинд хийчхэж болох байх гэж бодож байна.

За ажлын байрны дүгнэлт болон баталгаажуулалтын асуудлыг Зөвшөөрлийн хуулиар яаж зохицуулж байгаа вэ гэхээр 1 дүгээрт бол яг ажлын 22 хоногийн дотор

зөвшөөрлийг процессыг дуусгана гээд орсон байгаа угаасаа дуусгана гээд. Тэрэн дотроо тэр нөгөө бүрдүүлгийг нь хангаж байгаа эсэх гээд нэг ажлын 5 өдрийн дотор яг нөгөө баталгаажуулалт болон дүгнэлт гараад эцсийн зөвшөөрөл гартлаа одоо яг тэр 10 хэдэн хоногийн дотор хариу нь гарчихсан байх ёстой юм. Одоо яг хуульд ингэж орсон байгаа.

Жижиг дунд бизнес эрхлэх одоо ярьж байгаа энэ дэлгүүр эрсдэл багатай үйл ажиллагаа боловч гээд энд тэндээс асар олон дүгнэлт авдаг юмнуудыг халахын тулд л одоо энэ мэдэгдэл гэдэг томъёог оруулж ирж байгаа юм. За мэдэгдлээ явууллаа. Үйл ажиллагаа эхлүүлчих ээ. Тэгээд тэр мэдэгдэл явуулснаас хойш тэр баталгаажуулалт хийдэг байгууллагууд нь хойноос нь нөхөж ирээд баталгаажуулалтаа хийнэ гэсэн үг. Одоо тэр ажлын байрны дүгнэлтээ өөрөө ирээд гаргана гэсэн үг. Тэгэхээр тэрэн дээр бол одоо үйл ажиллагаагаа эхлүүлэхдээ тэд нарыг хүлээхгүйгээр шууд эхлэх боломжийг нь олгож байгаагаараа ялгаатай юм. Тэгээд Барилгын яамтай холбоотой асуудлыг Барилгын яам.

Ж.Бат-Эрдэнэ: Барилгын яамных.

Д.Батзориг: Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны хэлтсийн дарга Батзориг. Анх бол Барилгын хөгжлийн төв бол барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг бол хариуцаж хэрэгжүүлж байсан. Манай яамнаас 2018 оноос эхэлж Барилгын үндэсний ассоциаци төрийн бус байгууллагууд буюу одоо 8 төрийн бус байгууллагын түншлэлд бол тусгай зөвшөөрлөө шилжүүлсэн байгаа. Тухайн үедээ Барилгын хөгжлийн төв дээр нэг цэгийн үйл ажиллагаанд 10 гаруй хүн ажиллаж байсан. Өнөөдрийн байдлаар Барилгын үндэсний ассоциаци дээр 5 хүний бүрэлдэхүүнтэй нэг цэгийн үйл ажиллагаа ажиллаж байна. Мөн одоо энэ ондоо манай салбар бол Лайсенс.мн рүү барилгын тусгай зөвшөөрлөө шилжүүлснээрээ бол Е-Монголиатай бүрэн холбогдох ийм зохицуулалтууд хийгдсэн байж байгаа.

Мөн Усны зохицуулах хороотой холбоотой нэмэлт тайлбар өгье гэж бодож байна. Усны зохицуулах хороо нь ус хангамж ариутгах татуургын холбогдох хууль тогтоомжийнхоо хүрээнд ийм эрх үүрэгтэй ажиллаж байгаа байгууллага байгаа. Дэлхийн 128 улс оронд бол яг ийм чиг үүргийн аж ахуйн байгууллагууд үйл ажиллагаа явуулдаг. Энэ.

Ж.Бат-Эрдэнэ: Дахиж гүйцэд хариулъя.

Д.Батзориг: Энэ байгууллага нь мэдээж тусгай зөвшөөрөл олгох чиг үүргээс гадна дахиад өөр чиг үүргүүд мөн давхар хэрэгжиж байгаа. Гэхдээ энэ тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлынх нь хүрээнд бол өнөөдөр яг Зөвшөөрлийн хуулиар 14 зөвшөөрөл олгож байгаа юм байна лээ. Энэ зөвшөөрлүүдийн тоог бол багасгах бас боломжууд бол байгаа гэж харж байгаа. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Алдаржавхлан гишүүн тодруулъя.

Ж.Алдаржавхлан: Миний дүү худлаа ярьж байна аа. Тэр усны зохицуулах хороонд чинь би дүүргийн Засаг дарга байсан хүн. Орон сууцны конторууд дээр иргэд маш их гомдол гаргадаг. Тэгээд энэ конторуудынхаа асуудлаар хариуцлага тооцооч гэж Усны зохицуулах хороонд хандахад огт хөдөлдөггүй тийм байгууллага байдаг байхгүй юу. Тэд нар тэр контороо ерөөсөө араас нь явдаг ч үгүй, хяналт

тавьдаг ч үгүй, шахаж шаарддаг ч үгүй. Одоо жишээ нь нэг байгууллагын нэг орон сууцны хорооллын шугамыг солих ёстой конторын үйл ажиллагааг тэрийг солих шаардах эрх нь Усны зохицуулах хороонд байгаа юм. Нийслэл, дүүрэг шаардахлаар тэр нөгөө лицензийг нь нийслэл өгдөггүй болохоор тэд нар чинь нийслэлтэй харьцахгүй л байгаа юм л даа. Тэгэхээр усны зохицуулах хороо бол тэрийг өгөх шаардлага байхгүй. Болдог бол нийслэл нь өөрөө тэр тусгай зөвшөөрлийг нь өгөөд, тэгээд тэрэнтэйгээ хариуцлага тооцдог байхгүй бол иргэдээс тавьж байгаа шаардлага хэнд очдог гэвэл нийслэлд очиж байгаа юм. Энэ шугамаа сольж өгөөч.

Ж.Бат-Эрдэнэ: Болсон уу. Санал хэллээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Чуулганы нэгдсэн хуралдааныг 14 цаг хүртэл завсарлуулж байна аа.

ЗАВСАРЛАГА

Н.Учрал: Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаан эхэлж байна. Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Ерөнхий сайдаас урьдчилан хүргүүлсэн асуултын дагуу асуулт асууж, хариулт авах Улсын Их Хурлын асуулгын цаг эхэллээ. Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл, Монгол Улсын ерөнхий сайд Гомбожавын Занданшатар нарыг тусгайлан бэлтгэсэн индэрт урьж байна аа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.6-д заасны дагуу Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл Монгол Улсын Ерөнхий сайдад урьдчилан хүргүүлсэн асуултыг тавьж мэтгэлцэнэ. Бүлгийн цуварсан асуултын тоог 9-өөс хэтрүүлэхгүй асуулт асууж хариулт авах нийт хугацаа 37 минут 30 секундээс хэтрэхгүй байна гэсэн дэгийн хуулийг баримтална аа.

Ингээд асуулгын цаг эхэллээ. Цогтгэрэл даргын микрофон.

Н.Учрал: Гишүүддээ үдээс хойшийн мэндийг хүргэе. Ээлжит Улсын Их Хурлын асуулгын цаг эхэлж байна. Энэ удаагийн Улсын Их Хурлын асуулгын цаг дээр АН-ын бүлгээс сэдэв өгөхдөө унасан эдийн засаг, уруудсан итгэл гэдэг ийм сэдвийг өгсөн. Яагаад бид нар ингэж ярих болчхов оо? Шинэ Засгийн газар бүрэлдээд өмнөх асуулга дээр мэтгэлцээнүүд дээр 100 хоног ажил хийх хугацаа болоогүй гэдэг зүйлсүүд яригддаг байсан. Одоо ажлын эхний үр дүнгүүд нэлээн үр дүнгүүдийн тухай ярих боломжит буюу хагас жил өнгөрч байна. Энэ бага биш хугацаа. Тэгэхээр энэн дээр маш олон зүйлүүдийг бид нар манай гишүүд ч гэсэн бид нар өнгөрсөн цаг хугацаанд дүгнэх боломжтой олон олон зүйлүүдийг ярьж болно оо. Шинэ Ерөнхий сайд, шинэ Засгийн газар бүрдэхдээ олон нийтэд баялгийн хулгайтай тэмцэнэ. Унаж байгаа уруудаж байгаа эдийн засгийг унах гэж байгаа эдийн засгийг өсгөнө босгоно гэж олон олон зүйлд итгэл найдвар төрүүлсэн.

Гэтэл энэ бүхэн чинь улам алсарч одож байна аа. Өнөөдөр бид нар хэдүүлээ нийлээд тал талаас нэг дэд сайдын хэрүүл хийж байна. Энэ бол зөвхөн дэд сайдын асуудал биш ээ. Эдийн засаг чинь унаад байна, иргэдийн чинь итгэл уруудаад байна. Энэний чинь мөсөн уулын орой нь зөвхөн энэ жижигхэн зүйл байгаа шүү. Энэний цаана том зүйл байгаа гэдэг хүрээнд энэ асуудал өргөн баригдаж тавигдаж улс төрийн асуудал болоод явж байгаа гэдгийг ойлгож байгаа байх гэж бодож байна. Тэгэхээр эхний асуудал яагаад энэ ард иргэдийн итгэл унаад байна вэ? Энэний нэг нь та хууль хэрэгжүүлэх ёстой, хууль сахиулах ёстой субъектийг төлөөлж байгаа

хүний хувьд өнгөрсөн хугацаанд хэчнээн албан тушаалтныг авлига албан тушаалын хэргээр шийдвэрлэж шүүхэд шилжүүлсэн бэ? Баялгийн хулгайтай тэмцэх чиглэлээр. Энэ бол эхний үр дүн гарах ёстой хагас жилийн хугацаа.

Н.Учрал: Ерөнхий сайд.

Г.Занданшатар: Унасан эдийн засаг уруудсан итгэл гэж үнэн үнэн. Үнэхээр хамтарсан Засгийн газар ажилласан 2025 оны 6 дугаар сар хүртэл эдийн засаг унаж, эдийн засгийн өсөлт 2.4 хувь болж унасан байсан. Валютын ханш өсөөд 4 мянга руу хүрэх эрсдэлтэй болчихсон байсан. Төсвийн орлого дутагдаад долларын ханш 4 мянгад давах инфляц 15 хувь хүрэх тийм тооцоололтой байсан. Тэгвэл энэ улсын эдийн засаг сэргэсэн. Мэдээж инерцээрээ яваад одоо хүндрэлтэй нь бид нар нүүр тулж байна аа. Өнгөрсөн жил хүнд жил байсан, хөөс хагарч үнэтэй тулсан жил байсан. Ирэх жил ч гэсэн хүндрэлтэй жил байна. Дэлхийн эдийн засаг ийм байна. Нүүрсний үнэ 2.3 дахин 2.3 жилийн өмнөхөөс 4 дахин шахуу уначихсан байна.

Тийм учраас үнэнтэй тулсан жил бол энийг эрс шийдэмгий бодлогуудыг хэрэгжүүлсний үр дүнд энэ авлигатай тэмцсэний үр дүнд хэдий хэрэг хаашаа шилжсэнээсээ илүү энэ бодит үр дүнд эдийн засгийн өсөлт өнөөдрийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 6.5 хувь болж өсөх дүнтэй байна. 6 хувьд давах нь үү. 5.9 хувь байсан. 6.4, 6.5 хувьд хүрнэ. Долларын ханш 3600 давчихсан байсан. Одоо 3550 төгрөг болж буурсан. Төгрөгийн ханш маань чангаллаа. Инфляц өнөөдөр 8.2 хувь болж 15 хувь хүртэл өсөж байсан. Инфляц буурлаа. Энэ нөгөө тоо худлаа хэлдэггүй гэж баримтууд энэ авсан арга хэмжээнүүдийн чинь үр дүнд эдийн засаг сайжирч байгаа статистикийн бодит тоонууд. Бүүр дотоодын статистикийн тоо маань ийм байхаасаа гадна дэлхийн Монгол Улсыг үнэлээд дэлхийн нэр хүндтэй мүүдис агентлаг, Стандарт энд пүэрс агентлагууд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг B2-B1 тогтвортой ангилал руу шилжүүллээ.

Стандарт энд пүэрс агентлаг 10 дугаар сарын 25-ны өдөр Стандарт Энд пүэрс манай зээлжих зэрэглэлийг B плас болго.

Н.Учрал: Шилжээд явах ёстой Цогтгэрэл даргын микрофоныг өгье.

О.Цогтгэрэл: Тийм би унасан эдийн засгийн тухай асуултуудыг үргэлжлүүлээд асууна аа. Бид яагаад та иргэдийн итгэлийг уруудуулаад байна вэ гэдэг дээр би эхэлж асуусан. Тодорхой асуулт. Өнгөрсөн 6 сарын хугацаанд авлига, албан тушаалтай холбоотой, баялгийн хулгайтай холбоотой хэдэн хэргийг танай Засгийн газар хууль сахиулах байгууллага шүүхэд шилжүүлсэн бэ гэдэг асуудлыг л ярьсан. Ийм учраас наад ард иргэдийн чинь итгэл унаад байна гэж дахиад л яг энүүнтэй холбоотой өнгөрсөн 7 хоногт танай Засгийн газрын Хууль зүйн сайд хэлж байна лээ. Зарим хүмүүсийг том хулгайд холбогдсон хүмүүсийг хилээр гараад явчихсан эсэхийг асууж байна лээ. Энийг та нар хэн нэгэн хүнээс асуух биш тэр хил хамгаалах байгууллага чинь Засгийн газрын харьяа байгууллага. Та нар ард иргэдийн итгэл хүлээлт дээр гарч ирчхээд одоо битгий ингэж хоорондоо жүжиг тавьж бай. Хэн хилээр гарсан орсныг Монгол Улсад хэн биш та нар мэдэж байх ёстой. Тэр тусмаа би танд баримттай нь харуулъя.

2025 оны 10 дугаар сарын 17 оны чуулган дээр та хэлж байсан байна. Би хулгайтай эвлэрэх гэж тэмцээгүй. Би хулгайтай хамт унах гэж тэмцээгүй. Хулгайч би хулгайтай эвлэрэхгүй гэсэн. Гэтэл яг одоо нөхцөл байдал дээр дээр саяын

асуудлууд чинь бүх зүйл хэвээрээ та бүхэн олон нийтэд олон нийтийн өмнө ингээд жүжиглэлтийн байдал руу л орчихсон. Яг саяын хэлсэн тэр баялгийн хулгайчид дээр яг ямар бодлого тиймээ барьж бид асуултаа дахиад асууя. Хэдэн хэрэг шүүхэд шилжсэн бэ? Тэр хулгайчидтайгаа хариуцлага тооцож чадах юм уу чадахгүй юм уу? Үргэлжлүүлэн жүжиг тавих юм уу?

Н.Учрал: Ерөнхий сайд.

Г.Занданшатар: Авлигатай, хулгайтай тэмцэх ажил үргэлжилж байгаа. Өргөс авчихсан юм шиг нэг өдөр ингээд тоогоор хэмждэг үзүүлэлт биш ээ. Харин тэднийг өмгөөлөөд хамгаалаад байдаг л газрууд нь л асуудал байна гэж хариулья.

Тухайлбал өнгөрсөн жилүүд 58 хэргийг шүүхэд шилжүүлж, авлига, албан тушаал, баялгийн хулгайтай гэмт хэрэг илрүүлнэ. Саяхан хүртэл энэ АМХЭГ-ын даргаар ажиллаж байсан хүн Олон овоотын гэдэг 16 мянган кг алттай Монгол Улсын чухал алтны нөөцтэй ордыг хулгай хийгээд өгчихсөн байсныг илрүүлээд шалгаж байна. Ийм олон жишээг би дурдаж болно. Тэгэхдээ энэ шүүх хурлын танхим биш. Парламентын мэтгэлцээний танхим. Тийм учраас энэ хэрэг явдал ярихаасаа илүү бид унасан эдийн засаг, уруудсан итгэл юунаас болоод байгаа юм энэ авлига хулгай хаанаас гараад байгаа юм. Энийг язгуураар нь устгахын төлөө хийж байгаа тэмцэл ажлууд тууштай үргэлжилж байгаа. Хууль хяналтын байгууллагууд шүүх засаглалын эрх мэдлийг парламент шүүж аль эсвэл гүйцэтгэх засаглал шүүдэггүй. Гэхдээ улс төрийн хүсэл эрмэлзэл, манлайлал, авлигатай тэмцэх, тухайлбал баялгийн хулгайтай тэмцэх ажлууд тууштай үргэлжилж байгаа.

Олон арван хэргүүд шалгагдаж байна. Энэ талаар тусад нь ярилцвал хууль хяналтын байгууллагуудтай хаалттай хэлэлцээд тодорхой мэдээллүүдийг өгч болно оо. Ер нь энэ авлига хээл хахууль баялгийн хулгай нэг өдөр бий болчихсон. Тэрийг нэг өдөр ингээд өргөс авчихсан юм шиг засаж залруулдаг зүйл биш юм байна. Бүх шатад байна. Ийм учраас энэ язгуураар нь арилгахын тулд бид нар одоогийн байдлаар 2 их наяд төгрөгийн холбоотой үл хөдлөх хөрөнгө лиценз асуудлуудыг битүүмжлэх шалгах ажиллагаа явуулж байгаа. Энэ талаар нэхэмжлэл гаргаж байгаа. Тухайлах юм бол сая одоо үүсмэл ордууд болон стратегийн ордуудыг Засгийн газар ард түмний мэдэлд шилжүүлэх тодорхой ажлуудыг яг хэрэгжээд явж байхад л ингээд.

О.Цогтгэрэл: Энд ямарваа нэгэн хаалттай мэдээлэл ажил хийж байгаа тухай хаалттай мэдээлэл элдэв зүйл хэрэггүй. Энэ жинхэнээсээ та нар уриа лоозон биш жүжиг тавих биш. Жинхэнээсээ энэ авлига, ашиг сонирхлын хэрэгтэйгээ баялгийн хулгайтайгаа тэмцэх шаардлагатай. Ийм учраас энэ ард иргэдийн чинь итгэл унаад байна аа.

Хоёрдугаарт нь би нэг эдийн засагтай холбоотой ганц 2 асуултыг тэр унасан эдийн засагтай холбоотой асууна аа. Энэ нь манай ДНБ-д эзлэх татварын ачааллыг 35 орчим хувь гэж тооцдог. Яг энэ харьцаа GDP энэ тэр төсөв биш шүү. Татварын ачаалал 35 хувь. Яг энэ харьцааг коммунист Хятад улсад 22 хувь байдаг юм байна буюу дотоод бид нар бараг 60.70 хувиар Хятад Улсаас илүү ард иргэдээсээ, бизнес эрхлэгчдээсээ ийм татвар авч байна л гэсэн үг. Бодит нөхцөл байдал дээр өнөөдөр гучаад мянган ААН чинь дансаа хаалгасан. 6, 7 их наядаараа өрөнд орчихсон. Эдийн засаг яг ийм байна. Тэгэхээр эндээс асуулт байгаа нь энэ ААН-үүд чинь ашигтай ажиллаад ашигтай ажилласан мөртөө татвараа өгөхгүй байгаа учраас

хааж байгаад дарамталж байгаад авах ёстой гэж үзэж байна уу? Аль эсвэл эдийн засгийн тогтолцоо маань болохгүй байна гэж үзэж байна уу? Аль нь юм? Ашигтай ажиллачхаад тэд нар татвараа өгөхгүй байгаад байгаа юм уу. Аль эсвэл тогтолцоонд байна уу? Та эхлээд энийг нь хариулаад өгөөч.

Г.Занданшатар: Ер нь татварын тогтолцооны шинэчлэл хийхээр татварын багц реформыг барьчихсан. Аль алинд нь байгаа гэж үзээд энийг засан залруулахаар өгсөн. Ер нь гучин хэдэн мянга биш л дээ. Сүүлийн статистик тоогоор 23 мянга орчим ААН-ийн данс хаагдсан байсныг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд чиглэл өгөөд татварын багц хууль өргөн барьсантай холбогдуулаад бүгдийг нь нээсэн. Өнөөдрийн байдлаар 4300 нэгж, 4368 ААН-ийн дансыг нээгээд байна. Ингээд эрсдэлтэй холбоотойгоор ААН-үүдийн татварын данс хаагдсан явдлуудыг зогсоож байгаа. Одоо өргөн барьчихсан байгаа Татварын багц хуулиар өргөн барьж байгаа Татварын багц хуулиар өргөн барьчихсан багц хуулиар. Татварыг нөгөө албадлагын шинж чанартай дарамталдаг, данс хаадаг тогтолцооноос илүү зөвлөн туслах хэлбэр рүү шилжүүлж байгаа. Үзэл санааны философи нь. Одоо бизнес эрхлэхэд нь, зөвшөөрөл авахад нь ААН-үүдээ дэмждэг, тайлан баланс гаргахад нь дэмждэг. Асуудлыг нь шийдэхэд тусгадаг, зөвлөдөг хэлбэр рүү шилжүүлж зөвлөн туслах хэлбэрээр татварыг барагдуулдаг, бизнесийнх нь үйл ажиллагааг дэмждэг ийм тогтолцоо руу шилжүүлэх ийм өөрчлөлтийг Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлж хэлэлцүүлж байна.

Ийм учраас манай эдийн засгийн тогтолцооны энэ 30 жилийн гажуудлыг ч татварын тогтолцооны 30 жилийн гажуудлыг энэ хуулиудаар засаж, ололт, амжилттай сайн талуудыг нь тодотгож чангатгах хэрэгтэй.

Тэгэхдээ таны тоо статистикууд алдаатай байна. Хятадын миний санаж байгаагаар Хятадын татварын ачаалал 20 хувь биш, нийт бизнес ДНБ-тэй Европын улсуудад бүр 40 хүрдэг улсууд ч байна. Скандиновын орнууд дээр ч юм уу. Тийм учраас татварын GDP, ДНБ-д оногдуулдаг төсвийн зарлагын эзэлдэг хувь хэмжээгээрээ ялгаатай. Энэ болгон улс орон бүр ялгаатай. Улс орон болгон эдийн засгийн бүтцээрээ ялгаатай. Ийм учраас татварыг бол микро эдийн засгийн түвшинд нь зөвхөн макро эдийн засгийн тогтолцооных нь хувьд биш цогцоор нь харах.

О.Цогтгэрэл: Баярлалаа. Тэгэхээр та энэ ААН-үүд хүндрээд байгаа чинь тогтолцооны асуудал гэж та хэлж байна. Тогтолцооны татварын иж бүрэн шинэчлэл шаардлагатай юм гэж та хэлж байна. Үнэхээр таны энэ хариулттай би санал нийлж байна. Ийм учраас ийм учраас АН-ын бүлэг дээр ярилцаад нэг тодорхой байр суурь бид нар илэрхийлж байсан. Энэ яагаад ААН-үүдийн чинь 60 70 хувь нь ингээд бүтнээрээ өрөнд орчхоод байгаа юм бэ? Энэ чинь хувь ААН-ийнхээс тогтолцооны асуудал байна. Тогтолцооны асуудал байгаа учраас 1 дүгээрт нь эдийн засгийн реформ хийх ёстой. Энэ реформыг дагаад тодорхой хэмжээний өршөөлийн асуудал яригдах нь зүйтэй юм гэдэг санал гарсныг Сангийн яамнаас мэдэгдэл гаргаад олон долоон юм бараг АН-ын бүлэг Цогтгэрэл хэлснээс болоод татвар тасарлаа ч гэлүү. Өөр тийшээ мушгина лээ.

Бид нарын байр суурь бол энэ тэр магадгүй 75 мянган ААН-ийн чинь 70 мянгад нь хамаарч байгаа. ЖДҮ-үүд энэ бүхэн хамаарах ёстой. Энэ бүхнийг судалж байна гэдэг байр суурь гаргасан. Тэгэхээр эндээс гарч байгаа гол дүгнэлт та ерөөсөө бид нарын энэ асуудлын уг шалтгаан бол уг шалтгаан тэр нэг ашигтай ажиллачхаад татвараа өгөхгүй байгаа ААН-үүд ерөөсөө биш ээ. Энэ бол

тогтолцооны том шинэчлэлийг энэ Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал бизнесийн орчин чинь шаардаад байна аа. Иж бүрэн шинэчлэлийг шаардаад байна. Хаана байна тэр иж бүрэн шинэчлэлийн санал. Та бүхэн үндсэндээ хэдэн жилээрээ л зөвхөн таны Засгийн газар ч биш хэдэн жилээрээ ярьсан. Нөгөө нийгмийн даатгал, эрүүл мэндийн шинэчлэл, татварын тогтолцоо. Энэ элдэв сангууд. Яг үнэндээ бид нар ярьсан болохоос аль нь ч бодлогын түвшинд юу ч өнөөдрийг хүртэл орж ирээгүй. Магадгүй та нар одоо өнөө маргааш өргөн барина гэж хэлнэ. Энэ зүгээр л олон нийтийн нэг хий гаргах гэж л хийж байгаа ажлууд юм шиг л сүүлийн үед санагддаг болсон.

Ерөөсөө л бодлогын хувьд та бүхэн зүгээр нэг ийм асуудлыг яаж намжаах вэ? Гэтэл яг суурь асуудал чинь энэ системийн өөрчлөлтийг та бид нараас шаардаад байна.

Г.Занданшатар: Тэгээд тогтолцооны хувьд тантай санал нэг байна. Бид аль болох бүтээлч шийдэл гаргасан парламентын мэтгэлцээн өрнүүлж татварын цогц реформ, тогтолцооны шинэчлэлийг хийх учиртай. Энэ дээр нар санал нэг байна. Гэхдээ энэ өршөөл эхэлж явдаггүй. Татварын реформоо хийгээд татварын реформоо тууштай хэрэгжүүлэх явцдаа татварын өршөөл хэрэгждэг. Татварын өмнөх 4, 10-ын тогтолцооны реформыг би ажлын хэсэгт нь ажиллаж энэ 4, 10-ын реформын үзэл санааг анх хэрэгжүүлэх ажилд оролцож байсан. Тэгээд тэр үед бидний төсөөлөл өөр байсан. Үл хөдлөх хөрөнгийн татвар бусад татваруудыг хамтран цогцоор хийгдэх ёстой байсан боловч шийдэгдээгүй юм байгаа юм.

Тэгэхээр энэ Эдийн засгийн ил тод байдлын тухай 2015 оны хуулиар 35 их наядын хөрөнгө орлогыг ил болгож шийдсэн боловч энэ маань биднийг хар жагсаалт руу орох нэг үндэслэл болгочихсон. Саарал жагсаалтад орсноос зээлийн хүү нэмэгдэж таны яриад байгаа энэ тогтолцооны гажуудал үүсэж, ААН-ийн зээлийн хүү, санхүүжилтийн зардал өсөж энэ эдийн засагт ямар сүүдэр ужгирсныг та бид сайн мэдэж байгаа.

Тийм учраас энэ тогтолцооны реформ бол цогц хэлбэрээрээ эхэлж ярихгүй бол өршөөнө гээд түрүүлээд зарлачихаар ямар ч татвар төлөгч намайг өршөөх гэж байгаа юм бол би яах гэж төлөх юм бэ гэсэн сэдэл үүснэ шүү дээ. Энэ нөгөө нэг Адам Смитийн номд байдаг ерөөсөө үндсэн зарчим чинь зах зээлийн зарчим чинь ингээд гажуудуулсан мэдэгдлүүд зах зээлд ямар дохио сигнал өгөх вэ гэдгээ Засгийн газар парламент хамтарч хариу хэлчхээд зөв мессеж сигналаа өгч байж энэ татварын төсвийн реформуудаа хэрэгжүүлж байхгүй бол эхлээд л дандаа нөгөө нэг популист чиглэлтэй ч юм уу, аль эсвэл халамжийн чиглэлтэй ч юм уу энэ бодлогууд маань бидний тогтолцоонд гараад байгаа энэ улс төрийн шалтгаанууд болоод байж байгаа. Энийг харин бид хамтдаа шийдээд, зөв голдирлоороо.

О.Цогтгэрэл: Тэгээд тэр агуулгатай бол санал нийлж байна. Миний хувьд яг л энэ агуулгаар л асуудалд хандаж байгаа. Тэр тусмаа судлаад үзэхэд 2008 оны 4, 10-ын бодлого энийг залгаад гарсан татварын өршөөл энэ бол маш зөв зүйтэй бодлого байсан юм байна лээ. 2015 оных татварынх биш. Энэ бол тоо дүнгүй. Татварын өршөөл гэдэг чинь 100 сая төгрөгийн өртэй бол энэ тодорхой тоо бүхий зүйл.

2015 оны эдийн засгийн өршөөлийн асуудал бол энэ бол маш алдаатай бодлого гэж би боддог. Татварын өршөөл эдийн засгийн өршөөл тусдаа ил тод

байдал тусдаа. 2015 оных бол энэ бол Монголчуудын хувьд сургамж авах ёстой буруу зүйл гэж боддог оо.

Тэгэхээр яг тэр иж бүрэн реформ шинэчлэл тэрийг залгаад өршөөл. Өршөөл гэдэг нь 100 хувь хөнгөлөх чөлөөлөх тухай асуудал биш гэдгийг би бас дахин дахин хэлж байсныг давтаад хэлье.

Дахиад та 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр намынхаа Их Хурал дээр хэлсэн үгийг манайхан ингээд бэлтгэсэн байна. Энэ манай Засгийн газар эдийн засгийн хүнд сорилтыг даван туулахдаа ачааны хүндийг ард түмэн ААН-д үүрүүлэх бус төр өөрөө бүсээ чангалж даван гарна гэж албан ёсоор үг хэлээд яг ийм постоор гарч байсан байна. Гэтэл яг одоо бодлого саяын хэлдэг шинэчлэл өөрчлөлтийн олон бодлогууд яг саяын хэлснээр биш, саяын хэлсэн зүйлийн эсрэг нь ингээд явж байгаа ийм зүйлүүд харагдаж байна гэдгийг ингээд хэлье ээ.

Яг Одоо өнөөдөр нөхцөл байдал дээр харахад НДШ байна. Яг өнөөдөр Монголчуудын хувьд татварын шинж чанартай болоод хувирчихсан татварын шинж чанартай. Энэ бүгдийг оруулаад тооцвол 40 гаран хувийг нь татвартай далайгаас хол, тээврийн зардал өрсөлдөх чадварт нь нөлөөлчихсөн. Энэ бүхэн Монголчуудын хувьд бизнесийн орчны хувьд, өрсөлдөх чадварын хувьд үнэхээр дахиад л та бид нараас суурь дүгнэлтүүдийг л энд онцгойлон шаардаж байгаа ийм нөхцөл байдал байгааг мэдэж байгаа байх гэж бодож байна.

Г.Занданшатар: Тэгээд тантай санал нэг байна аа. Энэ татварын ерөнхий ачааллын хүрээнд бид нарын анхаарах ёстой асуудал бол НДШ мөн. Тэгэхдээ нийгмийн даатгалын санг хоосолсон сангийн менежментийг хэрэгжүүлж чадаагүй хулгайлсны улмаас нийгмийн даатгал дээр иргэдэд учруулж байгаа одоо энэ өндөр дарамтыг бууруулах ямар ч боломжгүй. 2030 он гэхэд бараг Оюу толгойтой адилхан хэмжээний нийгмийн даатгалын сангийн зарлага хуримтлал алдагдал үүснэ. Энэ бүхэн маань нөгөө нийгмийн даатгал дээр байгаа ачааллыг бууруулах боломжийг хүндрүүлээд байгаа юм. Түүнээс биш энэ одоо нийт татварын нийгмийн даатгалын энэ цогц реформын хүрээнд бид аль болох ААН-үүдээ дарамт багатай илүү чөлөөтэй эдийн засгийн эрх чөлөө олгосон хуулиудыг хэлэлцэж байна. Энэ зорилгоор Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг Улсын Их Хурлаас Засгийн газарт өргөн мэдүүлэн ажиллаж байгаа. Энийг Баялаг бүтээгчдийг дэмжих багц хууль гэж нэрлэж байгаа. Энд Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль, төрийн өмчийн компаниудын хувьд ч энэ үндсэн чиглэлүүд мөн Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль гээд ингээд багц хуулиудыг хэлэлцээд явж байна. Энэ бүхэн маань үндсэндээ эдийн засгийн либералчлал, чөлөөтэй байдлыг дэмжих, энэний үр дүнд хувийн хэвшлээ дэмжих, ингээд хувийн хэвшил давамгайлсан эдийн засгийн тогтолцоогоо бэхжүүлэхэд зах зээлийн тогтолцоогоо бэхжүүлэхэд чиглэгдсэн ийм өөрчлөлтүүдийг Засгийн газраас хэрэгжүүлж эхлээд ингээд явж байна аа. Гэвч саяын таны хэлсэн тэр ард түмэндээ ачааг нь үүрүүлэхгүй гэдэг бол инфляцаар ард түмний карманаас хулгайлж байдаг энэ инфляцыг бууруулахын тулд л төсвийн тодотголыг хийсэн. 2.2 их наядаар танахад нийт төрийн албан хаагчдын тоог 9 хувиар цомхотгосон. Энэ маш том тоо гээд та ч гэсэн хэлж байсан. Энэ 147 дарга цэргийн орон тоог цомхотгосон. 28 үндэсний хороодыг татан буулгасан. Энэ бүхэн маань бол тодорхой хэмжээний өвдөлт өгч байгаа тэр хэмжээгээр эсэргүүцлийг бий болгож байгаа.

О.Цогтгэрэл: Өнөөдөр чинь 12 дугаар сарын 26. Оны төгсгөлийн өдөр. 12 дугаар төгсгөлийн асуулга мэтгэлцээний өдөр болж байна. Ийм учраас энэ сэдэв өөрөө энэ оныг дүгнэж хэлэх боломжтой гэж бид бүхэн асуулга асуултынхаа сэдэв дээр ярилцсан. Тэгэхээр манай гишүүд өргөн сэдвээр танаас асуух боломжтой байх гэж бодож байна. Энд эрүүл мэнд, боловсрол бүхий л салбар энэ асуудлуудад хамаарна аа. Зөвхөн эрүүл мэндийн салбарын жишээг аваад үзэхэд яг өнөөдөр ЭМД-ын сангийн дампуурлаас болж үндсэндээ дампуурлаас гээд хатуухан хэлчихье. Эм тариа олон олон зүйлүүд чинь бүгдээрээ байхгүй болчихсон. Сая та бас нэг эмнэлэг дээр очсон мэдээллийг бид нар харж байсан. Нэг эмнэлгийн асуудлыг шийдлээ гээд нэг асуудал гарч байсан.

Гэтэл энэний цаана тогтолцооны асуудал маань дахиад та бид нараас том хариулт нэхсээр. Яг одоо энэ эрүүл мэндийн салбарын бараг жилдээ зуугаад мянган Монгол Улсын иргэн гадагшаагаа гарч эмчилгээнд явж байна. Энэ дотооддоо эмчлүүлчих боломжтой. Аль эсвэл техник технологийг нь асар өндөр тийм нөхцөл байдлыг шаардаагүй мөртөө өнөөдөр бид нар иргэдээ гадагшаа явуулж бүүр эдийн засаг талаас яривал тэр валютын асуудлууд, энэ эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа эмч ажилтнууд чинь гадагшаа гарч асрагч, сувилагч бүүр бусад ажлыг биеийн хүчний ажлыг хийдэг. Энэ салбар нь өөрөө ийм урвалт уналтын байдалд орчихсон. Дахиад л энэ салбар салбаруудыг дүгнээд ярих юм бол асар олон зүйлүүдийг та бид нар ярьж болж байна уу?

Дахиад боловсролын салбар эмч, Монгол Улсын ирээдүйн төлөө ирээдүй цагийн иргэнийг бэлдэж байгаа боловсролын салбарын багш нар гадагшаагаа гарч виз нь олдвол бүгдээрээ гарч ажиллахад бэлэн. Тэгэхээр энэ бүгдэд бид нар өнөөдөр ямар дүгнэлт хийж яг ямар хариу арга хэмжээ авах юм бэ? Энэ ингээд л бид нар та бид нар бие биедээ үг хаяж бие биедээ гайхаад ингээд явах юм уу? Одоо яг яах ёстой юм.

Г.Занданшатар: Бид бүх зүйл сайхан болж байна гэж бие биеэ хуурахгүй. Тэгээд бүх юм болохоо болиод унаж байна гэж оны төгсгөлд муу амлахгүй ээ. Монгол хүн амныхаа бэлгээр үнэн бодит тоог хэлэх ёстой. Тоо худлаа хэлдэггүй. 2.5-аас доош унаж байсан эдийн засаг өнөөдөр 6.4, 6.5 хувь болж өсөж байна. Энэ өсөлт биш гэж үү? Энгийг би унасан биш сэргэж байгаа эдийн засаг гэж хэлнэ. Валютын нөөц 2 тэрбум доллароор уруудаж байсан нөөц өнөөдөр түүхэндээ анх удаа 6 тэрбумыг даваад 6.5 тэрбум доллароор гарна. Энэ Монголын хувьд түүхэн рекордтой хэмжээнд хүрнэ. Энэ төгрөг чангарч байгаа сайн үзүүлэлт биш гэж үү? Ингээд эдийн засгийн өсөлт 6 хувь гараад явна. Валютын нөөц 6.5 тэрбум доллар руу давна, валютын ханш төгрөг тогтворжоод унаж байсан бол өсөж байна. Инфляц тогтворжиж байна, зээлжих зэрэглэл сайжирлаа. Энэ бүхэн бол сайн үр дүнгүүд. Оны эцсээр эерэг үр дүнгүүд гарч байна. Мэдээж энэ унаж байсан саарч байсан ард иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж байсан инерцээрээ ард түмний амьдралд, төсөвт хүндрэл учруулж байгаа нь бодит үнэн. Тэгэхдээ энэ эдийн засгийн тогтолцоо нүүрснээс хамааралтай эдийн засаг нэг өдөр бий болоогүй. Бид аж үйлдвэржилтээ, хүнсээ, татварын бодлого, үндэсний үйлдвэрлэлээ дэмждэггүй, алдаатай бодлогуудын чинь үр дүнд өнөөдрийн энэ тогтолцоог засаад зөв голдирол руугаа орж байна.

Ийм ч учраас Монгол Улсын Засгийн газраас эдийн засгийг сэргээх идэвхжүүлэх 300 хоногийн төлөвлөгөөг өнгөрсөн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж батлаад одоо ХАҮТ бизнес эрхлэгчдээрээ хэлэлцүүлээд явж байна. 30

хоног 10 сарын дотор энэ өдөр бүрийн төлөвлөгөөгөөр эдийн засгаа сэргээх эдийн засгийн эрх чөлөөг бий болгох зөвшөөрлийг багасгах, ийм эрчимтэй хувийн хэвшлээ дэмжсэн, ард иргэдийнхээ орлогыг дэмжсэн ард иргэддээ амьдралд наалдацтай бодитой бодлогуудыг хэрэгжүүлнэ.

Ойрын хугацаанд том мега төслүүд хэрэгжиж эхэлж байна. Тэгээд энэ олон ажлууд маань үр дүнтэй явснаараа ирэх он бол бас итгэл найдварын жил болох.

О.Цогтгэрэл: Би сая таны үгэнд гарсан нэг тоотой холбоотой дахиад тодотгоод асууя. Та валютын нөөц 6 тэрбум доллар хүрлээ. Түүхэн дээд хэмжээнд хүрлээ гэж байна. Яг энэ тоотой холбоотой. Өнгөрсөн жил валютын нөөц 4.5 орчим тэрбум байсан. 2025 оны туршид Монгол Улсын урсгал дансны алдагдал 1 тэрбум гаран долларын алдагдалтай. Экспорт, импорт, гадаад худалдаа биш шүү урсгал дансны алдагдал. Тэгэхээр 4.5-аас 1 тэрбум хасах гарахаар Монгол Улсын цэвэр бодит нүүрс чинь 4.5-аас 1-ийг хасаад бараг энэнээс ч их хасагдаад 3 руу орчихсон байх ёстой. Гэтэл та нар 6 гэж хэлээд байна. Энэ мөнгө хаанаас гарч ирсэн, ямар мөнгөний тухай ярьж байна?

Энэ бол зүгээр бонд авсан, өр зээл тавьсан Монгол банкнаас, Хөгжлийн банкнаас дахиад дээрээс нь арилжааны банкнууд энэ бүгдийг нь авсан зээлийг л та бүхэн Монгол Улсын нэг жилийн ажлын эдийн засгийн үр дүн гэж та нар зүгээр хууран мэхлэлт хэлж байгаа шүү дээ. 4.5 тэрбум доллароос 1 тэрбумын долларын урсгал дансны алдагдалтай гарахаар 4-өөс чинь нэг хасагддаг юм байгаа биз дээ. Өөр нэмэгдэх зүйл байхгүй шүү дээ. Үгүй энэ Хөгжлийн хөгжлийн банк чинь 500 саяыг аваад ирчихсэн байхгүй юу. Та нар Худалдаа хөгжил, Голомт банкнуудын бүх авч ирсэн бондыг та нар нэмээд 6 дээр биччихсэн байгаа шүү дээ. Та мэлзэх арга байхгүй шүү дээ. Би наад тоог чинь гадарлана. Та хариулаарай.

Г.Занданшатар: Тэгэхээр нөгөө энэ Цогтгэрэл гишүүний хэлж байгаа санхүүгийн дансны ашиг илүү байгаа нь үнэн. Урсгал дансны тэнцэл эхний хагас жилийн байдлаар буурч байсан нь үнэн. Гэхдээ экспортыг нэмэгдүүлж байгаа урсгал дансны тэнцэл бол одоо баланс бариад дээр нь санхүүгийн дансны ашгууд нэмэгдээд. Санхүүгийн дансны ашиг гэдэг нь таны хэлж байгаа санхүүжилтийн төлбөрийн тэнцлийг ингээд зүйл анги зүйлээр нь ялгаж үзэх юм бол манай энэ экспортын бүтцийн доголдол импортын хамаарал бүгд тодорхой болно. Энэ импортоос хамаарчихсан эдийн засаг чинь өөрөө валютын ханшийг хөөргөж байгаа хүчин зүйл болж байгаа нь үнэн. Гэхдээ одоо 6.5 тэрбум доллар хүрэхэд санхүүгийн дансны ашиг ч нөлөөлсөн зүйл бий. Илүү их экспорт унаад нүүрсний үнэ унаснаас шалтгаалсан илүү урсгал данс илүү алдагдалтай болчихсон байсныг эхний хагас жилийн байдлаар валютын цэвэр нөөц хасах руугаа орох эрсдэлтэй болчихсон байсныг өнөөдөр нэмэх болгоод урсгал дансны тэнцлийг эерэг болгоод ингээд явж байгаа.

Өөрөөр хэлбэл бид 87.4 сая тонн нүүрс экспортоллоо. Бодит хэмжээгээрээ нэмэгдүүлээ. Энэ бүхэн маань өөрөө валютын тэнцлээ, төлбөрийн тэнцлээ ашигтай болгох нөхцөлийг бүрдүүлж байгаа юм. Зүгээр Сангийн сайдын хэлж байгаа бол нөгөө Засгийн газрын бондуудыг хэлээд байх шиг байна. Хөгжлийн банкны бонд, арилжааны банкнуудын авч байгаа бонд төлбөрийн тэнцэлд санхүүгийн дансны ашиг болж тусдаг учраас тийм эерэг үзүүлэлтүүд нөлөөлсөн зүйлүүд бий бий.

О.Цогтгэрэл: Тэгээд эдийн засгийн асуудал дээр, амлалтууд дээр бас нэг жижигхэн тоо байна. Жишээ нь төсвийг зардлыг нэмэхгүй орон тоог нэмэхгүй гээд. Сүүлийн үеийн сүүлийн хэдэн өдрийн улс төр дээр дэд сайдын асуудал гэдэг зүйл яригдаж байгаа. Зарим нь ингээд дэд сайдын асуудлыг ярихлаар АН цөөхөн хүний, арван зургаахан хүний асуудал ярилаа. Энэ нь 900-аад сая төгрөгийн асуудал юм гэдэг. Энийг дагаад бусад үржүүлэгдэж гарах олон зардлыг нь больё. Шууд 900 сая төгрөг гэдгийг жижигхэн тооцоо хийсэн байна. Энэ 900 сая төгрөгийг цалинжуулахын тулд маш бага мөнгө. 9 тэрбум биш, 90 тэрбум биш. Би маш бага мөнгөний тухай нэг тооцоо хийж харуулъя. 900 сая төгрөгөөр цалинжуулахын тулд өнөөдөр Монгол Улсын нэг дундаж иргэн 2.7 сая төгрөгийн цалинтай. 2.7 сая төгрөгийн цалинтай иргэн нь 228 мянган төгрөгийн татвар төлж байна.

Тэгэхээр энэ 900 сая төгрөгийн 16 дэд сайдыг цалинжуулахын тулд өнөөдөр 3789 Монгол Улсын дундаж цалинтай иргэний татвараар 16 дэд сайдыг цалинжуулах юм байна. Монгол Улсын дундаж 3789 иргэний татварыг хурааж аваад арван зургаахан дэд сайдыг цалинжуулах тийм ээ.

Тэгэхээр та нарын хэлээд байгаа энэ жоохон мөнгө үү? Жоохон мөнгө, мөнгө биш бараг. Нөгөө талаасаа Монгол Улсын 3700 иргэнийг ажил амьдралаас нь татварыг нь хурааж аваад цалинжуулж байгаа ийм буюу энэний цаана байгаа энэ мөсөн уулын оройны тухай яриа. Өнөөдөр ярьж байгаа энэ унасан эдийн засгийн тухай том эдийн засгийн тухай яриа гэдэг энэнд АН-ын зүгээс ач холбогдол өгч ингэж ярьж байгаа юм аа. Гэтэл энэ бол.

Г.Занданшатар: Ер нь Монгол Улсад 220 мянга гаруй төрийн албан хаагч ажиллаж байгаа. 220 мянган дотор тэрнээс гадна энэ улсын секторт ажиллаж байгаа төрийн өмчийн компаниудын түвшинд ажиллаж байгаа 228 хүний зардал төсвийг хэмнээд, энэний зардал төсөв нь энэнээс 10 дахин их мөнгө. 10 дахин мөнгийг хэмнээд одоо жишээлбэл 10 дахин зардалтай бензин машиныг цахилгаан машинаар солиод ажиллуулахад илүү үр дүнтэй бол 900 сая төгрөгийн зардал гаргаад бид нар 24 тэрбум төгрөгийн зардал хэмнэж байна шүү дээ. 24 төгрөгийн зардал хэмнээд 900 сая төгрөг зарцуулах 2-ыг харьцуулахгүйгээр энэ зардлыг нь их бага мөнгө гэж ярих тухайтад биш харин энэ үр ашгийг нь тооцвол дэлхийн бүх улсуудад дэд орлогч сайдгүй ажил байхгүй. Сумын дарга хүртэл орлогчгүй бол ажил нь явдаггүй юм. Ажлаа хөөцөлдөөд явах гэж байна. Амьдрал дээр. Одоо энэ хойд урд хөршөөс хэдэн 10 дэд сайдтай. Дэд сайдын түвшний 3 талт механизмын ажил, том том ажлууд, нүүрс, бензин, 3 талт механизм ажиллахаа больчихсон. Дэд сайдгүйгээс болоод. Гадаад яамны дэд сайд нарын уулзалтууд зохион байгуулагддаг байсан. Энэ олон улсын түвшинд дэд сайдын олон механизмууд бий. Салбар хоорондын уялдаа холбоо гээд энэнээсээ гадна олон 100 тэрбумын асуудлыг хянаж шалгалтын үүрэг гүйцэтгэж байгаа. Нэг сайд дураараа авирлахгүйн тулд Дэд сайд хяналтын үүрэг гүйцэтгэж байгаа юм.

Ер нь аливаа төрийн байгууллагууд байдаг систем бол 2 орлогч нэг орлогч бол заавал 2 гарын үсэг зурдаг шиг давхар гарын үсгийн хяналтын тогтолцоо байдаг нь өөрөө Засгийн газрын хяналтыг бий болгож байгаа юм. Яамдад нэг сайдын компани шиг ажилладаг тийм соёл тогтоож болохгүй. Ийм учраас дэлхийн бүх улсуудад байдаг зарчим бол дэд сайд хяналтын үүрэг гүйцэтгэдэг. Нөгөө талаасаа салбар хоорондын уялдаа холбооны үүргийг гүйцэтгэдэг. Үр ашиг нь тэр 100 хүн ажилласнаас илүү үр дүнтэй байдаг. Эцсийн үр дүнд бүтээмж, үр ашиг, хяналтын тогтолцоо өнөөдөр төрийн дахин инженерчлэл үүргийг чиг үүргийг дахин процессыг

дахин инженерчлэхэд ч туйлын чухал байна. Ийм учраас гишүүд санал гаргаад төрийн чиг үүргийн.

О.Цогтгэрэл: Дахиад тодотгоод хэлье. Арван зургаахан дэд сайдыг ажиллуулахын тулд 3789 иргэний татвараар амьдардаг юм байна шүү гэдгийг энэний цаана тэгвэл төрийн албаны бүтэц гэдэг зүйл ямар их том үр дагавартай вэ гэдгийг. Тэгээд ингээд ярихлаар нөгөө талд нь АН-ын хэдэн хяналтын менежер, бүтээмжийн менежерээс болоод тэрийг цомхотгосноор тэрийг ингэснээр гэдэг АН-ын хувьд нийтдээ та бүхэнтэй танай Засгийн газартай танай намтай хамтарч ажиллаад 25 хүн л томилсон юм байна лээ. 25 менежер томилсон гэж бид нар ойлгож байгаа. Та нарын мэдээллээс л харахад. Гэтэл энэний цаана ямар их том асуудал тэр 200 мянга, энэний цаана жил жилд хэдэн 10 мянгаар нэмэгдэж байгаа энэ төрийн алба гэдэг чинь ямар үр дагавартай вэ гэдгийг нэг талаараа харуулж байна. Мөн АН-ын хувьд ямарваа нэгэн олон нийтэд нэг PR явахдаа АН хэдэн менежерээ хамгаалж байна гэж энд ямарваа нэгэн тийм одоо жишээ нь миний зүгээс аль нэг сайдад Ерөнхий сайдад АН-ын менежерийг үлдээж өгөөч ээ, Ингэвэл тэгье. Энэнээс болж ингэж байна гэдэг өчүүхэн төдий ч энд АН тийм яриа байхгүй. Бид бүгдийн зүгээс нэг ийм зарчмын шаардлагын хажууд нэг ийм хувь хувьсгалын жижиг юм, энэний цаана ярьж байсан тохиолдол ч байхгүй гэдгийг би улаан нүүрээрээ хэлчхэж чадна аа. Энд ямарваа нэгэн тийм жижиг сажиг энэний цаад талын асуудал байхгүй шүү гэдгийг олон нийтэд энийг хэлэх хэрэгтэй байх. Энэ мэдээллийн хэрэгслээр буруу зөрүү ойлголтуудыг төр түгээдэг. АН жижиг зүйлээр шантааж хийж байна гэдэг энэ бол ингээд зарчмын шаардлагууд байсан шүү гэдгийг хэлье. Энэ төгсгөлийн асуулт билүү? Дараа асуулт байгаа билүү?

Энэ төгсгөлийн асуулт дуусаж байгаа юм байна. Тэгэхээр 2026 онд Ерөнхий сайдаа юу өөрчлөгдөх вэ? Бид нар ингээд ард иргэдийн итгэлийг алдаад эдийн засгаа унагаад.

Г.Занданшатар: Би зөвхөн хяналтын болон бүтээмжийн менежерийн тухай асуудал огт яриагүй. Төрийн чиг үүргийн дахин инженерчлэл илүү, ард иргэддээ ээлтэй, олон түмэнд тустай, хяналттай, авлигагүй, ил тод ийм төрийн тогтолцооны дахин бүтцийг дахин том утгаар нь засаж залруулах. Энэ 16 дэд сайдын ч асуудал биш энэ 220 мянган төрд ажиллаж байгаа хүмүүсийг үр дүн бүтээмжид нь уялдуулж цалинжуулдаг үр дүнг нь хянадаг тогтолцооны тухай ярьж байна. Тэр 16 дэд сайд үр дүнтэй, бүтээмжтэй, өгөөжтэй ажиллаж байвал ард иргэддээ хэрэгтэй асуудал шийдэж байвал тэр хүмүүс ажиллах ёстой. Аль эсвэл тэр бүтээмжийн ч байна уу, хяналтын ч байна уу менежмент үр дүнгүй зардал гаргаж байгаа. Ямар ч ажил хийж бүтээгдэхгүй байгаа тэр орон тоонуудыг цомхотгох ёстой. Энэ бол ерөөсөө орчин үеийн төрийн чиг хандлага. Үүнтэй нийцүүлсэн цогц өөрчлөлт хуулийн төслийг Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барихаар төлөвлөж байна. Энэ ерөөсөө нийт төрийн албаны бүтцийн дахин инженерчлэлийн асуудал ярьж байгаа юм. Ингэж байж нөгөө ард иргэддээ ойрхон, ээлтэй, хүнд суртал, чирэгдэлгүй, авлигагүй ийм ээлтэй төрийн алба үйлчилгээг бий болгох ёстой.

Түүнээс биш энэ 17, 18 дэд сайдын асуудал биш. Төр үндсэндээ хөнгөн шуурхай ард иргэдтэй ойрхон байх нь л энэ ардчилсан төрийн хамгийн гол эрхэм зорилго байх ёстой. Тийм учраас төрийн чиг үүрэг шаардлагагүй чиг үүргүүд зөвхөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр бид үнэлгээ хийж үзэхэд гадаадын аргачлалаар хийж үзэхэд 114 огт шаардлагагүй чиг үүрэг. 1900-аад давхардсан чиг үүргүүд байж байна. Байгаль орчны яаман дээр орон нутагт, улсын хэмжээнд. Энэ

чиг үүргүүдийг оновчтой хуваарилж энэ процессыг дахин инженерчилж байж хэн юугаа хариуцах юм бэ гэдэг асуудлууд тодорхой болохгүй бол салбар бүр хяналтгүй болчихсон. Энэ хяналт гэдэг бол өөрөө авлигагүй тогтолцооны суурь. Бас ард иргэддээ ойрхон үйлчилгээний тогтолцоо юм.

Н.Учрал: Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийн дарга 37 минут 30 секунд дотор нийт асуултыг асууж дууслаа. Цөөнхийн бүлгийн гишүүд асуулт асууна. Цөөнхийн бүлгийн гишүүдийн нэрс гарсан байна. Ерөнхий сайдаас голд нь ямар нэгэн дараагийн гишүүнийг дурдахгүйгээр сая Цогтгэрэл даргатай хэлэлцүүлэг өрнүүлсэн шиг шууд нэрсийнхээ дагуу гишүүд орж ирээд асуугаад явах нь зөв байна аа. Тэгвэл анхаарал сарнихгүй ач холбогдол өндөртэй болж байна. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Ер нь дэд сайдуудаа татчихвал зүгээр байсан юм даа гэдэг үгээр асуултаа эхэлье ээ. 3 асуулт өгсөн байгаа.

Нэг нь энэ амьжиргаатай холбоотой бодит үр дүнтэй холбоотой асуулт байгаа. Мэдээж Засгийн газар бол хөтөлбөрөө дэвшүүлээд явж байгаа. 5 жилийн хөтөлбөр гээд явж байгаа. Тэгэхээр одоо байна шүү дээ Ерөнхий сайд аа. Нэг талаас засаг нь бол тоо баримт яриад байдаг, нөгөө талаас сөрөг хүчин нь асуулт асуугаад байдаг. Бодит амьдрал дээр хүмүүсийн яг нөгөө англиар хэлбэл инклюзив экономикс буюу хүртээмжтэй эдийн засаг чинь хүний хаалгаар хөргөгчид нь амьжиргаа болж орж байна уу үгүй юу гэдэг л асуулт байгаад байгаа юм.

Тэгэхээр та 2026 оны наадам гэхэд 2026 оны цагаан шинэ жил гэхэд ч юм уу ийм 6-аас 12 сарын үечлэлтэй ер нь яг ямар хэмжигдэхүйц үр дүнд эдийн засгаа босгочихсон байна гэж тооцож байгаа вэ гэдгийг сонсмоор байна товчдоо.

Хоёрдугаарт нь бол нэг гомдол Хүний эрхийн дэд хороонд ирсэн учраас энэ нь эргээд энэ шууд амьжиргаатай холбоотой учраас асуучихъя гэж бодож байна. Хөдөлмөрийн хуулийн 101 дүгээр зүйл дээр байгаа цалин хөлстэй холбоотой, цалин хөлсний үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, ээлжийн амралтын цалин, шагнал урамшууллаас бүрдэнэ гэж байгаа. Төрийн албаны хуулийн 9.2 дээр байгаа энэ дээр бол төрийн албаны зардлыг бууруулах талаар төрөөс авах арга хэмжээ гээд тодорхой зохицуулалтуудыг оруулчихсан байж байгаа. Ингээд Засгийн газар шийдвэр гаргаад урамшууллыг хасчихсан гэж ойлгож байгаа зөв үү? Хассан тиймээ. Тэгэнгүүт ийм гомдол ирээд байгаа юм. Дээр үед нөгөө 20 дугаар тогтоол гарахыг мэдээд дотор нь байсан хүн гарч яваад 2 диктофон худалдаж аваад хэрэгт орлоо гэдэгтэй адилхан яасан юм гэхээр Сангийн яам урамшууллаа өөрсдөө авчихсан байна гэдэг гомдол ирээд байгаа юм.

Тэгээд бусдууд нь бол хасчихлаа гэдэг гомдол ирээд байгаа. Хүний эрхийн дэд хороон дээр ирж байгаа энэ гомдлыг би уламжилж байна. Ерөнхий сайдаас энэ дээр хариулт авъя. Тэгээд ард маань олон хүмүүс байгаа учраас асуултаа ингээд товчхон дуусгачихъя.

Г.Занданшатар: Би таны асуултад хариулаад 3 асуултаар асуучихъя. Та бүхэн нөгөө төрийн хуулийг дагана гэж Улсын Их Хуралд тангараг өргөдөг тийм үү? Хууль дагах ёстой юу бид. Хуулиа дагаж мөрдөх ёстой юу энэ чинь мэтгэлцээн юм чинь асуулт хариулт явна биз дээ. Хууль дагаж мөрдөх ёстой юу үгүй юу? Засгийн газрын тухай хуулийн 18⁴-д сайдынхаа өмнө тодорхой үүрэг чиглэл хариуцах дэд

сайд байна гэчихсэн байгаа. Төрийн дахин инженерчлэл хийсэн олон улсын байгууллагуудын дүгнэлтээр дэд сайд буюу хяналтын механизм байхгүйгээс яамдад бас хууль зөрчигдөх нөхцөл байдлууд үүсэж байна гэсэн дүгнэлт гарсан байгаа. Тэгэхээр би хууль биелүүлэх үүрэгтэй.

Үндсэн хуульд заасны дагуу Ерөнхий сайд хууль биелүүлэх ажлыг хариуцах ёстой. Хууль нь дэд сайд байна гээд заачихсан байна. Би хууль биелүүлэх үүрэгтэй. Энэ хууль биелүүлээгүйгээс болсон гарсан үр дагаврыг сүүлд нь хууль хүлээлгээгүй бол Засгийн газар хариуцна.

Тийм учраас би хуулиа л хэрэгжүүлж байна гэдгийг хэлээд байгаа шүү дээ. Энэ зөвхөн хуульд биш дэлхий нийтэд байгаа жишиг байна. Гүйцэтгэх засаглал, Дэд сайдыг ажиллуулдаг жишиг дэлхийн бүх улсад байна. Дэд сайдын ажлыг олон салбар нэгжтэй энэ бүх систем салбарыг авч явж байгаа бүх улсад түүнтэй төстэй ямар нэгэн байдлаар ТНБД, парламент хариуцсан ТНБД хэдэн арваараа дэд сайдууд ажиллаж тухайн яам салбарын ажлууд явж байна. Нэршил нь янз бүр боловч эрх үүрэг нь дэд сайдын статусаар салбарын бодлогын хэрэгжилт төрийн байгууллагуудын уялдаа холбоо парламенттай харилцах харилцааг зохицуулахад чухал үүрэгтэй байна аа. Ингээд дэлхийн бүх улсуудад байгаа ийм манайд хэрэгжээгүй нь өөрөө ийм асуудалтай байна гэдгийг би хэлмээр байгаа юм. Нөгөө таны сүүлд асуусан асуултуудтай зарчмын хувьд санал нэг байна. Энэ дээр урамшуулал хасаагүй шүү. Эхний 3 улирлын урамшуулал олгочихсон.

Дөрөвдүгээр улирлын урамшууллыг зүгээр даргын үзэмжээр урамшуулал олгоод байгааг больж миний саяын хэлсэн бүтээмж үр дүнд суурилсан ажлын үнэлгээний үндсэн дээр урамшуулал олгодог тогтолцоог.

Н.Учрал: Саруулсайханы Цэнгүүн гишүүн.

С.Цэнгүүн: Тэгээд бүтцээ томруулах болохоор та Үндсэн хууль хуулиа биелүүлдэг гээд яриад унах юм. Хэрвээ Монгол Улсад хуулиа биелүүлдэг байсан бол бид нарт хуулиа биелүүлэх ёстой маш олон зүйлүүд байгаа. Хариуцлагаа хүлээдэг байсан бол маш олон сайд нар өнөөдөр сайдын ажлаа хийхгүй байх ёстой байсан. Тэгээд дэд сайд томилох болохоор л хуулиа бид нар барьж байна гээд яриад байгаа чинь ерөөсөө шалтаг юм шиг санагдаж байна Ерөнхий сайдаа. Та хэд дэд сайд гэдэг зүйлээ анхнаасаа оруулж ирэх ёсгүй ч байсан одоо ч гэсэн татаад авах ёстой гэдэг дээр хатуу байр суурьтай байна. Тэгэхээр миний асуулт бол олон улсын түвшинд эрчим хүчний салбарыг либералчлахдаа түгээх хангах салбараас нь эхэлдэг туршлагатай. Олон улсын байгууллагууд ч тэр манай эрчим хүчний салбарын мэргэжилтнүүд бүгдээрээ хэлж байгаа нь түгээх хангах салбараасаа бид нар энэ хувьчлалыг хийх ёстой гэж байхад эсэргүүцэж байгаа юм шигээр ТЭЦ-3, ТЭЦ-4-өөс ч байдаг юм уу энэ цахилгаан хуучны цахилгаан станцуудаасаа эхэлж байгаа нь өөрөө 2.3 жилийн дараа энэ салбарын үнийг чөлөөлөөгүйгээс болж эдгээр станцуудын үйл ажиллагаа доголдож эхэлнэ. Тэр үед нь өө энэ хувьчлал буруу байсан юм байна. Эрчим хүчний реформ ерөөсөө хэрэггүй байсан юм байна гэдэг зүйл рүү явуулах энэ алдаа давтагдах гээд байна Ерөнхий сайд аа.

Тийм учраас эрчим хүчний реформыг явуулах ёстой либералчлал хийх ёстой. Гэхдээ бодлогоо маш зөвөөр тодорхойлж хийх ёстой энэ үнэ тарифыг ингээд төрөөс бариад байдаг. Та өөрөө чуулган дээр байж байхдаа хэлж байсан. Дулааны үнэ тариф, цахилгааны үнэ тарифыг нэмэхгүй гээд. Гэхдээ өнөөдөр Ерөнхий сайдад

тэгэх эрх нь байхгүй хууль дээрээ. Их Хурлын гишүүнд энэ дулаан цахилгааны үнийг нэмэх эрх нь ч байхгүй хуулиараа. Эрчим хүчний зохицуулах хороо л энэ үнэ тарифын асуудлуудыг хуулиараа зохицуулах үүрэгтэй. Тэгээд 10 жил гаран ердөөсөө улс төржилтөөс болж үнэ тарифыг өөрчлөхгүй явж байгаад гэнэт 10.20 дахин нэмээд явчихдаг. Улс оронд энэ иргэд ААН-үүд төлөвлөх боломжгүйгээр гэнэт гэнэт өндөр дүнгээр энэ үнийн нэмэгдлүүдийг хийдэг. Өмнөх онд би хэлж байсан. Чойжилсүрэн сайдад хэлж байсан. Ердөөсөө шууд хэд дахин үнээр бид нар энэ үнийг өөрчилж болохгүй ээ. Бага багаар, жил болгонд нь, ард иргэдэд.

Г.Занданшатар: 1 дүгээрт хууль тогтоох байгууллага хууль сахиж мөрдөх ёсгүй гэж хэлж болохгүй ээ. Хууль дээдлэх тангараг өргөх би бүх хуулийг мөрдөж байгаа. Бид жишээлбэл төрийн албаны тоог 9 хувиар цомхтгож хууль биш бүр тогтоомжийг хэрэгжүүлсэн. 9 хувь гэдэг чинь асар том тоо шүү дээ. Хэдэн мянган хүнийг ажлаас чөлөөлөөд тэгээд энэ ажил үүргийн хийдэл, зөрчил, давхцал гаргагдахгүйн тулд төрийн хяналт механизмыг ажиллуулахын тулд хуульд заасан эрхэм чиг үүргээ л хэрэгжүүлж байна гэдгийг хэлж байгаа юм. Хэрвээ энийг шаардлагагүй гэвэл та хууль санаачлаад энийгээ хэрэгжүүлж болно. Эрчим хүчний либералчлал ч гэсэн тэр та бүхний хандлага чинь буруу байгаа юм. Ард иргэдэд үүрүүлэх ачааллаас нь эхлэх гээд байгаа юм. Та нар цахилгаан дулааны үнийг нэм гэж шаардаад байгаа юм.

Гэтэл тэр чинь анхан шатаас нь эхлээд чөлөөл гэдэг чинь нэм л гэсэн үг шүү дээ. Чөлөөл гэдэг чинь нэм гэсэн үг. Энэ суурь үнэ байдаг учраас инфляцад шууд нөлөөлдөг ард иргэдийн карман руу шууд орно. Цахилгаан эрчим хүчний үнэ шингээгүй нэг ч бүтээгдэхүүн байхгүй суурь үнэ. Энэ суурь үнийг чинь сууриас эхлэх ёстой юм аа. Яагаад гэвэл уул уурхайн үгүй үгүй нүүрсний нүүрс үйлдвэрлэж байгаа өртөг чинь авлигалаас болоод үр ашиггүй системээс болоод өндөр үнэтэй болох юм. Тэн дээр тодорхой хувь иргэдийн хяналт бий болгох хэрэгтэй байна. Энийг чинь хувьчлах гээд байгаа юм биш. Цахилгаан станцуудыг хувийн цахилгаан станцууд аль хэдийн байгуулаад гэрээ байгуулаад эхэлчихсэн байна. 9 центээр худалдаж авч байна. Гэтэл иргэдэд нийлүүлж байгаа хүн чинь өөр байна. Тэгэхээр чөлөөл гэсэн үг биз дээ. Тэгж бие биеийгээ хуураад яах вэ. Чөлөөлнө гэдэг чинь.

Тийм учраас 9 центээр жишээлбэл хувийн цахилгаан станц нийлүүлээд эхэлчихсэн. Тэгтэл 34 хувийг жишээлбэл Монгол шуудан компанийн 34 хувийг олон нийтийн болгож биржээр арилжаалснаар ашигт ажиллагаа, үр ашиг нь 1.6 дахин сайжирсан байна. Энэ ерөөсөө л иргэдийн хяналт бий болгож байгаа юм. Түүнээс биш стратегийн ач холбогдолтой салбаруудыг хувьчлах гээд байгаа юм огт байхгүй. Уучлаарай. Тэр ААН-үүд нь, иргэд нь 34 хувь. Тэр уурхайнууд дээр ард иргэдийн хяналтыг болгоё. Тэр станцууд дээр бий болгоё. Ингээд түгээх дамжуулах.

Н.Учрал: Нэг минут болчихсон уу? Аан болчихсон уу. Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Та хуулийн дагуу дэд сайдуудыг тавьж байгаа юм байна. Тэгэхээр дэд сайд гэдэг шагнал юм уу, ял юм уу? Миат компанийг 10 тэрбумын ерөнд оруулсан хүн өнөөдөр дэд сайд болсон. Энэ шагнал уу? ял уу? Дээрээс нь Ерөнхий сайдаа Монгол Улсад тогтвортой үйл ажиллагаа явуулдаг 99 мянган ААН байдаг юм байна. Энэнээс 70 гаруй мянга нь татварын өртэй. Татварын хүлээгдэж байгаа өр 6.2 их наяд төгрөг байна.

9 мянга гаруй ААН дансаа хаалгасан та түрүүн 4 мянга гаруй гэж хэллээ буулгасан бол сайн. Тэгэхээр одоо би нэг бодит жишээ асуух гээд байна. Иргэн А-ийн компани төрөөс тендер аваад 400 саяын ажил хийж гүйцэтгэсэн. Мөнгөө авч чадаагүй. НӨАТ-ын өр нь 40 сая. Гэтэл өнөөдөр татварын байгууллагаас 40 саяыг нь авахын тулд дансыг нь хаачхаж байгаа юм. Тэгэнгүүт нөгөө хүн чинь 40 саяа төлөхийн тулд ББСБ-аас 3 хувийн хүүтэй зээл авчхаж байгаа байхгүй юу. Төр өөрөө өглөгтэй мөртөө тиймээ өгөх ёстой мөртөө 40 саяын төлөө ААН-д ийм дарамт учруулж байгаа нь маш тийм дээрэлхүү бодлого байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг яагаад уян хатан болгож тохиролцоонд хүрч болдоггүй юм. НДШ-ийг тохиролцдог шүү дээ. Тэрэн дээр графикаар төлөөд явчихдаг. Татвар дээр бас ийм байж болох талтай шүү дээ, 2 асуулт.

Г.Занданшатар: Татварын байгууллагууд дээр сая энэ татварын реформын талаар хэлэлцүүлэг хийгээд данс хаахгүй зөвлөн туслах чиглэлийг илүү түлхүү баримтлах чиглэл өгсөн. Гэхдээ буруу хандлага хүлээлтийн улмаас санаатайгаар татвар төлөхөөс зайлсхийгээд байгаа уул уурхай нь ч байна уу тийм компаниуд дээр бас тодорхой хэмжээний шаардлага тавих хууль эрх зүйн орчин нь татварын байцаагчид байгаад байгаа юм. Ийм учраас энийг хуулиар зохицуулахаар Татварын багц хуульд тусгасан байгаа. Би 4398 ААН-ийн дансыг хаачихсан байснаа нээсэн гэж хэлсэн. Одоо бусад ААН-үүдийн татвар үе шаттайгаар данснууд нээгдэнэ. Энэ таны хэлж байгаа тэр шийдэлтэй холбоотой асуудал голцуу он дамнасан хөрөнгө оруулалтууд, он дамнасан хөрөнгө оруулалтууд он гараад шийдэгдэж болно. Он дамжаад тэдний хөрөнгө оруулалтын зардлыг шийдэж болдог тийм байдлаар шийдэж болох юм байна лээ. Он дотроо дуусаж байгааг бол ерөөсөө аль болох гүйцээж өгөх чиглэл барьж байгаа. Өртэй татвартай энэ тэр нь асуудлыг нь яриад нөгөө зөвлөн туслах маягаараа шийд гэсэн чиглэл өгөөд явж байгаа.

Асуудлын гол нь нөгөө Улсын Их Хурлаас баталсан Төсвийн хуулиар маань бид 1.3 их наяд, 1 их наяд 300 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар баталчихсан. Тэгэхээр зардлаа санхүүжүүлчихээр тэрийг давчих гээд байгаа учраас төрийн сангийн данс мөнгөтэй байгаа, шийднэ. Гагцхүү он дамнасан хөрөнгө оруулалтуудыг он гаргаад өгөхөөр нөгөө Төсвийн хуульдаа захирагдсан ийм зарим зохицуулалтыг Сангийн яамнаас хийж байгаа юм байна лээ. Урамшууллыг чиглэсэн эхний 3 дугаар улирлынхыг олгосон, 4 дүгээр улирлынхыг он гаргаад эхний улиралдаа шийдэж явдаг ажлын гүйцэтгэл үр дүнгээр нь шийдээд явна.

Татварын тодорхой ийм кэйсүүд дээр санал гомдлууд байвал энийг татварын маргаан таслах зөвлөл болон татварын гомдол маргаан шийдвэрлэх юмыг илүү хялбарчлах чиглэл өгчихсөн байгаа. Одоо хуулиар өөрчлөхгүй бол татварын байцаагчийн эрхийг Ерөнхий сайд буугаад ч гэсэн хууль зөрчиж хуулийн дагуу өөрчлөх эрхгүй юм байна лээ.

Тийм учраас Татварын багц хууль дээр та бас.

Н.Учрал: Нэмэлт нэг минут Мөнхбаясгалан.

Л.Мөнхбаясгалан: Та хуулиа биелүүлж дэд сайдуудыг тавьж байгаа. Тэгэхээр харин дэд сайд гэдэг чинь шагнал юм уу эсвэл ял үүрүүлж байгаа юм уу? Миат компанийг 10 тэрбумын өрөнд оруулсан хүн өнөөдөр дэд сайд болж байгаа байхгүй юу. Энэ хүн шийтгүүлээд байгаа юм уу, шагнуулаад байгаа юм уу? Уг ньбол хариуцлага тооцох ёстой гэж би бодоод байх юм. Хуулиараа ямар байдаг юм.

Ерөнхий сайд.

Г.Занданшатар: Ер нь орчин үед төрийн аливаа ажил албан тушаал нэг талаасаа хариуцлага болсон. Тэрийг ял гэж та хэлж байх шиг байна. Гэхдээ бид бас тэр хүнийг шалгаж үзсэн. Хүн шийтгэхэд хүндэтгэх шалтгаан хэрэгтэй. Тэр 10 тэрбумын алдагдалтай гээд чөлөөлсөн чинь дараа нь нарийвчилсан шалгалт хийгээд явсан чинь энэ бензиний авиа бензиний үнийн өсөлт, өөрөөр хэлбэл авиа бензиний гэрээ хэлэлцээрээ Улсын Их Хурлаар батлаагүйгээс шалтгаалаад энэнээс болоод үнэ цэн нь өндөр болоод зах зээлийн үнээс 30.40 хувиар өндөр шатахууны нийлүүлэлт энэнээс үндсэндээ шалтгаалсан алдагдал үүссэн учраас тэр хувь хүний буруу биш харин тодорхой ахиц дэвшил гаргасан, борлуулалт нэмэгдүүлсэн, үр дүнтэй байсан юм билээ. Тийм учраас энэ бол тэр алдагдлын шалтгааныг бид нарийвчилж судалж үзээд энийгээ аялал жуулчлалаар нөхөх ийм чиглэл үүрэг даалгавар оногдуулсан гэж үзвэл зохино. Үүрэг даалгавар өгч байгаа.

Н.Учрал: Даваагийн Цогтбаатар.

Да.Цогтбаатар: Энэ өдрийн мэнд хүргэе. Та тоо худлаа ярихгүй гэж ярьдаг 16 дэд сайд томилсон. Хэзээ ямар үр дүн гаргах вэ 1 дүгээр асуулт.

2 дугаарт нь, Монголчууд 7 хэмжиж нэг огтол гэдэг ээ. Та алдаатай шийдвэр гаргаж болохгүй. Хамгийн хариуцлагатай албан тушаалтан. Дэд сайд нараа сайн судалсан уу? Одоо энэ 16 дэд сайдын чинь ХОМ-тэй маш сайн танилцсан. Иргэдээс ирүүлж санал хүсэлт дотор бол 3 дэд сайдын боловсролын сангийн зээлээр авчихсан 7-оос 10 жил болж байгаа төлөгдөөгүй зээлийн өрийн үлдэгдэл байна. Энэ бол зээл. Зээл бол төлөгдөх ёстой тэглэгдэх ёсгүй. Энийг та ч мэдэж байгаа, би ч мэдэж байгаа. Эдийн засаг ойлгодог бүх хүн мэдэж байгаа. Тэгээд энэ дээрээ та ёс зүйн хариуцлага хүлээлгэж чадах уу гэдэг нэг ийм 2 дугаар асуулт байна.

Гуравт нь Булган аймгийн Засаг даргын асуудал байна. Иргэдийн хурал нь та ажлаа зохион байгуулж чадахгүй байна, болохгүй байна гэдгийг нь дүгнээд дүгнэлт гаргаад тан руу хүргүүлсэн байх. Гэтэл Булган аймгийн засаг дарга өнөөдрийг болтол ажлаа хийгээд яваад байгаа. Яг энэ нөхцөл байдал 4 дүгээр асуудалтай холбоотой Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Засаг даргын асуудал. Энэ 4 асуултад хариулт өгөөч.

Г.Занданшатар: Ер нь манай Улсын Их Хурлын энэ мэтгэлцээний цаг, парламентын мэтгэлцээний цаг гэж бид ойлгож байгаа. Урьдчилж асуулт асуух нь дүүрч ерөөсөө ингээд бүх талын асуултууд асуудаг бас UB комедиагийн дайралцаа шиг байж болохгүй гэж бодож байна. Дайралцаа нь ч гэсэн логиктой байх ёстой. Тэгэхдээ энэ дэд сайд нарын асуудлуудыг хянадаг шалгадаг газар өөр тусдаа хариуцлага тооцуулаад явах ч гэсэн тус хууль номынхоо дагуу шийдэгдэнэ.

Хамгийн гол нь үр дүн нь бүтээмжтэй ажиллах ёстой. Ер нь тухайн үед 2015 онд Ардчилсан нам засаглаж байх үед энэ боловсролын зээлийн санг анх тухайн үеийн Ерөнхийлөгчийн санаачилгаар эхлэхдээ төрд ажиллаж, энэ хүмүүс мэдлэг, ур чадвараараа энэ өрөө төлөх ёстой гэсэн ийм агуулгаар баталсан юм байна лээ. Одоо энэ хүмүүс эндээ ажиллаж үр ашгаа өгч сурсан мэдсэнээ улс орондоо зориулж энэ мэдлэг чадвараа Монголдоо зориулж гаднаа үлдчихгүй, гадаадад явчихгүй, энэ тархи оюунаа гадагш нь алдчихгүй улс орондоо ажиллаад улс орныхоо төлөө шинэ

бүтээл, санаачилга гаргаад, олон тэрбум төгрөгийн үр ашигтай бодлого хөтөлбөр хэрэгжүүлээд ажиллаж чадвал энэ харин үр дүнгээ өгнө гэсэн үг.

Түүнээс гадаадад сурсан болгоноо гадагшаа тавьж явуулчихаад байвал хайран улсын мөнгө болно шүү дээ. Тийм учраас одоо энэ хүмүүсээс хариуцлага, үр бүтээмж, үр дүн л нэхэж шаардаж ажиллах ёстой. Энд 30 хоногийн хугацаатай 300 хоногийн хугацаатай даалгавар өгөгдөөд байгаа. Энэ салбар болгондоо тодорхой ахиц дэвшил, үр дүн, хариуцлага тооцож ажиллах чиглэлтэй ажиллаж байгаа. Энийг тухайн үед нь хараад дүгнээд та асууж жич уулзаад явж болно.

Тэр Булган аймгийн Засаг даргын асуудал бол Үндсэн хуулийн цэц дээр маргаан үүсээд явж байгаа юм байна гэж ойлгосон. Тэгэхдээ шүүх дээр Цэц дээр маргаан үүсгэсэн асуудлаар Цэцийн шийдвэр маргаан гарсны дараа таслан шийдвэрлэх хуультай номтой. Тэр сумын Засаг даргын асуудлыг та надаас илүү өөрөө мэдэж байгаа учраас өөрөө улс төрийнх нь хувьд өөрөө очоод зохицуулаад шийдээд явах нь зөв байх. Орон нутгийн иргэдийн хуралд.

Н.Учрал: Нэмэлт нэг минут. Цогтбаатар гишүүн.

Да.Цогтбаатар: Би танд яг баримтыг нь харуулъя. Г.Ганболд. Ганболдын Уянгаа 2018-2020 онд 317 сая төгрөгийн зээл авч сурсан. Одоо болтол төлөөгүй. Д.Гантулга энэ охин энэ эхнэр нь байгаа юм. 1997-1999 онд 92 сая төгрөг авч сурсан. Тэглүүлсэн төлөөгүй. Энэ Гантулгын эхнэр юм байна.

Г.Занданшатар: Уянга гэж дэд сайд байхгүй шүү дээ.

Да.Цогтбаатар: Ганболдын Уянга. Ганболд сайд. Улсын Их Хурлын гишүүн байсан. Улс төрд мэдээлэлд нөлөөтэй байсан хүмүүс тэр байдлаа давуу байдлаа ашиглаж танай дэд сайд Зам, тээврийн дэд сайд. Ганболдын Уянга гэдэг хүнийг би энд яриад байна. Тэгээд би таныг энэ хүмүүсээ бүрэн сайн судалж байж томилсон уу? Та 7 хонож байж нэг огтлох ёстой. Хамгийн хариуцлагатай шийдвэрийг гаргах ёстой хүн шүү л гэж асуугаад байгаа юм.

Г.Занданшатар: Миний мэдэж байгаагаар Ганболд дэд сайдын охин Улсын Их Хурлын гишүүн байхад нь энэ Ерөнхийлөгчийн тэтгэлэгт шалгараад тэгээд өөрөө татгалзсан. Өндөр албан тушаал хашдаг учраас тэр онц сайн сурдаг өндөр чадвартай хүүхэд байсан боловч татгалзсан. Энэ бол бие даасан субъектүүд Үндсэн хуулийн дагуу таны ахын ч юм уу тэр хүний хүүхдийн ч юм уу хийсэн асуудлыг гэмт хэргийг бусдад нь нялзаадаггүй. Гэхдээ тэр тусдаа асуудал. Энэ чинь төлөөд л явж байна шүү дээ. Төлчихсөн л байгаа биз дээ. Тийм ер нь зээл авах бол гэмт хэрэг биш шүү дээ. Төлөх л ёстой.

Н.Учрал: Лодойсамбуу гишүүн.

Ч.Лодойсамбуу: Манай Ерөнхий сайд логик нэхээд байна. Би логик ярьж өгье. Миний минутыг 3 минутаар нь бүтэн өгчхөөрэй. Монгол Улс Ерөнхий сайдаа хайгаад байна л даа. Монголчууд Монгол Улсын Ерөнхий сайдыг олж харахгүй байна. АНУ-д сургууль төгссөн боловсролтой, тогтуун. Сүүлд Их Хуралд олон удаа суусан. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг гардан зохион байгуулсан эрдэм мэдлэгтэй Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга байсан. Шатар тоглодог, ном уншдаг ухаантай хүнийг харж байна, сайхан ухаантай Монгол ахыг харж байна.

Гэхдээ энэ хүнээс Ерөнхий сайдыг олж харахгүй байна л даа. Яагаад ингэж байна вэ гэхээр Монголчууд үе үед Ерөнхий сайд шиг Ерөнхий сайд нарыг харж байсан. Тусгаар тогтнолынхоо төлөө амь биеэ үл хайхран зүтгэж байсан Ерөнхий сайд нарыг харж байсан. Өмч хувьчлалыг хийж чадсан Ерөнхий сайдыг харж байсан.

Таван төгөлдөршил гэж нэрлээд Атрын 3 дугаар аян гэж хэрэгжүүлээд эхний 200 хоногтоо үр дүнгээ танилцуулж байсан Ерөнхий сайдыг харж байсан. Шинэчлэл бол сэтгэл хийж гаргаж хийх ажил юм гээд шинэчлэлийн бодлогоо 100 хоногтоо танилцуулаад 200 дахь хоног дээрээ үр дүнгээ танилцуулж байсан Ерөнхий сайд нарыг харж байсан учраас Монголчууд өнөөдөр Ерөнхий сайдаа хайгаад байгаа. Өнөөдөр яагаад Ерөнхий сайдыг хайж байна гэж хэлж байна гэхээр Монголчууд өнөөдөр өрх бүр, өрхийн гишүүн болгон амьдралд нь наалдахгүй тоо яриад байдаг, амьдрал нь дордоод доройтоод байгааг анзаарахгүй байгааг тэр төрийг хараад гомдоод байгаа юм. Нэгхэн тоо хамгийн сүүлийн тоо.

12 дугаар сард 11 дүгээр сараас бүтээгдэхүүний, бараа бүтээгдэхүүний үнэ, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ нэгхэн сарын дотор 6.7 хувиар өссөн статистик харагдаж байгаа. Эдийн засгийн өсөлт нь өрхийн хаалгаар орохгүй байгааг зүгээр энэ тоог л жишээлбэл харуулж байгаа юм. Бид нар өрхийн амьжиргаагаа ярихгүйгээр баахан тоо яриад байгаад л Монголчууд гомдоод байгаа.

Н.Учрал: Ерөнхий сайд хариулна. Дараа нь нэмэлт нэг минут.

Г.Занданшатар: Би улаан бал нэвтрүүлэг хөтөлж байсан. Шударга үнэний дуу болж байсан Лодойсамбуу гишүүнийг хайж олж харахыг хүсэж байна.

Энэ инфляц бол жилд 14 хувиар өсөж байхад энэ ковидын шалтгааны улмаас энэ бараа бүтээгдэхүүний үнэ 2.3 дахин өсөж байхад тэгээд өнөөдөр энийг нь сааруулаад бид өөрчлөлт гаргаж байхад мэдээж инерцээрээ хүний амьдрал нэг өдөр сайн сайхан болчихгүй. 6 сарын дотор сайн сайхан болчихгүй. Өнөөдөр харин энэ 53 хүнсний үйлдвэр шинээр нээгдсэнийг яагаад олж харахгүй байгаа юм бол? Яагаад хүнсний хангамж бүтээгдэхүүн сайжирч байгааг яагаад олж харахгүй байгаа юм бол? Яагаад инфляц саараад 8.2 болж байгааг дандаа тоо гэж үзэж байгаа юм бол? Өнөөдөр валютын ханш чинь нүдэн дээр чинь 3605-аас 4 мянгад хүрэх гэж байхад энийг бид 3550 болгож бууруулж байгааг яагаад харахгүй байгаа юм бол? Энэ хүний амьдралд наалдацгүй гэж үү? Ийм бодит үнэнийг олж харахгүй заавал юмыг үгүйсгэж яагаад хараад байгаа юм бол? Яагаад дандаа үгүйсгэхийн тулд биш болж бүтэж байгаа юмыг нь хараад ажиллаж болдоггүй юм бол. Яагаад энэ дээр хамтраад хууль санаачлаад, жишээлбэл энэ энэ үнийн өсөлтийг шийдвэрлэх ард иргэдэд амьжиргаанд шийддэг асуудлыг Улсын Их Хурлын гишүүний хувьд энэ дээр хамтраад ажиллаж болдоггүй юм бол гэх мэтчилэн ингээд тайлбарлаад байвал болно оо. Тэгэхдээ инфляцыг өдөөж байгаа хамгийн гол хүчин зүйл болох нийлүүлэлтийн инфляц, энэ эрэлтийн инфляцыг бид хязгаарлачихлаа. 2.3 их наяд төгрөгөөр төсөв таналаа шүү дээ. Энэ чинь төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулж, 9 хувь гэдэг чинь асар том тоо, олон мянган хүний асуудал. 5.2 их наядаар төсвийн унах байсан. Ер нь ингээд унаж байгаа бүх юмыг тоормослоод зогсоогоод дээш нь хошууг нь өргөж байгаа энэ бүхнийг үгүйсгээд байгаа юм бол. Энэ мэтчилэн.

Н.Учрал: Лодойсамбуу гишүүн нэг минут.

Ч.Лодойсамбуу: Таныг яг энэ өрхийн амьжиргаатай холбоотой энэ өрхийн санхүү муудаж байгааг олж харахгүй байгааг чинь харин бүгд гайхаад байгаа учраас асуугаад байгаа юм. Хамгийн сүүлийн жишээ та хэмнэлтийн горимд шилжиж, энэ тэтгэврийг нэмэгдүүлэхийн тулд хэмнэх ийм албан даалгавар гаргасан байна лээ. Жишээлбэл та энэ шинэ жилээр тэтгэвэр нэмэх гэж байна гэж мэндчилгээ дэвшүүлэх гэж байгаа юм шиг байгаа юм. Гэтэл тэнд цалин урамшууллаа хасуулчихсан төрийн албан хаагчдаас нэг халааснаас нь аваад нэг өрхөөс мөнгийг нь аваад нөгөө өрх рүү шилжүүлэх гэж байгаагаа улс төрийн PR болгож ярих гэж байгаа юм.

Өнөөдөр Монгол Улс яагаад энэ тухай сэтгэгдэл нь ийм байна вэ гэхээр өнөөдөр баярын уур амьсгалтай байгаа нэг ч айл өрх алга. Өнөөдөр Ерөнхий сайд 12 дугаар сарын 31-ний орой ямар мэндчилгээ дэвшүүлэх юм, юу хэлэх юм. Ямар ерөөл хэлэх юм. Ямар итгэл найдвар бид нарт байгаа юм.

Г.Занданшатар: Лодойсамбуу гишүүн ээ би ингээд шинэ жилээр сэтгүүлч хүн шиг гоё мэндчилгээ дэвшүүлэхдээ гол биш. Яг энэ бодитой наалдацтай үр дүнгүүдийг гаргахыг л эрхэмлэж хэлж байгаа юм. Таны нэг карманаас аваад нөгөө карманд өгч байгаа зүйл байхгүй шүү дээ. Энэ улсын төсвийн, таны баталсан, та бидний баталсан улсын төсөвт багш нарын цалинг 70 хувиар нэмэгдүүлэхээр, тэтгэвэр тэтгэмжийг 8.6 хувиар нэмэгдүүлэхээр. Тэтгэвэр тэтгэмж бүх тэтгэмж орж байгаа шүү дээ. Ийм хууль батлаад л энийгээ бид хэрэгжүүлээд явж байгаа хэрэгжүүлнэ. Тэр урамшуулал түрүүн би хэлчихсэн шүү дээ. Эхний 3 улирлын урамшуулал олгогдчихсон. 4 дүгээр улирлын урамшууллыг оны эцэст бүтээмж, үр дүнд нь суурилж, даргын үзэмжээр хуваарилдаг тогтолцоог халж хэн ажлаа сайн хийж байгаа нь, хариуцлагатай хийж байгаад нь урамшууллыг нь олгодог шинэ тогтолцоонд шилжүүлж байна.

Н.Учрал: Батбаярын Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Өнөөдөр Улсын Их Хурлаас Оюу толгой төслөөс Монголын талд ноогдох өгөөжийг 53 хувиас доошгүй байлгах асуудлыг баталгаажуулах чиг үүргийг Засгийн газарт өгсөн ийм тогтоол батлагдсан. Тэгээд бид хэд сая хэвлэлийн хурал хийсэн чинь сэтгүүлч нар ингэж асууж байна. Өмнө нь Улсын Их Хурлаас удаа дараалан хэд хэдэн тогтоол баталсан. Тэгээд тэдгээрийн хэрэгжилт маш муу байгаа нь сая сонсгол дээр ч гэсэн яригдсан. Энэ тогтоол чинь хэрэгжих үү гэж асууж байна. Өмнө нь ноднин бид нар хаврын чуулганаар агаарын бохирдолтой холбоотой нээлттэй ерөнхий хяналтын сонсгол хийсэн. Үүний ар дээр Улсын Их Хурлаас бас энэ утаатай тэмцэх асуудлаар нэг тогтоол баталсан. Тэр тогтоолын хэрэгжилтийн талаар би танд удаа дараалан албан бичиг явуулсан. Харамсалтай нь энэ тогтоол хэрэгжихгүй байгаад байгаа юм.

Тэгэхээр өнөөдөр бид нар итгэл ярьж байна л даа. Төрд итгэх итгэл үнэхээр алга. Улсын Их Хуралд тодорхой шийдвэр гаргаад байж болж байна. Гэлээ гэхдээ тэрийг нь хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгтэй Засгийн газар огтоос тэр хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүргээ биелүүлэхгүй байна. Гэтэл та өнөөдөр би дэд сайд томилсноороо хууль биелүүлж байна гээд яриад зогсож байдаг. Та нөхөд намаржингаа сандал суудал албан тушаалын хэрүүл маргаан хийлээ шүү дээ. Тэгээд хүмүүс яагаад энэ дэд сайд нар дээр чинь бухимдаад байна вэ гэхлээр энэ томилгоо чинь ерөөсөө дуусахгүй байгаад байна. Тэгээд одоо би хууль биелүүлж байна гээд ийм баатар шиг зогсоод байж болохгүй Ерөнхий сайд аа.

Тэгээд та энэ дэд сайд томилж байгаа явдал чинь ер нь энэ танай Засгийн газарт байгаа сайд нарт чинь ямар ч итгэл төрөхгүй байгаад байна. Энэ бодлогын манлайлал харагдахгүй байгаа чинь өнгөрсөн цаг хугацаанд Оюун-Эрдэнийн Засгийн газарт ажиллаж байсан сайд нар бүгдээрээ ингээд улираад тэгээд ингээд сандал суудлаа сэлгээд ажиллаж байгаа. Чойжилсүрэн сайд эрчим хүчний салбарт үр дүн гаргана гэдэгт ерөөсөө энэ улсад итгэж байгаа хүн алга. Жавхлан сайд яаж ч хичээгээд.

Н.Учрал: Жаргалан гишүүн нэг минут өгчихье.

Тэгэхээр таны баг бүрэлдэхүүнд итгэл ерөөсөө хүрэхгүй байгаад байна хүмүүсийн. Тийм л асуудал яригдаад байна. Тэгээд Засгийн газар зүгээр ийм гарчиг тавих маягаар ийм гоё аформизмтай гоё зурагтай постер хийх маягаар ажил хийгээд байна. Энэ гарчгаар битгий ажил хийгээч. Бид нар цаг хугацаа маш бага байна. Эд нар чинь та бид нарын адилхан л цаг хугацаа. Монголчуудын бүгдийнх нь цаг хугацаа. Тэгээд энэ цаг хугацааг битгий үрээч л гэж байгаа юм. Та 2025 оны 6 дугаар сарын 12-нд томилогдсон. Анхны энэ хэлэлцүүлэг энэ мэтгэлцээн болохлоор таны 100 хоног дээр явагдсан. Өнөөдөр та албан тушаалаа аваад 197 дахь хоногтоо ажиллаж байна. Тэгээд надад ерөөсөө ганцхан л асуудал байна асуулт байна. Танд Ерөнхий сайдын албан тушаал дахиад 100 хоног, бүүр больё, дахиад 3 хоног ажиллах үр дүн гаргах итгэл өөрт чинь байна уу?

Н.Учрал: Ерөнхий сайд.

Г.Занданшатар: Энэ таны хэлсэн 187 хоногт уруудаад байгаа эдийн засгийг сэргээсэн байна. Бодит тоо баримт та өөрөө эдийн засагч хүн сайн мэдэж байгаа. Эдийн засгийн өсөлт оны эцэст 6.4 хувьд хүрнэ. Энэ чинь тоо чинь итгэл. Хоосон итгэл биш бодит итгэл ярих ёстой. Хоосон шүүмжлэл биш бодит тоо ярих ёстой. Энэ тоо чинь худлаа хэлдэггүй гэж би хэлээд байна шүү дээ. Эдийн засгийн өсөлт 6.4 хувь болгочихсон байна. Энэ өөрөө болоогүй, валютын нөөц 6.5 тэрбум доллар болно. Энэ өөрөө болоогүй. Валютын ханш 3600-д аваад 4 мянга хүрэх гэж байсан өнөөдөр 3545 болгож буулгалаа. Энэ чинь тоо баримт. Энэ бүхэн чинь сэргэлтийг бодитой харж байгаа. Өөдрөгөөр харвал. Дандаа хар талаас нь хараад байвал амьдралд нэг ч болж бүтэж байгаа юм байхгүй байж болно. Харин бас гэрэл гэгээтэй өдрийг бас бид харж урагшаа алхаж байна. Хүнд жил байсан, сорилттой жил байсан. Бүх юмыг сайн сайхан болж байна гэж бид хэлэхгүй. Гэхдээ энэ хүндийг даваад шийдээд өөдрөг жилийг өгч байна. Ирэх жил хүнд болно олон улсын нөхцөл байдал, эдийн засгийн прогноз хүнд байгаа. Гэхдээ бид илүү сайн болгох эдийн засгийг сэргээх 300 хоногийн төлөвлөгөө батлаад ажиллаж байна. Өдөр өдрөөр нь шахаад, хийх функцээр нь шахаад. Сайд дэд сайдтай нь шахаад ажиллаж байна. Тэгтэл бүхэл бүтэн АН-ын бүлэг энэ 300 хоног сэргээх улс орныхоо эдийн засгийг сэргээх асуудлын талаар улсын эдийн засгаа сэргээх талаар биш 16 дэд сайд бүгдээрээ асуусаар байгаад өнөөдрийн цагийг барж байгаад харамсаж байна. Бид илүү бүтээлч юм яримаар байна шүү дээ. Монгол Улс чинь 220 мянган төрийн албан хаагч ажиллаж байна шүү дээ. Энэ 220 мянган төрийн албан хаагчийн ажлын бүтээмж, үр дүнг сайжруулах, эдийн засаг, үр өгөөжийг сайжруулах асуудлыг бүгдээрээ хамтдаа шийдмээр байна шүү дээ. 53 шинэ үйлдвэр баригдаж байгаа бол энийг 100 болгомоор байна шүү дээ. Ингэж байж байж бид эдийн засгаа сэргээж, татварын реформоо хийж тэр Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг маань батлаад өгчих хэрэгтэй байна. Татварын багц хуулийг хэлэлцмээр байна.

Н.Учрал: Жадамбын. Баясгалан гишүүн.

Ж.Баясгалан: Энэ өдрийн мэнд хүргэе. Тэгээд сая 21 аймаг тойроод ирлээ. 21 аймгийг нийт 10012км замыг 236 цагийн туршид машиндаа явлаа. Ажлын 21 хоногт 21 аймагтай уулзлаа. Ингээд нийт 5600 орчим иргэдтэй уулзаж 3 мянга гаран саналтай ирлээ. Тэгээд энэ хүмүүсийнхээ 1 дүгээрт үгийг нь гялс хэлчихье. Сайдаа нэмэхээр шатахуунаа нэмээч гэж байх юм. Сонгууль болгоноор Зоригийн хэрэг шиг ярьдаг бас нэг дэд сайд гээд хэрэг гараад ирлээ. Энэ хэргийг нэг мөсөн энэ Хууль зүйн яамандаа өгчхөөч гэсэн саналыг ард түмэн хэлж байна аа. Тэгээд ард түмэн бол ерөөсөө уг нь дан дээлтэй сайд нартай больё гэсэн чинь бүүр нэмэгдээд дан дээл байтугай дэд сайдтай болчихлоо шүү гэдэг саналыг дамжуулж байна шүү.

Гол асуудал гэвэл 1 дүгээрт Дундговь аймгийн хэмжээнд бөөрний аппаратад 23 хүн орж байна. Энэ бөөрний аппаратад орж байгаа 23 хүнээс ЭМД-ын сан хоосорсонтой холбоотой А, Б уусмалаа авч чадахгүйгээс болоод үйлчилгээгээ авч чадахаа байсан. Нэг диализын аппарат нь эвдэрсэн. Энэнээс болоод энэ 23 хүний амь настны асуудал тэнсэж байна аа. Энэ дээр яах ёстой вэ? Энэ ЭМД-ын сангийн асуудал дээр ямар арга хэмжээ авах вэ? Энэ дээр нэг яаралтай арга хэмжээ авч өгөөч ээ. Он дуусах гэж байгаа учраас 21 аймагт яг энэ ЭМД-ын сантай холбоотой гомдлууд ерөөсөө маш их ирлээ. Энэ саналыг бол Дундговь аймгийн 6 дугаар багийн иргэн Эрдэнэчулуу гэж хүн тавьсан байна аа. 1 дүгээр асуулт энэ байгаа. Энэ дээрээ би танаас яг хариултаа авчихъя. Тэгээд хоёрыгоо тавья.

Г.Занданшатар: ЭМД-ын санг шинэчлэн өөрчлөх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байна. Үнэхээр ЭМД-ын санд сахилга батгүй замбараагүй байдал ноёлчихсон байснаас болоод энэ сан өр үйлдвэрлэдэг сан болчихсон байсныг өөрчилж, яг ард иргэддээ хүрдэг, тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ үйлчилдэг асуудлыг нь шийддэг ийм өр биш өглөг, өр үүсгэдэг байсныг нь шийдвэрлэж 279.6 тэрбум төгрөгийн өр үүсгэсэн байсныг 200 гаруй тэрбум төгрөг болгож бууруулаад байна. Ер нь ЭМД, нийгмийн даатгалын сангуудын менежментийн шинэчлэлүүд хийгдэж байгаа.

Яах вэ шатахууны хувьд бол мэдээж ОХУ-ын дотоод нөхцөл байдал дотооддоо шатахуунаа хязгаарлаж байгаа дайны нөхцөл байдал довтолгоог та бүхэн сайн мэдэж байгаа. Гэсэн хэдий ч бидний яриа дипломат хэлэлцээний үр дүнд Монгол Улсын шатахуун таслахгүй нөхрийн хэрэг бүтвэл өөрийн бүтнээ гээд өөрсдөө хязгаарлаад манайд нийлүүлж байгаа. Сая ч гэсэн нөхцөл байдлыг нэмэгдүүлээд 2 дахин шатахуун нэмэгдүүлэх яриа хэлэлцээрийг ярьж шийдээд өнөөдрөөс улам нэмэгдэж байна. Өнөөдрөөс бол ШТС-ууд, хөдөө орон нутгийн хангамжийг сайжруулна. Ирэх сард 1 дүгээр сард бид нөөцтэй болох ийм бодлого баримталж байна. Үндсэндээ бид нар мега төслүүд яриад байгаа гэсэн мөртөө нэг ч сав бариагүй юм байна лээ. Орос нөхдүүд маань бидэнд хэлээд байна шүү дээ. Та нар нэг их шатахууны савтай болчихооч дүүргээд өгье өө тэгвэл танайх тасалдахгүй болно оо.

Тэгтэл манайд Улаанбаатар хотод гэхэд 100 мянган машин нэмэгдсэн. Манай бензин шатахууны хэрэглээний хэрэглээ 1 сая тонн байсан бол одоо 2 сая тонн болоод 2 дахин нэмэгдчихсэн. Тэр хэмжээндээ ШТС-ууд маань ч тоо нь хэвээрээ, захиалга маань ч хэвээрээ байсан зохицуулалтын алдаанууд байсныг засаж залруулж байна. Ингээд нийлүүлэлтээ бол ирэх 1 дүгээр сараас тогтворжуулахаар

ажиллаж байна. Тэгэхдээ энэ давагдашгүй хүчин зүйл гэж асуудлууд байна аа. Мэдээж Оросын.

Н.Учрал: Баясгалан гишүүнд нэг минут өгье.

Г.Баясгалан: ЭМД-ын сан хоосорсонтой холбоотой нөгөө ирээдүйд авах арга хэмжээг ойлгочихлоо. Яг одоо энэ он гартал энэ доголдоод байгаа тэр өвчтэй хүмүүсийн асуудлыг яах вэ? Тэр амь нас эрсэдвэл энэ асуудлыг хэн хариуцах вэ? Энэ дээр яг тодорхой хариулт авчихъя.

Хоёрдугаарт гэвэл Улсын Их Хурлаас батлагдсан тогтоол хэрэгжих юм уу? Энийг иргэд их асууж байна. Энэ нь нөгөө хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр тэтгэмжийг 20 хувь, асран хамгаалагчдын тэтгэвэр тэтгэмжийг 8.6 хувь нэмнэ гэсэн. Гэтэл энэ чинь 12 сарын 31-нд яригдах болчихоод байна аа. Энэ дээр ерөөсөө яг тодорхой мэдээлэл өгөөч ээ. Та энд нэмэгдчихсэн гээд яваад байна гэтэл энэ чинь нэмэхгүй болчихож байгаа юм биш үү гэдэг айдас иргэдийн дунд маш их байна.

Ахмадуудын хувьд ялгаа алга байна. Тэтгэвэр тэтгэмжийг нь нэмэхээ байчих шиг боллоо. Энэ ерөөсөө яг ямар асуудал байна энийг яг Ерөнхий сайдаас шууд асуугаач гэсэн ийм даалгавар өгсөн шүү.

Н.Учрал: Баярлалаа юуны өмнө Баясгалан гишүүндээ нөгөө ард иргэдтэйгээ уулзаж бүх аймгаа тойрсонд нь баяр хүргэе. Ингэж суусан цэцээс гэж явж ингэж ажиллаж байгаа нь сайн байна. Ард иргэдийнхээ асууж байгаа зүйлийг бидэнд хүргэж байгаад талархал илэрхийлье. Энэ гэнэтийн асуулт байна. Тэгэхдээ би хариулъя. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд 36.8 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн байдаг түүнээс 16.1 мянган хүүхэд бий. Нийлээд 51 орчим мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэмжийг 20 хувиар нэмэгдүүлэхээр Улсын Их Хурал тогтоол баталсан. Үүний дагуу 1 сарын 1-ээс нэмэгдээд явна. Хэрвээ би андуураагүй бол нэг 327500 төгрөгийн тэтгэмж авдаг хөгжлийн бэрхшээлтэй иргэд энэ нь 477500 болж нэмэгдэнэ. Түүнээс гадна нөгөө асаргааны тэтгэмж байна шүү дээ 75 мянгаар ч юм уу асаргааны тэтгэмж авдаг хүмүүс байдаг. Энэ бас 8.6 хувиар нэмэгдэнэ. Нийт тэтгэвэр тэтгэмжийг өндөр насны болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэмж бүгдээрээ жигд 8.6 хувиар нэмэгдэнэ.

Н.Учрал: Минут дууссан байна, хугацаа дууссан байна.

Аубакир сайд нэмэлт нэг минут тодруулж хэлье.

Т.Аубакир: Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд төрийн халамж шаардлагатай иргэдийн орлого амьжиргааг нэмэгдүүлэх хүрээнд нийт 93.3 тэрбум төгрөг зарцуулахаар баталсан. Энэ төсөвт багтаан 2026 онд хөгжлийн бэрхшээлтэй хүний тэтгэвэр тэтгэмжийг 20 хувиар, бусад халамжийн тэтгэвэр тэтгэмжийг 8.6 хувиар нэмэгдүүлэхээр Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын салбарын төсөвт тусгасан. Тийм учраас ирэх 3 дахь өдрийн хурлаар шийдэгдээд үндсэндээ 1 сарын 1-ээс саяын 8.6 хувь буюу 20 орчим хувиар бүх асаргааны халамжийн тэтгэвэр, шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр тэтгэмжүүд яг хууль ёсныхоо дагуу нэмэгдээд явна гэсэн залруулга хэлчихсэн байгаа.

Н.Учрал: Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийн гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Улсын Их Хурал дахь олонхын бүлгийн асуулт ирүүлсэн гишүүд ирцэд бүртгүүлсэн дарааллын дагуу асуулт асууна аа. Нэг л гишүүн нэрээ ирүүлсэн байгаа. Даваасамбуугийн Ганмаа гишүүнийг индэрт урья.

Д.Ганмаа: Сайн байцгаана уу? МАН-аас нэг хүн байгаа юм байна. Миний асуулт ч ойлгомжтой Ерөнхий сайд ойлгож байгаа байх. Эрүүл мэндтэй холбоотой л юм асууна. 2016 онд батлагдсан Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль гэж байгаа. Энэний хэрэгжилтийн түвшин ямар байгаа вэ. Тус хуулийн ямар зүйл заалтууд нь бодитоор хэрэгжихгүй байгаад байна? Хэрэгжихгүй байгаа гол шалтгаан нь юу гэж та үзэж байна аа? Энд би нэг товчхон хэдэн үг уншаад өгчихье. Тухайн үед 2016 онд энэ хуулийг батлахад ард иргэд тэгээд Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсгийн ахлагч, ер нь бүгдээрээ их хүч чадал гаргаж ажилласан байна лээ. Тэгээд их гоё сэтгэгдлүүд бичиж байсныг нь би бүгдийг нь нэгд нэгэнгүй уншсан.

Жишээлбэл энэ дээр энэ хуулиар эмнэлгийн засаглалын асуудал төрөөс хараат бус байна.

Хоёрдугаарт эмнэлгүүд санхүүгийн эрх мэдлээ өөрсдөө авна.

Гуравдугаарт, сонгуулийн үр дүнгээр ялсан намын томилгоо биш. Эмнэлгийн дарга нарыг томилдог хүмүүс нь өөрсдөө, мэргэжилтнүүд, ажилчид нь байна. Туршлагатай, мэргэжлийн, мэдлэгтэй хүмүүс эмнэлгээ удирдана. Төрийн болон орон нутгийн өмчит эмнэлэг нэгдсэн эмнэлгийн захирал нь батлагдсан төсвийг үр ашиггүй хэмнэхгүй. Даатгалын тэнцэтгэл хасахдаа орохгүй. Харин ч цалингаа нэмэх, эмч эмнэлгийн ажилчдаа урамшуулах, цаашилбал гадаад, дотоодын хөрөнгө оруулагчтай ажиллах гэх мэтийн бүх эр мэдэл нь нээгдэнэ гэх гэх мэтчилэн их сайхан хүлээж авсан байна. Гэтэл энэ хууль батлагдаад 9 жилийн хугацаанд нөхцөл байдал яг тийм биш байгаа. Энэтэй холбоотой эдгээр асуултад хариулж өгнө үү.

Н.Учрал: 2016 онд батлагдсан Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хуулийн хэрэгжилт хангалттай бус байна. Эрүүл мэндийн салбар 2021 оноос хойших нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжиж, эрүүл мэндийн багц хуулиар зохицуулж ирсэн. Тэр хуульд зааснаар хувийн хэвшил, хувийн хэвшлийн төрөлжсөн мэргэжлийн нэгдсэн эмнэлэг, клиник түргэн тусламжийн төвөөр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх улсын төсвөөс санхүүжүүлэх тусламж үйлчилгээний жагсаалт сонгон шалгаруулалт болон гэрээ байгуулах, хэрэгжилтийг нөхөх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам, гэрээний загвар, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг ЭМД-ын Үндэсний зөвлөлөөр Зөвлөлийн тогтоолоор батлан хэрэгжүүлж байгаа юм байна. Тэгэхээр нөгөө хуулийн хэрэгжилт дээр энэ журам заавруудыг цэгцлэх ажил Засгийн газраас хэрэгжиж хэрэгжүүлж эхэлсэн. Одоо мянга гаруй журмыг хүчингүй болгохоор ажиллаж байна. Манай хуульд нийцээгүй энэ мэт журмаар хүний эрхийг хязгаарлаж байгаа аль эсвэл хуулийн үзэл санааг дордуулж байгаа ийм нийт мөрдөгдөж байгаа журам дотроос мянган журмыг хүчингүй болгохоор манай ХЗДХЯ ажиллаж байна. Энэ дотроо энэ төлбөртэй тусламж үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ болон санхүүжилтийн зарцуулах журмыг эрүүл мэндийн болон Сангийн сайдын 2022 оны хамтарсан тушаалаар батлан хэрэгжүүлж байгаа. Энэ бол инфляц үнийн өсөлттэй уялдуулаад энэ 2022 оноос хойш гарсан эм, эмнэлгийн хэрэгслийн ковидоос хойших нөгөө эм, эмнэлгийн

хэрэгслийн үнийн өсөлт бусад асуудалтай холбогдуулж шинэчлэхээр 2 яам хамтран ажиллаж байна.

Хуульд заасан энэ бусад дүрэм журмуудыг нийцүүлж энэ хуулийн хэрэгжилтийг хангаж тодорхой болгох ёстой юм байна лээ. Ер нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхийн тулд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах цогц шинэчлэл хийх зорилгоор ажлын хэсэг байгуулж ажиллаж байгаа. Тухайлбал лабораторийн үзлэгийн стандарт тогтоохоос өгсүүлээд.

Н.Учрал: Ганмаа гишүүнд нэмэлт нэг минут. Баярлалаа.

Д.Ганмаа: Хуулиа давсан журам стандартуудыг шинэчилнэ өөрчилнө. Тэгээд ажлын хэсэг гаргаад ажиллаж байгаа гэж товчхондоо тиймээ хураангуйлъя. Нэмэлтээр мэдээж 2016 оны хуулиас хойш ковид гэж цар тахал гарсан. Тэрнээс хойш зөвхөн Монгол Улс ч биш бусад хөгжингүй орнууд эдийн засгийн хүч чадалтай орнууд ч гэсэн эрүүл мэндийнхээ бодлогыг цогцоор нь шал өөр нүдээр харж анхан шатны тусламж үйлчилгээ буюу өрхийн эмнэлэг тэдгээр дээрээ бүх нийтийн эрүүл мэндийн хамралтыг хүргэх нь зайлшгүй шаардлагатай юм байна гээд дэлхийн эрүүл мэндийн байгууллагууд бусад улс орнуудын төлөөллүүдтэй хамтраад нийтлээд ажиглагдсан. Төлөвлөсөн, шийдсэн ажлууд байгаа. Манай Монгол Улс ч гэсэн энэнээс мэдээж гажих аргагүй. Олон улсын стандарт цар тахалд тааруулсан ийм нөхцөл байдлаараа шинэчлэх хэрэгтэй. Энэ эрүүл мэнд тусламж үйлчилгээ.

Та энэнтэй санал нэг байна уу? Хэрвээ санал нэг байгаа бол та яг анхан шатын эмнэлэг тусламж үйлчилгээ дээр ямар асуудлууд энэ хуульд орвол зүгээр гэж үзэж байгаа вэ?

Г.Занданшатар: Товчхондоо санал нэг байна. Ер нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахын тулд лабораторийн үзлэг анхан шатын эмнэлгүүдийн үзлэг, хүртээмж чанар үйлчилгээг сайжруулах ёстой юм байна лээ. Энийг цоо шинээр стандартлах шаардлагатай юм байна лээ. Бусад улстай харьцуулах юм бол Монгол Улсын суурь дэд бүтцүүд бүх сумд аймгийн төвүүдэд эмнэлгүүддээ тогтолцооны хувьд бол харьцангуй нөгөө хатуу бүтцийн хувьд сайжирсан юм шиг боловч зөөлөн дэд бүтэц үйлчилгээний стандартыг цоо шинэчилж байж ийм шинэ дэг соёлыг нэвтрүүлэх шаардлагатай гэж үзэж байгаа.

Ийм ч учраас гадаад зогсоол сувилагчийн пост о дотор байх сандлаас авхуулаад стандартыг бүрэн шинэчлэх ёстой юм байна лээ. Орчин үеийн чиглэсэн зүйл ч тэгэхгүй бол орыг санхүүжүүлдэг биш урьдчилан сэргийлэх оношилгоо, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах нь дүгээр 1 дүгээр эрхэмлэх зорилго байх ёстой. Мэдээж шат шатны эмнэлгүүдийн чанар хүртээмжийг сайжруулах ёстой. Ирэх жил.

Н.Учрал: Баярлалаа. Ганмаа гишүүний эрүүл мэндийн салбарт тулгамдаад байгаа асуудлуудыг шийдвэрлэх хууль, тогтоомжийн төсөл боловсруулах ажлын хэсгийг ахалж ажиллаж байгаа. Тэгээд 59 ажлын хэсгийг татан буулгаад 12 ажлын хэсэгтэй болгосон. Тэгээд 1 ажлын хэсэг нь бол эрүүл мэндийн салбар. Тэгэхээр Ганмаа гишүүн ахалж ажиллана гэдгийг хэлье. Улсын Их Хурал дахь олонхын бүлгийн гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Одоо Улсын Их Хурал дахь цөөнхийн асуулт ирүүлсэн гишүүд ирцэд бүртгүүлсэн дарааллын дагуу асуулт асууна. Нэрсээ ирүүлсэн Энхнасан гишүүн байхгүй байна. Улсын Их Хурал дахь цөөнхийн гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Дэгээ барина. Улсын Их Хурлын асуулгын цаг дууслаа.

Улсын Их Хурлын гишүүдийн асуултад хариулж нээлттэй ярилцсан Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар танд талархал илэрхийлье ээ.

Дараагийн асуудалд орно. Гишүүдийг танхимд урья. Гишүүдийг танхимд урьж байна одоо санал хураалт явуулна.

15.36

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал нарын 3 гишүүн 2025.12.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Зөвшөөрлийн хууль дээр үг хэлэх дэмжсэн дэмжээгүй гишүүдийн нэр авсан байгаа. 2 хүний нэр байгаа. Тэр 2 хүний нэр хаана байна. 2 гишүүний нэр. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн үг хэлнэ. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн индэрт үг хэлэх юм байна шүү дээ. 1 дүгээр индэрт, дараа нь Эрдэнэбат гишүүний дараа Зөвшөөрлийн хуулийн төслийг санаачлагч, ажлын хэсгийн ахлагч Бямбацогт сайд үг хэлнэ. 2 дугаар индэрт.

С.Эрдэнэбат: Зөвшөөрлийн хуулийг дэмжиж байгаа. Бас нэг дор маш олон зөвшөөрлүүдийг хүчингүй болгох, мэдэгдэх, хүргүүлснээр тухайн үйл ажиллагааг эрхлэхийг хуульчилж байгааг үзэл баримтлал маш олон хүнд суртлууд шат дамжлагууд буурна аа. Энийг санаачилж байгаа Учрал дарга, мөн хамт санаачилсан гишүүддээ талархаж байна. Нэг асуудал байна. Анхаарах ёстой асуудал байж байгаа.

Тухайлбал сая би хөдөө орон нутгаар явж байхад нэг суманд 28 дэлгүүр байдаг болсон. Үндсэндээ тэр сумын хүн амыг авах юм бол өвөлдөө 1 мянга гаруй хүнтэй. Тэгэхээр цаашдаа энэ зөвшөөрлийг буруугаар ашиглаад ингээд явах юм бол магадгүй маш олон ААН, байгууллагууд жижигхэн зах зээл дээр өрсөлдөөд бүгдээрээ унах гэдэг нэг ийм эрсдэл байгаа. Үүнийг хэрхэн яаж зохицуулах тал дээр бид нарт бэлтгэл хэрэгтэй. Мэдээж өрсөлдөөн чухал. Тухайлбал АНУ, Австрали гэх мэтчилэн улс орнуудад зах зээлд нь тохирсон ийм цэгийг тодорхой хэмжээгээр олгодог ийм зохицуулалттай. Энэ нь юу вэ гэхээр зах зээл өндөр хөгжсөн оронд бол нэг талаар зөвшөөрөл лицензийг чөлөөлдөг. Нөгөө талаар нь урт хугацаандаа тогтвортой үйл ажиллагаа явуулах энэ зохицуулалтууд дээр нь тодорхой зохицуулалтуудыг хийдэг байх нь гэж. Тэгээд энэ тал дээр нэлээн анхаарах хэрэгтэй байна аа. Тухайлбал манай улсад зарим газар аптекад гээд. Зарим гудамжинд манай хотын төвөөр бол дараалаад 10.20 аптека байгаа. Гэтэл тухайлбал Хөвсгөл аймагт тэгэхэд 7 суманд ЭМД-аар үйлчилгээ үзүүлдэг аптека байхгүй. Тэр аптека яагаад байдаггүй вэ гэхээр аптека үйлчилгээ хэрэглэхэд эм найруулагч, эм зүйч мөн 3, 4 орон тоо шаарддаг. Үндсэндээ эмийнх нь зах зээл 1000.1500 орчим хүнд байдаг. Энд хэт өндөр стандарт шаардлага зөвшөөрлөөс болоод ингээд ажилладаггүй ийм зүйл байгаа.

Тэгэхээр энэ эрүүл мэндийн энэ зүйл дээр бүх нийтийн үүргийн зохицуулалтыг хийх нь зүйтэй юм байна гэж. Барилгын зөвшөөрөлтэй холбоотойгоор хэлэхэд барилгын зөвшөөрөл нэг барилгын зөвшөөрлөөс болоод одоо манай ихэнх барилгын ажил бригадын системд орчихсон. Яагаад гэхээр нэг барилгын зөвшөөрөл гарахын тулд бараг нэг жил нэг өвлийг алддаг. Энэний хугацаанд зээлийн хүү урсдаг. Ажилтнууд тогтвортой ажлын байр хийхэд нийгмийн даатгал бусад одоо сул зогсолт гээд маш их дарамт ирдгээс болоод манай барилгын салбарын ажиллах хүчний бараг үндсэндээ 80 хувь нь албан бус буюу үндсэндээ бригадын системдээ орчихсон. Мэргэжлийн ажилтнуудын юу буурсан.

Тэгээд энд эерэг үр дүн авчрах болов уу гэж би бодож байна. Нөгөө талаар зөвшөөрөлтэй холбоотойгоор хэлэхэд монополын эсрэг бас зүйлийг бодох хэрэгтэй. Манай зарим монопол компаниуд ерөөсөө бараг 8 нэрийн дэлгүүрээс авхуулаад ТҮЦ, бууз, хуушуур гээд л бараг орохгүй юм гэж алга. Тийм учраас ЖДҮ-лэл өрхийн ААН байгууллагуудыг томруулах, дэмжих, тогтвортой байлгах жижигхэн зах зээл дээр зүй ёсны болон энэ монополын эсрэг хөл дээрээ зогсоход нь арга хэмжээ авахгүй бол болохгүй. Тухайлбал манай улсад жижиг 8 нэрийн дэлгүүр 6 нэрийн дэлгүүр гээд аваад үзэхэд гадаадын томоохон сүлжээ үндсэнд нь ингээд л зах зээл нь маш богинохон хугацаанд ингээд л аваад явж байна л даа. Тийм учраас энэ нөгөө талд нь Зөвшөөрлийн хуулийн нөгөө талд нь жижиг, дунд өрхийн аж ахуй эрхэлж байгаа чөлөөт энэ ийм боломжийг ашиглаад хөл дээрээ тогтох тогтвортой ажиллахад нь зохион байгуулалтын хувьд болон үйл ажиллагааны хувьд дэмжлэг үзүүлэх. Манай улсад байж байгаа энэ CU, GS гээд энэ Солонгосын дэлгүүр гэхэд Севен, Элевен гээд том дэлгүүрийн сүлжээг ашиглаад энэ дээр нь Ноу Хауг нь сураад үндэснийхээ ийм ААН байгууллагуудыг хөл дээр нь босгож.

Н.Учрал: Эрдэнэбат гишүүнд баярлалаа. Бямбацогт сайд нэрээ татсан байна. Санал давхацсан байна.

Санал хураалт явуулна.

Төрийн хүнд суртлыг чөлөөлөх зөвшөөрөл, мэдэгдлийн хууль, түүнийг дагасан 90 гаруй хуулийн өөрчлөлтийг хэлэлцэх эсэхийг дэмжинэ.

Гишүүдийг танхимд урья. Бүлгийн дарга нар ирц бүрдүүлье. АН-ынхан энэ Батжаргал дарга гишүүдээ дууд. Одоо энэ Зөвшөөрлийн хууль хэлэлцэж байхад над руу энэ гомдол санал тасрахгүй байна шүү. Амьдралаа нэг авч явъя гээд ядаж байгаа нэг ард түмнээ дээрэлхээд тэр хорооллын байрны дунд яагаад байна гэнэ вэ? Хүнтэй хүн ёсоор харилцмаар байна. Нийслэлийнхэн, нийслэлээс сонгогдсон гишүүд ээ. Хүнтэй хүн ёсоор харилцаарай гэж тэр дүүрэг орон нутгийн удирдлагуудад хэлэхгүй бол ямар их дээрэнгүй юм. Шинэ жил болох гэж байхад. Хүнд суртал саад тээг болоод байгаа дээрээс нь ингээд зөвшөөрөл авах гээд би хэд хоног хүлээлээ гээд хэвлэлээр ярихаар дарамтлаад байдаг нөхдүүд байдаг гэж байна шүү. Тэр хүмүүсийг би өөрөө хамгаална аа. Тэгээд над руу тэр хүмүүс чинь гомдлоо илгээж байгаа юм.

Хүн ер нь амьдралаа авч явахын тулд өрхийн үйлдвэрлэл эрхэлж болж байна, бизнес эрхэлж болж байна. Гэтэл тэгээд ажил хийж байгаа хүн болгоныг дээрэлхээд ийм л байдаг л ийм л тогтолцоотой л болчихоод байна шүү дээ. Тэгээд. 1 боломж олгож чадахгүй юм гэхэд цалин хөлсийг нь нэмэгдүүлж чадахгүй юм гэхэд ядаж гай болохгүй баймаар байх юм. Хэдэн иргэдийг дарамтлахдаа их сайн юм.

Гишүүдийг танхимд урья.

Тэгвэл энэ бараг 90 хуулийн санал хураалт явах гэж байгаа юм.

Тэгэхээр үргэлжлүүлээд дараагийн асуудлын танилцуулгыг сонсчихъё тэгэх үү. 43.1-ээр.

Энэ санал хураалтыг хойшлуулаад нэгтгээд хураана.

Дараагийн асуудалд орно оо.

Үл хөдлөх хөрөнгө борлуулахад төлдөг 2 хувийн татварыг хүчингүй болгох асуудлаар хуулийн төсөл санаачлах тухай нийтийн өргөдлийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт

Энийг хаврын чуулганаар энэ дэгийг өөрчилнө шүү. Иргэд 100 мянган санал ирүүлчхээд байхад буцаад Хууль тогтоомжийн хуулиа барь гээд дахиад 2 сар олон нийтийн хэлэлцүүлэг гээд явуулдаг. Тэгээд ямар үр дүн байгаа юм. Тэгвэл нийтийн өргөдөл хэлэлцэж яах юм. Өргөдлийн байнгын хороо байж яах юм. Тэгээд Өргөдлийн байнгын хороо байх гэж байгаа бол Өргөдлийн байнгын хороог амьтай ажиллуулах гэж байгаа бол энэ иргэдийн санал гомдлыг шийдвэрлэдэг болгох хэрэгтэй байна. Тэрнээс зүгээр нэг ийм санал бодол сонсдог шийдэлгүй нэг ийм Байнгын хороо байж болохгүй шүү дээ. Тэгэхээр Өргөдлийн байнгын хороогоо одоо шийдвэр гаргадаг болгоно оо. Тийм учраас дэгийн хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай л гэж ингэж үзэж байгаа юм. Одоо энэ 15 дэд хороог багасгах шаардлага байна. Энэ хаврын чуулганаар энэ дэгийн хуулийг санаачилъя, Их Хурлын хууль. Энэ хэрэгтэй хэрэггүй Дэд хорооны чинь дарга болох ч хүн олдохгүй юм байна. Дэд хорооны дарга бол гэхээр би болохгүй гээд хэрэггүй газар юу хийх юм гээд. Тэгээд 15 дарга гээд нэртэй. Төсөвгүй, баггүй, ажлын албагүй, шийдэлгүй тэгээд 1 ийм дэд хороо нэмээд тавьчихсан. Тэгээд бүгдээрээ дарга гээд нэртэй. Тэгээд энийг багасгах хэрэгтэй. Тэгээд энэ далимд нь харин тэр Инновацын байнгын хороог татан буулгасан байгаа юм. Ингэж болохгүй шүү дээ.

Тэгэхэд энэ Анар гишүүний энэ дэд хороо яаж сайн ажиллаж байгааг харж байгаа биз дээ. Цахилгаан тэр олон улсын цахилгаан холбооны байгууллагын Азийн захирал ирсэн. Тэр рэ инженеринг дээр бодитой шийдэл гаргасан байна лээ шүү. Ажиллаж байгаа болж байгаа дэд хороо байгаа юм. Тийм учраас тэр Дэд хороог нь сайн ажиллаж байгаа Дэд хороог нь харин Байнгын хороо болгоод хэрэгтэй хэрэггүй тэр дэд хороог нь татан буулгах нь зөв өө л гэж.

Тийм учраас энэ дээр Их Хурлын гишүүдийн хамтарсан ажлын хэсэг байгуулаад гишүүд өөрсдөө энэ хуулиа санаачлаад ажиллах нь зөв байх гэж бодож байна аа. Тэгвэл хэлэлцэх асуудалдаа орох уу? Санал хураалтаасаа өмнө. Ингээд Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг танилцуулна аа. Таныг индэрт урья.

П.Сайнзориг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д Монгол Улсын Их Хурлын хууль тогтоох хянан шалгах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог

хангах зорилгоор нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаас иргэдээс гаргасан өргөдлийг цахим системээр хүлээж авч болно оо гэж заасны дагуу 2025 оны 8 дугаар сарын 15-ны өдөр нийтийн өргөдлийн систем цахим хуудсанд Монгол Улсын иргэн Отгоны Батхүүгийн гаргасан үл хөдлөх хөрөнгө борлуулахад төлдөг 2 хувийн татварыг хүчингүй болгох хуулийн төсөл санаачлах саналыг 100175 иргэн дэмжсэн болно оо.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5.1-д хуулийн төсөл санаачлах саналыг 100 мянга ба түүнээс дээш тооны иргэн дэмжсэн бол Улсын Их Хурал авч хэлэлцэнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар 2025 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн нэгдсэн хуралдаанд танилцуулж, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан эрхлэх асуудлын хүрээнд Өргөдлийн болон Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэж тус Байнгын хорооны 2025 оны 21 дүгээр тогтоолоор үл хөдлөх хөрөнгө борлуулахад төлдөг 2 хувийн татварыг хүчингүй болгох асуудлаар гаргасан нийтийн өргөдлийн дагуу үл хөдлөх хөрөнгө борлуулсан шилжүүлсний орлого ноогдуулах албан татварын асуудлыг судалж Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.5 дахь хэсэгт заасан хүрээнд санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг ажлын хэсгийн гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, Т.Аубакир, Д.Батбаяр, Р.Батболд, Б.Заяабал, Б.Мөнхсоёл, П.Мөнхтулга, Ч.Номин, Б.Түвшин, Даваагийн Цогтбаатар нар ажиллалаа.

Дээрх ажлын хэсэг нь нийтийн өргөлд тусгасан үл хөдлөх хөрөнгө борлуулахад төлдөг 2 хувийн татварыг хүчингүй болгох асуудлыг холбогдох татварын хууль, эрх зүйн зохицуулалт, бодлогын асуудлуудтай уялдуулан нарийвчлан судалж доорх санал, дүгнэлтийг боловсруулж танилцуулсныг Төсвийн байнгын хорооны 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн.

Үл хөдлөх хөрөнгө борлуулах шилжүүлэхэд төлөх татварын асуудал нь дан ганц татварын өнцгөөс харах бус хөрөнгийн зах зээл орон сууц болон татварын бодлого, мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх зэрэг бодлоготой холбогдуулан авч үзэх өргөн хүрээний асуудал байна аа.

Тухайлбал үл хөдлөх хөрөнгийн татварыг чөлөөлөх асуудал нь Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль ХХОАТ-ын тухай хууль ААНОАТ-ын тухай хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Орон сууцын тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон холбогдох бодлогын бичиг баримтууд зохицуулагдаж байгаа тул эдгээр хуулиудыг цогц байдлаар уялдуулан судлах зайлшгүй шаардлага байна аа.

Татварын ерөнхий хуулийн 6.1.5 дахь заалтад Албан татвар гэж хууль тогтоомжийн дагуу аливаа этгээдийн орлого, хөрөнгө, бараа, ажил үйлчилгээнд тодорхой хугацаанд тогтоосон хувь хэмжээг ногдуулж хариу төлбөргүйгээр төсөвт төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг гэж, мөн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн хэлбэрүүдийг заасан бөгөөд Татварын хувь

хэмжээ, хөнгөлөлт, чөлөөлөлтийн хүрээ нь татвар ногдох заалтыг бүхэлд нь хүчингүй болгохтой шууд холбоогүй байна.

ХХОАТ-ын хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.1 дэх заалтыг хүчингүй болгохыг татварын хөнгөлөлт чөлөөлөлтөө эдлүүлэхтэй шууд адилтгах боломжгүй бөгөөд бодлогын үр нөлөө татварын суурь болон шударга тэгш байх зарчимд нийцүүлэн тусгайлан авч үзэх шаардлага байна гэж үзлээ. Одоогийн байдлаар үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой бүхий л мэдээллийг агуулсан цахим бүртгэлийн систем төдийлөн сайн хөгжөөгүй. Үүнтэй холбоотойгоор үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог сайжруулах, холбогдох төрийн байгууллага олон нийтийн эрх зүйн хуулийн этгээд мэдээлэл солилцох асуудлыг хуулиар нарийвчлан зохицуулах шаардлага үүсэж байна аа.

Тухайлбал иргэн тухайн орон сууцыг өмчлөн өөрөө амьдарч байгаа эсэх, эс үгүй бол бусдад түрээсэлж байгаа эсэх, амьдран суух зориулалтаар ашиглаж байгаа эсэхийг нотариат хэрхэн бүртгэдэг мөн гэрээний бүртгэлтэй холбоотой мэдээллийн нэгдсэн сан бий болоогүй нь иргэн орон сууцаа ямар зорилгоор борлуулсныг бодитойгоор ялган тогтоох боломжгүй. Түрээслүүлэгч болон түрээслэгчийн бүртгэлийн хөгжүүлэлт сул, орон байр өмчилдөг, иргэдийн хөрөнгийг бодит ашиглалтын зорилго тодорхой бус байгаа зэрэгтэй холбоотойгоор иргэдийн орон сууц борлуулалтын зорилгыг нотлох ангилах нөхцөл бүрдээгүй асуудлууд ч бид нарт практик дээр байна аа. Үл хөдлөх эд хөрөнгийн татварыг дангаар нь чөлөөлөх нь хөрөнгийн зах зээлд татварын гажуудал үүсгэн үл хөдлөх хөрөнгө рүү хэт төвлөрөх, хувьцаа, бонд, үнэт цаас зэрэг санхүүгийн хэрэгслүүдийг хөрвөх чадвар сулрах, хөрөнгийн төрөлжилт буурах, богино хугацаанд ашиг олох үйл ажиллагаа нэмэгдэх, орон сууцын үнэ хөөрөгдөх, ирэлтийн хэлцлийн тоо өсөх зэргээс шалтгаалж бодит хэрэглээний худалдан авагчид зах зээлээр шахагдах орон сууцын хүртээмж буурах, санхүүгийн эко системд тогтворгүй байдал үүсэх эрсдэлүүдийг үүсгэж болохоор байна аа.

Мөн аль нэг төрлийн хөрөнгийг хөрөнгө борлуулсны орлогын татвараас чөлөөлж давуу байдал үүсэх нь эдийн засгийн салбар хоорондын хөрөнгө, борлуулалт, хөрөнгө оруулалтын хэвийн хуваарилалтыг алдагдуулж инновац үйлдвэрлэл зэрэг өндөр бүтээмжтэй салбаруудад чиглэх ёстой хөрөнгө оруулалт нь үл хөдлөх эд хөрөнгийн салбарт шилжих нөхцөлийг бүрдүүлэхээс гадна эдийн засгийн урт хугацаандаа хөгжилд сөргөөр нөлөөлж болзошгүй байна аа.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалтад үл хөдлөх эд хөрөнгө худалдан авах эс үгүй бол худалдах аливаа ажиллагаа явуулсан бол үл хөдлөх эд хөрөнгөтэй зуучлалын байгууллага, гүйлгээний талаар мэдээлэх үүргийг хүлээсэн бөгөөд энэ нь үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын мөнгө угаах өндөр эрсдэлтэй хүн хуулийн этгээд гэж хуулиар тодорхойлсон байна аа. Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогын татваргүй болгох нь өмчлөл, хөрөнгийн урсгалын талаарх татварын мэдээлэлд давхар хяналтыг сулруулж гүйлгээний ил тод байдлыг бууруулан мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг нэмэгдүүлэх Фатфаас онцолдог үл хөдлөх эд хөрөнгийн мөнгө угаах зорилгоор түгээмэл ашигладаг үл хөдлөх эд хөрөнгийн үнийг зориуд өндрөөр эсхүл багаар тогтоож гүйлгээнд оруулах. Гуравдагч этгээдийг ашиглан жинхэнэ өмчлөгчийг нуун дарагдуулах. Хөрөнгийн эх үүсвэрийг нуухын тулд үл хөдлөх хөрөнгийг бэлэн мөнгөөр худалдаалах, худалдан авах, үл хөдлөх эд хөрөнгийг худалдаж аваад богино хугацаанд дахин худалдах замаар

хөрөнгийг цэвэршүүлэх зэрэг мөнгө угаах өндөр эрсдэлийн аргуудыг ч илүү хялбараар үйлдэх боломжийг нэмэгдүүлж болзошгүй байна аа.

Дээр дурдсан хууль тогтоомжийнхоо судалгаа мэдээлэлд үндэслэн нийтийн өргөдөлд дурдсан асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.5,1 дэх заалтад заасны дагуу Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан Байнгын хороо болон Улсын Их Хурлын тухай чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлэх нь зүйтэй гэж танилцуулсан болно оо.

Байнгын хорооны хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар гарсан иргэдийн өргөдлийг Улсын Их Хурал хэлэлцэхдээ Засгийн газарт чиглэл өгөх нэрийдлээр асуудалд хандаж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан төрийн үйл хэрэгт шууд оролцож мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаар уламжлан энэхүү эрхээ эдэлнэ гэж заасан зарчим бодитоор хэрэгжихгүй байх талтай тул цаашид энэхүү асуудлыг бодитой, үр дүнтэй, иргэдэд ээлтэй байдлаар шийдвэрлэх талаар асуулт асууж хариулт авсан болно оо.

Нийтийн өргөдөл гомдлыг цахим хуудсанд байршуулсан үл хөдлөх хөрөнгө борлуулахад төлдөг 2 хувийн татварыг хүчингүй болгох асуудлаар хуулийн төсөл санаачлах өргөдлийг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд тараасан.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийтийн өргөдөл гомдлын систем, parliament.mn цахим хуудсанд байршуулсан үл хөдлөх хөрөнгө борлуулахад төлдөг 2 хувийн татварыг хүчингүй болгох асуудлаар хуулийн төсөл санаачлах өргөдлийг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүгдээс хүсье ээ.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Н.Учрал: Сайнзориг гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулна. Сангийн сайд Болдын Жавхлан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Батжаргалын Цогтнаран, УБЕГ-ын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын дарга Доржзовдын Болормаа, ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Оюунбаатарын Оюунзул, Татварын ерөнхий газрын Татварын удирдлага олон улсын татварын газрын дарга Дондогийн Сайханчулуу.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Нэрс ирүүлээгүй байгаа. Сүхбаатарын Ариунзаяа гишүүнээр тасаллаа. Шижир гишүүнээр.

Ингээд Эрдэнэбат гишүүн, Ариунзаяа гишүүн, Шижир гишүүн нараар тасаллаа. Өлзийхүүгийн Шижир гишүүн нэрээ татлаа. Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Энэ газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн УЦС, Сэлбэ дэд төв түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл гээд 3 төслийг нь бол дэмжээд байгаа байхгүй юу. Бид нар зээл авсан ашиглах ёстой.

Н.Учрал: Үл хөдлөхийн 2 хувь.

А.Ариунзаяа: Үл хөдлөхийн 2 хувь юм уу нэрээ татлаа. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн нэрээ татаж байгаа юм уу, асуух гэж байгаа юм уу? Эрдэнэбат гишүүн үг хэлнэ.

С.Эрдэнэбат: 2 хувийн үл хөдлөх хөрөнгийн 2 хувийн татвар санал хураахад 100 мянган хүний гарын үсэг зуруулсан. Гэхдээ энэ дээр бодох зүйлүүд нэлээн байгаа юм. Энэ маань яг зорилтот бүлэгт буюу анх удаагаа орон сууцдаа магадгүй 2 дахь удаагаа орон сууцад орох хүмүүст хэр зэрэг тусах вэ? Уул нь бол миний хувьд энэ Татварын багц хуультай холбоотойгоор татварын буцаалтыг 6 саяыг 15 сая болгох гэж байгаа төсөл танилцуулсан. Тэр хүрээндээ анх удаагаа буцаалтын нэг хувь хэрэглэхээс гадна, яг бодит амьдрал дээр хүний амьдрал дээр нь хүн дунджаар 2 дахь удаагаа магадгүй хүүхэдтэй болоод, гэр бүлтэй болоод нэг хашаа байшин авсан байсан бол тэрийгээ зараад тэр 2 өрөө байр авах энэ үед нь тэр татварын буцаалтынх нь орлогыг нэмэгдүүлбэл уул нь илүү хүртээмжтэй илүү нөгөө зорилтот бүлэгт хүрэх болов уу гэдэг талаас нь би бодоод байгаа юм.

Яг байр зарах болгонд нь 2 хувиас нь татварыг байхгүй болгочих юм бол нэг эрсдэл нь шууд 10 хувь руу орох нэг эрсдэл харагдаад байгаа татвар дээр.

Нөгөө талаасаа байрны энэ мөнгө угаалт гэдэг юм уу, сая энэ Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороон дээр дүгнэлт гарсан байж. Магадгүй байрны ченжүүдэд юм уу байрыг томоохон үл хөдлөхийн бизнесийг дэмжих гэдэг юм уу ийм зүйл рүүгээ гулсчих вий гэдэг талаас нь би хараад байгаа юм. Тийм учраас ер нь манайд энэ байр орон сууцын борлуулалт дээр хэчнээн байр орон сууцын борлуулалт жилдээ болдог юм бэ. Эндээс хэчнээн төгрөгийн татвар орж ирдэг вэ. Эргээд орж ирсэн татварыг орон сууцжуулах зорилгоор дэмжих сан болгоод тэгээд ийм байдлаар дэмждэг үү гэдэг асуудлыг би асуумаар байна аа.

Н.Учрал: Лувсанжамц гишүүн асуулт асууя. Лувсанжамц гишүүн асуулт асууна. Сайнзориг гишүүн хариулъя аа.

П.Сайнзориг: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя аа. Бид хэд яах вэ иргэдийнхээ гаргасан өргөдөлд маш хүндэтгэлтэй хандаж ж байгаа. Засгийн газарт өгөх чиглэл болгож байгаа энэ тогтоол дээр анхны орон сууц буюу тэр дундаа ипотекийн зээлээр авч байгаа энэ орон сууцыг орон сууцын нөхцөлөө сайжруулах зорилгоор зарж болно. Тодорхой ер нь яг зорилгыг ач холбогдол өгөхгүй. Ер нь энэ ипотекийн зээлээр болон анхны орон сууцаа борлуулахад авч байгаа энэ зүйл дээр нь татварын хөнгөлөлтийг үзүүлбэ гэдэг зүйлийг дэмжиж Засгийн газрын ажлын хэсэгтэйгээ ярилцсан. Харин иргэд маань зөвхөн орон сууцнаас гадна гарааш бусад үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгүүд ийм зүйлүүдийг өмчилж байгаа юм. Энэ болгоныг борлуулсан орлогыг, татвараас чөлөөлнө, хөнгөлнө гэх юм бол боломжгүй байгаа юм аа.

Тэгээд өргөдөл гаргагч маань ерөөсөө 2 хувийг тэр чигт нь хүчингүй болгоно гэхчхээр ингээд хавтгайтай болчих гээд байгаа учраас энийг нь зааг ялгааг нь

гаргаад манай өргөдөл гаргагч Батхүү гээд тэр залуутай уулзсан. Яг энэ залуугийн орон сууцын тэр анхны орон сууц гэдэг тэр зорилгыг нь бид хэд хангаж бас энэ хуулийн төслийг цаашдаа задалж зохицуулж орж ирье гэдэг дээр тохирсон. Ер нь бол одоо Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээн дээр бол анхны орон сууц худалдаж авч байгаа хүн дээр бол дэмжлэгүүд хангалттай байгаа юм байна лээ. Ер нь бол энэ буцаалтад гэхэд 5-аас 6 сая төгрөг өгч байгаа. Дээрээс нь эхний 2 орон сууцыг үл хөдлөх хөрөнгийн татвараас чөлөөлж байгаа зэрэг асуудлууд угаасаа бодлогын хүрээнд орон сууцжуулах бодлогоо дэмжээд явж байгаа.

Харин энэ борлуулах хэсэг дээр бол бас ингэж наанатай цаанатай буюу асуудлыг ялгаж зохицуулахгүй бол болохгүй гэж үзсэн.

Хоёрдугаарт яах вэ энэ борлуулах орлогоос орон нутгийн төсөвт ордог юм байна лээ. Орон нутгийн төсөвт жилдээ 115 тэрбум төгрөг ордог. Хэрэвзээ энийг хуулийг тэр чигт нь хүчингүй болгох юм бол одоо энэ орлогын эх үүсвэрийг хаанаас нөхөх вэ гэдэг асуудал бид нарт бодитойгоор тулна. Ерөнхийдөө яах вэ зүгээр орлогын асуудлууд бол мэдээж Улаанбаатар хот, Дархан, Эрдэнэт, Өмнөговь гэсэн аймгуудад түлхүү энэ орлогын бүрдүүлж байгаа зүйлүүд байгаа. Энэ 115 тэрбумын орлогоор дүүргүүд сумууд юу хийж байна вэ гэхээр нийтийн үйлчилгээ, зам засвар, хог хаягдлын менежмент, гэрэлтүүлэг, орчны тохижилт зэрэг энэ орон нутгийн чиг үүрэгт заасан энэ чиг үүргээ хэрэгжүүлэх орлогын эх үүсвэр болгож энэ татварыг ашигладаг юм байна аа. Эргээд эндээс орж байгаа орлого нь буцаад яг орон нутаг, тухайн аймаг, сум дүүрэгдээ очдог оо гэсэн үг.

Тэгэхээр энэ асуудлыг цаашдаа баланстай авч үзэхийг хичээсэн. Тэгээд Эрдэнэбат гишүүний хэлж байгаа сая бас Цэц дээр тэр үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний асуудлыг хүчингүй болгуулчихсан юм байна лээ. Түдгэлзүүлчихсэн. Тэгээд араас нь магадгүй энэ 2 хувийн татвар байхгүй гэдэг чинь бол өндөр үнэтэй.

Н.Учрал: Парламент иргэдийнхээ оролцоог хангаж байгаа D-parliament дээр ирсэн 100 мянган саналыг хүлээж авч байгаа гэдгээ өнөөдөр Их Хурлын нэгдсэн чуулганаар харуулж байна. Энэ бол зөв хандлага. Ажлын хэсэг байгуулагдаад ажилласан байна. Мөн өнөөдрийн энэ үл хөдлөхийн татварын 2 хувьтай холбоотой иргэн Батхүү D-parliament дээр энэхүү санал асуулга явуулаад 100 мянган хүн тоон гарын үсгээр санал өгсөн. Ийм асуудлыг цаашдаа Их Хурлын чуулганаар шууд хэлэлцдэг байх зарчмыг барих нь зөв гэж үзэж байна аа. Ингээд олон нийтээр хэлэлцүүлдэг байх нь эрүүл харилцаа юм аа. Тэгж байж энэ цаашаа иргэд парламентынхаа үйл ажиллагаанд итгэж үнэмшинэ ээ. Тэгээд сая Сайнзориг гишүүн хэлж байна. Тэр иргэн Батхүү, өмгөөлөгч Батхүүгийн зүгээс өөрийнх нь санаачилж байгаа хуулийн төсөл дээр анхны байр, анхны байраа өөрийн харьяалал дээр байгаа эхний байран дээрээ л тэр 2 хувийг чөлөөлөөд 2, 3, 4, 5 дугаар байранд орлого олох зорилго агуулж байгаа учраас тэр чөлөөлөхгүй гэдэг. Ингээд нарийвчлан зохицуулсан хуулийн төслөө боловсруулсан гэдэг мэдээллийг би хүлээж авч уулзахад илэрхийлсэн. Ингээд хуулийг нь санаачилчихмаар юм билээ. Уг нь манай Сайнзориг гишүүн ямар хууль бичиж чадахгүй биш. Бичье гэвэл орж ирээд хуулиа бичээд батлаад явчих бүрэн бололцоо байсан боловчиг Засгийн газарт чиглэл өгөх нэрийдлээр засаг руугаа явуулж байгаа юм байна л гэж би ойлгож байна. Уг нь Сайнзориг гишүүн өөрөө хуулиа санаачлаад өөрөө хэлэлцүүлээд эхний байран дээрээ гээд явах бололцоо байгаа.

Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе ээ. Ажлын хэсгийг ахалсан Сайнзориг гишүүнээс асуулт асууя. Тэгээд тэрний өмнө энэ өргөдлийг D-parliament.mn-ээр зуун мянган иргэнээс гарын үсэг цуглуулаад санаачлаад явж байгаа Батхүү хуульчид баярлалаа. Яг ийм хүмүүс маань л яг ийм нээлттэй парламент буюу ийм нээлттэй байдлаар хууль эрх зүйн орчныг засах асуудлуудыг орж ирдэг. Цаашдаа ч гэсэн олон төрлийн бодлогын хууль эрх зүйн орчны асуудал дээр саналууд гаргаад яваасай гэж бодож байна. Энэ 2 хувийн татвар бол авдаггүй улс бараг байхгүй. Энэ зорилтот татвар. Ямар зорилготой вэ гэхлээр үл хөдлөх хөрөнгийн үнийн өсөлтийг нь хязгаарлаж өгдөг татвар юм байгаа юм.

Өнөөдөр 2025 оны эцсийн байдлаар харахад 2024 онтой харьцуулахад шинэ байрны үнэ 10-аас 15 хувь нэмэгдсэн. Хуучин байрны үнэ ч гэсэн 10-аас 13 хувь нэмэгдсэн байгаа. Тэгээд энэ 2 хувийн татварыг хэрвээ тэг болгох юм бол үл хөдлөхийн салбарын хөөсрөл бий болоод магадгүй 2026 онд байрны үнэ 20 хувиар өсөөд одоо 4 сая төгрөг байгаа нь 4 сая 800 мянган төгрөг, тэгээд 5 сая төгрөг даваад явчих тийм эрсдэл байгаа.

Тэгэхээр бид нар энэ зорилтот татвар шүү гэдгийгээ сайн ойлгох ёстой. Гэхдээ мэдээж иргэдийгээ орон сууцтай болгох гэж байгаа болгох бодлогыг дэмжиж байна гэдэг нь бол би зөв гэж бодож байна. Тэгээд сая 2.3 асуулт байсан. Эхнийх дээр нь Эрдэнэбат гишүүн асуугаад Сайнзориг гишүүн хариулчихлаа. Татварын хуулиараа бид нар өнөөдөр яг орон сууц худалдаж авахад нь эхний орон сууц дээр нь 6 сая хүртэлх төгрөгийг татварын буцаан олголтыг өгч байгаа. Эхний 2 үл хөдлөх хөрөнгө дээр нь үл хөдлөх хөрөнгийн татвар авдаггүй хөнгөлдөг. 700м2 газар дээр нь ч гэсэн газрын төлбөр авдаггүй байгаа. Тэгээд энэ бүх бодлогууд бол ингээд хоорондоо уялдаатай цогцоороо иргэдийг орон сууцтай болгох газартай болгох гэсэн ийм төрийн бодлого хэрэгжээд явж байгаа.

Энийг цаашдаа тэг хувь болгох юм бол саяын хэлсэн үл хөдлөх хөрөнгийн хөөсрөл үүсээд явна. Гэхдээ зорилтот байдлаар энэ 2 хувийн татварын орлогоор бүрдэж байгаа хэсгийг нь бид нар дэд бүтэц татах гэр хорооллыг орон сууцжуулахад зориулсан зам, цэвэр, бохир усны шугам, цахилгааны шугам гэсэн энэ зүйлүүдийг нь татахад зарцуулдаг буюу үл хөдлөхийн борлуулалт нь ихсэх тусам дэд бүтэц илүү их баригдаж байдаг тийм зөв тогтолцоонд нь оруулбал хэрэгтэй болов уу гэж бодож байна. Тэгээд саяын орон сууцын үнийн хөөсрөл дээр хэрвээ энэ 2 хувийн татварыг авахаа больчих юм бол 2026 онд хэдий хэмжээний хувиар орон сууцын үнэ өснө гэсэн тийм судалгаа тооцоо гарсан болов уу? Ажлын хэсэг дээр ийм зүйл яригдсан болов уу гэдэг ганц. Асуулт байна.

Н.Учрал: Сайнзориг гишүүн хариулна.

П.Сайнзориг: Яг тодорхой эрсдэлүүд байгаа. Тэгээд Учрал дарга ч хэллээ. Бид иргэдийнхээ тэр гаргаж байгаа 100 мянган өргөдлийн агуулгыг дэмжихэж байгаа юм. Тэр агуулгаа бид нар харин тодруулж хуулийн зохицуулалтаа оруулж ирнэ. Тэр бусад хэсэг дээрээ харин ямар байдлаар зохицуулалтаа хийх вэ гэдэг зүйл байгаа. Ер нь зүгээр яах вэ зүгээр энэ татварын асуудлыг сая Лувсанжамц гишүүн маань зөв хэллээ. Энэ өөрөө эргээд үл хөдлөх хөрөнгийн бүртгэл мэдээллийг үнэн зөв болгохоосоо гадна энэ цаана нь яг энэ бүртгэл мэдээллийн мэдээллийн нэг хэсэг болох үнийн мэдээллийг ч гэсэн зөвтгөж өгч байгаа

хөөсрөлтөөс урьдчилан сэргийлж байгаа. Ийм зүйл байдаг. Тэгээд энэ зүйлүүд байхгүй болох юм бол тодорхой хэмжээний орон сууцууд бас тодорхой этгээдүүдийн гарт төвлөрөх, богино хугацаанд ашиг олох зорилгоор эргэлдүүлэх бололцоо буюу хөрөнгийн зах зээлийн бусад хэрэгслүүдийг санхүүжүүлэх байсан энэ хөрөнгүүд чинь өөрөө үл хөдлөх хөрөнгийн зах зээл рүү орж ирээд их төвлөрөх ийм эрсдэлүүд байна гэсэн үг.

Тэгэхээр магадгүй зүгээр богино хугацаандаа тийм эрэлтийг үүсгэх магадлал байгаа боловч урт хугацаандаа энэ чинь өөрөө эргээд яг орон сууц авах ёстой иргэд маань илүү их өндөр өртөг төлөх ийм нөхцөл байдал руу орох ийм эрсдэл байна гэдэг ийм суурь зүйлийг хэлж байгаа. Тэгээд манай ажлын хэсгээс бас нэмээд хэлэх бололцоо байвал хэлээрэй. Тэгэхээр энийг ер нь зүгээр ул суурьтай авч үзэх ёстой гэдэг зүйлийг хэлье. Тэгээд би Учрал даргатай санал нэг байна аа. Тэгээд би яг шууд хууль санаачлах бүрэн эрх манай ажлын хэсэгт байхгүй юм байна лээ. Дэгийн 95 дугаар зүйлийн 95.5-аараа бид нар 5 хувилбарыг л дэвшүүлэх ёстой. Нэг бол Засгийн газарт чиглэл өгнө. Нэг бол дахиад ажлын хэсэг гаргаж хууль санаачилъя гэдэг саналаа хурлын даргад өгөх юм байна лээ. Тэгээд нөгөө хэд нь болохоор сонсгол явуулах болон хяналт шалгалт явуулах гээд. Яг энэ асуудалтай шууд холбоотой зүйл биш.

Ер нь зүгээр цаашдаа энэ иргэдийнхээ гаргаж байгаа энэ санаачилгыг бүрэн дүүрэн Улсын Их Хурал дээрээ шийдвэрлэхийн тулд бас энэ Дэгийн хууль дээрээ өөрчлөлт оруулах ёстой гэдэг зүйлийг зарчмын хувьд дэмжиж байгааг хэлж байна аа.

Н.Учрал: Баярлалаа. Мэдээж Их Хурлын гишүүд хууль санаачлах эрхтэй. Өнөөдөр хиймэл оюун дээр дүгнэлт гаргаж байна, хуулиуд дээр. Тийм учраас Их Хурлын гишүүд өөрөө бие даагаад хуулиа санаачлах бүрэн эрхтэй. Дээрээс нь 100 мянган хүн зүгээр нэг веб сайтын доор коммент бичээгүй шүү дээ. 100 мянган хүн d-parliament-аар ороод дан системээр өөрийгөө таниулаад өөрөөрөө тоон гарын үсгээрээ санал өгчихсөн. 100 мянган хүн гэдэг чинь Их Хуралд жагсаалтаар бараг 4, 5 хүн оруулах хэмжээний суудал авсан намын саналын тоо шүү дээ. Тийм биз дээ 100 мянган хүн чинь. Бага тоо ерөөсөө биш шүү дээ. 100 мянган иргэн тоон гарын үсгээр санал өгчхөөд байхад Их Хурал үүн дээр хүндэтгэлтэй хандахгүй байна гэдэг өөрөө асуудал нь байхгүй юу. Тэр агуулгын мөн чанар биш тэр буруу зөвийг бол дэнслэх асуудал нь мэргэжлийн хүмүүс нь ороод дэнсэлнэ биз. Зүгээр энэ 100 мянган хүн иргэд маань өөрөө саналаа нэгтгээд ороод ирчихсэн байхад Их Хурлын гишүүд бүгдээрээ хэлэлцэх л үүрэгтэй. Үүнийг анхаар.

Хоёрт тэр Батхүү өмгөөлөгчийн өөрийнх нь хууль дээр анхны байран дээрээ өөрийнхөө нэр дээр байгаа байран дээрээ буюу 2 өрөө байртай хүн 3 өрөө байр болгож томруулахдаа 2 хувь төлж байгаа чинь шударга бус байна л гэж. Эрүүл асуудал шүү дээ. Эрүүл асуудал. Орлого олох ямар ч санаа байхгүй шүү дээ тэр чинь. Зүгээр л өөрийнхөө байрыг томруулж байгаа хүн яагаад 2 хувь төлөөд байгаа юм бэ гээд ийм л асуудлыг ярьж байгаа.

Тийм учраас хууль дээрээ тусгайлаад заачихсан юм байна лээ. Тэгээд манай Сайнзориг гишүүн бол хууль бичихдээ хурдан сайн бичдэг. Олон ч хууль бичсэн хүн. Тэгээд бүүр болохгүй бол миний нэр дээр наад хуулиа бичээд хэлэлцүүлээд хуулийг нь Их Хурлаар баталъя тийм миний нэр дээр Сайнаа гишүүн, Лувсанжамц гишүүн их зөв ярьж байна. Бид 3-ын нэр дээр хуулиа биччихье. Сайнаа чи өнөө орой

биччихэж чадна шүү дээ. Тэгээд маргаашаас хуулийг нь олон нийтийн хэлэлцүүлэгт тавиад тэгээд ингээд Батбаатар гишүүн юм байна. Батбаатар гишүүн нэмэгдэнэ. Ингээд хуулиа хэлэлцүүлнэ. Тэгээд энэ иргэний 100 мянган санал авсан асуудлыг шийдвэрлэнэ. Тэрнээс биш тоглоом шүү дээ. Засгийн газарт чиглэл өгнө өө анхаарч үзнэ үү гэнэ. Засгийн газар тэнд анхаарвал ямар юм бэ гээд ажлын хэсэг байгуулна. Тэгээд ажлын хэсэг нь тэнд нэг хууль боловсруулаад нэг баахан хүмүүс цуглуулна. Тэгээд энд орох гэсээр байтал энэ 4 жилийн бүрэн эрх дуусна. Тэгээд ажлын хэсэг байгуулж анхааралтай ажигласаар байтал амьдрал үргэлжилсээр байна.

Тэгэхээр хэдүүлээ иргэддээ жоохон хүндэтгэлтэй хандана. 100 мянган хүн гарын үсэг цуглуулсан асуудлыг ач холбогдол өгч олноороо хэлэлцдэг зөв жишиг рүү явж байж нээлттэй парламент бий болно тийм биз? Энэ чинь зүгээр нэг коммент биш шүү дээ. Тоон гарын үсэгтэй хэлээд байна шүү дээ. Бага тоо ерөөсөө биш. Тийм учраас бүгдээрээ ингэж байж цаашаа урагшилна. Манай Номинчимэг гишүүн, Өргөдлийн байнгын хороо бол яг 100 мянга хүрлээ. Хэлэлцдэг асуудал ярьдаг ийм болж байж цаашаа бид нар энэ шийдвэр буюу иргэдэд энэ хүрсэн шийдвэр гаргана. Ингэж байж бид нарын шийдвэр ард түмэнд ойртоно оо л гэж хэлмээр байна. Тэгээд дахиад хар даа. Сая гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дуусаж байгаа юм дууслаа. Үгүй энэ чинь дахиад энэ хар даа, дахиад үргэлжлэх юм байна. Дахиад үргэлжлэх юм байна. Батсуурь сайд яах вэ гэхээр Засгийн газарт чиглэл өгөх тухай Их Хурлын тогтоолын төсөл буюу саяын асуудлаар дахиад үргэлжлэх юм байна. Одоо нөгөө эхлээд сая нөгөө 100 мянган хүний санал, дүгнэлт танилцуулчхаж байгаа юм. Саяын асуудлыг хэлэлцэж. Ийм юм байна. Нэгдсэн хуралдаанаар үл хөдлөх хөрөнгө борлуулалт төлдөг 2 хувийн татварыг хүчингүй болгох асуудлаар хуулийн төсөл санаачлах тухай Нийтийн өргөдлийн талаарх Төсвийн байнгын хорооны санал дүгнэлтийг сонслоо. Баярлалаа.

16.08 цаг

Дараагийн асуудалд орно.

**“Засгийн газарт чиглэл өгөх тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Дэгээрээ ингэж явна. Сайнзориг гишүүний яриад байгаа чинь яг ийм м дэгийн дагуу байхгүй юу. Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг танилцуулна. Индэрт урья.

П.Сайнзориг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар гаргасан иргэний өргөдлийг Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэнтэй холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.5.1 дэх заалтыг үндэслэн боловсруулсан Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн байнгын хорооны 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж дэмжсэн болно оо.

Тогтоолын төсөлд монгол улсын хөгжлийн бодлогын бичиг баримт тусгагдсан орон сууцжуулах бодлоготой уялдуулан иргэн анх удаа орон сууц худалдан авах, өмчлөх анхны болон ипотекийн зээлээр худалдан авсан орон сууцаа борлуулах

орон сууцын нөхцөлөө сайжруулахад татварын дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох, мөн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог сайжруулах, холбогдох төрийн байгууллага болон нийтийн эрх зүйн хуулийн этгээдтэй мэдээлэл солилцох асуудлыг судлан иргэдийн орлогод нийцсэн орон сууцын зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг оновчтой тодорхойлон үл хөдлөх эд хөрөнгийн болон хөрөнгийн зах зээлийн үнэлгээтэй холбоотой хууль эрх зүйн орчныг сайжруулах, үл хөдлөх эд хөрөнгийн татвараас чөлөөлөх, татвар ноогдуулахтай холбоотой зохицуулагчдыг оновчтой болгож эд хөрөнгийн өмчлөл хөрөнгийн урсгалын талаарх татварын мэдээллийн давхар хяналтыг сайжруулах, гүйлгээний ил тод байдлыг хангах замаар мөнгө угаах терроризмоос санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд тусгай хамгаалалттай газрын бүсэд баригдсан орон сууцын татвар ноогдуулах төсвийн орлогыг нэмэгдүүлэх талаар хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхтэй холбогдуулан хуулийн төслийг боловсруулж Татварын багц хуулийн төслийн хамт эсхүл үзэл баримтлалыг тусад нь тодорхойлон 2026 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгах асуудлыг тусгалаа.

Төсвийн байнгын хорооны хуралдаанаар Засгийн газарт өгөх чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэн батлуулахыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бөгөөд тогтоолын төслийг Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамт та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт болон Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүгдээс хүсье ээ. Баярлалаа.

Н.Учрал: Их хурлын гишүүд нэрээ өгье өө. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууна. Асуулттай гишүүд алга байна.

2 гишүүн байгаа юм байна.

Ө.Шижир: Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууна.

Их Хурлын дарга нэг санал байна. Одоо ингээд бид нар хэлэлцэж байгаа асуудлаараа тухайн өдрөө шууд санал хураагаад явахгүй бол одоо жишээ нь өнөөдрийн 1.2.3 дахь асуудал өчигдрийн асуудлууд байгаад байгаа юм. Монгол Улс болон Европын сэргээн босголтын зээл, Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын санхүүжилтийн зээл, Засгийн газарт чиглэл өгөх тухай гээд энэ өчигдөр хэлэлцсэн асуудлуудыг өгч тухайн өдөрт нь санал хураахгүй бол өчигдрийн хуралд суугаагүй хүн, өнөөдөр чуулганы хуралдаанд суугаад хуралд суусан мэтээр санал өгч байгаа байхгүй юу. Энэ чинь өөрөө сайн ярих юм бол дэгийн тухай хуульд зөрчил болно оо. Тэгээд цаашдаа тухайн үедээ хэлэлцэж байгаа асуудлыг яг хэлж дууссаных нь дараа санал хураадаг болж байж энэ Улсын Их Хурлын гишүүн чинь танхимдаа суудаг болно, санал хураалтдаа оролцдог болно, ирцдээ идэвхтэй болно оо.

Тэгэхгүй бол одоо ингээд бид нар Их Хурлын гишүүдийнхээ эцсийг харж байгаад энийг маргааш санал хураая гэх юм бол өнөөдөр хуралд ямар нэгэн шалтгаанаар суугаагүй Их Хурлын гишүүн маргаашийн хуралд суугаад тухайн асуудлыг хэлэлцсэн болоод хэлэлцсэн асуудалд орсон болоод санал хураалтад орчхож байгаа юм. Тэгэхээр энэ маш том ийм зөрчил шүү, маш том логикийн алдаа.

Хэрвээ тухайн үед тухайн өдрөө Их Хурлын дарга сонсож байна уу? Учрал дарга аа, Батжаргал дарга аа. Хэрвээ та Батжаргал дарга өчигдөр хэрвээ та хуралд суугаагүй бол өнөөдрийн санал хураалтад оролцож болохгүй байхгүй юу даа зарчмын хувьд. Яагаад гэвэл өчигдрийн хэлэлцсэн асуудлыг өчигдөрт нь санал хураагаагүй. Өнөөдөр хэлэлцэхээр хуралд суугаагүй хүн хэлэлцсэн асуудалд орж хуралд оролцсон болж санал өгөөд байгаа юм. Тэгэхээр санал хураалтыг яг тухайн үед нь санал хураадаг болж байж энэ Их Хурлын гишүүд чинь хариуцлагатай болно. Санал хураалтдаа идэвхтэй оролцдог болно. Одоо ингээд үдээс хойш бүгд гараад явчихдаг шүү дээ. Тэгээд ирц нь хүрэхгүй болохоор санал хураалтыг маргааш болгон хойшлуулж байгаа. Одоо энийгээ ингээд таслан зогсооё оо Учрал дарга аа. Тэгэхгүй бол энэ чинь ийм энэ хууль чинь ингээд давтагдаад л байна. Одоо хэд давтагдах юм. Дахиад 3 жил давтагдах юм уу? Тэгээд яг тухайн үедээ саналаа хураадаг бол унавал тэр л биз, босвол тэр л биз. Унавал тэгээд тэр тухайн үед оролцсон хуралдаа суугаагүй эсвэл хууль санаачилж байсан гишүүдийнх нь өөрсдийнх нь л буруу шүү дээ. Үүнээс хойш ахиж санал хураалтыг хойшлуулахаа больё Учрал дарга аа.

Н.Учрал: Ойлголоо. Ер нь зарчмын зөв санал байна. Батын Батбаатар гишүүн.

Б.Батбаатар: 2024 оны Улсын Их Хурлын сонгуульд өрсөлдсөн улс төрийн намуудын мөрийн хөтөлбөр дотор манай Иргэний Зориг Ногоон намын мөрийн хөтөлбөр дотор орон сууцыг худалдан борлуулсны зөвхөн орон сууц шүү бүх үл хөдлөх хөрөнгө биш орон сууцыг худалдан борлуулсны 2 хувийн татварыг тэглэнэ гээд заачихсан байдаг юм. Иргэний Зориг Ногоон намын мөрийн хөтөлбөр өнөөдөр бас 100 мянган хүний дэмжлэгтэйгээр Улсын Их Хурлын чуулганы танхимд орж ирж байна.

Тийм учраас хууль санаачлах тал дээр Учрал даргын хэлдгээр ажлын хэсэг байгуулахгүйгээр Учрал дарга, Сайнзориг, Лувсанжамц гишүүд ингээд бид 4 хамтраад хууль санаачлахаар болчихлоо гэж ойлгож байгаа. Тэгэхээр Иргэний Зориг ногоон намын байр суурь бол ард түмэнд амласан мөрийн хөтөлбөрөөсөө өөрчлөгдөх ёсгүй. Тийм болохоор орон сууцын 2 хувийн татварыг тэглэхээр энэ хуулийг оруулж ирцгээе. Засгийн газарт чиглэл өгөхгүйгээр. Их хурлын гишүүд, иргэд, сонгогчдын төлөөлөл гэдгээ ойлгож Засгийн газарт бид нар даалгасан гэхгүйгээр ингээд оруулаад ирвэл сайн болов уу гэж бодож байна.

Н.Учрал: Саналыг хүлээж авлаа. Сайнзориг, Лувсанжамц гишүүнээр, Батбаатар гишүүнийг оруулаад ажлын хэсэг байгуулна аа. Их Хурлын даргын захирамжаар. Хуулийг нь бол 2 цагт Сайнзориг гишүүн бичнэ. Тэр бол олон жилийн дунджаар. Гол нь эрмэлзэл байх ёстой. Тэрнээс хууль бичихдээ биш.

Тийм учраас энэ иргэдийн саналыг шийдвэрлэх хэрэгтэй. Байнгын хорооны саналаар Засгийн газарт чиглэл өгөх тухай Их хурлын тогтоолын төслийг баталъя

гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулах ёстой. Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулна.

Байнгын хорооны саналаар Засгийн газарт чиглэл өгөх тухай Их Хурлын тогтоолын төслийг батлах ёстой. Санал хураалтад бэлтгэе.

Хуульд бол 44.3 дээр 7 хоногийн баасан гаргийн 10 цагт нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна.

Хуралдааны ирц хуулийн төсөл эцэслэн батлах шаардлага хангахаар бол бусад өдөр цагт хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулж болно гээд 44.3 дээр заачихсан юм байна лээ. Саналаа хураах уу? Байнгын хорооны саналаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явууллаа.

Санал хураалт.

Санал дэмжигдсэнгүй. Үгүй үгүй энийг оруулах ёстой шүү дээ. Засагт шимтгэл өгөхгүйгээр гишүүд зарлачихна тэгээд мөнгөний 4 тал болдог. Засаг төрийн дээд шатныхантайгаа энэ хориод янзын асуудал нөлөөлж байгаа юм байна лээ. Энэ хүүхдүүд нь өөрчлөгдөөд байгаа асуудал биш шүү дээ энэ байна шүү дээ 100 насаа төсөвт үзүүлэх нөлөө чинь 110 мянга гарчихсан байна лээ шүү дээ жишээ нь миний хувьд л байдаг шүү дээ. Санаачлах бол боломжтой. Их Хурлын даргын захирамжаар байгуулаад явах уу яах вэ гэдгээ л шийд. Сая Номинчимэг гишүүн яасан юм. Төхөөрөмж ажиллаагүй юм уу? Тэр сандал дээр суугаад байгаа юм биш үү та, өөр хүний кноп дээр. Номинчимэг гишүүн горимын санал гаргая.

О.Номинчимэг: Санал хураалтын үед төхөөрөмж дээр нөгөө улаан анхааруулга гараад ажиллаагүй учраас санал хураалтыг хүчингүй болгож дахин явуулж өгнө үү гэсэн горимын санал гаргаж байна аа.

Н.Учрал: Санал хураана аа. Номинчимэг гишүүний энэ төхөөрөмж дээр алдаа заасан байна. Тийм учраас төхөөрөмжтэй холбоотойгоор горимын санал гаргаж байна аа.

Сая хураагдсан саналыг хүчингүй болгоё гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Тогтоол дэмжигдсэнгүй ээ, тогтоол дэмжигдсэнгүй. 34 гишүүн дэмжээд сая горимын санал дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны саналаар Засгийн газарт чиглэл өгөх тухай Их Хурлын тогтоолын төслийг дэмжсэнгүй. Тэгэхээр одоо Их Хурлын дэгийн хуульд заасны дагуу Их Хурлын даргын захирамжаар хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийг байгуулж байна. Сайнзориг гишүүнээр ахлуулж, ажлын хэсгийг байгууллаа. Батбаатар гишүүн Лувсанжамц гишүүн гээд гишүүдийг ажлын хэсэгт оруулна.

Тийм ер нь 100 мянган хүний гарын үсэг цуглаад санал, дүгнэлтийг нь Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцчихсэн. Тэгэхээр энэ санал, дүгнэлтийг хэлэлцсэн талаарх энэ хуралдааны протокол, тэмдэглэлийг Засгийн газарт хүргүүлье. Тэгж болно биз дээ ингээд явуулъя.

Ингээд Их Хурлын ч ажлын хэсэг байгуулж болж байна. Ингээд Засгийн газарт ч гэсэн энэ хуралдааны тэмдэглэл протоколыг хүргүүлж байна. Юутай ч иргэдийн 100 мянган хүний саналыг Их Хурлаар хэлэлцсэн учраас энэ дээр шийдвэртэй алхмыг гаргахаар шийдвэрлэлээ.

Улсын Их Хурлын гишүүдэд талархал илэрхийлье.

Дараагийн асуудлыг хэлэлцэнэ.

Ер нь бол тэр дэгийн хуулийнх нь 44.3 дээр энэ саналуудыг нэгтгэж хураалгаж болно гэдэг талаар эрх зүйн зохицуулалт нь байгаа юм байна лээ шүү. Гишүүдэд хэлэхэд хуулийн дагуу л явж байгаа.

16.28 цаг

Дараагийн асуудалд орно.

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нарын 21 гишүүн 2025.12.12-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалд орно. Дараагийн асуудалд оръё оо гишүүд ээ, анхааралтай.

Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг хэлэлцэх талаар хуулийн төслийг хэлэлцэнэ ээ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Алтаншагай гишүүн танилцуулна. Алтаншагай гишүүнийг индэрт урья. Гадаад зээлийн ашиглалт үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн үзэл баримтлалын талаарх танилцуулга, илтгэлийг Алтаншагай гишүүн танилцуулна.

Н.Алтаншагай: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын нийт 20 гишүүнээс санаачлан Гадаад зээллэгийн ашиглалт үр ашгийг нэмэгдүүлэх тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ. Монгол Улс 1990 оноос хойш ОУВС, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг ОУБ-д гишүүнээр элсэж зах зээлийн эдийн засгийн шилжилтийг давах эдийн засгийн болон нийгмийн дэд бүтцийг бий болгох зэрэгт дээрх ОУБ-тай 2 талт хамтын ажиллагааны хүрээнд Засгийн газраас гадаадын нэн хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийг авч ашиглаж ирсэн. 2011 оноос нэн хөнгөлөлттэй зээл өөрчлөгдөж энгийн болон хөнгөлөлттэй зээлд хамрагдах болсон. Харин 2024 оноос эхлэн манай улс дунджаас дээгүүр орлоготой улс болсон тул зөвхөн арилжааны нөхцөлтэй зээл авах боломжтой болж зээлийн нөхцөл өөрчлөгдөж байна аа. Өнгөрсөн хугацаанд нийт 21.7 их наяд төгрөгийн гадаад зээллэгийг авч ашиглан дэд бүтэц, худалдаа,

эдийн засаг, эрчим хүч, эрүүл мэнд, боловсрол, уул уурхай, ХАА, нийгмийн хамгааллын чиглэлээр 300 гаруй төслийг хэрэгжүүлсэн байна.

Үүнд:

Япон улсын зээлээр шинэ олон улсын нисэх онгоцны буудал барих төсөл, тусламжийн хөрөнгөөр Япон Монголын анагаах ухааны эмнэлэг, Бүгд Найрамдах Хятад улсын зээлээр Төв цэвэрлэх байгууламжийг барих төсөл, Улаанбаатар Хөшгийн хөндийн шинэ нисэх онгоцны буудлын хурдны авто зам барих төсөл, Яармагийн болон замын цагдаагийн гүүр барих төслүүд, Гацуурт, Налайхын авто замын төсөл, Азийн хөгжлийн банкны зээлээр баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Дэлхийн банкны зээлээр эрчим хүчний алдагдал бууруулах, эрчим хүчний шинэчлэл хийсэн эрчим хүч 1.2 төсөл зэрэг томоохон төслүүдийг ашиглалтад оруулсан байна аа.

Харин өнөөдрийн байдлаар Улсын Их Хурлаас соёрхон баталсны дагуу Засгийн газрын шугамаар гэрээ хэлэлцээр нь байгуулагдсан гадаад зээлийн тусламжийн нийт 116 төсөл хэрэгжиж байгаагаас гадаад зээлийн 89 төсөл байна.

Эдгээрийн төсөл зээлийн санхүүжилтийн ашиглагдаагүй нийт үлдэгдэл 14.7 их наяд төгрөг.

Үүнд:

Түүнчлэн 95.5 хувь нь 2030 он гэхэд дуусахаар гэрээ хэлэлцээр байгуулагдсан байна аа. Гэвч гадаадын зээлийн ашиглалтын хэмжээ тухайн жилийн төсөвт хязгаарлагдмал байдлаар батлагдаж байгаагаас шалтгаалж эдгээр төслүүдийн хэрэгжилт удаашрах, нэмэлт санхүүжилт үүсэх, зээлийн үйлчилгээний төлбөрт нэмэгдэх зарим төслүүд 10 хүртэлх жилийн хугацаанд хэрэгжих эрсдэлтэй байна аа.

Иймд гадаад зээлийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа төслүүдээс Үндэсний аюулгүй байдлыг хангах Улсын Их Хурлаас баталсан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан 14 мега төслийн жагсаалтад багтсан импортыг орлож үйл ажиллагааны орлогоороо зардлаа нөхөх чадамжтай нийгэм эдийн засгийн өндөр ач холбогдол, үр ашиг бүхий газрын тос боловсруулах үйлдвэр Эрдэнэбүрэнгийн УЦС барих төсөл болон Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслүүдийг хугацаанд нь санхүүжүүлж ашиглалтад оруулах зорилго бүхий анхдагч хуулийн төслийг зарим гишүүдийн хамт боловсруулж өргөн бариад байна аа. Өмнө дурдсан гадаад зээлийн ашиглагдаагүй үлдэгдлийн 38 хувь буюу 5.6 их наяд төгрөг нь газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн УЦС барих төслүүдийн санхүүжилт байна аа.

Гадаад зээлийн эх үүсвэр хэрэгжүүлж буй зөвхөн дээрх 3 төслийн санхүүжилтийн ашиглалтын зардлыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12.1.4, 12.1.5 заасан нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээ болон нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн тооцооллоос тусад нь тооцож явах тухай зохицуулалт юм аа. Хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл бөгөөд дээрх төслүүдийг Улсын Их Хурлаас соёрхон баталсан хугацаагаар хэрэгжиж зээлийн ашиглалт нь гэрээ, хэлэлцээр батлагдсан дүнгээс хэтрэхгүй байх хязгаарлалттай бөгөөд бүтцийн хувьд 9 зүйлтэй. Хуулийн төсөлд хамаарах төслүүдийг тодорхой тусгасан болно оо.

Харин дээрх төслүүдийн ашиглалтын хэмжээгээр Засгийн газрын өр бүртгэх өрийн хязгаарт тооцох зэрэг бусад харилцаанд хуулийн төсөлд өөрчлөлт оруулахгүй бөгөөд хуулийн төсөлд тусгаснаас бусад асуудлыг холбогдох хуулиудаар зохицуулна аа.

Анхдагч хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг бүрэн хангаж холбогдох судалгааг боловсруулж өргөн барьсан. Тухайлбал судалгааны тайлангаас харахад олон улсын ийм туршлага түгээмэл байдаг бөгөөд ХБНГУ, Сингапур зэрэг өндөр хөгжилтэй улсууд хөгжлийн томоохон төслүүдээ ийм байдлаар санхүүжүүлж ирсэн туршлагатай байна аа.

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хууль батлагдсанаар дараах эерэг үр нөлөө үр ашиг гарна аа. Үүнд Газрын тос боловсруулах үйлдвэр хугацаандаа баригдсанаар жилд 1.5 сая тонн түүхий газрын тос боловсруулах дотоодын хэрэглээний 55 хувийг хангах, жил бүр 1 тэрбум доллар дотооддоо үлдэж импортын хараат байдлаас гарч шатахууны үнийг бие даан уян хатан зохицуулна. Эрдэнэбүрэнгийн УЦС ашиглалтад орсноор жилд 366 сая квт цаг цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэж баруун бүсийг цахилгаан эрчим хүчээр хангана. Жил бүр 17.5 тэрбум төгрөгийг дотооддоо үлдээж импортын эрчим хүчийг орлоно. Сэлбэ дэд төв гэр хорооллыг орон сууцжуулснаар нийт 158 мянган га талбайд 10 мянга гаруй айлын орон сууцын цогцолбор хороолол бий болно. 118 мянга гаруй янданг цөөрүүлж, Улаанбаатар хотын агаар, хөрсний бохирдлыг бууруулах, 4 мянга гаруй нүхэн жорлонг устгаж, хөрсний бохирдлоос бууруулах, цэвэршүүлэх.

Мөн зээлийн ашиглалтыг сайжруулснаас газрын тос боловсруулах үйлдвэр Эрдэнэбүрэнгийн УЦС-ын төслийн зээлийн ашиглаг ашиглаагүй үлдэгдэл төлөх төлбөрт 105.1 тэрбум төгрөгийг хэмнэх. Энэхүү хууль батлагдсанаар нийт гарах үр дүн, дээрх хязгаарлагдахгүй бөгөөд стратегийн гол бүтээгдэхүүний импортын хэт хамаарал буурч валютын гадагшлах хэрэгжилтийн валютын урсгал эрс багасаж Улсын Их Хурлаас соёрхон баталсан зээлийн гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж олон улсын хөгжлийн түншлэл байгууллагуудтай байгуулсан гэрээний үүргээ биелүүлнэ ээ.

Төсөвт учруулах гадаад зээлийн дарамтыг багасгаж, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах. Бусад шинэ зээлийн төслүүд хугацаандаа хэрэгжих зээлжих зэрэглэл нэмэгдэх боломж бий болох юм.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Үндэсний аюулгүй байдлын гол бүтээгдэхүүн болох газрын тосны бүтээгдэхүүний дотооддоо үйлдвэрлэх, үнийг дотооддоо тогтоох боломж олгох Баруун бүсийг эрчим хүчээр хангах импортын хараат бус байдлаас гарах, гэр хорооллыг орон сууцжуулах, Улаанбаатар хотод тулгамдаад буй агаарын бохирдлын асуудлыг шийдвэрлэх 3 төслийг хугацаанд нь ашиглалтад оруулах хууль, эрх зүйн орчин бий болох энэхүү хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг танилцуулна.

П.Сайнзориг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нарын 21 гишүүнээс 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гадаадын зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх, эсэх асуудлын хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар явууллаа.

Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталсан үндэсний аюулгүй байдлыг хангах Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 14 мега төслийн жагсаалт тусгагдсан.

Засгийн газрын өрийн баталгаагаар баталгаажсан импортыг орлох үйл ажиллагааны орлогоороо зардлаа нөхөх боломжтой нийгэм эдийн засгийн өндөр ач холбогдол үр ашиг бүхий газрын тосны боловсруулах үйлдвэр Эрдэнэбүрэнгийн УЦС, Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслийн санхүүжилтийн ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна аа.

Гадаадын зээллэгийн ашиглалтыг нэмэгдүүлэхтэй холбоотой хууль эрх зүйн орчныг бүрдүүлснээр хэлэлцээрийн шатад хүлээгдэж байгаа томоохон төслүүд хэрэгжих, хэрэгжиж эхлэх нөхцөл бүрдэх. Гадаадын зээлийн санхүүжилтийг богино хугацаанд үр дүнтэй ашиглах нь төсөвт учруулах дарамтыг багасгах, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, улмаар улсын олон улсын хэмжээнд Монгол Улсын нэр хүндийг дээшлүүлэх зээлжих зэрэглэлийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ гэж хууль санаачлагч үзсэн байна аа.

Хуулийн төслийг 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр D-parliament.mn цахим хуудаст байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байна аа. Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал улс орны хөгжилд ач холбогдол бүхий томоохон төслүүдийг хэрэгжүүлэхийг дэмжих нь зүйтэй бөгөөд гэрээ хэлцэл хийгдсэн боловч ашиглалт үр ашиг нь хангалтгүй байгаа гадаадын зээлийн ашиглалтыг сайжруулахад анхаарах төслүүдийг хэрэгжүүлснээр Монгол Улсын төсвийн тусгай шаардлага хангагдах эсэх, мөн Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллын орон сууцжуулах төслийн зардал нь төсөвт хэрхэн тусгагдсан талаар, цаашид томоохон төслүүдийн санхүүжилтийг Хөгжлийн банкаар хэрэгжүүлж Засгийн газар өрийн баталгаа гаргах хэлбэрээр зохицуулах боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд төсөлд тусгагдсан газрын тос боловсруулах үйлдвэр барих, Эрдэнэбүрэний УЦС барих төслүүдийг дэмжиж байгаагаа илэрхийлж Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллын орон сууцжуулах төслийг хэрэгжүүлэхдээ хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх боломжтой эсэх, мөн барилгын төсөвт өртөгт газар чөлөөлөлтийн төлбөр болон дэд бүтцийг барих зардал тооцсон эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ч.Номин томоохон төслүүдийн Хөгжлийн банкаар дамжуулан хэрэгжүүлэх нь зүйтэй бөгөөд дахин ийм агуулга бүхий нэг удаагийн шинжтэй хуулийн төслийг өргөн мэдүүлэх эсэх, мөн хуулийн төслийг батлагдсанаар үүсэх эрсдэл болон эдгээр 3 төслийн хэрэгжилтийн явц үр өгөөжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг гадаад зээлийг төсвийн тусгай шаардлагад тооцохгүйгээр ашиглах агуулга бүхий

хууль батлагдаж байсан эсэх талаар тодруулж гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэн, хурдан хугацаанд эргэлтэд оруулж ашиглалтыг сайжруулахад анхаарах зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар гадаад зээлийн ашиглалтыг Хөгжлийн банкаар дамжуулан хэрэгжүүлэх мөн холбогдох төрийн төрийн захиргааны байгууллагын ажлын уялдааг хангах, эрсдэлийг багасгаж хяналтыг сайжруулах нь зүйтэй талаар дурдаж БНСУ-ын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжиж буй 10 аймгийн төвд дулааны станц барих төслийн хэрэгжилтийн явцын талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийг төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн санхүүжүүлэх шаардагдах хугацаа, энэ хугацааны ашиглагдаагүй зээлийн хүүгийн зардал болон нийт гадаад зээлийн үлдэгдэл Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслийн дүн багтсан эсэх, мөн Монгол Улсын гадаад зээлийн жилийн дундаж хүүгийн түвшин ирээдүйн өв сангийн хөрөнгийн үлдэгдэл хэдэн хувийн хүүтэй хаана хадгалагдаж байгаа талаар.

Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслийг хэрэгжүүлэхдээ дэд бүтцийн зардлыг төр хариуцан барилга байгууламжийг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал төсөвтэй холбоотой буруу жишиг тогтоож байгаагаа анхааруулж, төсвийн урсгал зардал, зардал, шинэчлэл хийх ажлын явц болон удаашралтай үр дүнгүй төслүүдийн санхүүжилтийг зогсоох, эдгээр төслүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой Монгол Улсын 2025, 2026 оны төсөвт тусгагдсан санхүүжилтийн дүн, худалдан авалтын хэмжээ, ажлын байрны өсөлтийн талаар, мөн хууль хэрэгжих хугацаа болон зээлийн орон зай үүссэнтэй холбоотой нэмж дахин зээл авах эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг нийслэлд гаргасан бондын дүн, зарцуулалт, үлдэгдлийн талаар, мөн хуулийн төслийн нэрийг оновчтой тодорхойлсон эсэх газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын явцын талаар асууж хариулт авлаа.

Байнгын хорооны хуралдаанаар Гадаадын гадаад зээлийн ашиглалт үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн 55.6 хувь нь буюу олонх дэмжиж, хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Н.Учрал: Ажлын хэсгийг танилцуулъя. Буриадын Дашпүрэв, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны ТНБД, Батмөнхийн Ерөн-Өлзий ЭХЯ-ны ТНБД, Жамьяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Огнонгийн Хуягцогт ЭХЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга, Түмэндалайн Даваадалай НЗД-ын орлогч, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Маамбын Үнэнбат НЗДТГ-ын Хууль тогтоомжийн газрын дарга, Лхагвадоржийн Эрдэнэбадрах НЗДТГ-ын

Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Дашдаваагийн Алтанцэцэг Монголын газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал.

Урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Улсын Их Хурлын гишүүд урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж асуулт асууж, хариулт авна аа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн байхгүй байна. Ганзоригийн. Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Би энэ гадаад зээлийг төсвөөсөө гаргах гэж байгаа энэ хуулийн төслийг дэмжихгүй байгаа. Би өмнө нь ч энэ зарчмын ийм байр суурьтай байсан. Энэ өөрөө зарчмын асуудал. Үндсэндээ бид нар энэ хүндэрч байгаа эдийн засаг төсөв санхүүгийнхээ асуудлыг суурь шалтгаанаар нь агуулгаар нь харж нэг янзлахгүй бол зүгээр нэг өнгөц косметик төдий ийм өөрчлөлтийг хийгээд бол өөрөө явахгүй ээ. Энэ улс орон чинь өөрөө дүрэмтэй журамтай, төсөв санхүүчийн нэг бодлоготой эдийн засаг нь өөрөө онол зарчимтай асуудал. Тэгээд би зарчмынх нь бодлогынх нь асуудлаар нь энэ асуудалд хандаач ээ, зөв байгаач ээ, зарчмаар нь хийгээч л гэдэг саналыг тавих гээд байгаа юм.

Үндсэндээ энэ төсөв гадаад зээл тусламжаа энэ төсвийнхөн гадна гаргаад бид нар энэ асуудлаас ангижирна гэж байхгүй. Эсвэл тэр гадаад зээлийг юу гэдэг юм өр зээл, өглөгийг, өрийг, зээлийг зээллэг гэж өөрөөр нэрлээд, өөрсдийгөө хуураад, бодит үнэнээсээ бид нар нялзаж чадахгүй шүү дээ. Тэгэхээр үндсэндээ энэ асуудлыг бид нар сууриар нь томоор нь харж байж шийдэхгүй бол одоогийн өнгөц ийм байдлаар бол би завхруулж шийдэж болохгүй л гэдэг саналыг хэлэх гээд байгаа юм. Үндсэндээ энэ чинь 2012-2016 оны тэр үеийн АН-ынхны алдааг бид нар давтах гэж байна шүү дээ. Хөгжлийн банкныхаа бүх зээлүүдийг төсвийнх нь гадна гаргаж байсан. Эргээд л тэрнийх нь горьг нь бид нар эзэлж байсан зээлжих зэрэг л буурч байсан. Олон улсад нэр хүнд байхгүй болсон. Өөрсдөө хяналтгүй болсон. Төсвийн сахилга бат нь байхгүй болсон. Өрийн удирдлага дээр эрсдэл үүссэн. Тэгээд бид нар энэ төсвийн тогтвортой байдал, төсвийн сахилга бат гэдэг асуудлыг мянга яриад иймэрхүү байдлаар асуудалд хандаад байх юм бол нэмэргүй л дээ. Энэ асуудал дээр би зүгээр энэ хууль зүйн талаас нь санхүү засаглалынх нь талаас нь ч гэсэн зүгээр судалж нягталж үзсэн юм. Ингээд үзэхээр үндсэндээ тэр саяын миний хэлж байгаа асуудлууд байхгүй байна.

Дээрээс нь энэ хууль тогтоомжууд чинь өөрөө зөрчигдөх нь байна. Үндсэн хуулийн зарчмын асуудал ч гэсэн өөрөө энэ дээр зөрчигдөх асуудал үүсгэнэ. Монгол Улс чинь угаасаа энэ Төсвийнхөө тухай хуулиар төсөв чинь өөрөө иж бүрэн үнэн зөв байдлыг хангасан зарчмуудыг хангах ёстой гэдэг хуультай. Уг нь бол энэ хуулийг гишүүд зүгээр нэг хууль өргөн барьж ийм байдлаар шийдэх биш Сангийн яам энийг өөрөө шийдэх ёстой байсан юм. Засгийн газар өөрөө өргөн барих ёстой байсан. Үндсэн хуулиараа энэ чинь төсөв зээлийн төлөвлөгөө Засгийн газар өргөн барих онцгой эрхтэй.

Тэгэхээр энэ чинь нэг талдаа бол Засгийн газрын эрхэд халдаж байгаа асуудал. Хууль дээдлэх зарчим маань яасан бэ? Бид нар цаашид юу гэдэг юм энэ зээл төлөлтийнхөө асуудлуудыг яах юм, эргэн төлөлтийг нь хэн хариуцах юм. Төсвөөсөө гадна гаргалаа гээд энэ асуудлууд дээр бид нар ер нь яаж хандах юм? Олон улсад юу гэж хэлэх юм. Олон улсын гэрээгээр ч зөрчсөн асуудал үүсэх вий гэсэн ийм асуудлууд байгаа. Ер нь бол энэн дээр Улсын Их Хурал хууль зүйн дүгнэлт гаргуулах ёстой гэж бол харж байгаа. Тэгэхээр ийм асуудалд би зүгээр нэг

ийм байдлаар бол хандмааргүй байна аа. Өр зээлгүй юм шиг нүдээ аниад бид нар юу гэдэг юм харанхуй руу чиглээд яваад байвал хэзээ нэгэн цагт бүдэрч ойчих л байх. Тэгээд хүнээс авсан зээлээ бид нар төсвөөсөө хаслаа гээд өргүй болохгүй, зээлээ төлөхгүй гэдэг зүйл үүсэхгүй шүү дээ.

Тэгэхээр ийм байдал дээр бол би хандмааргүй байна. Энэ байдал дээр жоохон хариуцлагатай баймаар байна. Бид нар чинь төсөв санхүүгийн энэ хүндрэлийг чинь ард түмэн л амьжиргаа орлогоороо, амьдралаараа л үүрч туулж гарч байна шүү дээ.

Тэгэхээр арай илүү томоор нь зарчмынх нь өнцгөөс арай илүү шинжлэх ухаанчаар мэргэжлийнх нь хүмүүсийнх нь дуу хоолой тэр мэргэжлийн байгууллагуудынх нь санал, дүгнэлт, зөвлөмжийг бол харгалзаж байж шийдэх ёстой л гэдэг би ийм байр суурьтай байгаа.

Н.Учрал: Тэмүүлэн гишүүн санал хэллээ. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн байхгүй байна. Мөнхбаясгалан гишүүн.

П.Сайнзориг: Энэ хуулийг талархан хүлээн авч хамт өргөн барьж байгаа гишүүдийн нэг юм аа. Алтанширээгийн газрын тосны үйлдвэр дээр Байнгын хороон дээр ажлын хэсэг ахалж 2 чуулган дамжин ажилласан хүний хувьд энэ үйлдвэр яагаад баригддаггүй юм бэ гэдэг зүйлүүдийг нэлээн судалсан. Хэд хэдэн хүчин зүйл байгаа. Энэний хамгийн гол нь одоо энэ гадаадаас авсан зээлийн зарцуулалт байгаа юм. Манай улс БНЭУ-аас 6.1 их наядын зээл авсан. Энэ бол Монгол Улсын Засгийн газар түүхэндээ авч байгаагүй хамгийн өндөр зээл юм. Энэ зээлээ бид нар яг бүрэн ашиглаж чаддаггүй. Хамгийн гол нь бид нар өнөөдөр газрын тосны үйлдвэрийг яагаад баригддаггүй юм. Бариад л 2028 он гэхэд барьж дуусгах ёстой гэдэг чиглэл өгөөд л байдаг. Газрын тосны үйлдвэрийнхнийг Сангийн яамтай юутай хийтэй нь дуудаж ирээд л загнаад байдаг. Тэгсэн хэрнээ бид нар мөнгийг нь өгдөггүй байхгүй юу даа. Сая 2026 оны улсын төсөвт ерөөсөө 200 тэрбум төгрөг л газрын тосны үйлдвэр дээр тавьсан. Гэтэл одоо хэрэглэгдээгүй зээл нь 4 гаруй их наяд төгрөг тэнчээ байгаа. Бид нар энэнийхээ шимтгэлд жилд өнгөрсөн 2025 онд 20 тэрбум төгрөг төлчихсөн байж байгаа. Хамгийн гол нь энэ чинь бид нар банкнаас зээл авсан юм болохоороо хүүгээ төлнө, шимтгэлээ төлнө. Хэрэглээгүй зээлээсээ мөнгөө төлнө. Тэгчхээд өнөөдөр бид нар энд хуулиараа явна гээд байдаг. Тэгвэл хуулиараа явах юм бол өнөөдөр жилд 200 тэрбумаар газрын тосны үйлдвэрийг барина гэх юм бид нар 15 жил барих гээд байгаа байхгүй юу.

Дээрээс нь ашиглаагүй зээлийнхээ үлдэгдлийг биш, шимтгэлийг төлөх гээд байгаа байхгүй юу. Тэгээд энэ чинь шударга ёс юм уу. Энэ чинь зөв зохицуулалт юм уу? Газрын тосны үйлдвэрийг барих гэж бид нар 2016 онд анх хэлэлцээрээ хийсэн. 2017 онд 1 тэрбумыг зээлсэн, дараа нь 1.2 болгож 2 болгож соёрхон баталсан. Өнгөрсөн жил 1.7 болгож соёрхон баталсан. Тэгээд өнөөдөр энд попрох болохоороо тэр үйлдвэр яачихсан гэдэг. Өнөөдөр бид нар ингээд бензиний хараат байдалд орчихсон. Бид нар жил болгон газрын тосны бүтээгдэхүүн худалдаж авахдаа 2 тэрбум доллар гадагшаа гаргадаг. Энэнээсээ гарах ёстой юм биш үү. Тэгэхээр энэ 3 төсөл бол үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцсэн төсвийнхөө үр өгөөжийг маш хурдан төлж чадахаар зээл нь батлагдсан ийм л төсөв. Бид нар хэрвээ зоригтой ийм алхам хийхгүй бол яг энэ байдлаараа 15 жил өнөөдөр байсаар л байх болно оо.

Тийм учраас би Газрын тосны үйлдвэр Сангийн яамнаас ийм асуулт асууя аа. Бид нар Энэтхэгээс хэдэн хувийн хүүтэй зээл аваад өнөөдөр хэдэн төгрөгийг нь ашиглаад байгаа юм бэ? Яг энэ хэвээрээ жилдээ 200 тэрбумаар явах юм бол энэ үйлдвэрийг хэдэн жилийн дараа барьж ашиглалтад оруулах юм. Энэ хуулийг энэ анхдагч хуулийн төслийг бид нар өнөөдөр хэлэлцэх эсэхийг дэмжихгүй бол бид юу алдах юм. Ийм 3 асуулт асуугаад тодруулъя.

Н.Учрал: Хэн хариулах вэ? Дэлгэржаргал дарга хариулна 4 дүгээр микрофон.

Ж.Дэлгэржаргал: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Газрын тос боловсруулах үйлдвэрийн хүү яг 1.75 хувь жилийн. Хугацаа 20 жилийн хугацаатай. Хөрөнгө баталгаажуулсны шимтгэл буюу ашиглаагүй зээлийн үлдэгдэл дээрээ 0.5 хувийн шимтгэл төлдөг. Тэгэхээр одоо яг 6.1 их наядаас 1.3-ыг бид нар ашигласан. Яг гэрээ хэлэлцээрийн хугацаагаараа 2028 он гэхэд бид нар үлдэгдэл 4.7 их наядыг ийм ашиглах Улсын Их Хурлаар соёрхон баталсан хэлэлцээрийн ийм хугацаатай байгаа. Яг үйлдвэрийн бодит гүйцэтгэл 40 гарчихсан хувьтай явж байгаа. Гэтэл зээлийн ашиглалт маань өөрөө 22 хувьтай явж байна. Тэгэхээр одоо яг байгаа 2026 оны төсөв маань угаасаа батлагдсан. Гадаад зээлийн ашиглалт 2026 оны төсөв дээр нийтдээ бүх төслүүдийн хүрээнд нийтдээ 1.2 их наяд байгаа. Яг энэ дүнгээсээ бид нар хуваарилах юм бол 200 тэрбумыг гадаад зээлийн ашиглалт дээр санхүүжүүлэх боломжтой. Яг газрын тос боловсруулах үйлдвэрээс ирж байгаа хэрэгцээ шаардлага болон авах шаардлагатай дүн бол 2026 он дээр 1.7 их наядын хэрэгцээ шаардлага байгаа гэж байгаа.

Тэгэхээр яг энэ хууль батлагдах юм бол бид нар 1.7-г санхүүжүүлэх боломж бүрдэнэ. Одоогийн байгаа зохицуулалтаар явбал 200 тэрбум, нийт үлдэгдлийг яг энэ 200 тэрбумаар ингээд тооцоод үзвэл 10-аас 15 жилд л бид нар ашиглалтаа гаргаж дуусах нь гэдэг ийм тооцоолол байгаа. Үйлдвэрийн яг ТЭЗҮ-ээр 2024 оны тооцооллоор бид нар дотоодын яг шатахууны хэрэглээний 55 хувийг энэ үйлдвэр ашиглалтад орсноор хангана. Одоо хамгийн багадаа ер нь бол гадагшаа гарч байгаа нийт шатахууны импортын төлбөрт гарч байгаа төлбөр бүрийн 1 тэрбум ам.долларыг дотооддоо үлдээх ийм боломж ажлын байр гээд нийгэм эдийн засгийн ач холбогдлын хувьд маш олон үзүүлэлтүүд байгаа.

Н.Учрал: Хариулт хэллээ. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн байхгүй байна. Нямтайширын Номтойбаяр гишүүн байхгүй байна. Та чинь хууль санаачлагч биз дээ. Ариунзаяа гишүүн та чинь санаачлагч уу, үгүй юу. Ариунзаяа гишүүн асуулт асууна.

А.Ариунзаяа: Би энэ хуулийг дэмжихгүй байгаа юм аа. Би Тэмүүлэн гишүүнтэй Төсвийн байнгын хорооны даргаар ажиллаж байсан хүн, Сангийн яаманд ч ажиллаж байсан хүн. Тэмүүлэн гишүүнтэй Хөгжлийн банканд ажиллаж байсан Даваагийн Цогтбаатартай санал нэг. Энэ ер нь бол Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиудыг зөрчсөн. Энэ дээр Улсын Их Хурлын Тамгын газар хууль зүйн дүгнэлт гаргуулах хэрэгтэй гаргах хэрэгтэй. Энэ санаа ер нь хэзээ анх төрсөн юм бэ гэхээр өнгөрсөн жил алдагдалгүй төсөв батална гэсэн тэр давлагааны дараахан төрсөн юм. Яаж энэ зээлүүдээ энэ төслүүдээ явуулах вэ гэж тэгээд ийм мэргэн санаа сэдсэн байхгүй юу төсвөөс гаргачихъя гэж болохгүй шүү дээ. Давхар давхар төсөв бид нар чинь яаж цэгцлэлээ тэгээд юуны тулд Хөгжлийн банкныг байгуулсан юм. Хөгжлийн банкаараа

дамжуулаач дээ болно шүү дээ. Тийм гуравхан төслийг онцлоод энэ 3 төслийн эсрэг байгаа хүн нэг ч байхгүй бүгд гурвуулаа чухал. Эрдэнэбүрэний усны цахилгаан станц ч тэр, энэ тойрог зам ч тэр, газрын тосны боловсруулах үйлдвэр тэр тусмаа. Гэхдээ Алтанцэцэг захирал боломж олдвол юунаас болоод гацаад гацаад байгаа вэ гэдгийг хэлэх юм бол ямар ч энэ зээлтэй холбоотой бас биш шүү. Энэ манай дотоодын төрийн албан хаагчдын хойрго байгаа нөхцөл байдлаас болоод нэлээдгүй хэсэг нь бол гацаж хойшилж байгаа.

Сангийн яамнаас асуумаар байна. Мэдээж Сангийн яам бол энийг дэмжиж байгаа. Яагаад гэвэл төсвөө цэвэрлэх гээд байгаа байхгүй юу бид нарт хамаагүй. Болохгүй шүү дээ. Тэгээд ер нь бол зүгээр бүртгэлийн л асуудал юм байна лээ. Би Жавхлан сайдтай өмнө нь энийг ярьж байсан. Орлого талдаа бид нар зээлээ бүртгэдэггүй. Зөвхөн зарлага талдаа л зээл нь бүртгэгдээд тэгээд нөгөө тавигдсан хэмжээ хязгаартаа ердөөсөө ингээд давчхаад байдаг учраас болохгүй гээд. Тэгээд шийдэл нь бол бид нар энэ акрюал суурьтай бүртгэл рүүгээ шилжих ёстой гэж байгаа юм. Тэгээд энийгээ бол нэг 5, 6 жилийн хугацаандаа хийх юм байна хугацаа орно оо гэж байгаа байхгүй юу. Тэр ажлаа эхлүүлэх үү? Хэзээ эхлэх вэ? Хэзээ бид нар энийгээ зөв төсөвтэй байж бүртгэлээ зөв хийж эхлэх вэ? Тэгээд өөрөөсөө л холдуулчих юм бол хашаанаасаа л давуулчих юм бол тэгээд бүх юм цэвэр сайхан гэсэн ойлголттой байж болохгүй шүү дээ. Тэгээд энэ зүгээр нэг бүртгэлийн шилжилтийг хийхээсээ өмнө зүгээр хийтлээ энэ мега төслүүдийг санхүүжилтийг бусад энэ Хөгжлийн банкаараа дамжуулж болдоггүй юм уу? Тэгээд энэ хуулийн төслийг бол 1 дүгээрт Засгийн газрын эрхэд халдсан байна. Хуулиудыг зөрчсөн байна. Гуравхан төслийг онцолж энэ авч байгаа нь бол туйлын буруу. Энэний дараа дараагийнх нь чухал асуудлууд л гарч ирнэ. Тэгээд бас л энэ зээлийг ашиглая.

Өнөөдөр бид нар 2 зээлийг соёрхон баталлаа шүү дээ. Бас л маш чухал асуудлууд. Тэгээд ирэх оны төсөвт хэрэвзээ энд хүч түрээд олноороо энэ хуулийг баталлаа гэж бодоход ирэх оны төсөв дээр яаж нөлөөлөх юм? Төсвийн тодотгол хийх үү? Их сайхан орон зай гараад ирэх нь байна шүү дээ тиймээ. Тэгээд зөв байцгаая. Нэг улс л юм бол төсвөө өөрсдөө Улсын Их Хурал мэддэг баймаар байна. Хуулийн төслийг дэмжихгүй байгаа. Өөр байгаа гарц шийдлээр нь шийдэж болохгүй байна уу гэдгийг Сангийн яамнаас асууя.

Н.Учрал: Ариунзаяа гишүүн санал хэллээ.

Даваагийн Цогтбаатар гишүүн, Батбаатар гишүүн байхгүй байна хаслаа. Цэндийн Сандаг-Очир гишүүн байхгүй байна. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн байхгүй. Ц.Мөнхтуяа гишүүн байхгүй, Алдаржавхлан гишүүн байхгүй. Ингээд хаана байна байхгүй болсон байна аа. Одоо Ганбаатар гишүүн асуугаад араас нь Цогтбаатар гишүүн асуугаад тэгээд хаана гэсэн үг. Ганбаатар гишүүн.

А.Ганбаатар: Өдрийн мэнд хүргэе гээд. Энэ 3 төсөлд зориулж 2.3 хууль зөрчөөд байна л даа. Тухайлбал Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг энэ 3 төсөлдөө зориулаад нэг удаагийн хуулиар даваад гишгэчхэж байгаа байхгүй юу. Тэгэхээр нөгөө ДНБ-ий 30 хувиас хэтрэхгүй. Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал нь ДНБ-ий 2 хувиас хэтрэхгүй. Засгийн газрын гадаад өр ДНБ-ий 60 хувиас хэтрэхгүй гэсэн бүх заалтуудаа хэмжээнүүдээсээ даваад явчхаж байгаа юм. Тэгээд Алтаншагай гишүүнээс асуух гээд байгаа юм. Энэ нөгөө нэг удаагийн хуулиар бусад хуулиа даваад нэг удаа ашиглаад хаачих хууль юм уу? Тэгж ойлгоод байна л даа.

Хэрэв үнэхээр тийм шаардлагатай бол энэ 3 төслийн 2-ыг нь дэмжээд тухайлбал газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл, Эрдэнэбүрэнгийн УЦС барих төсөл 2-ыг тэр нэг удаагийн хуулиар бусад хуулиар даваад ашиглаад хийж болдог бол энэ 2-ыг нь явуулаад Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллын орон сууцжуулах төслийг хасмаар байгаа юм. Яагаад гэвэл хот өөрөө бизнес яриад байгаа байхгүй юу. Хувийн хэвшилтэй өрсөлдөөд барилга бариад яваад байгаа. Тухайлбал НЗД-ын 1 дүгээр орлогч Даваадалай дарга Төсвийн байнгын хорооны хурал дээр хэлсэн үг нь энд байж байгаа. 1м2-ыг 3950-аар бариад 4250-аар зарна гээд. Ингээд бизнесийн үйл ажиллагаа шууд явуулж байгаа хот өөрөө. Тэгэхээр энэ төслийг Хөгжлийн банк руугаа оруулаад хувийн хэшилдээ өгөөч гээд.

Нөгөө 2 нь үнэхээр амин чухал тэгээд энэ хууль нь нэг удаа ашиглаад цаашаа ашиглаж болдог хааж болдог хууль юм. Эхний 2-ыг нь дэмжээд явуулж болж байна. Ер нь Тэмүүлэн гишүүний хэлээд байгаа тэр Ариунзаяа гишүүний хэлээд байгаа хуулийнхаа дэг журам, төсвийнхөө дэг журмыг бид нар алдаад байна л даа. Тэгээд ингэж болдог юм бол нэг удаагийн хуулиа ашиглаж болж байна. Тэгэхдээ зөвхөн эхний 2 төслийг дэмжихээр, 3 дахийг нь бол хасах ийм саналтай байна.

Тэгээд энэ хууль санаачлагчаас асууж байгаа юм. Засгийн газрын эрхээ даваад төсвийн хүрээний мэдэгдэл төсвийн хууль чинь Засгийн газраар орж ирэх ёстой. Тэгээд засаг нь биш гишүүн санаачлаад орж ирж байна л даа Их Хурлын гишүүд. Тэгээд хуулийнхаа хувьд болж байна уу, үгүй юу Алтаншагай гишүүн ээ. Тэгээд ингээд нэг удаа ашиглаад дараа нь хаачихдаг хууль байгаа бол энэ 3 төсөл чинь хамт явах юм уу? Хэрвээ тэгж болно гэвэл эхний 2-ыг нь дэмжиж байна. Сүүлийнхийг нь дэмжихгүй байна аа.

Н.Учрал: Алтаншагай гишүүн хариулъя.

Н.Атаншагай: Ганбаатар гишүүнд баярлалаа. Энэ хуулийг өргөн барихдаа нэлээн судалгаа тооцоо хийж байж өргөн барьсан. Эхний 2 асуудал дээр бол гишүүд харилцан адилгүй байр суурьтай байгаа. Тэр 3 дахь асуудал бол Улаанбаатар хотын хэмжээнд 2012 оноос эхэлсэн дахин төлөвлөлт буюу энэ гэр хорооллыг орон сууцжуулах энэ хөтөлбөр эхэлсэн. Хууль эрх зүйн орчин нь бүрдээгүй 1 дүгээрт.

Хоёрдугаарт энэ газар чөлөөлөлттэй холбоотой маш олон асуудлууд бий болж байсан. Байнгын хороон дээр ч гэсэн яригдаж байсан. Эхний ээлжид бол Улаанбаатар хотын зүгээс хотын зүгээс энэ дээр заавал анхаарал тавьж төр оролцож байж энэ эхний ажлыг явуулах нь зүйтэй юм байна гэж. Энэ чиглэлийнхээ дагуу энэ хуульд оруулж орж ирсэн. Сэлбэ дэд төвийн хүрээнд өөрөө хот бонд гаргаж 500 сая долларын бонд босгож санхүүжилтээ бүрдүүлсэн байгаа. Тэгэхээр энэн дээр бол нийслэлийн зүгээс ч тэр мөн олон олон өмнөх асуудлууд дээр ч судлаад үзэхэд яалт ч үгүй эхний энэ гарааны нөхцөл дээр төр өөрөө оролцохгүй бол болохгүй юм байна гэж. Тэгээд энэ хотоос сонгогдсон гишүүний хувьд гэр хорооллыг барилгажуулах орон сууцжуулах агаарын бохирдол хөрсний бохирдлоос сэргийлэх салах энэ ажлын хүрээнд санаачилж энийг оруулсан байгаа юм.

Тэгээд Даваадалай нэмэлт мэдээлэл өгөх үү?

Н.Учрал: Жавхлан сайд нэмж мэдээлэл өгье. Дараа нь Даваадалай дарга.

Б.Жавхлан: Гишүүдийн асуултад нэмэлт мэдээлэл өгье өө. Юуны өмнө яг одоо бидний тулчхаад байгаа бодит байдалтайгаа тулчхаад байгаа биднийг бас бид өөрөө өөрсдийнхөө энэ зохиосон дүрэмдээ боомилгогдчихоод байгаа хөгжлийг бас тодорхой хэмжээнд хязгаарлах ийм эрсдэл үүсчхээд байгаа ийм зүйл дээр энэ байдлыг ойлгож, хууль санаачилж өргөн барьж байгаа гишүүддээ талархлаа. Мөн дэмжиж үг хэлж байгаа гишүүддээ ч талархлаа? Засгийн газрын хувьд бол энийг дэмжиж байгаа. Тийм ч учраас Одоо энэ дээр санал зөрж байгаа дэмжихгүй байгаа гишүүдтэйгээ нэмэлт мэдээлэл өгөх, өргөн барьсан гишүүдтэйгээ хамтарч энийг олон нийтэд ойлгуулах ажлууд дээр Засгийн газар дутуу ажиллаад байж магадгүй ээ. Энэ дээр бид их хамтарч сайн ажиллая гэж ингэж бодогдож байна. Зүгээр би нэг хэдхэн нэг ийм тайлбар хэлье гэж бодож байна. Хуулийн төслийг уншаад бид ийм ойлголтууд авч байгаа шүү.

Зээлийг ДНБ-д харьцуулах тусгай шаардлага энэ хязгаараас огт хасаж болохгүй.

Н.Учрал: Жавхлан сайдад нэмэлт минут өгье.

Б.Жавхлан: Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр байдаг тэр төсвийн тусгай шаардлагуудыг огт зөрчсөн зүйл байхгүй юм байна аа. Энэ бүртгэлийн асуудал байна. Тухайн жилийн зээлийн ашиглах хязгаараас бол энийг бүртгэлийн хувьд өөрөөр тооцъё оо. Тэрнээс биш Монгол Улсын Засгийн газрын зээлийн хязгаарын тусгай шаардлагыг огт хөдөлгөхгүй юм байна аа. Бид хуучин системээрээ яваад байгаа бүртгэлийн системээрээ 80 оны, 90 оны 2000 оны 2010 он хүртэл ингээд бүүр 90-ээд оныхоо системээр яваад байгаа. Одоо GFS 14 гээд олон улсын ОСТ-ийн улсууд шилжиж байгаа энэ систем рүүгээ. Сангийн яам, Засгийн газар бодлогоор төлөвлөгөөгөө гаргаад шилжээд эхэлсэн байгаа. Үүн дээр ялангуяа ОУВС-тай хамтарч тэндээс техникийн тусламж авч хамтарч ажиллана. Энэ бол нөгөө дор хаяж 4-өөс 5 жилийн ийм процесс болно. Ингээд эхлээд явж байгаа гэж ойлгож.

3 төслийн хувьд бол томоохон дүнтэй хамгийн гол нь өөрөө өөрийгөө дараа нь төлөөд явах.

Н.Учрал: Даваадалай дарга нэмж хариулна.

Н.Учрал: Гишүүний асуултад хариулъя.

НЗД-ын 1 дүгээр орлогч Даваадалай. 1 дүгээрт Улаанбаатар хот бол хувийн хэвшилтэй барьцалдаж бизнес хийгээгүй ээ. Энэ 157 га газар нийт 48 багц дээр бүхэл бүтэн хот босгож байгаа. Үүнээс ингээд дурдах юм бол энэ 1.8 их наядад бол ярьж байгаа орон сууцжуулалтын төсөл байгаа болохоос бид нар гадна тохижилтыг 4 багцад гадна инженерийн шугам сүлжээ, гадна дохио холбоо, дулаан, цахилгаан, ус хангамж, цахилгааны багцууд, дээрээс нь хөрсний ус зайлуулах, гүний дулаан гээд ингээд инженерингийн 12 багц ажлыг 157 га дээр бүхэл бүтэн хот босгох хэмжээний суурь дэд бүтцүүдийг хийж байгаа учраас ийм хэмжээний зардал гарч байгаа.

Дээрээс нь нийгмийн дэд бүтцүүд болох сургууль, цэцэрлэг, үйлчилгээний байгууллагуудын суурь, дэд бүтэц, нийтийн тохижилтыг нь хийж өгч байгаа. Ийм

учраас бол ийм хэмжээний зардал гараад ингээд явж байгаа гэж хэлэхээр байна аа. Тэгэхээр нийслэл хувийн хэвшилтэй.

Н.Учрал: Нэмэлт нэг минут.

Дээрээс нь хэлээд нийгмийн дэд бүтцүүд дээр хамгийн анхны 20 минутын концепц дээр нийгмийн дэд бүтэц, хүртээмжтэй ийм хот хийж байгаа учраас бусад энэ гадна тохижилт, дэд бүтцүүд дээр зардал гаргаж байгаа. Ийм учраас бас метр квадратын 1м²-ад ноогдох үнэ бол бас тодорхой хэмжээний хувийн хэвшлийг бодвол өндөр болсон.

Хувийн хэвшлүүд яг зах зээлийн зарчмаараа хийхээр бол нийгмийн дэд бүтцүүдийг бол ингэж хийж чаддаггүй. Тийм учраас бол өнөөдөр Улаанбаатар хотод энэ нийтийн эдэлбэр газар хүүхдийн ногоон байгууламж талбай эд нар маш дутмаг байдаг асуудал байдаг. Тийм учраас бид нар энэ иргэддээ ээлтэй, хүртээмжтэй 20 минутын хотыг байгуулах үүднээс 157 га дээр бүхэл бүтэн 48 багц ажлыг хийх гэж ийм төсөв мөнгийг тавьж байгаа юм аа. Баярлалаа.

Н.Учрал: Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууна.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе ээ. Алтаншагай гишүүнийг би Төсвийн байнгын хороон дээр барьж орж ирж байхад нь хэлсэн юм аа. Гишүүнийхээ хувиар улсдаа санаа зовоод Газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн дулааны станц, энэ нийслэлийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн асуудлууд дээр санаа зовоод байгаа гэж ойлгож байна аа. Гэтэл Монгол Улс яах гэж Хөгжлийн банк байгуулсан юм бэ? Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль гэдэг хуулиуд чинь бүүр эсрэгээрээ төсвийн тогтворгүй байдлын тухай хууль болтлоо өөрчлөгдөөд байна шүү дээ. Бид нар хуулиудынхаа бүүр царай төрхийг ч танихааргүй болтлоо өөрчилж байгаа юм. Тэгээд Засгийн газар, Сангийн яам, Сангийн сайд өөрөө бид нар ийм хуулиар ингэж явмаар байна гээд саналаа оруулаад ирвэл тэр дээр нь ярилцаж болно оо.

Тэгэхгүй манай Сангийн сайд бол өөрөө буруу яриад байгаа юм. Жишээлэхэд Төрийн банкны 51 хувийг Сангийн яам эзэмшиж, арилжааны 11 банктай өрсөлдөж яах гэж байгаа юм.

Тэтгэврийн хүү бууруулж чадахгүй, МИК-ын орон сууцын зээлийн хүү бууруулж чадахгүй. Тэгээд төр хувьцаа гаргаж байх үеийнх нь үнийн ханшаас одоо байгаа ханштай нь харьцуулахад 55 тэрбум төгрөгийн алдагдлыг тавиад туучихсан байгаа банкныг нэг ч хариуцлага тооцохгүйгээр авч үлдээд байгаа хариуцлагагүй байдал байгаад байна. Одоо энэ 3 төсөл дээр дараад нь яг ийм асуудал үүсвэл хэн хариуцлага хүлээх юм. Тусад нь тавьж өгөөд тусад нь мөнгийг нь өгөөд явуулчихлаа.

Хөгжлийн банкаар явуулах давуу тал нь ядахдаа хяналт хэрэгжүүлнэ. Ядахдаа ханшийн эрсдэлийг нь удирдана гээд яг мэргэжлийнхээ талаас харах юм бол банк нь ажлаа хийгээд энэ нийслэлд ч гэсэн миний бодлоор буруу тайлбар өгөөд байна Даваадалай дарга. Манай Бямбацогт сайдын компани жишээлэхэд тэр дэд бүтцийн чинь асуудлуудыг нийслэл тендер зарлахад хийчихнэ. Чойжилсүрэн сайдын компани барилгуудыг чинь барьчихна. Заавал нийслэл дахиж барилга барих гээд байх шаардлага хаана байгаа юм бэ? Тэгэхээр бид нар энэ Засгийн газар

байгаа бүтцүүдээ зөв ашиглаад хоорондын уялдаа холбоогоо сайжруулахгүй бол Зам, тээврийн сайд нь Улаанбаатар хотоос түгжрээд байна гээд төмөр замаа гаргаад Богд уулынхаа урд талаар холбохоор үгүй энэ түгжрэлийг чинь бид нар шийдэхгүй л болохгүй гээд Туул гол дээгүүрээ 2.7 их наяд төгрөгөөр зам барих гэж байна шүү дээ. Зам, тээврийн яам одоо энэ нийслэлтэй уялдаж ажиллаж байгаа чинь энэ юм уу? Ийм аймаар хариуцлагагүй байдлуудаа засаад хариуцлагатайхан шиг нэг Засгийн газар 1 бодлогоор явж болдоггүй юм уу?

Алтаншагай гишүүн Хөгжлийн банкны ажлыг нь хийлгэ. Энэ хуулиа та бүүр буцаагаад татчихвал сайн. Танай нам дотор энийг ойлгож байгаа гишүүд байна. Ариунзаяа гишүүнд жишээлэхэд баярлалаа. Хөгжлийн банк чинь банк чигээрээ ажиллахгүй юм бол баахан шахааны зээл олгосоор байгаад болсон болоогүй худлаа хүмүүст ял өгч явуулсаар байгаад одоо тэгээд банк ч үгүй болох гэж байгаа шүү дээ. Банкныхаа хийх ажлыг хийлгэ. Хувийн хэвшлийнхээ хийх ажлыг хийлгэ. Тэгээд бид нар дэмжихгүй биш энэ газрын тос боловсруулах үйлдвэрийг бүгдээрээ дэмжинэ ойлгомжтой. Нийслэлийн энэ утааны асуудал түгжрэлийн асуудлыг бүгдээрээ шийдэхийг хичээж байна ойлгомжтой. Баруун бүсийн цахилгааны асуудлыг шийдэхийг бүгдээрээ хичээж байна ойлгомжтой.

Хийх хийх ажлаа хариуцлагатайхан шиг хяналттайхан шиг хийхгүй бол бүүр дур дураараа нэг асуудал дээр нэг хууль байж болохгүй байхгүй юу. Тэгэхээр би энэ дээр эсрэг байр суурьтай байна.

Н.Учрал: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн эсрэг байр суурьтай бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу үг хэлнэ. Дэмжсэн дэмжээгүй байр сууриа хэлнэ ээ.

Дэгийн хууль дээр чинь нэг ийм л дэгийн хуультай юм байна. Дэгдээ л захирагдана даа.

Тэгэхээр ийм Дэгийн хууль дээр ажилламаар байна. Тэмүүжин гишүүнийгээ ажиллуулъя.

Завсарлагаанаар Тэмүүжин гишүүнээрээ энэ Дэгийн хуулийг янзлуулна. Энэ ер нь бол Сайнзориг гишүүн энэ хуульч гишүүдээрээ Дэгийн хуулийг нэг цэгцэлж авахгүй бол болохгүй байна аа. Энх-Амгалан гишүүн байна уу? Байхгүй. Номтойбаяр гишүүн байхгүй, Соронзонболд гишүүн байхгүй. Жаргалсайхан гишүүн байна уу? Жаргалсайхан гишүүн индэрт. Жаргалсайхан гишүүн индэрт биз дээ?

Жаргалсайхан гишүүн 2 дугаар микрофон.

Д.Жаргалсайхан: Өнөөдөр Монгол Улсад томоохон төслүүд хэрэгжиж байж энэ аж үйлдвэр, ажлын байр эдийн засагт нөлөө учруулна аа. Гэтэл бидний хувьд ингээд нэг төсөв дээрээ том төслүүдээ оруулж чаддаггүй. Яагаад гэхээр нөгөө том төслүүд маань бол асар том мөнгөн дүнгүүдийг дагуулж явдаг учраас бол улсын төсөв ингээд хязгаарт орчхоод байгаа юм.

Тийм учраас өнөөдрийн энэ орж ирж байгаа ингээд том төслүүд бол Монгол Улсын хувьд тулгамдчихсан, нэн шаардлагатай ийм төслүүд байгаа юм. Тэр ч үүднээсээ Улаанбаатар хотоос өнөөдөр ингээд төслүүд дээрээс нь ингээд Сэлбэ

тойрог зам, төмөр зам төсөл, метро төсөл гээд ингээд л ар араасаа хүлээгдэж байгаа юм. Тэгээд дээрээс нь эрчим хүчний төслүүд.

Тэгэхээр энэн дээр бидний хувьд бол улс орноо л томоор нь харах хэрэгтэй. Тэр ч үүднээсээ өнөөдөр ингээд гаднын зээл тусламж янз янзын төслүүд маань л ар ар араасаа ингээд дараагийнхаа төслийг хүлээгээд байж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ төслийг дэмжиж байгаа. Тийм учраас өнөөдөр энэ чуулганд байгаа гишүүдийг маань бас энийг дэмжиж санал өгөөч ээ. Бидний өнөөдрийн энэ хүндрэл бэрхшээл энэ ЖДҮ-лэл яахын аргагүй энэ том төслүүдээ хөдөлгөж байж л энэ ажлын байр, энэ үйлдвэрлэлүүд чинь ар араасаа дагаад сэргэдэг юм аа. Тийм учраас бол бидний хувьд бол цааш цаашдаа энэ 3 төсөл гэхгүйгээр яг энэ том төслүүдийг бол тоог нь нэмж оруулж ирмээр байгаа юм. Ийм зүйлийг хэлэх гэсэн юм. Тийм учраас та бүхнийг дэмжихийг хүсэж байна аа. Баярлалаа.

Н.Учрал: Энэ чинь бүлгээс нэр өгч байгаа шүү дээ? Би байхгүй болгоогүй шүү дээ. Бүлгээс нэр ирсэн биз дээ? Яасан юм айн? Даваадалай дарга. Түрүүн хариулсан тиймээ?

Өнөөдөр нөгөө Зөвшөөрлийн хууль хэлэлцсэн. Зөвшөөрлийн хууль хэлэлцсэнтэй холбогдуулаад зэрэгцээд нөгөө энэ шинэ оны босгон дээр. Аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа зарим нөгөө ТҮЦ-тэй холбоотой асуудлуудаар хүмүүс ингээд гомдол гаргаад тэр ямар арга хэмжээ явагдаж байгаа талаараа нэг мэдээлэл өгвөл их сайн байна. Мэдээж энэ чинь 2 талтай асуудал байх. Зарим нь шүүхэд хандчихсан л байдаг л гэнэ. Шүүхийн шийдвэртэй л гэнэ. Зарим нь шүүхийн шийдвэргүй л гэнэ. Тэгэхээр гол нь энэ шинэ оны босгон дээр энэ явуулж байгаа арга хэмжээнүүдээ бас нэг тодорхой зөв мэдээлэл өгөхгүй бол тэгээд энэ нэг янз бүрийн ийм мэдээллүүд яваад байна.

Даваадалай дарга та нэг хэлээдхээч. Ямар ямар үйл ажиллагаа энэ явагдаад байгаа юм бэ? Бид нар чинь бүрэн мэдээлэл байхгүй шүү дээ. Зарим нь болохоор ингээд шүүхийн шийдвэртэй. Тэгээд энэ эрхэд халдаад байна гээд л ингээд л яриад байна шүү дээ. Энэ чинь шинэ оны босгон дээр энэ чинь ахуй амьдралаа авч явж байгаа өрх толгойлсон олон эмэгтэйчүүд байна гэдэг ингээд гомдол гаргаад байна. Та нар заавал 29, 30-ыг угтаад ингээд энэ нэг хэдэн эмэгтэйчүүдийг ингээд байх шаардлага байдаг юм уу? Энийгээ ялгаж салгаж тайлбарлахгүй бол болохооргүй байна.

Гишүүд танхимд орж ирмээр байна. Гишүүдийг танхимд урья. Даваадалай 4 дүгээр микрофон.

Т.Даваадалай: Их Хурлын дарга Учрал даргын асуусан асуултад хариулъя. НЗД-ын 1 дүгээр орлогч Даваадалай. ТҮЦ эрхлэгчдийн холбооноос дахиж ойрын хугацаанд бас нэг 30-аад байрлалууд дээр ТҮЦ-үүдийг байршуулсан асуудлууд гарсан. Өнөөдөр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас бол эдгээр байрлалууд дээр чөлөөлөх арга хэмжээнүүдийг авч байгаа. Зөвшөөрөлгүй газар байршуулсан дээр бол зарим иргэдээс шүүх дээр гомдол гаргаад маргаантай явж байгаа асуудлууд байгаа. Гэхдээ Улаанбаатар хотын зүгээс бол ТҮЦ эрхлэгчдийн 3 холбоотой уулзаж 3 төрлийн саналыг албан байдлаар тавьсан. Өмнө нь болохоор 1 дүгээрт болохоор ижил төрлийн худалдаа үйлчилгээний байгууллагууд дээр бол зуучилж 6 сарын хугацаанд НЗДТГ-аас дэмжиж хөнгөлөлттэй үнээр бизнес эрхлэх боломжийг нь олгоё оо.

Хоёрдугаарт ТҮЦ гэсэн нэртэй болж өгвөл СУ шиг ийм фаранчайз маягийн орчин үеийн тохилог 0 бүхий хүнсний аюулгүй байдлын стандартыг хангасан Улаанбаатар хотын энэ хүнсний болон худалдааны стандартуудыг хангасан байдлаар худалдаа үйлчилгээ эрхлэхэд нь жижиг, дунд бизнес эрхлэгчдийн газраар дамжуулан хамтран ажиллая гэдэг ийм саналуудыг тавьсан.

Харамсалтай нь бол ТҮЦ эрхлэгчдийн холбоо бас зарим нь хүлээж аваад, зарим нь хүлээж аваагүй ийм маргаантай явж байгаа асуудлууд байж байгаа.

Н.Учрал: Тэгээд хотын удирдлагууд иргэдийн хурал ч тэр ойлголцож, зөвшилцөх талдаа байх хэрэгтэй шүү. Том бизнесийнхнийг болохоор ширээний ард суугаад хэлэлцээр хийе гэдэг жижгүүдийг нь болохоор ингээд дээрэлхээд байж болохгүй шүү дээ. Тэгэхээр зүгээр энэ бол том, жижиг гэлтгүй бизнес эрхлэгч нартай хүндэтгэлтэй харилцаад аль аль талдаа ойлголцох зөвшилцөх тэгээд боломжуудыг нь тайлбарлах тэгээд ингээд 2 талдаа асуудлаа шийдээд явах хэрэгтэй. Тэгээд аливаа зүйлийг хүчээр хийгээд үр дүнд хүрэхгүй.

Тийм учраас өнөөдөр бид нар энэ төрийн хүнд суртлыг бууруулах зөвшөөрлийн хууль хэлэлцэж байна шүү дээ. Тэгэхээр энэ хүмүүс чинь Их Хурлын гишүүддээ хандахаас өөр зам байхгүй. Тэгээд та нар ингээд 12 сарын 31 болох гэж байхад ингээд хуулийн байгууллага баахан цагдаа нар аваачаад ингээд жижиг бизнесийнхэнтэйгээ ойлголцох биш шууд ингээд хүч хэрэглээд асуудлыг шийдчихвэл болохгүй шүү. Тийм учраас наад асуудлаа л мэдээж кэйс болгон нь өөр. Зарим нь шүүхийн шийдвэртэй байгаа, зарим нь шүүхийн шийдвэргүй байгаа. Тэгээд Их Хурлын гишүүд бол тойрог төлөөлж байгаа, ард түмнээ төлөөлж байгаа. Тийм учраас энэ гишүүдэд тойргийнх нь иргэд сонгогчид бүгдээрээ л захиа занаа бичиж байгаа. Асуудлаа илэрхийлж байгаа шүү дээ. Тийм биз дээ Ганхуяг гишүүн ээ? Танай БГД дээр тэнд хороололд юу болж байна. Тэгээд би ч энд СБД-ээс сонгогдсон хүн. Энэ дотор бүгдээрээ л нийслэлээс сонгогдсон гишүүд байгаа. Тэгэхээр бүгдээрээ жижиг том гэлтгүй энэ бизнес эрхлэгч нарт хүндэтгэлтэй хандъя гэж яриа биз дээ.

Тийм учраас наадхаа нийслэлийн иргэдийн хуралд, нийслэлийн удирдлагууд тухайлан авч үзээд уулзалтуудаа хийгээд, илүү зөвшилцөх, ойлголцох талдаа. Тэрнээс ингээд хүч түрээд шийдэж чадахгүй. Нийгэм чинь ард түмэн бухимдалтай байна шүү дээ.

Тийм учраас та бүхэн наад асуудлаа дахиж очиж тайлбарла. Зөвшилц ойлголц. Тэрнээс ингэж хүч хэрэглээд юу ч шийдэхгүй ямар ч арга зам байхгүй. Энэ чинь хүний эрхийн зөрчил шүү дээ. Яах вэ тэнд хууль зөрчсөн юм хум байвал тэгээд тэрүүгээр явдаг юм байгаа биз. Наадах чинь шүүхийн шийдвэртэй асуудлууд хүртэл байна л гээд байна шүү дээ. Тийм учраас энэнээс бид нар хол тойрч чадахгүй шүү гэдгийг хэлье.

Их Хурлын гишүүдийг танхимд урья. Одоо хуулийн төслийн талаар Байнгын хорооны саналаар дэмжсэн дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлж дууслаа.

Дэгийн хуулийн 44.3-д тэгж заасан. Санал хураалтыг нэгтгэж хийж болно. Тэгэхээр хуулийнхаа дагуу л явж байна. Дэгээ л баримталъя. Тэгээд энэ дэгийн хууль дээр АН-ын бүлгээс, Ардын намын бүлгээс гишүүдийг оруулаад дэг дээр

хамтарч ажиллая. Түрүүн би хэлсэн тэр Дэд хорооны бүрэлдэхүүн, зарим Байнгын хороодын бүрэлдэхүүн дээрээс солимоор байгаа гэсэн хүсэлтүүдээ илгээсэн гишүүд маш олон байна шүү дээ. 5 нам, эвслээс төлөөллийг оруулна. Гол нь оролцох ёстой, ажиллах ёстой.

Санал хураалт.

Нэг бүртгэлийн санал хураалт нэг явуулж үзье. Бүртгэлийн санал хураалт явуулагдахъя. Бүртгэлийн санал хураалт. Гишүүд танхимдаа цуглая. Санал хураалт явуулна аа. Зөвшөөрлөөр эхэлчихье.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудал санал хураалтаар үргэлжлэв.

Зөвшөөрлийн хуулиар санал хураалт явуулж эхэлнэ.

Санал хураалт явуулна гишүүд анхааралтай. Санал хураалтыг явуулна аа. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцье дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураана.

Санал хураалт.

55 гишүүн дэмжиж 61.1 хувиар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн хуулиудыг дээр санал хураалт явуулна.

2.Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлц сэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураана.

Санал хураалт.

56 гишүүн дэмжиж, 62.2 хувиар санал дэмжигдлээ.

3.Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалт.

56 гишүүн дэмжиж 62.2 хувиар санал дэмжигдлээ

4.Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

Санал хураалт.

55 гишүүн дэмжиж 61.1 хувиар санал дэмжигдлээ.

5.Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

55 гишүүн дэмжиж 61.1 хувиар санал дэмжигдлээ.

6.Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

56 гишүүн дэмжиж, 62.2 хувиар санал дэмжигдлээ.

7.Аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

56 гишүүн дэмжиж, 62.2 хувиар санал дэмжигдлээ.

Ажлын хэсгийнхэнд баярлалаа. Нийт төрийн албан хаагч нартаа талархал дэвшүүлье ээ. Ажлын амжилт хүсье. Баярлалаа.

8.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

58 гишүүн дэмжиж, 64.4 хувиар санал дэмжигдлээ.

8.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

55 гишүүн дэмжиж 61.1 хувиар санал дэмжигдлээ.

9.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

55 гишүүн дэмжиж, 61.1 хувиар санал дэмжигдлээ.

10.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

56 гишүүн дэмжиж 62.2 хувиар санал дэмжигдлээ.

11.Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

56 гишүүн дэмжиж 62.2 хувиар санал дэмжигдлээ.

12.Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

55 гишүүн дэмжиж, 61.1 хувиар санал дэмжигдлээ.

13.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

59 гишүүн дэмжиж 65.6 хувиар санал дэмжигдлээ.

14.Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

56 гишүүн дэмжиж, 62.2 хувиар санал дэмжигдлээ.

15.Боловсролын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

16.Байнгын хороон дээр уначихсан юм байна шүү. Тэгээд дарахгүй байж байж босгоно.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

17.Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

55 гишүүн дэмжиж, 61.1 хувиар санал дэмжигдлээ.

18.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

56 гишүүн дэмжиж, 62.2 хувиар санал дэмжигдлээ.

19.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

53 гишүүн дэмжиж, 58.9 хувиар санал дэмжигдлээ.

20.Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

56 гишүүн дэмжиж, 62.2 хувиар санал дэмжигдлээ.

21.Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

55 гишүүн дэмжиж, 61.1 хувиар санал дэмжигдлээ.

22.Газрын хэвлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

56 гишүүн дэмжиж, 62.2 хувиар санал дэмжигдлээ.

23.Галт зэвсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

55 гишүүн дэмжиж, 61.1 хувиар санал дэмжигдлээ.

24.Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцье дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

59 гишүүн дэмжиж, 65.6 хувиар санал дэмжигдлээ.

25.Генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

57 гишүүн дэмжиж, 63.3 хувиар санал дэмжигдлээ.

26.Геодези зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

58 гишүүн дэмжиж 64.4 хувиар санал дэмжигдлээ.

27.Гэрийн тэжээвэр амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

55 гишүүн дэмжиж, 61.1 хувиар санал дэмжигдлээ.

28.Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

57 гишүүн дэмжиж, 63.3 хувиар санал дэмжигдлээ.

29.Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

58 гишүүн дэмжиж, 64.4 хувиар санал дэмжигдлээ.

30.Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

60 гишүүн дэмжиж, 66.7 хувиар санал дэмжигдлээ.

31.ЗХАБТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

58 гишүүн дэмжиж, 64.4 хувиар санал дэмжигдлээ.

32.Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

57 гишүүн дэмжиж, 63.3 хувиар санал дэмжигдлээ.

33.Засгийн газрын тусгай сангийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

57 гишүүн дэмжиж, 63.3 хувиар санал дэмжигдлээ.

34.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

56 гишүүн дэмжиж, 62.2 хувиар санал дэмжигдлээ.

35.Зээлийн мэдээллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт,

59 гишүүн дэмжиж, 65.6 хувиар санал дэмжигдлээ.

36.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

59 гишүүн дэмжиж, 65.6 хувиар санал дэмжигдлээ.

37.Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

56 гишүүн дэмжиж, 62.2 хувиар санал дэмжигдлээ.

38.Мал амьтны тэжээлийн нэмэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцье дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

60 гишүүн дэмжиж, 66.7 хувиар санал дэмжигдлээ.

39.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

59 гишүүн дэмжиж, 65.6 хувиар санал дэмжигдлээ.

40.Монгол. Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

60 гишүүн дэмжиж 66.7 хувиар санал дэмжигдлээ.

41.Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

42.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

59 гишүүн дэмжиж, 65.6 хувиар санал дэмжигдлээ.

43.Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

58.Гишүүн дэмжиж, 64.4 хувиар санал дэмжигдлээ.

44.Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

59 гишүүн дэмжиж 65.6 хувиар санал дэмжигдлээ.

45.Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

59 гишүүн дэмжиж, 65.6 хувиар санал дэмжигдлээ.

46.Оюуны өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

47.Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

58 гишүүн дэмжиж, 64.4 хувиар санал дэмжигдлээ.

48.Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

58 гишүүн дэмжиж, 64.4 хувиар санал дэмжигдлээ.

Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

54 гишүүн дэмжиж, 60 хувиар санал дэмжигдлээ.

50.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

56 гишүүн дэмжиж, 62.2 хувиар санал дэмжигдлээ.

51.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих архидан согтууруулахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

57 гишүүн дэмжиж, 63.3 хувиар санал дэмжигдлээ.

52.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

58 гишүүн дэмжиж, 64.4 хувиар санал дэмжигдлээ.

53.Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

48 гишүүн дэмжиж 53.3 хувиар санал дэмжигдлээ.

54.Таримал ургамлын үр сортын тухай хуульд. нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

55 гишүүн дэмжиж, 61.1 хувиар санал дэмжигдлээ.

55.Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

57 гишүүн дэмжиж, 63.3 хувиар санал дэмжигдлээ.

56.Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

58 гишүүн дэмжиж, 64.4 хувиар санал дэмжигдлээ.

57.Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

58 гишүүн дэмжиж, 64.4 хувиар санал дэмжигдлээ.

58.Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцье дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

59 гишүүн дэмжиж, 65.6 хувиар санал дэмжигдлээ.

59.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

60 гишүүн дэмжиж, 66.7 хувиар санал дэмжигдлээ.

60.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцье дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

55 гишүүн дэмжиж, 61.1 хувиар санал дэмжигдлээ.

61.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

57 гишүүн дэмжиж, 63.3 хувиар санал дэмжигдлээ.

62.Усан замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

58 гишүүн дэмжиж, 64.4 хувиар санал дэмжигдлээ.

63. Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

58 гишүүн дэмжиж, 64.4 хувиар санал дэмжигдлээ.

64 ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

60 гишүүн дэмжиж, 66.7 хувиар санал дэмжигдлээ.

65.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

59 гишүүн дэмжиж, 65.6 хувиар санал дэмжигдлээ.

66.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

58 гишүүн дэмжиж, 64.4 хувиар санал дэмжигдлээ.

67.Үйлдвэр технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

57 гишүүн дэмжиж, 63.3 хувиар санал дэмжигдлээ.

68.Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

58 гишүүн дэмжиж, 64.4 хувиар санал дэмжигдлээ.

69.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

58 гишүүн дэмжиж, 64.4 хувиар санал дэмжигдлээ.

70.Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

60.Гишүүн дэмжиж, 66.7 хувиар санал дэмжигдлээ.

71.Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

60 гишүүн дэмжиж, 66.7 хувиар санал дэмжигдлээ.

72.Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

58 гишүүн дэмжиж, 64.4 хувиар санал дэмжигдлээ.

73.Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

59 гишүүн дэмжиж, 65.6 хувиар санал дэмжигдлээ.

74.Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

61 гишүүн дэмжиж, 67.8 хувиар санал дэмжигдлээ.

75.Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

61 гишүүн дэмжиж, 67.8 хувиар санал дэмжигдлээ.

76.Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт

60 гишүүн дэмжиж, 66.7 хувиар санал дэмжигдлээ.

77.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

58 гишүүн дэмжиж, 64.4 хувиар санал дэмжигдлээ.

78.Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

59 гишүүн дэмжиж, 65.6 хувиар санал дэмжигдлээ.

79 хувийн хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

56 гишүүн дэмжиж, 62.2 хувиар санал дэмжигдлээ.

80.Хувиргасан амьд организмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

53 гишүүн дэмжиж, 58.9 хувиар санал дэмжигдлээ.

81.Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

57 гишүүн дэмжиж.

63.3 хувиар санал дэмжигдлээ.

82. Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

59 гишүүн дэмжиж, 65.6 хувиар санал дэмжигдлээ.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлал хийх хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалт.

58 гишүүн дэмжиж, 64.4 хувиар санал дэмжигдлээ.

Чөлөөт бүс чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

57 гишүүн дэмжиж, 63.3 хувиар санал дэмжигдлээ.

85.Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

60 гишүүн дэмжиж, 66.7 хувиар санал дэмжигдлээ.

Шүүх шинжилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

54 гишүүн дэмжиж, 60 хувиар санал дэмжигдлээ.

87.Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

56 гишүүн дэмжиж, 62.2 хувиар санал дэмжигдлээ.

Эм, эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураая.

Санал хураалт.

57 гишүүн дэмжиж, 63.3 хувиар санал дэмжигдлээ.

89.Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

58 гишүүн дэмжиж, 64.4 хувиар санал дэмжигдлээ. 90-ийг уншсан уу.

90.Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхээр дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

57 гишүүн дэмжиж, 63.3 хувиар санал дэмжигдлээ.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн болон ХЗБХ-нд шилжүүллээ.

Хууль зүйн байнгын хороонд давхар шилжүүллээ шүү.

Гишүүд ээ, суугаарай.

18.00 цаг

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нарын 21 гишүүн 2025.12.12-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Гадаад зээлийн ашиглалт үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслөөр гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан.

Дэмжсэн, дэмжээгүй, байр сууриа илэрхийлсэн гишүүд санал хураалтад бэлтгэе.

Одоо Байнгын хорооны саналаар Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалтыг явуулна.

Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураана.

Санал хураалт.

52 гишүүн дэмжиж, 57.8 хувиар санал дэмжигдлээ.

Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

18.01 цаг

Дараагийн асуудалд оръё.

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 40 гишүүн 2025.10.10-ны өдөр өргөн мэдүүлсэн/

Хянан шалгах түр хороо байгуулах тухай Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ ээ.

Хянан шалгах түр хороо байгуулах тухай тогтоолтой холбогдуулаад асуулт асууж, үг хэлж дууссан. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж Улсын Их Хурал дахь МАН-ын бүлэг 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр ажлын 5 өдрийн завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан байна аа. Ардын намын бүлгийн дарга Жигжидийн Батжаргал үг хэлнэ.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ оройн амар амгаланг айлтгая.

Уг асуудлаар МАН-ын бүлэг ажлын 5 хоногийн завсарлага авсан юм. Тодорхой мэдээлэл, тооцоолол, янз бүрийн юмнуудыг бид нар судалж үзээд хараахан байр суурь бүрэн нэгтгэгдэж чадаагүй байна.

Тийм учраас Дэгийн тухай хуулийн дагуу ажлын 3 хоногийн завсарлага авах санал оруулж байна аа.

Энэ асуудлыг дэмжиж шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Н.Учрал: Энэ түр хороо байгуулах асуудал дээр гишүүд гарын үсгээ зурсан байгаа. Батжаргал дарга ч гэсэн зурсан. Гэхдээ энэ бол 2 улсын Засгийн газар

хоорондын хэлэлцээр байгаа учраас энэ Түр хорооны сонсголын хүрээ, Түр хорооны ажиллах хүрээг бол дахиж ярилцах, мөн дээрээс нь Зам, тээврийн сайдын зүгээс Хятад талтай энэ гэрээ хэлцэл байгуулсан талуудтайгаа харилцан ойлголцох энэ сонсголын хүрээн дээр ярилцахгүй бол аль аль талдаа буруу зөрүү ойлголт өгөөд байна гэдэг ийм тайлбар хэлээд байгаа юм.

Тэрнээс биш Их Хурлын гишүүд манай намын бүлгээс ч гэсэн зурчихсан байгаа. Тэгэхээр үүн дээр бол яг тэр Түр хорооны ажиллах хүрээн дээрээ бас ярилцах шаардлага байна гэж ингэж үзэж байгаа.

Дээрээс нь Баярмаа гишүүн, Ганбат гишүүн нар ч гэсэн энэ манай энэ бүлгийнхэнтэй яриад энэ ажиллах хүрээгээ тодорхой болгох хэрэгтэй. Тэрнээс эсэргүүцээд байгаа зүйл огт байхгүй гэдгийг хэлье.

Ажлын 3 өдрийн завсарлага өглөө.

18.04 цаг

Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, гүйлгээ, сангийн орлого, зарлагын 2025 оны гүйцэтгэл төсвийн тухай Их хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Энэ асуудлыг хэлэлцэж дуустал чуулганы өнөөдрийн хуралдааныг сунгалаа.

Эрдэнэсийн сангийн 2025 оны орлого зарлагын тайланг Монголбанкны Ерөнхийлөгч танилцуулах ёстой. Энэ асуудлаар Ажлын хэсэг байна уу?

Эцсийн найруулгууд уншаадахъя.

Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулга сонсох

Энэ хуулийн цаг хугацаатай асуудал биш байна. Тэгэхээр эцсийн найруулга юутай ч уншаадахъя. Монгол банкныхан бэлэн юм уу? Энэ хугацаанд гишүүд байрлалаа эзэлнэ шүү.

Энэ дээр санал хураалттай баталсан хууль тогтоолын эцсийн найруулгыг сонсгож байя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46.1.3-д Улсын Их хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль тогтоолын эцсийн найруулгатай танилцаж ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу хууль тогтоолын эцсийн найруулгыг Байнгын хороод бэлтгэж Улсын Их Хуралд танилцуулахад бэлэн болсон байна.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр Соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хууль, тогтоолын төслүүдийн эцсийн найруулгыг сонсголоо.

***“Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, гүйлгээ сангийн орлого, зарлагын 2025 оны гүйцэтгэл, 2026 оны төсвийн тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

Ингээд дараагийн асуудалдаа орёё.

Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, гүйлгээ сангийн орлого, зарлагын 2025 оны гүйцэтгэл, 2026 оны төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Эрдэнэсийн сангийн 2025 оны орлого, зарлагын тайланг Монголбанкны ерөнхийлөгч Санжаагийн Наранцогт танилцуулна.

Индэрт урья.

Байнгын хороогоор орсон материал аль хэдийн тараагдсан байгаа.

С.Наранцогт: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2, 3 дугаар заалтын дагуу Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого зарлагын 2026 оны төсвийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр өргөн барьж байна. Улсын Их Хурлын 2025 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 12 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2025 оны төсвийн гүйцэтгэлийг мөн танилцуулж байна аа.

Үүнд:

1.2025 оны эрдэнэсийн сан хөмрөгийг нэмэгдүүлэхээр 2 тэрбум төгрөгийг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, байгалийн ... заалт худалдан авах, урлагийн бүтээл захиалан хийлгэх, археологи түүхийн судалгааны байгууллагатай хамтран ажиллахад зарцуулахаар төсөвлөсөн болно оо.

Эрдэнэсийн санд 2025 оны иргэдээс ирүүлсэн хүсэлтээс Жанрайсэг бурхныг 100 сая төгрөгөөр худалдан авч Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн байнгын бус орлогоор бүртгэсэн байна.

2.Монголбанкны дурсгалын зоос, дээж болон франчат зоосыг гүйцэтгэлээр орлогод авахаар төлөвлөснөөс 162 ширхэг зоосыг үндсэн сангийн байнгын бус хэсэгт орлогоор бүртгэсэн байна.

3.1945 оны зоосон мөнгөн тэмдэгт 2 мянган ширхэг, Монголбанкны хүндэт банкер тэмдгийг Үндсэн сангийн байнгын бус орлогын хэсэгт орлогоор бүртгэсэн.

4.Монголбанкны санаачилгаар болон франчайзаар үйлдвэрлэсэн дурсгалын зоос, үрлэн мөнгө, гулдмай 5701 ширхгийг эрдэнэсийн сангийн гүйлгээ санд орлогоор бүртгэн авсан байна.

5.Гүйлгээ сангаас 24500 ширхэг дурсгалын зоос болон алт, мөнгөн гулдмай, үрлэн мөнгө зарлагдахаар тусгагдсанаас 184 ширхэг дурсгалын зоосыг зочин төлөөлөгчийн зардлаар зарцуулж, 4561 дурсгалын зоос, алт, мөнгөн гулдмай, үрлэн мөнгийг 11.9 тэрбум төгрөгөөр худалдсан байна аа.

6.Чингис хаан баримлын үзэсгэлэнгийн нээлт болон эрдэнэсийн сан хөмрөг дэх эд зүйлсийг сэлбэн тордох болон бусад ажлын зардалд 2025 онд нийт 200 сая төгрөгийг төсөвлөснөөс 46.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Эрдэнэсийн сан хөмрөгт нийт 1.1 их наяд төгрөгийн үнэ бүхий. 2706275 ширхэг эд зүйлс хадгалагдаж байгаа бөгөөд төр заалт 32 ширхэг, Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт зүйлийн ангилалд хамаарах 30 дэсийн 130 ширхэг эд зүйлс байна аа.

2026 оны эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого зарлагын төсвийн төслийг танилцуулъя.

Монголбанкнаас эрдэнэсийн сан хөмрөгийг 2026 онд дараах байдлаар нэмэгдүүлж үндсэн санд орлогоор бүртгэхээр төлөвлөсөн байна.

Үүнд:

1.Эрдэнэсийн сан хөмрөгийг нэмэгдүүлэхээр түүх, соёлын хөдлөх, дурсгалт зүйл, урлагийн бүтээл, сэргээн засварлалт, байгалийн түр заалт худалдан авах, археологи, түүхийн судалгааны байгууллагатай хамтран ажиллахад 2 тэрбум төгрөгийг зарцуулахаар, франчайз болон дурсгалын дээжийг орлогоор бүртгэхээр.

3.Гүйлгээ сангаас 24500 ширхэг дурсгалын зоос болон гулдмай үрлэн мөнгө зарлагдаж худалдах зориулалтаар 24300 ширхэг зочин төлөөлөгчийн зардлаар 200 ширхэг дурсгалын зоос зарцуулахаар төлөвлөсөн байна.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого зарлагын 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, 2026 оны төсвийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга танилцуулна аа. Индэрт урья.

Б.Уянга: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэг, 68 дугаар зүйлийн 68.3 дахь хэсэг, Хууль тогтоомжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасныг болон Монголбанкнаас ирүүлсэн саналыг тус тус үндэслэн Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, гүйлгээ, сангийн орлого, зарлагын 2025 оны гүйцэтгэл, 2026 оны төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хороо боловсруулж уг тогтоолын төслийг 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед хуралдаанд оролцсон гишүүдийн зүгээс асуулт асууж санал хэлээгүй болно.

Монголбанкнаас ирүүлсэн саналыг үндэслэн Байнгын хорооноос Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, гүйлгээ, сангийн орлого, зарлагын 2025 оны гүйцэтгэл, 2026 оны төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, гүйлгээ, сангийн орлого, зарлагын 2025 оны гүйцэтгэл 2026 оны төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: Уянга гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя. Санжаагийн Наранцогт Монгол банкны Ерөнхийлөгч, Атарбаатарын Энхжин Монголбанкны Санхүүгийн зах зээлийн газрын захирал, Түмэнжаргалын Тэлмэн Монголбанкны Санхүүгийн зах зээлийн газрын Эрдэнэсийн сангийн ахлах эдийн засагч. Ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Эрдэнэсийн сангийн орлого, зарлагын тайлан шийдвэрийн төсөлтэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

Хосбаяр гишүүнээр тасаллаа.

Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууна.

А.Ариунзаяа: Наранцогт даргаас асуулт асууя. Томилогдоод 7 хоног болж байгаа ажилтайгаа танилцсан байлгүй. Таныг очсон чинь үнэхээрийн шинэ мөнгөн тэмдэгт хэвлээд өрөө нь цоожилсон байна уу үгүй юу гэдэг дээр нэг хариу өгөөч.

Монголбанкны өр бас хэд байна вэ гэдэг тал дээр бүтэц нь ямар байна вэ гэдгийг нэг сонсох гэсэн юм. Баярлалаа. Наранцогт Ерөнхийлөгч 4 дүгээр микрофон.

С.Наранцогт: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя.

Мөнгөн тэмдэгтийн хувьд бол дурсгалын зориулалтаар худалдахаар 100 мянгатын дэвсгэрт хэвлэгдсэн. Тэрийгээ дурсгалын зориулалтаар худалдаж борлуулж байгаа юм билээ. Тэрнээс өөр том тэмдэгт хэвлэгдээгүй байсан. Би өөрөө яг Мөнгөн тэмдэгтийн газрын үйл ажиллагаатай танилцаж агуулахад байгаа мөнгөн дэвсгэрүүдтэй өөрийн биеэр танилцсан. Бүтцийн хувьд бол 683 хүнтэй ийм бүтэц байгаа. Одоо бид нар бүтэц, зохион байгуулалтын чиг үүргийн давхардлыг арилгах, оновчтой ухаалаг, цомхон технологжсон ийм Төв банк болох зорилтынхоо хүрээнд энэ дээрээ бид нар ажлын хэсэг гаргаад ажиллаж байгаа.

Н.Учрал: Ариунзаяа гишүүн тодруулна.

А.Ариунзаяа: 100 мянгатын дэвсгэрт хэвлэгдсэн байсан нь үнэн юм байна. Гэхдээ дурсгалынх байсан юм байна гэдгийг та хэллээ тиймээ? Тэгээд нийт хэдэн ширхэг вэ? Хаанаас яаж худалдаж авч болох вэ? Олон нийтэд нээлттэй юм уу үгүй юм уу, нийт хэдэн ширхэг байна вэ гэдгийг хэлээд өгөөч.

Н.Учрал: Наранцогт дарга.

С.Наранцогт: Тоо ширхгийн хувьд бол нөгөө нууцад авсан мэдээж болдоггүй юм байна. Тэр өр нь эрдэнэсийн санд энэ франчайз болон Монголбанкны захиалгаар хийгдсэн зоос худалдах үнэт эдлэл ийм жижиглэсэн гулдмай алтууд ч хүртэл байдаг юм байна. Тэгээд энийг бол өр нь веб сайт дээр тавьсан байгаа. Тэгээд одоо бол би ямар үүрэг өгсөн гэхээр энэ эрдэнэсийн сангаас худалдагддаг зоос, энэ дурсгалын зүйл, мөнгөн дэвсгэртийг бүгдийг нь онлайнаар шууд худалдан авч хүргэх боломжийг ойрын хугацаанд хангаж ингэж ажиллах үүрэг өгөөд манай Монголбанкныхан энэ дээр ажиллаж байгаа.

Тэгээд иргэдэд бол Монголбанкны веб сайтаар шууд энэ эрдэнэсийн санд худалдагдах боломжтой зоос, үнэт эдлэл энэ мөнгөн дэвсгэртүүдийг худалдан авах ийм боломжтой болж байгаа.

Н.Учрал: Ариунзаяа гишүүн нэмэлт тодруулна.

А.Ариунзаяа: Би 100 мянган төгрөгийн дурсгалын тэмдэгтийг худалдаж авлаа гэхэд түүгээр худалдаанд хэн нэгэнд бэлэглэлээ гэж бодъё. Түүгээр худалдаанд ямар нэгэн зүйл худалдан авч болох уу мөнгөн тэмдэгттэй ижил адил уу эсвэл зүгээр л ханандаа л өлгөх тийм тэмдэгт үү?

Н.Учрал: Наранцогт дарга.

С.Наранцогт: Зөвхөн дурсгалын зориулалттай худалдагдаж байгаа учраас энүүгээр мөнгөн төгрөгтэй тэнцүүлж худалдан авах боломжгүй ээ. Гүйлгээнд хэрэглэх боломжгүй гэсэн үг.

Н.Учрал: Хосбаяр гишүүн асуулт асууна.

Б.Хосбаяр: Чингис хааны музейд одоо бид нар чинь их хааныхаа том сайхан дүрийг мөнхжүүлсэн байгаа. Тэгээд энэ нэлээн үнэ цэнтэй маш чухал бүтээл болсон байна лээ. Тэгэхээр энэ их хааны маань энэ хөшөө энэ дурсгалд эрдэнэсийн санд байгаа юу, ер нь нууц биш бол ямар өртөгтэй ер нь ямар үнэ цэнтэй эд вэ гэдгийг хэлж өгмөөр. Ер нь тэгээд цаашдаа ер нь энэ эрдэнэсийн сангаар дамжуулаад үнэ цэнтэй бүтээл хийх, хадгалах энэ асуудал байх уу? Жишээ нь одоо энэ жил Өвөрхангай аймагт Өндөр гэгээний маань 390 жилийн ой болсон. Тэгээд Өндөр гэгээний ойд зориулсан Өндөр гэгээний сэрэг дүрийг бүтээх үнэ цэнтэй бүтээл гаргах тухай ярьж байгаа. Тэгээд тодорхой шалтгаануудаар ингээд хойшилсон. Тэгэхээр энэ ер нь амжилт олох уу? Ер нь ийм зүйлийг цаашдаа ийм үнэ цэнтэй зүйлийг хийж хадгалж явж болох уу гэдэг энэ дээр нэг хариулт өгөөч.

Н.Учрал: Энхжин захирал хариулна. 4 дүгээр микрофон.

А.Энхжин: Монголбанкны Эрдэнэсийн сан сүүлийн 3 жилийн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгч Хүрэлсүхийн санаачилсан Чингис хаан баримлыг бүтээлгэсэн байгаа. баримлыг Итали улсын Флоренц хотод бол яг дэлхийн хамгийн шилдэг ур загвар хийцтэйгээр бүтээлгээд Чингис хааны Чингисийн музейд залсан байгаа. Тэгэхээр энэ бүтээлийг хийхэд нийтдээ 105 кг алт орсон байгаа. Тэгэхээр шүтээнийг өөрийг нь бүтээхэд 5 кг алт, төрийн тамгыг бүтээхэд 99 кг алт орсон. Нийт өртөг нь ойролцоогоор 30 орчим тэрбум төгрөг болсон байгаа. Энэ хөрөнгө Эрдэнэсийн санд бүртгэлтэй. Чингисийн музейд үзмэрийн хэлбэрээр байршиж байгаа ийм бүтээл байгаа. Энэ оны хувьд бол бид нар Өндөр гэгээний 390 жилийн ойд зуруулаад дурсгалын зоосон мөнгөн тэмдэгт гаргасан байгаа. Тусгайлсан ийм бүтээл бүтээх асуудлын хувьд бол бид нар онцгой анхаарч судалж үзэж байж шийдэхгүй бол бидний хувьд энэ тийм байнга хийгдээд байдаг үйл ажиллагаа биш байгаа юм аа.

Н.Учрал: Хосбаяр гишүүн тодруулна.

Г.Хосбаяр: Тэгэхээр ер нь иймэрхүү санал санаачилга гаргаад явбал хаана яг шийдвэр нь гарах юм? Ер нь дэмжигдээд явбал санал санаачилга гараад дэмжигдвэл хийгээд явахад хадгалаад явахад боломжтой гэж ойлгож болох уу?

Н.Учрал: 4 дүгээр микрофон.

А.Энхжин: Эрдэнэсийн сангийн тухай хуулиар Эрдэнэсийн санд эд зүйл авах шинээр бүтээлгэх энэ ажлын мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэж шийдвэрлэдэг.

Монголбанкны эрдэнэсийн сангийн мэргэжлийн зөвлөл эрдэмтэн судлаачид хөндлөнгийн экспертүүд бас мэргэжлийн зөвлөл гаргаад тэгээд Монголбанкны мэргэжлийн зөвлөл эрдэнэсийн санд хүсэлтээ гаргах юм бол мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцээд шийдвэрлэдэг байгаа.

Н.Учрал: Гишүүд асуулт асууж, хариулт авч үг хэлж дууслаа.

Гишүүд танхимд цуглая. Санал хураалт явуулна.

Санал хураалтад бэлтгэе.

Гишүүд танхимд цуглая. Бүртгэлийн санал хураалт.

Бүртгэлийн санал хураалт.

Байнгын хорооны саналаар Эрдэнэсийн сангийн орлого, зарлагын гүйцэтгэл 2026 оны төсвийн тухай Их Хурлын тогтоолын төслийг батлах ёстой.

Тогтоолын төслийн санал хураалтыг 12 дугаар сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар эхний 10 цагт хураая.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул 12 дугаар сарын 26-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

18.25 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА